




“БАГАНУУР” ХК
Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, Улаанбаатар, Монгол Улс

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Бүртгэл	Монголын Хөрөнгийн Бирж
Хувьцааны код	BAN
Нийт хувьцааны тоо	30,844,647 ширхэг
Нэмж гаргаж буй хувь	32%
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	9,870,287 ширхэг
Нэмж гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд байршуулах	Нэмж гаргаж буй хувьцааг “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот тогтоол болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 тоот тогтоолын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр хувьцаа эзэмшиж байсан Хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд санал болгоно.
Санал болгох үнэ	Тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгон худалдана. “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 29 тоот тогтоолын дагуу одоогийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэх үнэ болон олон нийтэд санал болгох үнийг 2,650 төгрөг байхаар шийдвэрлэсэн болно.






01 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ МОНГОЛ УЛСЫН "КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ" БОЛОН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БАТАЛСАН 2016 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БУЙ ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫН ДАГУУ НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ ЗАМААР ӨӨРИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГАА БОЛНО.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд үнэт цаас худалдан авах шийдвэр гаргахад туслах, шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн тусгаагүй байж болох бөгөөд үнэт цаас гаргах үйл ажиллагааны талаар болон үнэт цаасны танилцуулгатай холбоотой тодруулах зүйлсийг Үнэт цаас гаргагч "Багануур" ХК болон андеррайтер "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-тай танилцуулгад тусгагдсан хаягаар холбогдон авна уу.



0000002




ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА



Үнэт цаас гаргагч	"Багануур" ХК
Бүртгэгдсэн бирж	Монголын Хөрөнгийн Бирж
Хувьцааны код	BAN
Үнэт цаасны бүртгэл	Хувьцаа нэмж гаргах
Нийт хувьцааны тоо	30,844,647 ширхэг
Хувьцааны төрөл	Энгийн
Нэрлэсэн үнэ	100.0 (нэг зуун) төгрөг
Нэмж гаргаж буй хувь	32%
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	9,870,287 ширхэг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	26,156,260,550.0 төгрөг
Хувьцааг анхдагч зах зээлд байршуулах	Нэмж гаргаж буй хувьцааг 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр хувьцаа эзэмшиж буй Хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд санал болгоно. Нэмж гаргаж буй хувьцааны тэргүүн ээлжинд хэрэгжээгүй үлдсэн хэсгийг олон нийтэд санал болгон худалдана.
Тэргүүн ээлжинд санал болгох үнэ	Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд санал болгох үнэ 2,650 төгрөг
Олон нийтэд санал болгох үнэ	Хувьцааг олон нийтэд санал болгох үнэ 2,650 төгрөг байна
Үнэт цаасны арилжаа явуулах арга хэлбэр	Захиалгын бүртгэлийн арга
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт
Андеррайтерын үүрэг	Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгосон үнэт цаасыг худалдан аваагүй нөхцөлд тухайн үнэт цаасыг гэрээгээр тохиролцсон үнээр худалдан авах баталгаа гаргах
Андеррайтер	Ти Ди Би Капитал ҮЦК

0000003





АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД..... 2

ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА 3

ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР 10

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ 12

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 13

1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ 13

1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАЯГ 13

1.3. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ 13

1.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМЭЛ
СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ 15

1.4.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ 15

1.4.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД 15

1.4.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОХИН БОЛОН ХАРААТ КОМПАНИУД 16

1.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 17

1.5.1 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 17

1.5.2 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ 17

1.5.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХОРООД 18

1.5.4 ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА 21

1.5.5 ХЭЛТЭС НЭГЖҮҮДИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 23

1.5.6 ХҮНИЙ НӨӨЦ 27

1.6. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ 29

1.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 31

1.7.1. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА 31

1.7.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХ 33

1.7.3. БАГАНУУРЫН УУРХАЙН ОРД ГАЗРЫН ТУХАЙ 35

1.7.3.1. Ордын байршил 35

1.7.3.2. Орд газрын үндсэн үзүүлэлт 35

1.7.3.3. Орд газарт хийгдсэн хайгуулын ажлууд 35

1.7.3.4. Нүүрсний чанар 37

1.7.3.5. Орд газрын нөөц 37

1.7.3.6. Багануурын орд газрын тусгай зөвшөөрлийн эзэмшил 38

1.7.4. ОРД ГАЗРЫН АШИГЛАЛТ, УУРХАЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ 40

1.7.4.1. Уурхайн ашиглалтын хэмжээ 40

1.7.4.2. Уурхайн ашиглалтын үндсэн технологи 42


1.7.4.3. Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ 42

1.7.5. ДЭД БҮТЭЦ, ТЭЭВЭР 43

1.7.5.1. Барилга, байгууламж 43

0000004






1.7.5.2.	Усан хангамж	43
1.7.5.3.	Цахилгаан хангамж	43
1.7.5.4.	Дулаан хангамж	44
1.7.5.5.	Тээвэр	44
1.8.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРААТ БОЛОН ОХИН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	45
1.8.1.	БАГАНУУР СУВИЛАЛ ХХК	45
1.8.2.	БАГАНУУР ИЛЧ ХХК	45
1.8.3.	МОН-ЦАХИМ ХХК	45
1.9.	САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ	47
1.9.1.	БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	47
1.9.2.	БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	52
1.10.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО	56
1.11.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ	58
1.11.1.	БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ	58
1.11.2.	БУСАДТАЙ БАЙГУУЛСАН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ	58
1.12.	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	59
1.13.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ ЗАХ ЗЭЭЛ	65
1.13.1.	ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	65
1.13.2.	МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	68
1.13.3.	МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	69
1.13.4.	МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛ	69
1.13.4.1.	Монгол улсын нүүрсний нөөц	69
1.13.4.2.	Монгол улсын нүүрсний зах зээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт	69
1.13.4.3.	Монгол улсын нүүрсний зах зээлийн эрэлт	71
1.13.4.4.	Эрчим хүчний зах зээлийн хандлага	72
1.13.4.5.	Эрчим хүчний нүүрсний үнэ	74
1.13.4.6.	Үнэт цаас гаргагчийн зорилтот зах зээл	75
1.14.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, SWOT ШИНЖИЛГЭЭ	78
1.15.	ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ	80
1.15.1.	ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ	80
1.15.2.	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	85
ХОЁР.	ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ	88
2.1.	НЭМЖ ГАРГАХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА	88
2.2.	НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР	89
2.3.	ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ	89

00000005






2.3.1.	ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ	90
2.3.2.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ	91
2.3.3.	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРИУЦЛАГА	92
2.4.	ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ	91
2.4.1.	ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ	91
2.4.2.	ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ХЭЛБЭР	91
2.4.3.	ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	91
2.4.4.	ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ	91
2.4.5.	ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД АРИЛЖААЛАХ ЖУРАМ	92
2.4.6.	ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ, АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ	92
2.5.	НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗОРИЛГО	95
2.5.1.	ҮНЭТ ЦААС ГАРГАЖ ХУРИМТЛУУЛСАН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	95
2.5.2.	ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ	95
2.5.2.1.	Уулын ажлын төлөвлөлт	95
2.5.2.2.	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнд ашигласан таамаглал үзүүлэлтүүд	97
2.5.2.3.	Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	101
2.6.	НЭМЭЛТ ХУВЬЦААНЫ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ	104
ГУРАВ.	ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	106
3.1	АНДЕРРАЙТЕР	106
3.2.	АУДИТЫН БАЙГУУЛЛАГА	107
3.3.	ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА	108
3.4.	ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГА	109

0000006





ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ



Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид	15
Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн охин болон хараат компаниуд	16
Хүснэгт 3: Ажиллагсдын судалгаа	27
Хүснэгт 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	29
Хүснэгт 5: ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд	29
Хүснэгт 6: Хяналтын зөвлөлийн гишүүд	30
Хүснэгт 7: “Багануур” ХК-ийн Захирлын зөвлөлийн гишүүд	30
Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн охин компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл	30
Хүснэгт 9: Багануурын орд газрын үндсэн үзүүлэлт	35
Хүснэгт 10: Топограф-геодезийн ажлын гүйцэтгэл	36
Хүснэгт 11: Багануурын орд газарт хийгдсэн өрөмдлөгийн ажил	36
Хүснэгт 12: Багануурын орд газарт хийгдсэн геофизикийн ажил	36
Хүснэгт 13: Багануурын орд газрын нүүрсний чанар	37
Хүснэгт 14: Багануурын орд газрын JORC стандартаар тооцогдсон нүүрсний нөөц	38
Хүснэгт 15: Багануурын орд газрын ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн нөөц (2015.01.01-ний байдлаар)	38
Хүснэгт 16: “Багануур” ХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл	39
Хүснэгт 17 : Сүүлийн 5 жилийн уурхайн ажлын хэмжээ	42
Хүснэгт 18: Дэлгэрэнгүй орлогын тайлан	47
Хүснэгт 19: Санхүүгийн байдлын тайлан	49
Хүснэгт 20: Орлого, үр дүнгийн бүтэц, динамикийн шинжилгээ	52
Хүснэгт 21: Хөрөнгө, капиталын бүтэц, динамикийн шинжилгээ	53
Хүснэгт 22: Орлогын тайлан болон санхүүгийн байдлын тайланд хийсэн харьцааны шинжилгээ	54
Хүснэгт 23: Давхар татварын хэлэлцээртэй улс орнууд	61
Хүснэгт 24: Монгол улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	68
Хүснэгт 25: Монгол улсын нүүрсний тэнцэл	70
Хүснэгт 26: Монгол улсын томоохон дулаан, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүд	72
Хүснэгт 27: 2017-2020 онд шинээр баригдах эрчим хүчний эх үүсвэр	73
Хүснэгт 28: Зорилтот зах зээлд шинээр орох цахилгаан станцууд	76
Хүснэгт 29: Эрчим хүчний нүүрсний зах зээлийн эрэлт (мян.тонн)	76
Хүснэгт 30: Эрчим хүчний нүүрс үйлдвэрлэгч томоохон байгууллагууд	78
Хүснэгт 31: SWOT шинжилгээ	78
Хүснэгт 32: Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх хэрэгжүүлэх хугацаа	93
Хүснэгт 33: Тэргүүн ээлжийн эрх хэрэгжүүлэхтэй холбоотой хувьцааны мөнгө шилжүүлэх мэдээлэл	93
Хүснэгт 34: Шинээр хувьцаа эзэмшихтэй холбоотой төлбөр тооцоо гүйцэтгэх хугацаа	94
Хүснэгт 35: Шинээр хувьцаа эзэмшихтэй холбоотой хувьцааны мөнгө шилжүүлэх мэдээлэл	94
Хүснэгт 36: Нэмэлт хувьцаанаас төвлөрүүлэх хөрөнгийн эх үүсвэрээр хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	95
Хүснэгт 37: Төлөвлөж буй уулын ажлын хэмжээ	97
Хүснэгт 38: 2016-2025 оны нүүрсний борлуулалтын таамаг хэмжээ (мянган тонн)	98
Хүснэгт 39: 2016-2025 оны нүүрсний борлуулалтын таамаг дүн (сая төгрөг)	99
Хүснэгт 40: Төсөвлөсөн орлогын тайлан	102
Хүснэгт 41: Төсөвлөсөн мөнгөн урсгалын тайлан	103

0000007





ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1: Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй компанийн хувьцааны үнэ (2015 он)	14
Зураг 2: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц	15
Зураг 3: Байгууллагын бүтэц зохион байгуулалт	17
Зураг 4: Багануурын орд газрын талбай	40
Зураг 5: Багануурын уурхайн уулын ажлын байдал	41
Зураг 6: Дэлхийн эрчим хүчний эх үүсвэр болон эрэлт	65
Зураг 7: Дэлхийн нүүрсний нөөц	66
Зураг 8: Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үйлдвэрлэл ба хэрэглээ	66
Зураг 9: Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ	67
Зураг 10: Монгол улсын эдийн засагт эзлэх уул уурхайн салбарын хэмжээ	69
Зураг 11: Монгол улсын нүүрсний нийлүүлэлт	70
Зураг 12: Нүүрсний экспортын хэмжээ, төрлөөр (2015 он)	71
Зураг 13: Дотоодын нүүрсний хэрэглээ	71
Зураг 14: Монгол улсын эрчим хүчний систем	72
Зураг 15: Үйлдвэрлэсэн цахилгаан дулаан	73
Зураг 16: Монгол улсын эрчим хүчний эрэлтийн төлөв	74
Зураг 17: Эрчим хүчний нүүрсний зохицуулалттай үнэ болон үйлдвэрлэлийн өртөг	75
Зураг 18: Монгол улсын нүүрсний хэрэглээний таамаг	77
Зураг 19: “Багануур” ХК-ийн зах зээлд эзлэх байр суурь	78
Зураг 20: Эрсдэлийн удирдлагын бүтэц	85
Зураг 21: Үнэт цаасыг зах зээлд байршуулах хэлбэр	91
Зураг 22: Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц	92
Зураг 23: Үнэт цаасыг зах зээлд байршуулах төлөвлөгөө	93
Зураг 24: Уурхайн одоогийн ашиглалтын чиглэл	96
Зураг 25: Уурхайн шинэ төлөвлөлтийн чиглэл	96
Зураг 26: Төлөвлөгөөт хөрөнгө оруулалтын хэмжээ	97
Зураг 27: Нүүрс борлуулах үнийн төсөөлөл	98
Зураг 28: Борлуулалтын орлогын эзлэмж	99
Зураг 29: Борлуулалтын орлогын таамаглал	100
Зураг 30: Компанийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн бүтэц	100
Зураг 31: Ашгийн таамаглал	101



0000008



ХАВСРАЛТ



**АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛСЭН ТУХАЙ ТАЙЛАН
ХУУЛЬ ЗҮЙН ХӨНДЛӨНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ
АНДЕРРАЙТЕРЫН ДҮГНЭЛТ
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАРИМТ БИЧГҮҮД**

0000000




ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
АНУ	Америкийн нэгдсэн улс
БДК	Монголын хөрөнгийн биржийн гишүүн брокер, дилерийн компаниуд
Бирж	Монголын хөрөнгийн бирж
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Гкал	Гегакалорь
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДС	Дулааны станц
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
кВт	Киловатт
кВт.цаг	Киловатт цаг
Компани	"Багануур" ХК
мВт	Мегаватт
МҮХАУТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрлэлийн танхим
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МҮЭ	Монголын үйлдвэрчний эвлэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТС	Салхин цахилгаан станц
Төгрөг	Монгол улсын мөнгөн тэмдэгт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭХС	Төвийн эрчим хүчний систем
УБ	Улаанбаатар хот
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын их хурал
УЦС	Усан цахилгаан станц
ҮҮГ	Улсын үйлдвэрийн газар
Үнэт цаас гаргагч	Багануур ХК
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
ҮЦК	Үнэт цаасны компани
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ЦС	Цахилгаан станц



0000010





BAN

"Багануур" ХК-н хувьцааны код

JORC кодекс

Австрали улсын хамтарсан хүдрийн нөөцийн хорооны кодекс

0000011



Handwritten signature



НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ

Компанийн нэр:	"Багануур" ХК
Байгуулагдсан огноо:	1977 оны 12 дугаар сарын 16-ны өдөр
Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо:	2005 оны 12 дугаар сарын 6-ны өдөр
Улсын бүртгэлийн дугаар:	9010001045
Регистрийн дугаар:	2008572
Үйл ажиллагааны үндсэн чиглэл:	Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах
Үйл ажиллагааны туслах чиглэл:	Алтны шороон ордыг ашиглах Цайны газар Гадаад худалдаа

1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАЯГ

Нэр:	"БАГАНУУР" ХК ("БАГАНУУР" гэх)
Хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, "Багануур" ХК-ийн байр
Утас:	(976)-70210114, (976)-70213739
Факс:	(976)-70213130
Э-шуудан:	bjsc@baganuurmine.mn

1.3. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

Багануурын нүүрсний уурхай нь 1977 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн №368 дугаар тогтоолоор 100 хувь төрийн өмчит хуулийн этгээд хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Монгол улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн №63 тоот тогтоолоор Багануурын нүүрсний уурхайг хувьцаат компани болгон өөрчилж, нийт хувьцааны 25 хувийг нийтэд худалдаж, үлдсэн 75 хувийг төрийн өмчид үлдээн төрийн өмчийг төлөөлөх эрхийг Монгол улсын Засгийн газраас эрх олгосон байгууллагад олгохоор шийдвэрлэсэн. Тус тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн бирж нь 1994 оны 3 дугаар сарын 18-ны өдөр "Багануур" ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,097,436,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 20,974,360 ширхэг хувьцааг анх бүртгэсэн бөгөөд үүнээс 75% буюу 15,730,770 ширхэг хувьцааг төрийн өмчид бүртгэжээ. Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2013 оны 9 дүгээр сарын 19 өдрийн 488 тогтоолын дагуу "Багануур" ХК-ийн төрийн өмчид бүртгэгдсэн 15,730,770 ширхэг хувьцааг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлэн бүртгэсэн.


"Багануур" ХК-ийн хувьцаа нь Монголын Хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 4776 хувьцаа эзэмшигчидтэй, компанийн 5 хувиас дээш хувьцааг эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигчтэй байна.

Монголын хөрөнгийн биржийн бүртгэл


Нэр:	"БАГАНУУР" ХК
Код:	BAN
ISIN:	MN00BAN03966
52 долоо хоногийн дундаж ханш (2015)	2,638.0 төгрөг
Зах зээлийн үнэлгээ (2015.12.31)	51.8 тэрбум төгрөг



0000013



Зураг 1: Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй компанийн хувьцааны үнэ (2015 он)



0000014



1.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН НЭГДМӨЛ
СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

1.4.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ


Зураг 2: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц




1.4.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид

№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь (%)	Хувьцааны тоо (ширхэг)	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг
1	Эрдэнэс Монгол ХХК	75.00	15,730,770	Стратегийн ач холбогдол бүхий ордыг болон улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж, нөөцийг тогтоосон ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, гэрээгээр ерөмдлөг хийх, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, 15 давхар, Улаанбаатар хот 14240
2	“Монголиан Нэшнл Коал Корпорэйшн” ХХК	21.06	4,416,668		Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамъяангүний гудамж, Ар Монгол трэвел бьолдинг, 307 тоот, Улаанбаатар хот,
3	Бусад 4774 хувьцаа эзэмшигчид	3.94	826,922		
	Нийт	100.00	20,974,360		





“Эрдэнэс Монгол” ХХК

“Эрдэнэс Монгол” ХХК нь Монгол улсын эдийн засгийн тулгуур салбарууд болох уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний салбарт тэргүүлэх үндэсний компани болох зорилготойгоор 2007 онд үүсгэн байгуулагдсан. Тус компани нь Монгол улсын эдийн засгийн хөгжил дэвшлийг байгалийн баялагийг үр дүнтэй, зүй зохистой ашиглах замаар нэмэгдүүлэхэд үндэсний компаниудад туслах, хөрөнгө оруулалт хийх, охин болон хараат компаниудад компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, арилжааны зарчмаар ашгийн төлөө ажиллах нөхцөлөөр хангах, үнэлгээг нь нэмэгдүүлж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үндэсний компаниудыг бий болгохыг зорин ажилладаг. Монгол улсын Засгийн газраас эрх олгосноор “Эрдэнэс Монгол” ХХК нь “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, “Эрдэнэс Таван Толгой” ХХК, “Эрдэнэт Үйлдвэр” ХХК, “Шивээ Овоо” ХК, “Багануур” ХК зэрэг Монгол Улсын тэргүүлэх уул уурхайн компаниудын хувьцааг эзэмшдэг.

“Монголиан нэшнл коал корпорэйшн” ХХК

“Монголиан нэшнл коал корпорэйшн” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан ба уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, гэрээгээр өрөмдлөг хийх, гадаад дотоод худалдаа эрхлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус компани нь 2014 оноос эхлэн “Багануур” ХК-ийн хувьцааг эзэмшиж байна.

1.4.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОХИН БОЛОН ХАРААТ КОМПАНИУД

Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн охин болон хараат компаниуд

№	Нэр	Үнэт цаас гаргагчийн эзэмшил (%)	Үйл ажиллагааний чиглэл	Хаяг
1	"Багануур сувилал" ХХК	100%	Сувилал, зочид буудал, амралтын газар, түр хоноглох байрны үйлчилгээ, зоогийн газар, хүнсний дэлгүүр, мал аж ахуй, нүүрс борлуулалт, баар, нарийн боов, зайрмаг, ундаа үйлдвэрлэх	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1-р хороо, Нацагдоржийн гудамж, Багануур сувилалын байр
2	"Багануур Илч" ХХК	100%	Нүүрс борлуулах, худалдааны зуучлал, гадаад худалдаа зочид буудал, цайны газар, бильярд тоглуулах	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, Хөвдөр судлалын баруун талд
3	"Монцахим" ХХК	46%	Нүүрсний болон бусад үйлдвэрлэлийн зориулалт бүхий цахилгаан машин, тоноглолын засварын үйлчилгээ	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, "Багануур" ХК-ийн байр




0000016

1.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх) байна. Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаас бусад тохиолдолд компанийн удирдлага болон бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) хэрэгжүүлнэ.

1.5.1 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зураг 3: Байгууллагын бүтэц зохион байгуулалт



1.5.2 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ


“Багануур” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд ХЭХ нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулах ба шаардлагатай гэж үзвэл Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий этгээд зарлан хуралдуулж байна.

Компанийн ХЭХ-аар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг. Үүнд:

- Компанийн дүрэм болон дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах,
- Компанийг өөрчлөн байгуулах, хэлбэрийг өөрчлөх,
- Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох,

0000017





- Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох,
- Хувьцааг хуваах, нэгтгэх,
- ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх, тэдний цалин, урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох,
- Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг хууль тогтоомжид заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх,
- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
- Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах,
- Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах,
- Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн шийдвэрээр ХЭХ-аар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

ХЭХ-аас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргах ба Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болдог.

1.5.3 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ХОРООД

Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд Компанийн тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн дүрмийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажилладаг.

Компанийн ТУЗ-өөр дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох, зорилтын хүрээнд холбогдох асуудлаар шийдвэр гаргах,
- Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах,
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах,
- Компанийн зарласан хувьцааны тоо, хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх,
- Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох,
- Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, чөлөөлөх,
- Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах,
- Компанийн гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих,
- Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах,
- Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох,
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах,
- Компанийн шинээр худалдаж авах болон ашиглалтаас хасах, акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг толгой компанийн гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн ТУЗ шийдвэрлэх,
- Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах,
- Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох,
- Дотоод хяналтын алба байгуулан ажиллах журмыг батлах.

0000013





- ТУЗ-ийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах,
- Компанийн худалдан авалтын төлөвлөгөөг баталж хяналт тавих,
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх.

"Багануур" ХК-ийн ТУЗ нь 13 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн ба Компанийн ТУЗ-д нэр дэвшигчдийг ХЭХ-аар хэлэлцэн кумулятив аргаар сонгодог. ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тухайн сард ээлжит бус хуралдааныг ТУЗ-ийн дарга, гишүүн, Компанийн гүйцэтгэх удирдлагын санаачилга, шаардлагаар хуралдуулж болно. ТУЗ нь жилийн ажлын тайлангаа хувьцаа эзэмшигчдийн хуралд тавьж хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт гаргуулдаг. ТУЗ нь тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй Аудитын байнгын хороо, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороодтой байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2012 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 12 тоот ТУЗ-ийн тогтоолоор баталсан бөгөөд тус журмаар ТУЗ-ийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хурлын бүрэн эрх, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн дарга, ердийн гишүүд, хараат бус гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, цалин, урамшуулал, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, нэр дэвшүүлэх зэрэг харилцааг зохицуулдаг.

ТУЗ-ийн гишүүдийн товч мэдээлэл

Б.Ариунболд нь "Эрдэнэс Монгол" ХХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаад 2015 оны 5 дугаар сарын 15-аас эхлэн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

Д.Артаг нь Уул уурхайн яамны төрийн нарийн бичгийн дарга бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Д.Болд нь "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Бодлого төсөл хөтөлбөр хариуцсан захирал бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар ажилладаг.

М.Хуягбаатар нь "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Засгийн газартай харилцах менежер бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажилладаг.


Г.Мэргэнбаяр нь Эрчим хүчний яамны Эрчим хүчний хөгжлийн төвийн дэд захирал бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар ажилладаг.

Д.Нарангэрэл нь Сангийн яамны Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт хяналтын хэлтсийн дарга бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны гишүүнээр ажилладаг.

Л.Оюунчимэг нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор

0000019





"Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажилладаг.

О.Банзрагч нь эдийн засагч бөгөөд 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 31 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон Цалин урамшууллын хорооны гишүүнээр ажилладаг.

Д.Цэрэнбадам нь эрхзүйч, судлаач бөгөөд 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 31 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажилладаг.

Г.Ёндонгомбо нь Эрчмийн аж үйлдвэрийн хөгжлийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажилладаг.

Т.Наран нь Нүүрс ассоциацийн тэргүүн бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо болон, Цалин урамшууллын хорооны гишүүнээр ажилладаг.

Б.Осоргарав нь Улаанбаатар Аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүнээр ажилладаг.

Б.Ганбат нь "LEXLOC" ХХК-ийн өмгөөлөгч бөгөөд 2015 оны 4 дүгээр сарын 29-ний 06 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Б.Ганбаатар нь "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ахлах шинжээч бөгөөд 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 08 тоот тогтоолоор "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг

Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын зөв бодлого, зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол өгч ажилладгийн хувьд Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурал, түүний дэргэдэх хороодын хурлыг тогтмол зохион байгуулж, эрх хэмжээний хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэн ажилладаг.

Аудитын хороо

Тус хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд Компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнд үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторчуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна. Хорооны бүрэн эрхэд дараах асуудлууд хамаарна. Үүнд:

- Дотоод хяналт, эрсдэлийн удирдлага,
- Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн тайлан,

0000020



- Хөндлөнгийн аудитортой хамтран ажиллах,
- Дотоод хяналт,
- Хууль, журмын хэрэгжилтэнд хяналт тавих,

Цалин урамшууллын хороо

Компанийн Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, Компанид үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд түүний боловсруулсан компанийн цалин урамшууллын бодлого, практик нь чадварлаг ажилтан, менежерийг ажилд авах, улмаар тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулан хөгжүүлэх замаар Компанийн бизнесийн зорилтдоо хүрэх, тогтвортой бизнесийн хөгжил авч ирэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлага гаргаж ТУЗ-д танилцуулах ба ТУЗ тус зөвлөмжийг харгалзан шийдвэр гаргаж болно. Тус хороо нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- ТУЗ, удирдах ажилтан болон бусад эрх бүхий ажилтанд олгох цалин хөлс болон урамшууллын бодлогыг тухайн ажилтны компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратегийн зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үйлдэл, оруулсан хувь нэмэр болон ТУЗ-өөс баталсан зорилго, зорилтыг хэрхэн биелүүлсэн байдлыг харгалзах зарчмыг баримтлан боловсруулж, түүнд хяналт тавих;
- ТУЗ-ийн дарга, хорооны гишүүн болон бусад зөвлөлийн гишүүдэд компаниас олгох цалин урамшууллын шалгуурыг гишүүдийн хараат бус байдалд нөлөөлөхгүй өрсөлдөх чадвартай байлгахаар боловсруулах;
- Хорооноос Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн болон бусад удирдах албан хаагч, Компанийн эрх бүхий албан тушаалтны жилийн үндсэн цалингийн дээд хэмжээ, санхүүгийн болон ажлын гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтэд суурилсан жилийн хувьсах урамшууллын систем, менежерүүдийн ашиг сонирхлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолтой нийцүүлэх, урт хугацааны урамшууллын систем мөн тэтгэвэр, тэтгэмж болон бусад нэмэлт орлогыг тогтоож, тогтмол хянах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан захирал, удирдах албан тушаалтны цалин урамшуулалтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, түүнчлэн захирлуудын цалин урамшууллын талаарх мэдээллийг ил тод болгох;

Нэр дэвшүүлэх хороо

Тус хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, компаниуд ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд мэдлэг, ур чадвартай захирал, удирдах ажилтныг нэр дэвшүүлэх, улмаар компанийн бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Хорооноос чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, санал, зөвлөмж боловсруулах, шаардлага гаргаж ТУЗ-д танилцуулах үүрэгтэй бөгөөд тэдгээр нь ТУЗ-өөр хэлэлцэн баталснаар дагаж мөрдөх шийдвэр болно.


Хорооны ажил, үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байна. Хорооны хурал нь ээлжит ба ээлжит бус байх ба хурлыг хорооны үйл ажиллагаа, үндсэн үүргийг цаг тухайд гүйцэтгэхэд шаардагдах тогтмол хугацаанд аль болох ойрхон зайтай хуралдуулна.

1.5.4 ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх удирдлага нь Компанийн гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн дарга нэр дэвшүүлэх хороотой зөвшилцөн ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхи дэмжсэнээр томилдог. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан Хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах ба гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэрэг асуудлыг тусгана.

0000021





Гүйцэтгэх захирал нь компанийн тухай хууль, холбогдох хууль дүрмийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, аж ахуйн менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг биелүүлэх, үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, осол аюулгүй ажиллагааг хангаж, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэж, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллах үүрэгтэй. Төлөөлөн удирдах зөвлөлд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн улирал, хагас жил, бүтэн жилийн тайлан тэнцлийн үр дүнгийн талаар үнэн зөв мэдээлэл өгч тайлагнана.

Захирлын зөвлөл

Багануурын уурхай нь "Багануур" ХК болон өөрчлөн зохион байгуулагдсанаар 1995 оны 4-р сарын 25-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаа хийж, Гүйцэтгэх захиралд өдөр тутмын шуурхай ажиллагааны талаар зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Захирлын зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална. Захирлын зөвлөл нь удирдлагын зохион байгуулалтын үндсэн нэгж бөгөөд Гүйцэтгэх захиралд зөвлөн Компанийн хэлтэс, албаны бүтэц зохион байгуулалтын чиг үүргийн тогтолцоонд суурилсан компанийн удирдлагын дунд шатны нэгж бөгөөд компанийн бүтэц, зохион байгуулалтын хэлтэс, нэгжүүдийн хоорондын харилцан холбоотой ажлын чиг үүргүүдийн технологийн дэс дараалал уялдаа холбоог хангах, хэрэгжүүлэх, өдөр тутмын ажлын гүйцэтгэлийг зохицуулах, дүгнэх, үр дүнг тооцох, үйл ажиллагааны ажил үүргийн хийдэл, завсардлын улмаас үүдэх захиргааны хомсдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн богино, дунд, урт хугацааны төлөвийг тодорхойлон дүгнэх, эдгээртэй холбоотой санал зөвлөмж гаргах, компанийн хүний нөөцийн ажлын байран дахь хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын нөөц бололцоог тогтоох, байгууллагын болон ажилтан тус бүрийн хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн хариуцлага, хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд шат дараатай сургалтын хөрөнгө оруулалт хийх тухай санал зөвлөмж гаргах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Захирлын зөвлөлийн үйл ажиллагаа нь 2012 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн Б/50 Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан "Захирлын зөвлөлийн ажиллах журам"-аар зохицуулагддаг бөгөөд тус журмын зорилго нь Захирлын зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүрэг, гишүүдийн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлж, хурлын хэлэлцэх асуудал, гишүүдийн эрх үүрэг, Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг хурлаас гарах санал зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих арга зүйн тогтолцоог тогтооход байдаг. Захирлын зөвлөлийн хурлаар компанийн үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг авч хэлэлцэн хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ.


Гүйцэтгэх захирал

"Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал буюу Компанийн гүйцэтгэх удирдлага нь Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана. Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм, Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах эрхийн хүрээнд дараах үүрэг хүлээж, эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ТУЗ-ийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх ба энэхүү тайланд тухайн хугацаанд хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх талаар тусгасан байна;
- Компанийн дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;



0000022



- Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх
- Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж биелэлтийг хангуулах;

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлыг 2012 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 28 тоот ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилсон. Гүйцэтгэх захирал М.Отгонбаяр нь 1960 онд Төв аймгийн Баянцагаан суманд төрсөн Геологийн инженер мэргэжилтэй, 1978-1983 онуудад Политехникийн дээд сургуулийг Геологийн инженер мэргэжлээр, 1996-1998 онуудад Техникийн их сургуулийг Байгалийн шинжлэх ухааны магистр зэрэгтэй, 2006-2007 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. "Хөтөлийн Цемент Шохой" ХК-д Уурхайн геологи, Геологи маркшейдерийн хэсгийн дарга, НҮБ-ийн үйлдвэр хөгжүүлэх багт Төслийн инженер, БМАХ экспедицэд Ерөнхий инженер, "Баянгол жалга" УҮГ-т Захирал, "Санчир инвест" ХХК, "Санчир буудай" ХХК-д захирлын албан тушаалыг хашиж байсан. Тэрээр 2016 оны 3 дугаар сарын байдлаар бусдад хугацаа хэтэрсэн өр зээлгүй, ял шийтгэлгүй, хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэн шалгагдаж байсан зөрчилгүй болно.

1.5.5 ХЭЛТЭС НЭГЖҮҮДИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Компани нь 2016 оны 01 дүгээр сарын 15-ны 5/07 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан бүтэц зохин байгуулалтаар дараах хэлтэс, нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хэлтэс, хэсэг, албад нь Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан ажиллах журам, аюулгүй ажиллагааны заавартай байх ба уг журмаар үйл ажиллагаа нь зохицуулагдана.

Хэлтэс, хэсэг, албаны ажилтан бүр хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийг гүйцэтгэж хариуцлага хүлээх ба хэсэг, хэлтэс, албад нь өөрсдийн үйл ажиллагаандаа бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, ажлын байрны соёл 5С-ыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулдаг. Хэсгүүд өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг компанийн захиргаанд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд захиргаа асуудалд хэсгийн саналыг хүндэтгэх байр суурь баримтлана. Захиргааны гаргасан шийдвэрийг хэсэг, нэгж, бүх ажилтнууд биелүүлэх үүрэгтэй.

- **Тэргүүн дэд захирал:** Уулын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу явуулах, хэрэглэгчдэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өдөр тутам шуурхай удирдлагаар ханган ажиллах үүрэгтэй. Гүйцэтгэх захирлын эзгүйд орон ажиллана.

Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал Компанийн ашиглалтын үндсэн үйл ажиллагаа, технологийн болон уул тээврийн үндсэн тоног төхөөрөмжийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, техник технологийн шинэчлэлийг хариуцах бөгөөд удирдлагад хэсэг албууд бүгд хамаарагдана.

- **Хөгжил, нийгмийн асуудал эрхэлсэн дэд захирал**
Компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг тодорхойлж хариуцан ажиллах бөгөөд мөн нүүрсийг боловсруулах, дагалдах эрдэсийг ашиглах талаар судалгаа туршилтын ажлыг хариуцаж, компанийн хөгжлийн бодлогыг тодорхойлж Судалгаа, хөгжлийн хэлтсийг хариуцан ажиллана.
- **Техникийн хэлтэс**
Компанийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, барилга байгууламж, техникийн засвар үйлчилгээ, цахилгаан, дулаан, халуун хүйтэн ус хангамжийн бодлогыг боловсруулж хэрэгжилтэнд нь хяналт тавьж гүйцэтгүүлдэг. Техникийн цаг ашиглалтын мэдээ, эвдрэл саатлын судалгаа гарган дүгнэлт хийж, шалтгааныг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Техникийн бүх бичиг баримт, хувийн хэрэг хөтлүүлэх ажилд хяналт тавьж, тоног төхөөрөмж, машин механизм шинээр авах, актлуулах ажлыг хариуцна.

0000023



Сэлбэг түүхий эд, шатах тослох материалын захиалгыг оновчтой хийж түүний зарцуулалтад тогтмол хяналт тавина. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг хэлтэст төвлөрүүлж тогтмол ажиллуулна.

Мэдээллийн технологийн алба

Үйлдвэрлэлийн онцлог шинжийг агуулсан нэгдсэн мэдээллийн сантай, орчин үеийн мэдээлэл холбооны шинэ техник технологитой системүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, түүний найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тухай мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь дамжуулах үүрэгтэй. Өндөр хурдны интернет, технологийн холбоо, мэдээллийн системийг компанийн хэмжээнд хариуцах ба холбооны үйлчилгээний бодлогыг боловсруулж хяналт тавина.

Эрчим хүчний нэгдсэн хэсэг

Үйлдвэрлэлийн талбайн бүх объект, уул тээврийн машин тоног төхөөрөмжүүдийг цахилгаан дулааны эрчим хүч, хэрэглээний халуун, хүйтэн ус, сувагжуулалт, сантехникийн ба инженерийн байгууламжийн кабель, дэд станц, хуваарилах байгууламж тэдгээрийн засвар үйлчилгээний асуудлыг бүрэн хариуцна. Тус хэсэгт цахилгаан шугам сүлжээ, дулаан ус хангамжийн нэгжүүд хамрагдана. Үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангахын тулд дэд станц, хуваарилах байгууламж, шугам сүлжээ, уул тээврийн тоног төхөөрөмжийн цахилгаан хуваарилах байгууламжийн засвар, тохируулгыг графикийн дагуу гүйцэтгэж үйлчилнэ.

Үйлчилгээний автомашины хэсэг

Компанийн бүхий л ажил үйлчилгээнд ашиглагдаж байгаа бүх төрлийн авто хэрэгслийн засвар, үйлчилгээ, бэлэн байдал ашиглалтыг хариуцна. Автомашины хангамж, ашиглалтын талаар бодлого боловсруулан үр ашигтайгаар үйлчилгээг хангах асуудлыг шийдвэрлэнэ.

Засварын хэсэг

Уулын үндсэн тоног төхөөрөмжийн бүх төрлийн засвар, цахилгаан тоног төхөөрөмжийн засвар тохируулга хийж өөрийн нөхцөлд хийх боломжтой эд ангиудыг урьдчилан бэлтгэх, үйлдвэрийг азот, хүчилтөрөгч, шахсан хийгээр хангах үүрэгтэй. Хэсгийн үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хүчин чадлыг ашиглаж үйлдвэрлэлийг хэвийн ажиллуулах нөхцлийг бүрдүүлнэ.

Технологийн автомашины засварын хэсэг

Уул тээврийн бүх төрлийн хүнд даацын автомашин, замын машин механизм, дугуйт болон гинжит бульдозер, дизель хөдөлгүүртэй ачигч, усны машин, скрепер, өрмийн машин, илчит тэрэгний засвар үйлчилгээг хийнэ.


Уурхайн технологийн зориулалтаар ашиглагдаж байгаа машин механизмуудад засвар үйлчилгээний тэргүүний арга барил нэвтрүүлж техникийн бэлэн байдал итгэлцүүрийг нэмэгдүүлэхэд гол ажлаа чиглүүлнэ. Хэсгийн үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж ашиглалтын түвшинг өндөржүүлнэ.

▪ **Санхүү эдийн засгийн хэлтэс**

Эдийн засаг санхүүгийн төлөвлөлт, цалин хөлс, сэлбэг материал, хөдөлмөрийн норм үнэлгээтэй холбогдсон асуудлуудыг хянаж шийдвэрлэнэ. Бүртгэл хөтлөх, тооллого тооцоо хийх, өртөг зардлыг бууруулах ажлыг зохион байгуулах, тайлан баланс гаргах, судалгаа дүгнэлт хийж авах арга хэмжээг зохион байгуулна. Үйлдвэрлэлийг санхүү эдийн засгийн нөөцөөр хангах, бүтээгдэхүүн борлуулах, өр авлагыг бууруулах, компанийн ашиг орлого, бүтээмж үр ашгийг нэмэгдүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. Компанийн хэмжээнд бүтээмж үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангаж зохион байгуулна.

0000024





▪ **Худалдаа хангамжийн хэлтэс**

Компанийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байгаа бүх тоног төхөөрөмж, сэлбэг материал, тос, түлш шатахуун, түүхий эд, материалаар хангах ажлыг зохион байгуулж, агуулахад байгаа бараа материал, сэлбэг хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, түгээлтэд байнгын хяналт тавьж ажиллана. Тус хэлтэс нь худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу явуулж худалдан авалт бүрээр хавтаст хэрэг бүрдүүлж ажиллана. Хэлтсийн харъяанд сэлбэг материалын төв агуулах, шатахуун түгээх станц, хоёрдогч түүхий эдийн нэгж ажиллана.

▪ **Үйлдвэр технологийн хэлтэс**

Уулын ажлын урт, дунд, богино хугацааны төсөл төлөвлөгөө, бодлого чиглэл боловсруулж, гүйцэтгэл хэрэгжилтэд нь байнгын хяналт тавьж ажиллана. Үйлдвэр технологийн хэлтэс нь уурхайн геологи, гидрогеологийн тайлан судалгааг хийж хайгуул ашиглалтын лиценз, эдэлбэр газрын гэрчилгээг эх материалд тулгуурлан авч, төлбөр тооцоог цаг хугацаанд нь хийх үүрэг хүлээнэ. Ашиглагдсан талбайг нөхөн сэргээх, сэргээсэн талбайг газрын албанд хүлээлгэн өгч төлбөрөөс чөлөөлүүлэх, геодезийн үндсэн болон тулгуур цэгүүдийг байгуулах, баталгаажуулах, маркшейдерын хяналтын хэмжилт хийж ашиглалтын үеийн дэвсгэр зураг, зүсэлтүүдийг сар, улирал, жилээр зурж архивт материал бүрдүүлж хадгална. Геологи, гидрогеологийн судалгааны үндсэн дээр уурхайн технологи ажиллагааг, зураг төсөл, аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулах, стандартын шаардлага хангахуйц бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулна.

Усны түвшиний бууралтыг сар бүр хэмжих, ус шүүрүүлэх цооног, коллекторыг шинээр барьж байгуулах захиалга боловсруулах, ажилд нь хяналт тавих, геологи, геофизикийн хайгуул хийж нүүрсний нөөц нэмэгдүүлэх, нүүрсийг боловсруулж ашиглах чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулна.

Тэсэлгээний ажлын тооцоо, аюулгүй ажиллагаа, тэсрэх хэрэгсэл, тэсэлгээний материалын захиалга, зарцуулалт, нөөцийг төлөвлөж хянана. Байгаль орчны хяналт, нөхөн сэргээлт, бүтээгдэхүүний чанарт урьдчилан хяналт шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ.

Үйлдвэр борлуулалтын алба

Үйлдвэр борлуулалтын алба нь үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай хэвийн, жигд ажиллагааг хангаж уул тээврийн үндсэн тоног төхөөрөмж, технологийн дамжлагуудыг ээлжийн турш үр бүтээлтэй ажиллуулах асуудлыг удирдан зохион байгуулж, хяналт шалгалт хийх, мэдээлэл авах, дамжуулах, шийдвэр гаргах түвшинд ажиллана.


Мөн нүүрсний чанар, жингийн зөрүү, вагон хангалт, вагон ашиглалтын зардал, зар сурталчилгаа гэх мэт нүүрс борлуулалтын гадаад хүчин зүйлсийн нөлөөлөлд судалгаа, дүн шинжилгээ хийх, нүүрс авах байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулж, гэрээний үүргийг хэрэгжүүлэх, борлуулалтын ашгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж УБТЗ-ын Багануур өртөөний вагоны захиалга, ашиглалтын тооцоог тогтмол хийнэ. Үйлдвэр борлуулалтын алба нь компанийн өмч хөрөнгө алдагдах үрэгдэхээс урьдчилан сэргийлж өөрийн хариуцсан ажлын чиглэлээр харуул хамгаалалтын ажилд хяналт тавьж, шалгаж ажиллана.

Технологийн автомашины ашиглалтын хэсэг

Уулын 1, 2-р хэсгийн хөрс хуулалт, нүүрс гаргалтын ажилд технологийн автосамосвалыг оновчтой хуваарилж, батлагдсан төлөвлөгөөт ажлыг экскаватор нэг бүрээр нь биелүүлэх үүрэгтэй. Уурхайн харъяаны бүх төрлийн авто замыг шинээр байгуулах, арчлах, батлагдсан зураг төслийн дагуу замын байгууламжийг хийнэ. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахуйц тэмдэг, тэмдэглэгээгээр хангана. Технологийн автосамосвал, бүх төрлийн бульдозер, замын машин механизм, өрөм, ачигч тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын түвшинг өндөржүүлэх, сул гүйлт, зогсолт

0000025





саатлыг бууруулах, түлш тосны зарцуулалтыг хэмжиж хянах, тооцоолох үр дүнгүй зарцуулалтыг багасган шаардлагатай ажлын байр талбайд үр бүтээлтэй ажиллуулна.

Уулын 1, 2-р хэсэг

Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөгөөр тээвэртэй ба тээвэргүй системээр хөрс хуулалтын ажлыг технологийн дагуу явуулж, нүүрсний нөөц бэлтгэн, хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан чанар сайтай нүүрсээр хангах, нээгдсэн нүүрсийг технологийн автосамосвалд ачиж технологи дамжлагад буулгана. Уулын ажилд маркшейдерийн хэмжилт хийх технологийн паспорт боловсруулж, техникийн ашиглалт аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу үйлдвэрлэл явуулна. Хэсгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хариуцах, хүчин чадлыг бүрэн ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавих үүрэгтэй. Хэсгийн үйл ажиллагааг эдийн засгийн үр ашигтайгаар явуулах бодлого баримтлан ажиллана. Батлагдсан төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт, хэлбэршүүлэлтийн ажлыг зураг паспортын дагуу гүйцэтгэнэ. Уул геологийн хүндрэл, гулсалт, нуралт, гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг урьдаас төлөвлөж, үүссэн нөхцөл байдлын үед шуурхай арга хэмжээ авч ажиллана. Хэсгийн хэмжээний өрөмдлөг тэсэлгээний ажлыг төлөвлөж, хянаж гүйцэтгэнэ. Уул тээврийн тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт үйлчилгээ, цахилгаан тоног төхөөрөмжийн тохируулгыг хийнэ.

Нүүрс бутлан ачих хэсэг

Технологийн автосамосвалаар тээвэрлэж ирсэн нүүрсийг хүлээн авч буталж ангилах, вагонд паспортын дагуу ачих, хэрэглэгчдийг нүүрсээр хангах үүрэгтэй. Нүүрс бутлан ачих тоног төхөөрөмжүүдэд техникийн үзлэг үйлчилгээ хийх, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах, цэвэрлэгээг ээлж тугам тогтмол хийнэ. Уурын зуух, өртөө нүүрс бутлан ачих хэсэгт харъяалагдана.

Ус шүүрүүлэх хэсэг

Шүүрүүлэх цооногуудын жигд найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг тогтмол хийж, уурхайн гүний усыг шүүрүүлэх, Дулааны станцын тэжээлийн усны нөөцийг хангах үүрэгтэй. Дулааны улиралд зам услах машиныг усаар цэнэглэх, шаардлагатай тохиолдолд ус шүүрүүлэлтийг эрчимжүүлэх зорилготой усны зумфыг байгуулж найдвартай ажиллуулна.

Дотоод хяналт шалгалтын алба

Компанийн үйл ажиллагаа, ажил үйлчилгээ нь хууль, тогтоомж, засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд компанийн хэмжээнд хяналт тавьж, компанийн ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг тооцох, эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын хууль бус ажиллагааг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.


Захиргаа хүний нөөцийн хэлтэс

Ажилтнуудыг ажилд шалгаруулж авах, сургаж дадлагажуулах, хүний нөөц бэлтгэх, чөлөөлөх болон хөдөлмөрлөх эрхтэй холбогдсон бусад асуудлыг хариуцна. Компаниас гаргасан тушаал шийдвэр, компанид ирсэн болон явуулсан бичиг баримтыг бүрдүүлэх, түүний шийдвэрт хяналт тавих, сахилга дэг журмыг бэхжүүлэх, компаниас зохион байгуулах урлаг, спортын бүх төрлийн арга хэмжээ хурал зөвлөгөөнийг зохион байгуулах ажлыг хариуцана. Ажилтнуудын мэргэжлийн зэргийг ахиулах болон шинээр мэргэжил олгох, шалгаж баталгаажуулан үнэмлэх олгох мэргэжлийн комиссыг байгуулж ажиллана. Хэлтсийн бүтцэд Захиргаа, ахуй үйлчилгээний тасаг харъяалагдаж харуул хамгаалалт, захиргааны эд аж ахуй, эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээг, мөн уурхайчин спорт цогцолбор харъяалагдаж уурхайчдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тэдний спортоор

0000006



26



хичээллүүлж чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зэргийг хариуцан ажилладаг.

▪ **Судалгаа хөгжлийн хэлтэс**

Компанийн найдвартай, эдийн засгийн хэмнэлттэй ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн шинэ техник технологи нэвтрүүлэх нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг холбогдох хэлтэс, хэсэг, албатай хамтран зохион байгуулна.

Байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээ, стратеги, төлөвлөгөө боловсруулах, техникийн болон бусад асуудлаар шийдвэр гаргахад удирдлагад тодорхой техникийн шийдэлтэй санал боловсруулан танилцуулна. Үр ашгийн тооцоог холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулна.

Компанийн хэсэг, нэгжүүдээс гарсан инноваци, Кайзен санал, чанарын дугуйлангийн ажилд үнэлэлт, дүгнэлт өгч, идэвхижүүлэлт, урамшууллын арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, бүтээмжийн бусад арга хэрэгслүүдийг хөгжүүлж ажиллана.

▪ **Мэдээллийн технологийн алба**

Үйлдвэрлэлийн онцлог шинжийг агуулсан нэгдсэн мэдээллийн сантай, орчин үеийн мэдээлэл холбооны шинэ техник технологитой системүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, түүний найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тухай мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь дамжуулах үүрэгтэй. Өндөр хурдны интернэт, технологийн холбоо, мэдээллийн системийг компанийн хэмжээнд хариуцах ба холбооны үйлчилгээний бодлогыг боловсруулж хяналт тавина.

▪ **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс**

Компанийн техник, технологи, хөдөлмөрийн үйл ажиллагаанд Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу аюулгүй ажиллагааны болон хөдөлмөрийн нөхцлийн стандарт шаардлага хангасан орчинд үйлдвэрлэл явагдаж буй эсэх, санхүүгийн үйл ажиллагаа эдийн засаг, санхүү татварын хууль тогтоомжийн дагуу явуулахад дотоодын хяналт шалгалтын ажлыг чиглүүлэн ажиллана. Мөн компанийн захирлын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, гүйцэтгэлийг хангуулж тайлагнана. Компанийн хэмжээнд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хяналт шалгалтыг улирал тутам зохион байгуулж, зөрчил дутагдлыг тухай бүр нь илрүүлж арилгах, засаж сайжруулах ажлыг хянаж гүйцэтгүүлнэ. Хэлтсийн харъяанд аваарийн эмнэлэг, галын пост ажиллана. Мөн компанийн харуул хамгаалалтын ажлыг хариуцаж байгаа хамгаалалтын албаны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, үүрэг даалгавар, заавар зөвлөгөө өгч ажиллана.

1.5.6 ХҮНИЙ НӨӨЦ


"Багануур" ХК-ийн хүнийн нөөцийн бодлого нь ажиллах хүчний зардлыг бууруулах, орон тоог шаардлагатай хэмжээнд байлгах, ажилтнуудын чадвар, бүтээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын туршлага санал, санаачлагийг идэвхитэйгээр дэмжин ажиллах, хөгжүүлэхэд чиглэгдэж байна. Компанид ажиллагсдын 96 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр 4 хувь нь хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байна.

Хүснэгт 3: Ажиллагсдын судалгаа

№	Ажилтан	2014	2015	2016
1	Нийт ажилтан	1079	1117	1115
	Үүнээс: мэргэжлийн ажилтан	778	810	812
2	Хөлсөөр ажиллах гэрээтэй ажилтан	50	43	42
	Нийт	1129	1115	1119

0000007






Компанийн гүйцэтгэх захирлын 2016 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн тушаалаар баталсан дөрөв тоогоор нийт ажилтнуудаас удирдах албан тушаалтан 23, Мэргэжилтэн 26, инженер техникийн ажилтан 75, Ажилтан 44, Туслах ажилтан 17, Үйлчилгээний ажилтан 122, Мэргэжлийн ажилтан 812 гэсэн албан тушаалуудыг хашиж байсан ба ажилтнуудын дундаж нас 30 байна.

0000028





1.6. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 84-р зүйлд зааснаар компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Компани нь нийт 13 ТУЗ-ийн гишүүний бүрэлдэхүүнтэй, Захирлын зөвлөл нь 11 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1	Б.Ариунболд	Дарга	Монгол
2	Д.Артаг	Ердийн гишүүн	Монгол
3	Д.Болд	Ердийн гишүүн	Монгол
4	М.Хуягбаатар	Ердийн гишүүн	Монгол
5	Г.Мэргэнбаяр	Ердийн гишүүн	Монгол
6	Д.Нарангэрэл	Ердийн гишүүн	Монгол
7	Л.Оюунчимэг	Ердийн гишүүн	Монгол
8	О.Банзрагч	Ердийн гишүүн	Монгол
9	Д.Цэрэнбадам	Ердийн гишүүн	Монгол
10	Г.Ёндонгомбо	Хараат бус гишүүн	Монгол
11	Б.Осоргарав	Хараат бус гишүүн	Монгол
12	Т.Наран	Хараат бус гишүүн	Монгол
13	Б.Ганбат	Хараат бус гишүүн	Монгол
14	Б.Ганбаатар	Нарийн бичгийн дарга	Монгол

Хүснэгт 5: ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд

№	Хороо	Гишүүдийн тоо	Гишүүд	Үүрэг
1	Аудитын хороо	5	Г.Ёндонгомбо Б.Осоргарав О.Банзрагч М.Хуягбаатар Т.Наран	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
2	Цалин урамшууллын хороо	5	Г.Мэргэнбаяр О.Банзрагч Д.Нарангэрэл Т.Наран Д.Цэрэнбадам	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн

0000029



3	Нэр дэвшүүлэх хороо	5	Д.Болд Д.Цэрэнбадам Л.Оюунчимэг М.Хуягтбаатар Г.Ёндонгомбо	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
---	---------------------	---	--	---

Хүснэгт 6: Хяналтын зөвлөлийн гишүүд

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1	Г.Ёндонгомбо	ТУЗ-ийн Аудитын хорооны дарга	Монгол
2	Г.Мэргэнбаяр	ТУЗ-ийн гишүүн	Монгол
3	Б.Наранчимэг	Дотоот хяналт шалгалтын албаны дарга	Монгол
4	Н.Цагаанхүү	Үйлчилгээний автомашины хэсгийн жолооч	Монгол

Хүснэгт 7: “Багануур” ХК-ийн Захирлын зөвлөлийн гишүүд

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1	М.Отгонбаяр	Гүйцэтгэх захирал	Монгол
2	Н.Базарсүрэн	Тэргүүн дэд захирал	Монгол
3	Г.Болд	Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал	Монгол
4	П.Найданзул	Хөгжил, нийгмийн асуудал эрхэлсэн дэд захирал	Монгол
5	А.Энхболд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга	Монгол
6	Л.Шагдарсүрэн	Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга	Монгол
7	Ч.Очирлхам	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга	Монгол
8	Ч.Чулуунбат	Худалдаа хангамжийн хэлтсийн дарга	Монгол
9	Б.Хэрлэнчимэг	Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга	Монгол
10	Э.Ганбат	Үйлдвэр технологийн хэлтсийн дарга	Монгол
11	Д.Бямбажав	Техникийн хэлтсийн дарга	Монгол

Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн охин компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл

№	Нэр	ТУЗ-ийн гишүүд	Албан тушаал
1	“Багануур Сувилал” ХХК	М.Отгонбаяр Ч.Очирлхам Л.Шагдарсүрэн	ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн
2	“Багануур илч” ХХК	М.Отгонбаяр Н.Базарсүрэн Н.Эрдэнээ	ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн гишүүн ТУЗ-ийн гишүүн
3	“Монцахим” ХХК	-	-

0000030





1.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.7.1. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Алсын хараа

Монгол улсын нүүрсний салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч байна.

Эрхэм зорилго

Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.

Уриа

Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлж хамтдаа хөгжицгөөе.

Товч танилцуулга

"Багануур" ХК нь анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор ажиллаж эхэлснээс хойш 38 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани нь Монгол улсын нүүрсний хэрэгцээний 43 орчим хувийг дангаараа хангаж ирсэн бөгөөд 2015 оны 2-р сарын 9-нд 100.0 сая.тн дахь нүүрсээ олборложээ. Компани нь эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагуудад нүүрс нийлүүлэхээс гадна 0-200 мм бутармагтай нүүрсийг хэрэглэгчдэд нийлүүлдэг.

Компанийн үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал нь 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч жилд 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож, 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулж байна. Уурхайн үйлдвэрлэлийн талбайд иж бүрэн механикжсан нүүрсний уурхай, нүүрсийг буталж, ангилан ялгаж, ачих хоёр ширхэг технологи дамжлага, уул-тээврийн тоног төхөөрөмжийн үйлчилгээний машин засварын газрууд, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн механикжсан агуулахын аж ахуй, кислород компрессорын станц ажиллаж үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж байна.

Уурхай нь байгуулагдсанаасаа хойш анхны төсөл болох ЗХУ-ын ГИПРОШАХТ институтын боловсруулсан төслийг мөрдлөг болгон ажиллаж байсан ба 1995 оноос техник технологийн шинэчлэл хийх, хөрс хуулалтын хоцрогдлыг арилгах, нүүрс олборлолтыг тогтворжуулах зорилгоор "Монгол нүүрс" төслийг хэрэгжүүлэн уурхайн өмнө тулгарч байсан олон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэсэн. 2014 онд Олон улсын хөгжлийн ассоциациас Монгол улсын Засгийн газарт үзүүлсэн зээлийн тусламжаар Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд Багануурын нүүрсний ордын нэмэлт хайгуул, нөөцийн тодотгол тооцооны ажлыг "Эрдгео" ХХК болон "Норвест" корпораци хийж гүйцэтгэсэн байна. Уг хайгуулын ажлын үр дүнд орд газрын нөөц 290 сая тонноор нэмэгдэж, 2015 оны 1дүгээр сарын 1-ний байдлаар, ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээр нийт орд талбайн хэмжээнд тооцоолсон нүүрсний нөөц 812 сая тонн болсон бөгөөд олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нүүрсний нийт нөөц 839 сая тонн болж нэмэгдсэн байна. Компани 2015 оноос эхлэн Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар уурхайн хаалт хүртэлх урт хугацааны ТЭЗҮ боловсруулж байгаа бөгөөд 2016 онд тус ТЭЗҮ-ийг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Мөн уурхайн хөрс, нүүрс тээвэрлэлтийн зардлыг багасгах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг сайжруулах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон 2014-2018 он хүртэлх компанийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн хариуцлага

2014 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Нормисур интернэйшнлийн зөвлөх багтай хамтран Компанийн нийгмийн хариуцлагын стратегийг 5 үндсэн чиглэлээр боловсруулан хэрэгжүүлж байна.


Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн томоохон ажлууд:

0000031





- 640 хүний суудалтай Спорт цогцолборыг ашиглалтанд оруулсан
- 385 айлын орон сууцыг ажилтнууддаа үнэ төлбөргүй хувьчилсан
- Дүүргийн төв талбайг шинэчлэн засварласан, гэх мэт



Нөхөн сэргээлт


"Багануур" ХК нь 1999 оноос Байгаль орчныг хамгаалах, ашиглалтын талбайг нөхөн сэргээх ажыг эхлүүлсэн анхдагч байгуулагын нэг. Багануурын нүүрсний уурхай нийт 1319.4 мян.м3 шимт хөрс хуулж, 160.5 га талбайд бульдозерын хэлбэржүүлэлт, 9204.8 мян.м3 экскаваторын нөхөн дүүргэлтийн ажил хийгээд байна. Энэ хугацаанд 160.5 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж, үүнээс 100.0 га талбайг орон нутагт хүлээлгэн өгч, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн 22,382 гаруй мод, бут сөөгийг тариалсан. "Бага гүн" нуурын усны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор 950 м урттай сувгийг байгуулж гүний усаар нуурыг тэжээж эхэлсэн нь үр дүнтэй болж, нуурын түвшинг 2м дээшлүүлж тус нуурын орчмыг компанийн хамгаалалтанд авч, нуурын орчмыг цэвэрлэх, зэгс тарих, загас жараахай үржүүлэх зэрэг ажлуудыг хийж байна. "Багануур" ХК нь "Нөхөн сэргээлтийг үр дүнтэй, үлгэр жишээ хийж байгаа байгууллага", "Тэргүүний нөхөн сэргээгч аж ахуйн нэгж", Эко-Уурхай өргөмжлөл, талархлуудыг хүртсэн байна.

Шагнал урамшуулал

"Багануур" ХК нь 2005 онд бүтээмжийг амжилттай хэрэгжүүлэн "Азийн загвар компани"-аар шалгарсан. 2011-2013 онд МҮХАҮТанхимаас шалгаруулдаг "ТОП-150 аж ахуйн нэгж"-д багтаж, 2012 онд "Нүүрсний салбарын оны шилдэг олборлогч", 2013 онд Уул уурхайн салбарын "Шилдэг уурхай"-гаар шалгарч, 2013 онд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнагдсан.

0000032





1.7.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХ

Уурхайн эхлэл (1978-1992 он)

1978 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Бага гүн нуурын зүүн дэнжид уурхайн анхны гэр баригдаж, мөн оны 3 дугаар сарын 1-нд анхны тэсэлгээ хийгдсэнээр жилд 300.0 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтай Багануурын нүүрсний уурхайг барьж байгуулах их ажил өрнөн 1978 оны 9 дүгээр сарын 2-нд уурхайг улсын комисс хүлээн авч ашиглалтанд оруулж анхныхаа нүүрсийг гаргаснаар Багануурын нүүрсний уурхай байгуулагдсан түүх эхэлдэг. Багануурын орд газарт жилд 6.0 сая тонн нүүрс олборлох ил уурхайг байгуулах тухай БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн шийдвэр гарч уурхайн зураг төслийг Зөвлөлт холбоот улсын Ленинград хотын "Гипрошахт" институт болон бусад 15 институтын оролцоотойгоор амжилттай гүйцэтгэн төслийг хэрэгжүүлэхээр 1978 онд Зөвлөлтийн "Медьмолибденстрой" барилгын удирдах газрын харьяа Зөвлөлт-Монголын барилгачид Багануурын түлшний томоохон цогцолборыг босгох ажлын эхлэл тавигдсан.

1978 оны 10 дугаар сарын 4-нд Багануур Багахангайн төмөр замын хөдөлгөөнийг нээж, 1978 оны 12 дугаар сард Улаанбаатар-Багануурын 220 кВт-ын өндөр хүчдэлийн шугамыг ашиглалтад оруулснаар уурхай барьж байгуулах үндсэн нөхцлүүд хангагдаж, Багануурын түлшний иж бүрэн цогцолборыг босгох эхний алхамууд амжилттай биелэгдсэн байна.

1979 оны 11 дүгээр сарын 16-нд барилгын баазын үндсэн объектууд, 1980 оны 12 дугаар сарын 24-нд 15.0 мян.м2 талбай бүхий орон сууцны хороолол, соёл ахуйн үйлчилгээний барилгуудын хамт ашиглалтад оруулснаар Багануур дүүргийн суурь тавигдаж байсан бол өнөөдөр 30 орчим мянган хүн амтай дүүрэг болон хөгжиж байна.

1983 оны 7 дугаар сарын 3-нд ЭШ 15/90 алхагч экскаватор ашиглалтанд орсноор уурхайн эхний ээлжийг ашиглалтад оруулах нөхцлийг бүрдүүлж, 1982 оны 12 дугаар сарын 17-нд жилд 1.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай эхний ээлжийн тоног төхөөрөмж, барилга байгууламжуудыг ашиглалтад оруулсан. 1985 онд 20 м3 багтаамж бүхий шанагатай аварга том ЭШ 20/90 экскаваторыг ашиглалтад оруулсан нь уурхайн нүүрс гаргалт жил ирэх тутам нэмэгдэхэд томоохон нөлөө болсон бөгөөд 1987 оны 12 дугаар сарын 29-нд уурхай жилд 2.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай болсон байна.

1989 оны 1 дүгээр сарын 31-нд Багануурын уурхай жилд 4.0 сая тонн нүүрс олборлох хүч чадалтай II ээлжийн эхний ээлж, 1992 оны 1 дүгээр сарын 25-нд 2 дахь ээлжийн эхний байгууламжийг барьж дуусган улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.

Төрийн өмчит хувьцаат компани ба "Монгол нүүрс" төсөл (1992-2004 он)


Багануурын үйлдвэрлэлийн хэмжээ 1990 оноос эхлэн жил дараалан буурч үүнийг дагаад хөрс хуулалтын хэмжээ ч буурч, төмөр замаар тээвэрлэх хөрсний ажлын явц хангалтгүй болсноос алхагч экскаваторуудын фронтыг хангаж чадахгүйд хүрч, уурхайн санхүү хүндэрч, эрчим хүчний байгууллагууд уурхай хоёрын дунд асар их өр үүсч, сэлбэг материалын нийлүүлэлт буурсан бөгөөд уурхайн удирдлага, олон улсын төслийн группүүдтэй хамтран ажиллаж уурхайн ирээдүйн автомашины тээврээр хуулах хөрсийг эрчимжүүлэх зорилгоор Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 32 тоннын даацтай өөрөө буулгагч автомашин, 320 морины хүчтэй бульдозерыг 1992 оны 2 дугаар сард, АНУ-ын Олон улсын хамтын ажиллагааны тусламжийн хөрөнгөөр 1993 онд бульдозер, 6 м3 шанагатай ачигч, автогрейдер зэрэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч ашиглалтад оруулсан нь уурхайн хөрс хуулах ажлыг эрчимжүүлэн хүндрэлээс гарах, дэлхийн тэргүүний техник нэвтрэх үндэс суурийг тавьсан чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Багануурын уурхайг Монгол улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссын шийдвэрээр төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болгон өөрчлөх шийдвэр гарч 1994 онд "Багануур" ХК-ийг үүсгэн байгуулсан.

1993 оноос Япон улсын засгийн газрын гадаадтай хамтран ажиллах нийгэмлэгийн хийсэн Монгол улсын нүүрсний салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, 1994 онд Дэлхийн банкны хийсэн төвийн районы

0000033





нүүрсний хангамжийг сайжруулах судалгааны үр дүнгээр Багануурын уурхайд урт хугацааны хөнгөлттэй зээл олгож хамтын санхүүжилтээр уурхайг шинэчлэх төсөл хэрэгжүүлэх ажил 1995 онд эхэлсэн. "Монгол нүүрс" төсөл нь Монгол улсын нүүрсний үйлдвэрлэлийн бууралтыг зогсоож, Багануурын уурхайн нүүрс олборлолтыг жилд 4.0 сая тоннд хүргэх, төвийн хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээг найдвартай хангахын тулд Багануурын уурхайн уул, тээврийн болон бусад тоног төхөөрөмжийг шинэчлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, санхүүгийн хувьд бүрэн бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, боловсон хүчний менежментийг сайжруулах, урт хугацааны туршид хүрээлэн буй орчныг тогтвортой хамгаалах боломжтой арга, горимоор ажиллуулах, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх зорилготойгоор 1996-2002 оны хооронд хэрэгжсэн. Төслийн хүрээнд Катерпиллар маркийн 90 тоннын даацтай CAT-777 хөрс тээврийн автосамосвал, Комацу маркийн 40 тоннын даацтай HD-405 нүүрс тээврийн автосамосвал, нүүрс бутлан ачих зориулалттай технологийн дамжлага, гинжит болон дугуйт бульдозер, автогрейдер, Терекс маркийн зам усалгааны машин, D50KS өрмийн машин болон дугуй засварын багаж тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, байгаль орчны шинжилгээний иж бүрэн лаборатори зэрэг нь дагалдах сэлбэг хэрэгслийн хамт орж ирсэн.

1998 оноос хөрс хуулалтын төмөр замын системийг бүрэн өөрчилж, автотээврийн системд шилжүүлснээр уурхайн автаар тээвэрлэх хөрсний хэмжээ 2-2.6 дахин нэмэгдсэн байна. Багануурын уурхайг өргөтгөн шинэчлэх "Монгол нүүрс" төслийн техникийн тусламжийн хүрээнд АНУ-ын "Норвест" корпораци уурхайн уулын ажлын байдалд иж бүрэн судалгаа явуулж, 2017 он хүртэлх урт хугацааны төлөвлөлтийг хийж гүйцэтгэсэн нь үйлдвэрлэлийн бодит боломжийг тооцоход чухал ач холбогдолтой ажил болсон. Түүнчлэн Австралийн Артур андерсэн компанитай хамтран компанийн санхүү, бүртгэлийн ажлыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад шилжүүлж, иж бүрэн программ хангамж, сүлжээг бий болгосноор үйлдвэрлэлийн өртөг зардлыг хэсэг, нэгж бүрээр тогтмол хянаж, дүгнэлт хийх боломжтой болсон. Мөн дан ганц уурхайн үйл ажиллагааг тогтворжуулаад зогсохгүй дулааны цахилгаан станцууд, түүнчлэн Монгол улсын түлш эрчим хүчний салбарын тогтвортой байдлыг хангаж өгснөөрөө маш чухал ач холбогдолтой төсөл болсон. "Монгол нүүрс" төсөл хэрэгжсэнээр өндөр хөгжилтэй орны шинэ дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг ашиглах болсон нь Багануурын уурхай төдийгүй нүүрсний салбарт анх удаа хэрэгжсэн том шинэчлэлт, онцлог үйл явдал байсан төдийгүй орчин үеийн техник, тоног төхөөрөмж дээр ажиллах, түүнийг оншлох засварлах чадварлаг боловсон хүчинтэй болж чадсанд төслийн томоохон ач холбогдол оршино.

Мөн уг төслийн хүрээнд 1999 онд уул уурхайн салбарт анх удаа уурхайн үйл ажиллагааны явцад эвдэрч гэмтсэн хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд ихээхэн анхаарч ажиллан нөхөн сэргээлтийн ажлыг бэлчээрийн зориулалттайгаар хийж өнөөдрийн байдлаар жилд 160 гаруй га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийсэн бөгөөд үүнд жилд 350.0-400.0 сая төгрөг зарцуулж байна.

"Өөрчлөлтийн менежмент" хөтөлбөр ба Техникийн шинэчлэл (2004-одоог хүртэл)

2004 онд уурхайн хамт олон гадаад орчиндоо зохицох, бүх шатны удирдлагын арга барилыг өөрчилж, үйл ажиллагааны шинэлэг түвшинд хүрэхээр "Өөрчлөлтийн менежмент" хөтөлбөрийг Үндэсний бүтээмж хөгжлийн төв, Азийн бүтээмжийн байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн "Бүтээмжийн шагнал", Монгол улсын бүтээмжийн хөдөлгөөний манлайлагч байгууллага, олон улсын "Загвар компани"-ийн гэрчилгээ олгосон нь уурхайчдыг идэвхижүүлсэн томоохон дэмжлэг болсон байна.


2006-2009 онд ЭКГ-8и, ЭКГ-10и, ЭШ-20/90 экскаваторуудын цахилгаан удирдлага болох хагас дамжуулагчийн аналог системийг орчин үеийн дэвшилтэт технологи програмчлагдсан тоон системд шилжүүлсэн нь экскаваторын удирдлагын уян хатан байдлыг сайжруулж, бүтээмжийг 20-80% хүртэл нэмэгдүүлсэн юм. Энэхүү өөрчлөлт нь анх удаа Багануурын уурхайд хийгдсэн бөгөөд техникийн хүчин чадлыг ихээхэн нэмэгдүүлсэн ажил болсон.

2009-2010 онд "Монгол улсыг хөгжүүлэх сан"-ийн хөрөнгө оруулалтаар 12.3 тэрбум төгрөгөөр техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийн хөрс хуулалтын экскаватор 1 ширхэг, хөрс тээврийн 100 тоннын даацтай 2 ширхэг автосамосвал худалдан авч ашиглалтанд оруулсан байна.

2013-2015 онд нийт 25.4 тэрбум төгрөгийн техник технологийн шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба жилд 3.6-3.8 сая тонн нүүрс олборлон борлуулж, хүчин чадлыгхаа 90-95%-ийг ашиглан үйл

0000031





ажиллагаагаа явуулж байна. 2015 онд уурхай 3.7 сая тонн нүүрс борлуулан, 19.3 сая м3 хөрс хуулж нийт 29.8 сая м3 уулын цулын ажил хийсэн үзүүлэлттэйгээр ажиллаж байна.

1.7.3. БАГАНУУРЫН УУРХАЙН ОРД ГАЗРЫН ТУХАЙ

1.7.3.1. Ордын байршил

Багануурын хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн хойш 130 км, Төв аймгийн Баяндэлгэр сумын төвөөс зүүн зүгт 15 км зайтай, Тавансувайн хөндийд, Хэрлэн голын сав газарт оршдог. Мааньт өртөөтэй 80 км төмөр замаар холбогдсон ба Улаанбаатараас Дорнодын чиглэлд тавигдсан асфальт бетон хучилттай авто зам дайран өнгөрдөг. Засаг захиргааны хувьд Нийслэлийн Багануур дүүрэгт харъяалагдана. Багануурын нүүрсний орд нь газарзүйн хувьд хойд өргөрөгийн 41039'45", баруун уртрагийн 108017'50" солбилцолд оршино.

1.7.3.2. Орд газрын үндсэн үзүүлэлт

Багануурын хүрэн нүүрсний орд нь Төв Монголын атираат мужид Хангай-Хэнтийн газарзүйн дүүрэгт, грабен-синклиналь структурт оршино. Энэхүү грабен-синклиналь нь Хангай-Хэнтийн атираат тогтолцоо, Төв Монголын эртний өргөгдөл хоёрын заагийн дагуу Адаацагийн гүний хагаралын бүсэд 20 км өргөнтэй, 200 км урттай, Цагаанцав, Шинэхудаг, Хөхтээг горизонтуудад ангилагддаг доод цэрдийн контраст вулканитын ба нүүрс агуулсан терриген формацаар дүүргэгдсэн хожуу мезозойн эх газрын рифтоген структур болно.

Хүснэгт 9: Багануурын орд газрын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	
Эзэмшил газрын хэмжээ	3597.11 га
Ордын нийт нүүрсний нөөц	812.0 сая.тн /2015 оны 1 сарын 1-ны байдлаар/
Ордын талбай	14*5 км
Нүүрсний үндсэн давхаргын тоо	3
Хөрсний дундаж зузаан	80 метр
Нүүрсний үнслэг	дунджаар 17.5%
Нүүрсний ажлын чийг	дунджаар 37.5%
Нүүрсний хүхрийн агуулга	дунджаар, шатах массдаа 0.73%
Нүүрсний илчлэг	3360 кКал/кг
Нүүрсний хувийн жин	1.23-1.31 тн/м3
Хөрсний хувийн жин	1.95-2.25 тн/м3
Гүний усны ундарга	1100 м3/цаг

1.7.3.3. Орд газарт хийгдсэн хайгуулын ажлууд

Багануурын нүүрсний ордын хайгуулын ажил дараах гурван үе шаттайгаар явагдсан байна. Үүнд:

- **Хайгуулын үе шат:** Хайгуулын ажлыг 1974-1975 онд явуулж ордын хил хязгаарыг тогтоон, эхэлж ашиглах талбайд нарийвчилсан хайгуулын ажлыг явуулсан.
- **Гүйцээх хайгуулын үе шат:** Гүйцээх хайгуулын ажлыг 1988-1989 онд явуулж, ордын хэмжээнд 1,200 м түвшин хүртэлх гүнд нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэсэн.
- **Нэмэлт хайгуулын үе шат:** Нэмэлт хайгуулын ажлыг 2014 онд явуулж ордын хэмжээнд 960 м түвшин хүртэлх гүнд нүүрсний давхаргуудыг АМХЭГ-ын даргын 1998 оны 2-р сарын 18-ны өдрийн 27 тоот тушаалаар баталсан "Ашигт малтмалын нөөц, баялгийн ангиллын түр заавар" болон олон улсын хэмжээнд мөрдөж байгаа журам стандартад нийцүүлэн судалж, нөөцийн тодотгол тооцоог хийсэн.

0000035



35

Багануурын ордын хэмжээнд 2014 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

Топограф-геодезийн ажил

"Багануурын уурхайн нүүрсний ордын нарийвчилсан хайгуул, нөөцийн үнэлгээ хийх" төслийн техникийн даалгаврын дагуу Багануурын орд газрын нэмэлт хайгуулын талбайд дор дурьдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 10: Топограф-геодезийн ажлын гүйцэтгэл

Ажлын төрөл	Геодези, байрзүйн ажлын техникийн төсөл бичих	Багануурын уурхайн геодезийн сүлжээний цэгүүдийг судлах, сэргээн босгох ажил	M1:2,000 масштабын байрзүйн зураглал үйлдэх ажил	Хайгуулын үед өрөмдсөн цооногуудын байрзүйн холболт хийх	M1:2,000 масштабын тоон зургийн боловсруулалт хийх
Хэмжээ	1 төсөл	10 цэг	2,520 га талбай	90 цооног	750 дм2

Өрөмдлөгийн ажил

Нэмэлт хайгуулын үе шатанд өмнөх үе шатны ажлуудаар эргэлзээтэй хийгдсэн холболтуудыг тодотгох, нөөцийн зэргийг ахиулахын тулд цооног хоорондын зайг нөөц бодох орчин үеийн стандартад тохируулан ойртуулах, хагарал байгаа эсэхийг батлах болон гидрогеологи-инженергеологийн судалгааны зориулалттай өрөмдлөгийн ажлыг хайгуулын ажлын гол арга болгон явуулсан байна. Цооногуудыг өмнөх үе шатны ажлын үед өрөмдсөн цооногуудыг оролцуулан геологийн төвийн бүсэд 250 x 250м, огцом салааллын бүсэд 250 x 150-100м-ийн тороор өрөмдсөн. Кернийн гарц 95%-иас дээш байсан ба цооногийг PQ, HQ, NQ голчоор өрөмдсөн.

Хүснэгт 11: Багануурын орд газарт хийгдсэн өрөмдлөгийн ажил

Үе шат	Хайгуулын ажлын үе шатуудад өрөмдсөн цооногийн тоо, т/м		Үүнээс Нөөцийн зэрэг ахиулах, структур тодотгох, геотехникийн		Гидрогеологи, инженер-геологийн		СВМ (ордын метан хийн судалгаа)	
	цооног	хэмжээ	цооног	хэмжээ	цооног	хэмжээ	-	-
Хайгуул	502	49,881.8	483	48,212.7	19	1,669.1	-	-
Гүйцээх хайгуул	125	18,601.1	120	17,381.8	5	1,219.3	-	-
Нэмэлт хайгуул	83	14,398.3	63	10,216.3	8	1,626.0	12	2,556
Бүгд	710	82,881.2	666	75,810.8	32	4,514.4	12	2,556

Геофизикийн ажил

Хайгуулын үе шатуудад өрөмдсөн бүх цооногт каротажийн ажил хийгдсэн ба хайгуулын үе шатанд талбайн геофизикийн ажил хийгджээ.

Хүснэгт 12: Багануурын орд газарт хийгдсэн геофизикийн ажил

Хайгуулын ажлын үе шат	Цооногийн тоо	Ажлын хэмжээ (т/м)
Хайгуулын	458	46,212
Гүйцээх хайгуулын	79	16,149
Нэмэлт хайгуулын	78	13,763
Нийт	615	76,124

Мэдээлэл боловсруулалт

Цооногийн хэмжилтийн анхдагч мэдээллийг Люксембургийн ALT компанийн WELLCAD программаар боловсруулсан байна.





Лабораторийн судалгаа

Нүүрсний чанарт үнэлгээ өгөх зорилгоор чийг, үнсжилт, дэгдэмхий бодисын гарц, хүхрийн агуулга, элементийн найрлага, үнсний химийн найрлага, гэрлийн шинжилгээ, петрограф, микрокомпонентын найрлагыг тус тус тодорхойлуулсан. Мөн гидрогеологи, геотехник, технологийн дээжүүдийг цаашид үйлдвэр болон бусад байгууламжуудыг барих, ашиглах, олборлоход шаардагдах шинж чанаруудыг судлах зорилгоор шинжлүүлсэн байна. 2014 онд ордын нүүрсний метан хийг судлах зориулалтаар нийт 12 цооног 2556 т/м өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, нүүрсний давхаргын метан хийн туршилтын хээрийн ажлыг гүйцэтгэжээ.

Судалгааны талбайн үнэлгээ

- **Нүүрс.** 2014 оны нэмэлт хайгуулын ажлаар Багануурын ордын нүүрсний нийт нөөц А+В+С зэргээр нийт 812 сая тонн, үүнээс Баттай (А) зэргээр 326 сая тонн, Бодитой (В) зэргээр 431 сая тонн, Боломжтой (С) зэргээр 55 сая тонн гэж тооцоолов. Үүнээс оновчилсон ил уурхайн хил доторх нөөцийн хэмжээ А+В+С зэргээр 582 сая тонн байна.
- **Барилгын материал.** Ордын талбайд барилгын материал болгон ашиглаж болох элс, хайрга өргөн тархалттай, зузаан нь зарим газар 20-25 м хүрсэн ба муу сортлогдсон, мөлгөржилт муутай зэрэг сөрөг талууд бий боловч дэд бүтцийг оролцуулаад эдийн засаг талаас нь авч үзвэл ашиглах боломжтой байна. Элс хайрганы ордод 2009-2012 онд хийсэн эрэл, хайгуулын ажлаар элс хайрганы Бодитой (В) нөөцийг 2,984,800 м³, элс хайрганы хольц дахь хайрганы агуулга дунджаар 57 %, элсний агуулга 43 % бөгөөд хайрганы нийт Бодитой (В) нөөц нь 1,638,322 м³ байна. Орд нь уул-техникийн нөхцлийн хувьд ил аргаар олборлоход тохиромжтой бөгөөд дэд бүтэц сайн хөгжсөн, хэрэглэгчиддээ ойр байгаа зэрэг давуу талтай юм.

1.7.3.4. Нүүрсний чанар

Багануурын нүүрсний уурхайн чанарыг тодорхойлох зорилгоор петрографийн шинж чанар, хими-техникийн шинж чанар, хими-технологийн шинж чанар, баяжигдах чанар, цацраг идэвхит чанарыг тодорхойлох, нүүрсний метан хийн (СВМ) судалгаа зэрэг иж бүрэн судалгаанууд хийгдсэн. Багануурын нүүрс нь Монгол улсын нүүрсний ангилал MNS 6456:2014 стандартын дагуу Х2 марк, ОХУ-ын ангиллын дагуу Б2 марк, кодын зэрэглэлээр 30 индекст, олон улсын ангиллаар хагас битумжсан ангилалд багтана. Петрографийн судалгаагаар (ГОСТ 21489-76) R_o нь 0.34-0.39, хувирлын зэрэг O₂ ангид багтаж байна.

Хүснэгт 13: Багануурын орд газрын нүүрсний чанар

Чанарын үзүүлэлт	Ажлын чийг	Үнс	Хүхэр	Дэгдэмхий бодис	Илчлэг
Хэмжээ	37.5% гүн рүүгээ багасдаг	17%	0.73% (шатах массдаа)	43.8% (шатах массдаа)	3,360 ккал/кг, гүн рүүгээ ихэсдэг
Тайлбар	Нүүрсний ажлын чийг 32% байхад бутрах чанар хэвийн байна	Орд нь дунд зэргийн үнстэйд хамаарна	Нүүрс нь хүхэр багатай		Ажлын түлшний хамгийн бага илчлэг

Багануурын ордын нүүрсийг чанартай нь холбогдуулан дүгнэхэд эрчим хүчний сайн чанарын түлш болно. Хагас коксжуулах, брикетлэх зэрэг технологийн чиглэлээр ашиглахад тохиромжгүй.

1.7.3.5. Орд газрын нөөц

2014 оны нэмэлт хайгуулын үе шатанд Багануурын ордын нөөцийн жишгийг уурхайд нэмэлт судалгаа явуулах ажлын даалгаврын дагуу дараах байдлаар тогтоосон. Үүнд:



0000037

- Нүүрсний давхаргын хамгийн бага зузаан - 1.0 м;
- Нүүрсний давхарга дахь чулуулгийн үенцэрийн хамгийн их зузаан ≤ 0.1 м;
- Нүүрсний үнслэг ≤ 45 %;
- Нүүрсний илчлэг ≥ 3400 ккал/кг;
- Хүхэр болон ураны агуулга зөвшөөрөгдөх хэмжээнд байх;
- Нөөцийн оновчлол тооцоонд MINEX, AutoCad программуудыг ашиглахын зэрэгцээ өмнөх хайгуулын нөөцийн тооцооны үр дүнтэй харьцуулахын тулд нөөцийг блокын ба зүсэлтийн арга зэрэг уламжлалт аргуудаар заавал давхар тооцоолж шалгах.

Ийнхүү нүүрсний нөөцийг дахин тооцоолохдоо 1974-1975 онд хийгдсэн хайгуул, 1989 онд хийсэн гүйцээх хайгуул, 2014 онд хийсэн нэмэлт хайгуулын ажлын үед өрөмдсөн бүх цооногийн зүсэлт, каротажийн хэмжилтийн тайлал, кернийн дээжийн лабораторийн шинжилгээний үр дүнг ашиглажээ.

Нэмэлт хайгуулын ажлын даалгаварт тусгагдсанаар АНУ-ын "Норвест" корпорацийн геологичид Австралын JORC кодексийг баримтлан MINEX программаар ордын нөөцийг тооцоолсон ба тус үр дүнгээр 839 сая тонн нүүрсний нөөцтэй болох нь тогтоогдсон.

Хүснэгт 14: Багануурын орд газрын JORC стандартаар тооцогдсон нүүрсний нөөц

Үзүүлэлт	Баттай нөөц (Measured)	Бодитой нөөц (Indicated)	Боломжтой нөөц (Inferred)	Ордын нийт нөөц
Нөөцийн хэмжээ (сая тонн)	817.2	20.9	0.9	839.0
Нөөцөд эзлэх хувь (%)	97.4	2.5	0.1	100

Орд газрын уламжлалт блокын болон зүсэлтийн аргаар тооцон ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн нөөцийн хэмжээ нь 812 сая тонн байна.


Хүснэгт 15: Багануурын орд газрын ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн нөөц (2015.01.01-ний байдлаар)

Хамрагдах талбай	Гүний түвшин (үнэмлэхүй тугшин, м)	Нүүрсний ангилал (MNS 6456)	Нөөц (мян.тн)				Нийт нөөц (мян.тн)
			Баттай (A)	Бодитой (B)	Баттай болон бодитой (A+B)	Боломжтой (C)	
Орд газрын нийт нөөц	1200м хүртэл	X2	188,850.47	256,808.53	445,659.0	41,224.84	486,883.84
	1200м-960м	X1	136,843.15	174,246.09	311,089.24	14,087.52	325,176.76
	Дүн		325,693.62	431,054.62	756,748.24	55,312.36	812,060.60
Үүнээс, "Багануур" ХК-ийн эзэмшиж буй ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрэн дэх нөөц	1200м хүртэл	X2	115,883.42	117,275.73	233,159.15	20,268.15	253,427.31
	1200м-960м	X1	54,989.45	71,175.10	126,164.55	2,243.93	128,408.49
	Дүн		170,872.87	188,450.84	359,323.71	22,512.09	381,835.79

1.7.3.6. Багануурын орд газрын тусгай зөвшөөрлийн эзэмшил

Багануурын уурхайн орд газрын нийт талбайн хэмжээ нь 4,778 га бөгөөд Багануурын хүрэн нүүрсний ордод 1974-1975 онд, 1988-1989 онд, 2014 онуудад нийт 3 удаа хайгуулын ажил хийгдэж, нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын санд бүртгэж авсан байна. Тус ордод улсын төсвийн хөрөнгөөр 1974-1975 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнд ордын нийт нөөцийг 599.8 сая тонн гэж тогтоон улмаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн бол 1988-1989 онд хийсэн гүйцээх хайгуулын ажлын үр дүнд ордын нийт нөөцийг 708.2 сая тонн гэж тогтоон 1989 оны





ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна. Харин 2014 онд "Эрдгео" ХХК болон АНУ-ын "Норвест" корпорацийн хамтарсан багаас нэмэлт хайгуулын ажлыг хийн ордын нүүрсний нийт нөөцийг 812 сая тонноор тогтоон ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн. Үүнээс "Багануур" ХК-ийн эзэмшлийн MV-001371 тусгай зөвшөөрлийн талбайд 340 сая тонн, MV-013631 тусгай зөвшөөрлийн талбайд 41.8 сая тонн нийт 381.8 сая тонн буюу Багануурын ордын нөөцийн 47 хувь нь Компанийн тусгай зөвшөөрлүүдийн талбайд ногдож байна. Үлдсэн 53 хувь буюу 430.2 сая тонн нөөц нь MV-013631 тусгай зөвшөөрлийн анх олгогдсон талбайгаас хасагдсан, "Алтайн гянт" ХХК-ийн эзэмшиж байгаад 2012 оны 10 дугаар 23-ны өдөр Ашигт малтмалын газрын даргын 615, 616 тоот тушаалуудаар хүчингүй болгосон 12959А тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд ногдож байна. Тус талбайг буюу Багануур дүүргийн Нарийны талд орших Баруун хонхор L-49-1 нэртэй 1181.16 га талбайг Монгол улсын Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 392 тоот тогтоолоор нөөцөд авсан байна.

Үнэт цаас гаргагч нь дараах Хүснэгтэд дурьдагдсан Ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн бүртгэгдсэн эзэмшигч байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн анхны хүчинтэй хугацаа нь 30 жил байх бөгөөд тус бүр 2 удаа сунгуулах боломжтой юм.

Хүснэгт 16: "Багануур" ХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл


Үзүүлэлт	Ашиглалт	Ашиглалт	Ашиглалт
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-001371	MV-013630	MV-013631
Байршил	УБ хот, Багануур дүүрэг, Нарийний тал	УБ хот, Багануур дүүрэг, Нарийний тал	УБ хот, Багануур дүүрэг, Нарийний тал-1
Талбайн хэмжээ	1,444.06 га	12.24 га	2,140.81 га
Тусгай зөвшөөрлийн хугацаа	30 жил 1998.10.09-2028.10.09	30 жил 2008.05.01-2038.05.01	30 жил 2008.05.01-2038.05.01

0000039



Зураг 4: Багануурын орд газрын талбай

Багануурын орд газрын талбайн
 төсвийн байршил, шилжүүлэн өгөх



1.7.4. ОРД ГАЗРЫН АШИГЛАЛТ, УУРХАЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.7.4.1. Уурхайн ашиглалтын хэмжээ


Уурхай 1978 онд анх байгуулагдсанаас хойш 2015 он хүртэлх буюу 37 жилийн хугацаанд нийт 103.1 сая.тн нүүрс олборлон борлуулж, 359.1 сая.м3 хөрс хуулалтын ажлыг хийсэн. Үүнээс тээвэргүй хөрс хуулалт 162.9 сая.м3, төмөр замаар 24.2 сая.м3, 171.9 сая.м3 авто тээвэртэй хөрс хуулалтын ажлыг хийсэн байна. Мөн хөрс шидэлтийн ажлыг 107.8 сая.м3, инженерийн ажил 28.4 сая.м3, нөхөн сэргээлтийн ажил 9.4 сая.м3, 8.8 сая.м өрөмдлөгийн ажлыг хийж 663.5 сая.м3 уулын цулын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Тус ордыг ашиглахаар 1977 онд ЗСБНХУ-ын Гипрошахт институтэд анхны төслийг боловсруулж түүний дагуу ил уурхайн ашиглалтыг өнөөг хүртэл явуулж байна. Уг төслөөр ордыг нийт 15км урт, 8 км өргөн, нийт 60км2 талбайд 1, 2, 3, 4, 5 гэсэн хэсгүүдэд хуваасны 1, 2, 5-р хэсгүүдийн уулын

0000040



ажил нь үргэлжлэн явагдсаар байна. 2015 оны байдлаар уурхай нь 80 - 125м гүн, 1300м өргөг, 9000м урттай, 1170 га талбайг хамарч байна. Уулын 1-р хэсэгт уурхайн нүүрсний үндсэн олборлолт явагддаг ба нүүрсний 2, 2а, 3-р давхраасуудыг ашигладаг.



Зураг 5: Багануурын уурхайн уулын ажлын байдал



Уурхай нь хөрсөө дотоод болон гадаад овоолгод байрлуулдаг бөгөөд гүний ус зайлуулалтын ажлыг тогтмол хийж, жилдээ дунджаар 70 гаруй цоонгоор 4.5-5.0 сая.м3 ус шүүрүүлэн зайлуулж байна. Уурхайн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг төвийн бүсийн шугамаас хангадаг. Нүүрс борлуулалтын ихэнхийг Улаанбаатар хотын цахилгаан станцуудад, багахан хэсгийг бусад жижиг хэрэглэгчдэд нийлүүлж байна. Нүүрсний нийлүүлэлтийг томоохон хэрэглэгчдэд төмөр замаар хүргэдэг ба жижиг хэрэглэгчид өөрийн авто тээврээр татан авч байна.

0000041



Хүснэгт 17 : Сүүлийн 5 жилийн уурхайн ажлын хэмжээ

Уулын ажлын үзүүлэлт	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015
Нүүрс гаргалт	м.тн	3,253.3	3,541.6	3,876.7	3,617.1	3,731.2
Нүүрс борлуулалт	м.тн	3,263.8	3,541.6	3,824.5	3,683.3	3,747.0
Хөрс хуулалт	м.м3	15,453.3	15,259.8	18,640.5	17,269.3	19,135.7
Нийт уулын цул	м.м3	26,398.2	26,590.7	30,566.5	29,363.8	30,855.6

1.7.4.2. Уурхайн ашиглалтын үндсэн технологи

Багануурын уурхай нь уулын 2 хэсэгт тээвэртэй, тээвэргүй ашиглалтын хосолсон систем бүхий технологийг хэрэглэн хөрс хуулалтын ажлыг явуулж байна. Хөрсний дээд доголдуудад тээвэртэй, доод доголд тээвэргүй хөрс хуулалт, нүүрсний давхаргад тээвэртэй ашиглалтын системийг хэрэглэж байна. Мөн нүүрсний давхарга хоорондын хөрс хуулалтанд тээвэргүй хөрс хуулалт хийх зэргээр уулын ажлыг аль болох бага зардлаар явуулах арга замыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Уурхайн барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийн дийлэнх нь төслийн хөрөнгө оруулалтаар шийдэгдсэн, олон жил үр бүтээлтэй ашиглагдаж байгаа болно. Багануурын уурхайн хөрс хуулалтанд ОХУ-д үйлдвэрлэсэн алхагч, шууд утгуурт экскаваторууд, нүүрс олборлолтод шууд утгуурт, гидравлик экскаватор, ачигч, 160-240мм өрөмдөх өрмийн машинууд, уурхайн дотоод тээвэрт Беларусь улсын Белаэ, АНУ-ын Катерпиллар, Япон улсын Комацу зэрэг 45-90тн даацтай автосамосвалууд, өрөмдлөгт ОХУ-ын СБР, АНУ-ын Сэндвик фирмийн D-50ks өрмийн машинууд уулын үндсэн тоног төхөөрөмжүүд ажиллаж байна.

1.7.4.3. Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ

"Багануур" ХК нь 1999 оноос Байгаль орчныг хамгаалах, ашиглалтын талбайг нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн анхдагч байгууллагын нэг. Нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн хөрсний дотоод овоолгууд, Уулын 1, 2-р хэсэг, уурхайн ойролцоо орших Бага гүн нуурын усыг гүний усаар сэлбэх, хэсэг нэгжүүдийн гаднах талбай зэрэг уурхайн эдэлбэрт мод тарих, Хэрлэн голын эрэг, хот тосгоны гудамж, талбайг мод, бут тарьж цэцэрлэгжүүлэх зэргээр хийж ирсэн байна.

Нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн чиглэлээр, Монгол Улсад мөрдөж байгаа MNS-5915-2008, MNS-5916-2008, MNS-5917-2008, MNS-5918-2008 стандартуудын дагуу гүйцэтгэж байна. Нөхөн сэргээлтийн ажлуудыг гүйцэтгэн, орон нутгийн захиргааны байгууллага, улсын мэргэжлийн хяналтын байгууллагын байцаагч нарт шалгуулан газар дээр нь дүгнэлт гаргуулж хүлээлгэн өгч байна. Нөхөн сэргээлт хийж эхэлснээс хойш жил бүр уулын ажлын болон бизнес төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн ажилд 350-500 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтэнд 65-100 сая төгрөгийг тусган нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж байна.

0000042





1.7.5. ДЭД БҮТЭЦ, ТЭЭВЭР

1.7.5.1. Барилга, байгууламж

Уурхайн барилга байгууламж нь ОХУ-ын "Гипрошахт"-ын төслийн үе шатанд баригдаж, 38 дахь жилдээ ашиглагдаж байна. Эдгээр барилга, байгууламжуудийн хүчин чадал нь уурхайн хүчин чадал 4-6 сая тн нүүрс олборлох үеийн хэрэгцээг хангах хэмжээнд байгаа бөгөөд барилга байгууламж нь үйлдвэрлэлийн ба иргэний зориулалтаар тус тус баригдсан байна.

Уурхайн хотхоны барилга байгууламж нь уурхайн хилээс баруун хойд зүгт 4.5 км зайд салхины дээд талд байгуулагдсан. Хотхонд орон сууц болон нийгэм хангамжийн бүхий л хэрэгцээг хангасан ОХУ болон Монгол улсын барилгачдын бүтээн байгуулсан 60,000 м² орон сууц, соёл, ахуй үйлчилгээний зориулалттай олон арван барилга байгууламж бүхий хотыг барьж босгосон. Хотод нэгдсэн эмнэлэгийн цогцолбор, 5-9 давхар орон сууц бүхий "Наран" хороолол, дэлгүүр, цайны газар, ахуй үйлчилгээний барилга, хурлын ордон, холбоо, худалдаа үйлчилгээний төвийн барилгууд, төв талбай, амралт сувилалын барилгууд, спортын ордон, соёлын төв зэрэг байна.

Багануурын анхны цогцолбор уурхайн дэргэд үйлдвэрийн зориулалттай барилга байгууламжууд буюу тээврийн зам, цэвэрлэх болон дамжуулах байгууламжууд, цахилгаан болон усан хангамжийн байгууламжууд, барилгын материалын баазын иж бүрэн барилга байгууламжуудаас бүрдэж байсан байсан. Үйлдвэрлэлийн барилга байгууламжид оффис, ахуй үйлчилгээний газар, хоолны газар, технологийн автомашины засварын хэсэг, үйлчилгээний машинуудын засварын хэсэг, гараж, цахилгаан хангамжийн дэд өртөө, дулаан хангамжийн байгууламжууд, цэвэр бохир усны шугам, сэлбэгийн агуулахууд, галын хэсэг, усан сан, компрессорын станцууд болон бусад барилга байгууламжууд байна.

1.7.5.2. Усан хангамж

Багануур дүүрэг нь усан сүлжээний хувьд хангамж сайн, гол горхи, нуур сайтай бүс нутагт хамаарна. Усан хангамжийн хамгийн том эх үүсвэр нь уурхайгаас зүүн тийш 15-20 км зайд орших Хэрлэн гол юм. Хан-Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн гол дүүргийн нутаг дэвсгэрээр 14 км урсан өнгөрдөг ба өргөн нь 40-100 м, гүн 1-3 м. Мөн ордын өмнө захад Багануур мэт жижиг хэмжээний нуур нилээд хэд байсан ба уурхайн шүүрүүлж буй уснаас дэмжиж байгаагийн ачаар хатаж ширгээгүй байна.

1.7.5.3. Цахилгаан хангамж


Тус нүүрсний уурхай нь Монгол улсын "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ХК-ийн сүлжээнээс Улаанбаатар хотоос 220 кВ-ийн 140 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдсон, 220/110/35 кВ-ийн "Багануур" төв дэд станцаас 110 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар дамжуулан 110/6 кВ-ийн "Уул", "Төв", "Галуутай" гэсэн 3 дэд станцуудаас уурхайн үндсэн цахилгаан хэрэглэгчдийг эрчим хүчээр хангаж байна. Уурхайчдын тосгон буюу Багануур дүүргийг 110/10 кВ-ийн "Хот" дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангадаг. 220/110/35 кВ-ийн "Багануур" дэд станц нь Монгол Улсын эрчим хүчний сүлжээний гол том зангилаа станц учраас цахилгаан эрчим хүчээр найдвартай хангагдах ба хэт ачааллын үед Диспетчерийн үндэсний сүлжээгээр дамжуулан ОХУ-ын эрчим хүчний системтэй холбогдох боломжтой тул Багануурын нүүрсний уурхайг цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангагдсан гэж үзэж болно.

Ил уурхайн дотоод цахилгаан хангамж нь дараах тоног төхөөрөмжөөс бүрддэг. Үүнд:

- Өрмийн машинуудыг тэжээхэд зориулагдсан зөөврийн иж бүрэн хуваарилах байгууламж /ПКТП-6/0.4-250/
- Экскаваторуудыг тэжээхэд зориулагдсан зөөврийн сэлгэн залгах пункт ЯКНО-10У
- Цахилгаан дамжуулах агаарын шугам /АС-16-120/, /А16-120/

0000043





- Кабель шугам /ААБлУ-6*120, КГЭ-3*35-95/
- Экскаваторуудын 6кВ-ийн асинхрон, синхрон хөдөлгүүрүүд

1.7.5.4. Дулаан хангамж

Уурхайн дулаан хангамжийн хэсэг нь анх 1982 онд байгуулагдсан. Тус хэсэг нь "Багануур" ХК-ийн үйлдвэрийн талбай, "Породная" станцын объектууд, "Монцахим" ХХК, "Багануур Сувилал" ХХК, дулаан, цэвэр бохир ус, инженерийн шугам сүлжээтэй бөгөөд хэвийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг 14 засварчин 2 инженер, нийт 16 ажиллагсадтай.

Дулааны төв шугам 3.1 км, хүйтэн усны төв шугам 4.2 км урттай ба туннель болон газар дор ил тавигдсан. Үйлдвэрийн талбайд цэвэр усны насосны станц, 250 м³ багтаамжтай цэвэр усны 2 резервуар, "Породная" станцад бохир ус соруулах насосны станц, бохир ус зайлуулах 3.5 км хос шугам ажилладаг. Жилд дулааны эрчим хүч 30000 Гкал дулаан, цэвэр ус 90000 м³ хэрэглэж, 80000 м³ бохир ус зайлуулдаг. Багануурын дулааны станц нь буцалмал үет шатлалтай 20 зуухтай. Эдгээр зуухнуудыг хүйтний ба дулааны улиралд хуваарьтайгаар ашигладаг бөгөөд ЦНСГ-400/210 маркийн 5 ш сүлжээний насос зэрэг үндсэн тоноглолуудтай.


1.7.5.5. Тээвэр

Багануурын уурхай байгуулагдсан цагаасаа эхлэн нүүрс борлуулалтын тээврийн ажлыг төмөр замаар гүйцэтгэж ирсэн. Уурхайн нүүрс ачиж буулгах сэлгээний ажлыг 1978-1983 оны хооронд 1978 онд ашиглалтанд орсон "Нүүрсний өртөө", 1983-1988 онд "Багануур өртөө" тус тус гүйцэтгэж байсан бол 1988 оноос Багануурын уурхай нь нүүрс борлуулах хэсэг байгуулан өөрийн төмөр замын боловсон хүчинд тулгуурлан "Нүүрсний өртөөнд" сэлгээний ажлыг хийх болсон.

Тус өртөө нь жилдээ 45,000 орчим вагонд нүүрс ачуулах сэлгээний ажлыг нийт 24.5км урттай 12 зам дээр сэлгээний ТЭМ-2У маркийн илчит тэрэг, КЖДЭ-25 маркийн ТЗ-ийн кран, МСШУ маркийн замын чиг татагч ПРМ маркийн зам засварын машины бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байна.

0000044





1.8. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРААТ БОЛОН ОХИН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.8.1. БАГАНУУР СУВИЛАЛ ХХК

Багануурын уурхайчдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар, эрч хүчийг нөхөн сэргээх зорилгоор МҮЭ-ийн төв зөвлөлөөс “Уурхайн профилактори сувилал”-ыг 1984 онд байгуулж, 1990-2000 он хүртэл Багануурын уурхайн дэргэд үйл ажиллагаагаа явуулж байгаад 2000 оноос бие даан “Багануур сувилал” ХХК болсон.

Багануур сувилал нь 8 хэсгээс бүрдсэн нийт 91 ажилтантайгаар эрүүл мэнд, худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээ, туслах аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь нэг дор 100 сувилуулагч хүлээн авч эмчилгээ сувилгаа үзүүлэх хүчин чадалтай, 160 хүний суудалтай 2 зоогийн газар, нэг ээлжинд 31 хүн хүлээн авах зочид буудлын үйл ажиллагааг мөн явуулдаг.

2004 оноос эхлэн улирлын чанартай гүүний саамны эмчилгээг стандартын дагуу явуулж, сувилуулагчдад эмийн бус сэргээн засах эмчилгээг стандартын түвшинд үзүүлэн 2008-2011 онд “Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага”-аар хоёр удаа итгэмжлэгдсэн. Тус сувилал нь 1984 оноос уурхайчдыг сувилгах зорилготойгоор байгуулагдсанаас хойш 32 дах жилдээ үйл ажиллагаагаа тасралгүй явуулж байгаа ба 2004 онд Эрүүл мэндийн яамнаас улсын хэмжээнд сувиллын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг авч, эзэмшиж байна.

1.8.2. БАГАНУУР ИЛЧ ХХК

“Багануур-Илч” ХХК нь Багануурын нүүрсний уурхайн даргын 1993 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Б/171 тоот тушаалаар Багануурын нүүрсний уурхайн Улаанбаатар хот дахь Худалдаа, хангамжийн тасаг /Төлөөлөгчийн газар/ нэртэйгээр байгуулагдаж, мөн оны 6 дугаар сарын 1-ээс үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэ үеийн компанийн гол зорилго нь Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээр хангамжийн нэгдсэн ажиллагаа алдагдсантай холбоотойгоор уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай сэлбэг материалыг захиалгын дагуу олж нийлүүлэх, гадаад, дотоодын зах зээлд түншлэлийг бий болгох, Улаанбаатар хотын цахилгаан станцуудад нийлүүлэгдэж байгаа нүүрсний чанарт хяналт тавих, хэрэглэгчдийн зүгээс гарсан санал гомдол, техникийн гэмтлийг газар дээр нь шалгаж акт тогтоох, вагон ачилтанд хяналт тавих зэрэг асуудал байсан.

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2000 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хот дах төлөөлөгчийн газрыг бие даалган “Багануур” ХК-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болгон өөрчлөн зохион байгуулсан. “Багануур-Илч” ХХК нь “Багануур” ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, материал сэлбэг олж нийлүүлэх, нүүрсний чанарыг сайжруулах, байгууллага хоорондын төлбөр тооцоог барагдуулах, гадаад дотоодын байгууллага компаниудад зуучлах, тэдгээрийн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Тус компани нь нүүрс борлуулалтын чиглэлээр Толгойт өртөөнд нүүрс борлуулах цэг 1-ийг, Амгалан өртөөнд нүүрс борлуулах цэг 2-ийг, Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүд, суурин газруудын халаалтын уурын зуухыг чанар сайтай, хямд өртөгтэй нүүрсээр хангах чиглэлээр ажиллуулж байна.


1.8.3. МОН-ЦАХИМ ХХК

“Мон-Орос цахим” ХХК нь 1996 оны 5 сард “Багануур” ХК-ийн санаачлагаар “Шарын гол” ХК, ОХУ-ын “Уралэлектроремонт” концерн, Электромаркет компаниуд хамтран хөрөнгө оруулж Монгол Улсын хэмжээнд цахилгаан машиныг засварлах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх зорилготойгоор анх байгуулагдаж байжээ.

Тус компани нь одоогоор “Багануур” ХК-ийн 46%, “Монмеханик” ХХК-ийн 54% -ийн хөрөнгө оруулалттай, жилд дунджаар уул уурхайн болон бусад бүх төрлийн цахилгаан тоног төхөөрөмжийн 600 гаруй тогтмол болон хувьсах гүйдлийн цахилгаан хөдөлгүүр, генератор засварлаж 40 гаруй ажиллагсадтайгаар ажиллаж байна.



0000045




Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд:

- Уул уурхайн экскаваторуудын цахилгаан хөдөлгүүр, генераторуудын засвар үйлчилгээ;
- CATERPILLAR, KOMATSU болон Белаэ зэрэг уул уурхайд ажилладаг хүнд даацын авто самосвал, явах ангийн хүч нэмэгдүүлэх генераторуудын засвар үйлчилгээ;
- "УБТЗ"-ын илчит тэрэг (АНУ-н ДАШ, ЗЗАГАЛ, ОХУ-н ТЭМ2, 2М62)-ний цахилгаан хөдөлгүүр, генераторуудын бүх төрлийн засвар үйлчилгээ;
- Уул уурхайн баяжуулах үйлдвэрүүдийн болон конвейрийн тээврийн цахилгаан хөдөлгүүрүүд;
- Дулааны Станцын түлш дамжлага болон үнс зайлуулах тоног төхөөрөмжийн цахилгаан хөдөлгүүр;
- Цэвэр ус, цэвэрлэх байгууламжийн гүний ус зайлуулах тоноглолуудын цахилгаан хөдөлгүүр;
- Барилгын өргөх, буулгах тоног төхөөрөмжийн хөдөлгүүр, мөн түүний агааржуулалт, хөргөлтийн тоног төхөөрөмжийн цахилгаан хөдөлгүүрийн бүх төрлийн засвар;
- Механик боловсруулалт зэрэг засвар үйлчилгээ үзүүлдэг.

Тус компанийн үндсэн хэрэглэгчид нь "Багануур" ХК, "Шарын гол" ХК, "ШивээОвоо" ХК, "Улаанбаатар Төмөр Зам" ХНН, "ДЦС-3" ТӨХК, "ДЦС-4" ТӨХК-ууд, Монросцветмет нэгдлийн харъяа үйлдвэрүүд, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр зэрэг юм. "Мон-Цахим" ХХК нь харилцагч байгууллагуудын цахилгаан машинуудын захиалгат засваруудыг богино хугацаанд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг.

0000046





2015 оны түвшинд Компани 3747 мянган тонн нүүрс борлуулсан бөгөөд үүний 90 орчим хувийг станцууд худалдан авсан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бүрдүүлж буй голлох зардлууд нь үйл ажиллагаанд ашигласан сэлбэг хэрэгслийн зардал, цалин хөлс урамшууллын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл болон түлшний зардал байна. Эдгээр зардлууд нь 2015 оны байдлаар нийт борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 83 орчим хувийг эзлэж байна.

Орлогын албан татварын зардал

2015 оны орлогын албан татварын зардал нь тухайн жилийн үр дүнд суурилан тооцсон болон хойшлогдсон орлогын албан татвар, татварын өршөөлийн нөлөөллийг тусгасан болно.


Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын тайлант жилийн орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулан 3 тэрбум төгрөг хүртэлх ашгаас 10%, 3 тэрбум төгрөгөөс дээш ашгаас 25%-ийн орлогын албан татвар төлөхөөр зардлыг тооцсон.

Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох ашгийг тооцоолохдоо Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниудын тухайн жилийн цэвэр ашгийн дүнг тухайн жилийн энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж тооцсон байна.

870000





Хүснэгт 19: Санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2013 "Багануур" ХК	2014 Нэгтгэсэн	2015 Нэгтгэсэн
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,299.6	3,115.3	6,180.4
Дансны авлага	5,454.5	9,903.3	8,757.1
Бараа материал	12,306.7	14,638.4	14,009.7
Урьдчилж төлсөн зардал ба бусад авлагууд	2,508.4	3,531.2	1,900.2
Эргэлтийн хөрөнгийн дүн	29,569.2	31,188.2	30,847.4
Уурхайн хөрөнгө	7,419.7	24,943.1	36,056.7
Үндсэн хөрөнгө	73,629.1	74,371.1	68,560.2
Биет бус хөрөнгө	17.7	19.7	305.3
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	807.5	160.6	274.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,151.1	1,204.8	1,292.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	83,025.1	100,699.4	106,488.9
Нийт хөрөнгийн дүн	112,594.3	131,887.6	137,336.3
Дансны болон бусад өглөг	22,401.3	32,808.9	44,732.2
Зээллэг	19,802.2	18,563.6	23,917.3
Засгийн газрын тусламж	3,215.8	2,487.9	2,461.3
Орлогын албан татварын өглөг	0.0	3,157.2	11.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн	45,419.3	57,017.6	71,121.9
Зээл	31,224.6	24,761.7	15,257.4
Засгийн газрын тусламж	26,657.7	28,802.6	25,921.7
Сан	1,140.3	1,107.0	1,374.5
Ажилчдын тэтгэврийн сан	7,288.6	8,014.0	9,547.4
Урт хугацаат өр төлбөрийн дүн	66,311.2	62,685.3	52,101.0
Нийт өр төлбөрийн дүн	111,730.5	119,702.8	123,222.9
Энгийн хувьцаа	2,097.4	2,097.4	2,097.4
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,233.6)	10,087.3	12,015.9
Нийт эздийн өмчийн дүн	863.8	12,184.7	14,113.4

Санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтүүдийн тодруулга

Дансны авлага

Дансны авлагууд нь хүүгүй ба тохиолдол тус бүрээс хамааран ерөнхийдөө 30 хоногийн хугацаатай байна. Эдгээр авлагуудыг тэдгээрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ болох нэхэмжлэхийн дүнгээр хүлээн зөвшөөрсөн байна. Үнэт цаас гаргагч нь төрийн өмчит байгууллагуудаас томоохон хэмжээний авлагуудтай бөгөөд удирдлагын зүгээс эдгээр нь эрсдэлгүй гэж үзсэн байна.

Уурхайн хөрөнгө

Уурхайн хөрөнгө нь уурхайн хөгжүүлэлт болон хөрс хуулалтын хөрөнгөнөөс бүрдэж байна. 2014 онд хийгдсэн Компанийн нүүрсний нөөцийн геологийн судалгааны зардал нь Уурхайн хөгжүүлэлтийн хөрөнгөд бүртгэгдсэн байна. Энэхүү судалгааны зардал нь Засгийн газрын тусламжаар санхүүжигдэн гүйцэтгэгч талд шууд төлөгдсөн. Хөрс хуулалтын хөрөнгөнд Үнэт цаас гаргагчийн хөрс хуулалттай холбоотой гарсан элэгдлийн зардал, цалин хөлс, түлш шатахуун, гэрээний төлбөрүүд болон бусад зардлууд багтдаг. 2015 оны Хөрс хуулалтын хөрөнгө нь олборлолт хийгдээгүй талбайн хуулсан хөрсний хэмжээгээр нэмэгдсэн.

0000079





Дансны болон бусад өглөг

Дансны өглөгүүд нь хүүгүй, ерөнхийдөө 30-аас 60 хоногийн хугацаанд эргэн төлөгддөг байна. Эдгээр өглөгт тогтсон төлөх хугацаа болон хүү байхгүй юм.

Зээллэг/Зээл

Нийт зээлийн үлдэгдэл нь барьцаатай банкны зээл болон барьцаагүй Сангийн яамнаас авсан зээлүүдээс бүрдэж байна.

Барьцаатай зээл – Банкны зээл

▪ Монгол улсын Хөгжлийн банкны зээл

Компани нь 2013 оны 4 дүгээр сард Монгол улсын Хөгжлийн банкнаас 18.3 тэрбум төгрөгийн зээл авсан. Уг зээл нь Монгол улсын Засгийн газрын 10 дугаар тогтоолын дагуу уурхайн машин, тоног төхөөрөмж худалдан авалт болон Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон байна. Зээл нь 5 жилийн дараа буюу 2018 онд төлөгдөж дуусах бөгөөд жилийн 9.6%-ийн хүүтэй ба уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно.

▪ Хаан банкны зээл

Компани нь 2014 оны 8 дугаар сарын 22-нд 2.0 тэрбум төгрөгийн зээлийг Хаан банкнаас авсан. Тус зээл нь 12 сарын хугацаатай, 19.2%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан бөгөөд 2015 онд бүрэн төлөгдөж дууссан ба 2015 оны 8 дугаар сарын 22-нд үргэлжлүүлэн 4.0 тэрбум төгрөгийн зээл авсан. Тус зээл нь 12 сарын хугацаатай, 19.2%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно.

▪ Голомт банкны зээл

Компани нь 2015 оны 7 дугаар сарын 4-нд 2.0 тэрбум төгрөгийн зээлийг Голомт банкнаас авсан. Тус зээл нь 12 сарын хугацаатай, 21.6%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно.

▪ Худалдаа, хөгжлийн банкны зээл

Компани нь 2014 оны 7 дугаар сарын 4-нд 3.0 тэрбум төгрөгийн зээлийг Худалдаа, хөгжлийн банкнаас авсан. Зээл нь 12 сарын хугацаатай, 19.2%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно. 2015 онд тус зээлийг бүрэн барагдуулсан.

▪ Бусад зээл

Компани нь 2013 оны 9 дүгээр сарын 27-нд Дулааны 3-р цахилгаан станцаас 6.9 тэрбум төгрөг, 2013 оны 9 дүгээр сарын 6-нд Дулааны 4-р цахилгаан станцаас 9.9 тэрбум төгрөгийн зээлүүдийг авсан. Зээлүүд нь 12 сарын хугацаатай, жилийн 4.5%-ийн хүүтэй, борлуулалтын орлогоор баталгаажсан болно. Эдгээр зээлүүд нь 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр бүрэн төлөгдөж дууссан.


Барьцаагүй зээл – Сангийн Яам

▪ МОГ-2854

МОГ-2854 зээлийг 1996 оны 5 дугаар сарын 24-нд Монгол улсын Засгийн газраар (Сангийн яам) дамжуулан Олон улсын хөгжлийн Ассоциациаас авсан. Анхны гэрээний дүн 23,800,000 ам.доллар (26.5 тэрбум төгрөг) байсан. Монгол улсын Засгийн газар тухайн зээлийг Багануурын уурхайн сэргээн босголтонд зориулсан бөгөөд 2010 оны Засгийн газрын 72 дугаар тогтоолын дагуу Компани болон Сангийн яам зээлийг төгрөгт

0000050





хөрвүүлэхээр тохиролцож 2012 онд гэрээг дахин үйлдсэн байдаг. Уг зээл нь эрдэс баялагын салбарын хөгжил болон тус салбарын засаглалыг сайжруулах зорилгоор жилийн 1.7%-ийн хүүтэй олгогдсон ба 2031 онд бүрэн төлөгдөж дуусна.

▪ МОН-П4

МОН-П4 зээлийг 1997 оны 5 дугаар сарын 24-нд Монгол улсын Засгийн газраар (Сангийн яам) дамжуулан Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлагаас авсан. Гэрээний анхны дүн 5.827 тэрбум Япон йен (19.6 тэрбум төгрөг) байсан. Монгол улсын Засгийн газар тус зээлийг Багануурын уурхайн сэргээн босголтонд зориулсан бөгөөд 2010 оны Засгийн газрын 72 дугаар тогтоолын дагуу Компани болон Сангийн яам зээлийг төгрөгт хөрвүүлэхээр тохиролцож гэрээг 2012 онд дахин үйлдсэн. Зээл нь эрдэс баялагын салбарын хөгжил болон тус салбарын засаглалыг сайжруулах зорилгоор жилийн 1.7%-ийн хүүтэй олгогдсон ба 2031 онд бүрэн төлөгдөж дуусна.

Засгийн газрын тусламж

Засгийн газрын тусламж нь үндсэн хөрөнгө худалдан авалт, геологын хайгуулын үйлчилгээний төлбөр болон эрдэс баялагын салбар болон засаглалыг сайжруулахтай холбогдон Сангийн яам болон Дулааны цахилгаан станцуудаас бага хүүтэй авсан зээлүүдээс үүссэн байна.

Сан


Сан нь уурхайн нөхөн сэргээлтийн сан болон нийгмийн хариуцлагын сангуудаас бүрдэнэ. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу уурхайн талбар хөндөгдөх үед нөхөн сэргээхтэй холбогдох ирээдүйд гарах зардлуудаар сан байгуулах шаардлагатай байдаг. Гэвч Үнэт цаас гаргагч нь уг тооцооллыг 1999 оноос хойш шинэчлээгүй байна. Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд нь олон нийтийн болон байгаль орчны хөгжлийн үйл ажиллагаанд зориулан компанийн ирээдүйн нийгмийн хөгжлийн санг байгуулдаг. Уг санг бүртгэхдээ төлөвлөгөөт борлуулалтаас давсан бодит борлуулалтын хувь хэмжээ, дайвар болон шинэ бүтээгдэхүүний борлуулалт ба түрээсийн орлого зэрэг дээр тулгуурлана.

Ажилчдын тэтгэврийн сан

Үнэт цаас гаргагч болон түүний охин компаниуд нь ажилтнуудаа тэтгэвэрт гарах үед салбарт ажилласан жилийн тоог тухайн үеийн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгодог.

0000051





1.9.2. БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 20: Орлого, үр дүнгийн бүтэц, динамикийн шинжилгээ

Үзүүлэлт /сая.төг/	Тайлангийн дүн		Хувийн жин		Өөрчлөлт	
	2014	2015	2014	2015	2014	2015
Борлуулалтын орлого	90,914.3	101,597.1	100%	100%	10,682.80	12%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(70,289.3)	(95,500.8)	-77%	-94%	(25,211.50)	36%
Нийт ашиг	20,625.0	6,096.3	23%	6%	(14,528.70)	-70%
Бусад орлого	5,458.7	6,030.5	6%	6%	571.80	10%
Удирдлагын зардал	(4,712.5)	(5,404.2)	-5%	-5%	(691.70)	15%
Бусад зардал	(2,487.1)	(3,608.6)	-3%	-4%	(1,121.50)	45%
Санхүүгийн зардал	(5,070.2)	(4,564.4)	-6%	-4%	505.80	-10%
Хараат компани дахь ашгийн хувь	62.2	73.3	0%	0%	11.10	18%
Татварын өмнөх ашиг	13,876.1	(1,377.0)	15%	-1%	(15,253.10)	-110%
Орлогын албан татварын зардал	(3,195.3)	3,305.6	-4%	3%	6,500.90	-203%
Тайлант жилийн татварын дараах ашиг	10,680.8	1,928.6	12%	2%	(8,752.20)	-82%
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0%	0%	0.00	0%
Татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого	10,680.8	1,928.6	12%	2%	(8,752.20)	-82%
Нэгж энгийн хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашиг (нэгж хувьцаа/төгрөг)	509.0	92.0			(417.00)	-82%

2015 оны жилийн эцсийн дэлгэрэнгүй орлогын тайланд хийгдсэн орлого, үр дүнгийн бүтэц, динамикийн шинжилгээнээс харахад борлуулалтын орлогын 94 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг эзлэх бөгөөд үлдэх 6 хувийг нийт ашиг бүрдүүлж байна. Тайлант жилд татварын дараах нийт дэлгэрэнгүй орлогын борлуулалтын орлогод эзлэх хэмжээ 2 хувь байв. 2014 онтой харьцуулахад борлуулалтын орлогын дүн 10.7 тэрбум төгрөгөөр буюу 12 хувиар нэмэгдсэн байна.

Борлуулалтын орлого нэмэгдэхэд дулааны болон цахилгаан станцуудад борлуулж буй 1 тонн нүүрсний суурь үнийг 2014 оны 12 сараас эхлэн Эрчим хүчний зохицуулах хорооноос 3,000 төгрөгөөр нэмсэн, 2015 онд Амгалан дулааны станц ашиглалтанд орж улмаар компанийн нүүрс борлуулалтын хэмжээ 2014 онтой харьцуулахад 63.7 мянган тонноор нэмэгдэж, 2015 оны түвшинд 3,747 мянган тонн болсон, нүүрсний дундаж илчлэг өмнөх оныхоос 16.8 ккал/кг-аар нэмэгдэж 3,491.4 ккал/кг болсон зэрэг нь нөлөөлсөн байна.

0000052



Хүснэгт 21: Хөрөнгө, капиталын бүтэц, динамикийн шинжилгээ

Үзүүлэлт /сая.төг/	Тайлангийн дүн		Хувийн жин		Өөрчлөлт	
	2014	2015	2014	2015	2014	2015
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,115.3	6,180.4	2%	5%	3,065.1	98%
Дансны авлага	9,903.3	8,757.1	8%	6%	(1,146.2)	-12%
Бараа материал	14,638.4	14,009.7	11%	10%	(628.7)	-4%
Урьдчилж төлсөн зардал ба бусад авлагууд	3,531.2	1,900.2	3%	1%	(1,631.0)	-46%
Эргэлтийн хөрөнгийн дүн	31,188.2	30,847.4	24%	22%	(340.8)	-1%
Уурхайн хөрөнгө	24,943.1	36,056.7	19%	26%	11,113.6	45%
Үндсэн хөрөнгө	74,371.1	68,560.2	56%	50%	(5,810.9)	-8%
Биет бус хөрөнгө	19.7	305.3	0%	0%	285.6	1442%
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	160.6	274.0	0%	0%	113.4	71%
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,204.8	1,292.7	1%	1%	87.9	7%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,699.4	106,488.9	76%	78%	5,789.5	6%
Нийт хөрөнгийн дүн	131,887.6	137,336.3	100%	100%	5,448.7	4%
Дансны болон бусад өглөг	32,808.9	44,732.2	25%	33%	11,923.3	36%
Зээллэг	18,563.6	23,917.3	14%	17%	5,353.7	29%
Засгийн газрын тусламж	2,487.9	2,461.3	2%	2%	(26.6)	-1%
Орлогын албан татварын өглөг	3,157.2	11.2	2%	0%	(3,146.0)	-100%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	57,017.6	71,121.9	43%	52%	14,104.3	25%
Зээл	24,761.7	15,257.4	19%	11%	(9,504.3)	-38%
Засгийн газрын тусламж	28,802.6	25,921.7	22%	19%	(2,880.9)	-10%
Сан	1,107.0	1,374.5	1%	1%	267.5	24%
Ажилчдын тэтгэврийн сан	8,014.0	9,547.4	6%	7%	1,533.4	19%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	62,685.3	52,101.0	48%	38%	(10,584.3)	-17%
Нийт өр төлбөрийн дүн	119,702.8	123,222.9	91%	90%	3,520.1	3%
Энгийн хувьцаа	2,097.4	2,097.4	2%	2%	0.0	0%
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	10,087.3	12,015.9	8%	9%	1,928.6	19%
Нийт эздийн өмчийн дүн	12,184.7	14,113.4	9%	10%	1,928.7	16%

2015 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд хийгдсэн хөрөнгө, капиталын бүтэц, динамикийн шинжилгээнээс харахад нийт хөрөнгийн 22 хувийг эргэлтийн хөрөнгө, 78 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. 2014 онтой харьцуулахад эргэлтийн хөрөнгийн дүн 0.3 тэрбум төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байгаа нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 98 хувиар өсч, дансны авлага 12 хувиар, бараа материал 4 хувиар, урьдчилж төлсөн зардал ба бусад авлагууд 46 хувиар тус тус буурсантай холбоотой. Суурь оноос эргэлтийн бус хөрөнгийн дүн 5.8 тэрбум төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Энэхүү өөрчлөлт нь уурхайн хөрөнгө 45 хувиар, биет бус хөрөнгө 1442 хувиар, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 71 хувиар, хойшлогдсон татварын хөрөнгө 7 хувиар тус тус нэмэгдэж үндсэн хөрөнгө 8 хувиар буурснаас шалтгаалсан байна.

0000053





Компани тайлант онд 19,135.7 мян.м3 хөрс хуулсны 6,391.0 мян.м3 хөрсийг СТОУС 20-ын дагуу хөрөнгөөр бүртгэснээс уурхайн хөрөнгө 11.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Тайлант жилд дансны болон бусад өглөгийн өсөлт өндөр байгаа нь бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг 8.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, мөн цалин болон бусад татварын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

2015 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд хийгдсэн хөрөнгө, капиталын бүтэц, динамикийн шинжилгээнээс харахад нийт өр төлбөр болон эздийн өмчийн 90 хувийг нийт өр төлбөр, 10 хувийг эздийн өмч бүрдүүлж байна. 2014 онтой харьцуулахад нийт өр төлбөрийн дүн 3.5 тэрбум төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байгаа нь дараах дансуудын өсөлт, бууралтаас шалтгаалсан байна. Үүнд: дансны болон бусад өглөг 36 хувиар, уурхайн нөхөн сэргээлтийн болон нийгмийн хариуцлагын сан 24 хувиар, ажилчдын тэтгэвэрийн сан 19 хувиар тус тус өссөн бол зээллэгийн хэмжээ 8 хувиар, Засгийн газрын тусламж 11 хувиар, орлогын албан татварын өглөг 100 хувиар буурсан байна.


Хүснэгт 22: Орлогын тайлан болон санхүүгийн байдлын тайланд хийсэн харьцааны шинжилгээ

Үзүүлэлт (%)	2014	2015
Хөрвөх чадварын харьцаа		
Эргэлтийн харьцаа	0.55	0.43
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	0.23	0.21
Мөнгөн хөрөнгийн харьцаа	0.05	0.09
Үйл ажиллагааны харьцаа		
Дансны авлагын эргэц (хоног)	40	31
Бараа материалын эргэц (хоног)	76	54
Дансны болон бусад өглөгийн эргэц (хоног)	170	171
Борлуулалтын орлого / Нийт хөрөнгийн харьцаа	0.69	0.74
Борлуулалтын орлого / Эргэлтийн бус хөрөнгийн харьцаа	0.90	0.95
Төлбөрийн чадварын харьцаа		
Өр төлбөр / эздийн өмчийн харьцаа	9.82	8.73
Өр төлбөр / нийт хөрөнгийн харьцаа	0.91	0.90
Санхүүгийн хөшүүрэг	10.82	9.73
Ашигт ажиллагааны харьцаа		
Татварын өмнөх ашгийн хувь	0.12	0.02
Нийт ашгийн хувь	0.23	0.06
Татварын дараах ашгийн хувь	0.15	(0.01)
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	0.08	0.01
Эздийн өмчийн өгөөж (ROE)	0.88	0.14

Компанийн эргэлтийн харьцааны үзүүлэлт 2015 онд 0.12 нэгжээр буурч 0.43 байгаа нь зохистой нормоос нилээн доогуур байна. Сүүлийн жилүүдэд бараа материалын худалдан авалтын өглөг нэмэгдэж байгаа нь энэхүү үзүүлэлт буурахад нөлөөлжээ. Шаардлагатай үед үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүйгээр бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөрийг барагдуулах боломж муу байсантай холбоотойгоор төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны үзүүлэлт 2015 онд зохистой хэмжээнээс доогуур буюу 0.21 байв. Дулааны болон цахилгаан станцууд Компанид төлөх нүүрсний хуримтлагдсан өглөгөө бууруулахын тулд оны эцэст нүүрсний төлбөрөө бөөн дүнгээр шилжүүлснээс мөнгөн хөрөнгийн харьцаа 0.09 гарч өмнөх онтой харьцуулахад 0.04 нэгжээр нэмэгдсэн байна.

0000054






Дансны авлагын эргэц 2015 онд 31 хоног болж өмнөх онтой харьцуулахад 9 хоногоор буурсан байгаа нь тайлант жилд борлуулалтын орлого нэмэгдэж, станцуудаас авах авлагын хэмжээ буурснаас шалтгаалсан байна. Зарим бараа материалыг акталсан, мөн борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурсантай холбоотойгоор бараа материалын нөөц 54 хоног болж буурсан. Тайлант хугацаанд нийт хөрөнгийн эргэц, эргэлтийн бус хөрөнгийн эргэц нэмэгдэж хөрөнгийн ашиглалт бага зэрэг сайжирсан байна.

Өмнөх онтой харьцуулахад ашгийн хувь болон өгөөжийн түвшин буурсан байгаа нь тайлант жилд борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өсөлтийн хувь өндөр байсантай холбоотой юм.

0000055



1.10. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан холбогдох дүрэм, журамд үндэслэн боловсруулагдсан ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 17 тоот тогтоолоор батлагдсан. Компани нь хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг тогтоон, зохистой түвшинд байлгах бодлого баримтална.

Компанийн дүрмийн 8 дугаар зүйл, Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлд ногдол ашиг хуваарилах нөхцөл бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Ногдол ашиг хуваарилах нөхцөл

Дараах тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна.

- Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүнийг татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх
- Компани эргүүлэн худалдан авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх

Компани нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, компанийн ашигт ажиллагааны түвшин, чадавхийг дээшлүүлэх шаардлагын үүднээс Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр тодорхой хугацаанд ногдол ашиг хуваарилахгүй байж болно.

Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох

Ногдол ашгийг Компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах бөгөөд ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь адил байна.

Ногдол ашиг хуваарилах

ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэж, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэг хүлээнэ. Компанийн тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, түүнийг олгох хэлбэр, арга зам, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдрийг тогтоох, ногдол ашиг олгох ажлыг гүйцэтгэх албан тушаалтны эрх үүрэг, хариуцлагыг тусгайлсан журмаар зохицуулна.

Ногдол ашиг төлөх

Ногдол ашиг хуваарилах шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилах бөгөөд хууль тогтоомжид заасан бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд ногдол ашгийг төлнө. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болох бөгөөд уг шийдвэрийг ТУЗ гаргана. Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд бүртгэх бөгөөд компани нь хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар тус ногдол ашгийг олгох үүрэгтэй.


Тайлагнах

Ногдол ашгийг хуваарилаагүй бол шалтгааныг ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах бөгөөд ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана. Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд СЗХ болон ҮЦТХТ ХХК-д хүргүүлнэ. Ногдол ашгийг олон хэлбэрээр хувьцаа

56

0000056





эзэмшигчдэд олгож болохоор хууль, журам болон компанийн дүрэмд тусгасан хэдий ч компани аль болох мөнгөн хэлбэрээр ногдол ашиг хуваарилахыг эрмэлзэнэ. Ногдол ашиг хуваарилах хэлбэр олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна. Ногдол ашгийг хуваарилах хэлбэр, аргыг сонгохдоо хувьцаа эзэмшигчдийн оршин суугаа газар, ногдол ашгийг шуурхай хүргэх боломжийг харгалзана.

0000057





1.11. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

1.11.1. БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 болон 87.1.2 дугаар зүйлүүдэд тус тус зааснаар хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл хийсэн эвсэл компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт хийсэн бол их хэмжээний хэлцэл гэж тооцохоор заасан байна.

СҮҮЛИЙН 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХИЙСЭН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛҮҮД

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрээр Багануур ХК-ийн нийт гаргасан хувьцааны 32 хувьтай тэнцэх хувьцааг, нэмж гарган олон нийтэд нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл хамаарч байна.

Компани нь дээрх шийдвэртэй холбогдуулан Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь заалтыг үндэслэн Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 25 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг мөрдүүлсэн нь Компанийн тухай хуульд нийцэж байгаа болно.

1.11.2. БУСАДТАЙ БАЙГУУЛСАН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ТУХАЙ


Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно. Үүнд:

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа
- Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа

СҮҮЛИЙН 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХИЙСЭН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛҮҮД

Компани сүүлийн 1 жилийн хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн талаархи мэдээлэл байхгүй байна.

0000058



1.12. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



ҮНЭТ ЦААС ГАРГАН САНХҮҮЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:

Компанийн тухай хууль

УИХ-аар 2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Компанийн тухай хуульд заасан эрх, үүргийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулж, хувьцаа нэмж гарган нээлттэй зах зээлд арилжаалах замаар Компанид хөрөнгө оруулалт татаж байгаа болно. Дээрх үйл ажиллагаа нь Компанийн тухай хуулийн доорхи зүйл заалтуудад хуульчлагдсан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хувьцаа нэмж гаргах бүрэн эрх /Компанийн тухай хуулийн 62.1.3 дахь заалт/
- Нээлттэй хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх /Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл/
- Энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх мэдэгдэл хүргүүлэх болон хурал зарлах журам /Компанийн тухай хуулийн 38.2, 62.1.3 дахь заалт/
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх /Компанийн тухай хуулийн 31.2.2 дахь заалт/
- Нэмж гаргах хувьцааны бүртгэлийн эрх зүйн үндэслэл болон төлбөр төлөх журам /Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйл/

Үнэт цаас гаргагчийн зүгээс Компанийн тухай хуульд заасан нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангасан төдийгүй олон нийтэд санал болгох хувьцаанд аливаа эрхийн зөрчил үүсэхгүй.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль


УИХ-аар 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбогдсон дараах харилцааг зохицуулдаг. Үүнд:


- Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам, заавар, дарааллыг СЗХ, МХБ батлах эрх зүйн үндэслэл
- Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, анхдагч зах зээлд худалдах, бүрдүүлэх бичиг баримт, үнэлгээ тайлан, тайлагнах үүрэг
- Үнэт цаасны танилцуулгын талаарх нарийвчилсан зохицуулалт
- Нийтэд санал болгох үнэт цаас гаргах ажиллагаан дахь андеррайтерийн оролцоо
- Үнэт цаас гаргагчийн удирдлагад тавигдах нөхцөл, шаардлагыг СЗХ, МХБ тогтоох эрх зүйн үндэслэл

Тус хуульд зааснаар Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг СЗХ үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг олгож, МХБ нь үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-т Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад зааснаас өөрөөр зарцуулахыг хуулиар хориглосон байдаг.

0000059





ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

УИХ-аар 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулинд зааснаар үнэт цаас гаргагч болон түүний охин компани нь дараах тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Үүнд:

- Ашигт малтмал хайгуул хийх
- Ашигт малтмал ашиглах
- Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх
- Эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ

Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

УИХ-аар 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар Үнэт цаас гаргагчийн 75 хувийн хувьцаа эзэмшигч нь төрийн байгууллага болохын хувьд өдөр тутмын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа бусдаас бараа бүтээгдэхүүн ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа нь энэ хуулиар зохицуулагддаг. Үнэт цаас гаргагч нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын журам
- Тендер шалгаруулалтын онцгой журам
- Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
- Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам

Ашигт малтмалын тухай хууль

УИХ-аар 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиар Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах үйл ажиллагаа зохицуулагдана. Үнэт цаас гаргагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувиар Ашигт малтмалын тухай хуулийн дагуу дараах эрхийг хэрэгжүүлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- Тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах
- Уурхайн талбайд ашигт малтмалын хайгуул явуулах
- Ашиглалтын үйл ажиллагааг явуулах зорилгоор уурхайн талбайд нэвтрэн орох, дамжин өнгөрөх, шаардлагатай барилга байгууламж барих, түүнийг ашиглах
- Уурхайн талбайн гадна орших газар нутгаар дамжин өнгөрөх
- Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар, ус ашиглах гэх мэт байна.

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИУДЫН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль

УИХ-аар 2006 оны 6 дугаар сарын 29-ний батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчийн төлөх татвар, хураамж түүнийг төсөвт тайлагнах үйл ажиллагааг зохицуулдаг.

Үнэт цаас гаргагчаас нэмж хувьцаа гарган нээлттэй зах зээлд арилжаалахтай холбоотойгоор хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь компанийн тухай хуулийн дагуу компаниас ногдол ашиг хүртсэн тохиолдолд ногдол ашгийн албан татвар төлөх бөгөөд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад

0000060





худалдаж орлого олсон тохиолдолд хөрөнгө борлуулсны албан татварыг тус тус төлөх үүрэг хүлээнэ.

Албан татвар төлөгч өөрийн эзэмшлийн хувьцаанаас бусдад худалдаж орлого олсон тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө. Ногдол ашгийн орлогод ногдох албан татварын тус хуульд заасан албан татвар суутгах үүрэг бүхий этгээд (ногдол ашиг хуваарилсан компани) нь дээрх хувь хэмжээгээр суутгаж, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлэх үүрэг хүлээнэ.


Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгч нь Монгол улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлогоос 20 хувиар тооцож татвар төлнө гэж заасан. Харин давхар татварын гэрээтэй улсуудын хувьд ихэнх тохиолдолд үнэт цаас гаргаж буй компанийн буюу Монгол улсад ногдол ашгийн татвар төлөхөөр зохицуулсан байдаг боловч гэрээнд заасан хувь хэмжээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаас бага байдгийг анхаарах нь зүйтэй.


Танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монгол улс дараах 24 улстай байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр" хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хүснэгт 23: Давхар татварын хэлэлцээртэй улс орнууд

№	Улсын нэр	Татварын хувь хэмжээ	Гэрээ үйлчилж эхэлсэн огноо
1	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	5%	1993.01.01
2	Бүгд Найрамдах Солонгос Улс	5%	1993.01.01
3	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	5-10%	1997.01.01
4	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	15%	1997.01.01
5	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	10%	1997.01.01
6	Бүгд Найрамдах Турк Улс	10%	1997.01.01
7	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	5-15%	1997.01.01
8	Бүгд Найрамдах Унгар Улс	5-15%	1997.01.01
9	Малайз Улс	10%	1997.01.01
10	Оросын Холбооны Улс	10%	1998.01.01
11	Бүгд Найрамдах Индонези Улс	10%	1998.01.01
12	Бүгд Найрамдах Франц Улс	5-15%	1999.01.01
13	Бүгд Найрамдах Чех Улс	10%	1999.01.01
14	Бельгийн Вант Улс	5-15%	1999.01.01
15	Бүгд Найрамдах Казахстан Улс	10%	2000.01.01
16	Бүгд Найрамдах Киргиз Улс	10%	2000.01.01
17	Бүгд Найрамдах Польш Улс	10%	2002.01.01
18	Бүгд Найрамдах Болгар Улс	10%	2002.01.01

0000061





19	Швейцарын Холбооны Улс	5-15%	2002.01.01
20	Украин Улс	10%	2003.01.01
21	Канад Улс	5-15%	2003.01.01
22	Бүгд Найрамдах Сингапур Улс	5-10%	2005.01.01
23	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	10%	2005.01.01
24	Бүгд Найрамдах Австри Улс	5-10%	2005.01.01

Эх сурвалж: Татаарын ерөнхий газар

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

УИХ-аас 2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар хөрөнгө оруулагч хувь хүний төлөх татвар, хураамж түүнийг төсөвт тайпагнах үйл ажиллагааг зохицуулсан.

Үнэт цаас гаргагчаас нэмж хувьцаа гарган нээлттэй зах зээлд арилжаалахтай холбоотойгоор хөрөнгө оруулагч хувь хүн нь Компанийн тухай хуулийн дагуу компаниас ногдол ашиг хүртсэн тохиолдолд ногдол ашгийн албан татвар төлөх бөгөөд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад худалдаж орлого олсон тохиолдолд хөрөнгө борлуулсны албан татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу тус тус төлөх үүрэг хүлээнэ.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс хуулийн 23.1-д заасан 10 хувийн татвар төлөх бөгөөд татварыг мөн хуулийн 26.1.1-д зааснаар суутгагч (ногдол ашиг хуваарилсан компани) суутгаж, улсын төсөвт шилжүүлнэ.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлөх бөгөөд хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д зааснаар татвар төлөгч орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиар

УИХ-аар 2009 оны 7 дугаар 9-ний өдөр батлагдсан Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу МХБ-ын арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр хийгдэнэ.


ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ СЗХ-ООС БАТАЛСАН ДАРААХ ЖУРМУУДЫН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:

Үнэт цаасны бүртгэлийн журам

СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмаар СЗХ-оос Компанийн шинээр болон нэмж гаргасан үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхэд үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, Хорооны эрх, үүргийг тодорхойлох үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, бүртгэхээс татгалзах, бүртгэсэн үнэт цаасыг нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд арилжих, тайлагнахтай холбогдсон харилцаа зохицуулагдана.

0000062





Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам

СЗХ-ны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журмаар үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, хүргэлтийн давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журам

СЗХ-ны 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 65 тоот тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих тухай журмаар үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилах үйл ажиллагааг зохицуулдаг.

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ МХБ-ЭЭС БАТАЛСАН ДАРААХ ЖУРМУУДЫН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭР ЗОХИЦУУЛАГДАНА. ҮҮНД:

Үнэт цаасны бүртгэлийн журам

МХБ-ийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны 2015/14 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн тухай журмаар Үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгслийг МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Арилжааны журам

МХБ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдаж, 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан Арилжааны журмаар МХБ-ийн үнэт цаасны арилжааны төрөл, хэлцэл хийгдэх нөхцөл, арилжааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг.

Биржийн харилцагчийн тухайн өдрийн үнэт цаасны арилжаагаар хийсэн худалдах, худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс хамааруулан шимтгэлийг дараах байдлаар тооцно. Үүнд:

1.1. Хувьцаа худалдсан ба худалдан авсан тал тус бүрээс:

- 1.1.1. 100 сая хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.4 хувийн;
- 1.1.2. 100 саяаас 1 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.38 хувийн;
- 1.1.3. 1 тэрбумаас 10 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.3 хувийн;
- 1.1.4. 10 тэрбумаас 30 тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүнгээс 0.2 хувийн;
- 1.1.5. 30 тэрбумаас дээш төгрөгийн үнийн дүнгээс 0.15 хувийн;

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам


МХБ-ийн 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмаар МХБ-д бүртгэлтэй компанийн шинээр болон нэмж гаргасан хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг зохицуулдаг.

Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар

МХБ-ийн Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан бөгөөд тус заавраар Биржид бүртгэлтэй компаниудаас хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг ил тод

0000063





болгох, компаниудаас ирүүлэх мэдээллийн төрөл, жагсаалтыг тогтоох, олон нийтэд мэдээллийг хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг.

0000064



Handwritten signature


1.13. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ

1.13.1. ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Дэлхийн эрчим хүчний эх үүсвэрийн 32.3 хувийг газрын тос, 23.6 хувийг байгалийн хий, 29.9 хувийг нүүрс, 4.4 хувийг цөмийн энерги, 6.7 хувийг ус, сэргээгдэх эрчим хүч 2.2 хувь тус тус эзэлдэг бөгөөд дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор урт хугацаанд дэлхийн зах зээл дээрх эрчим хүчний эх үүсвэрт эзлэх нүүрсний хэрэглээ буурч сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ ихсэх хандлагатай байна.

Зураг 6: Дэлхийн эрчим хүчний эх үүсвэр болон эрэлт

Эрчим хүчний анхдагч эх үүсвэрийн бүтэц



Жилийн эрэлтийн хэмжээ



Эх сурвалж: BP Energy outlook 2016


Дэлхийн зах зээл дээрх эрчим хүчний нүүрсний үнэ 2011 оны эхэн үеээс эхлэн тасралтгүй унаж, 2015 оны 4 дүгээр улиралд 9 хувиар буурсан нь нүүрсний эрэлт суларсан, эрэлтээсээ давсан нийлүүлэлт, их хэмжээний бэлэн нөөц, дэлхийн хамгийн том нүүрс хэрэглэгч болох БНХАУ болон Энэтхэг улсын импортын хэмжээ багассан зэргээс хамаарсан байна. АНУ болон Евро бүсийн хувьд цэвэр болон сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ рүү анхаарал хандуулан, нүүрсний хэрэглээний бодлогодоо өөрчлөлт оруулснаар нүүрсний хэрэглээ нь буурч зах зээлийн нийлүүлэлтийн илүүдэл бий болоход нөлөөллөө.

2015 оны байдлаар аж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа удааширсан, эрчим хүч үйлдвэрлэх бусад эх үүсвэрүүдийг ихээр ашиглах болсон, мөн БНХАУ-ын Засгийн газраас нүүрсний хэрэглээгээ багасгах бодлого хэрэгжүүлж, ирэх 3 жилийн хугацаанд шинээр уурхайн тусгай зөвшөөрөл олгохыг хориглон, агаарын бохирдлын түвшинг багасгах зорилгоор эрчим хүчний нүүрсний үйлдвэрлэлийг хумьж эхэлсэн байна.

Хямд өртөг бүхий байгалийн хий, түүний хэрэглээг дэмжсэн бодлого, цэвэр эрчим хүчийг түлхүү ашиглах хандлага зэрэгтэй холбоотойгоор дэлхийн нүүрсний зах зээл хүндрэл, бэрхшээлүүдтэй тулгарсаар байна. Дэлхийн томоохон байгууллагуудын судалгаагаар БНХАУ-ын импорт буурсаар байх төлөвтэй байгаа бөгөөд Энэтхэг болон бусад хөгжиж буй орнуудын нүүрсний эрэлт нэмэгдэж байгаа нь зах зээлд бага боловч эерэг нөлөө үзүүлэхээр байна.

НҮҮРСНИЙ НӨӨЦ


0000065



Нүүрс нь дэлхийн 70 гаруй орны газар нутгаас олдох боломжтой хамгийн элбэг шатах түлшнүүдийн нэг юм. Дэлхийн хэмжээнд нийт 891.5 тэрбум тонн батлагдсан нүүрсний нөөц байдгаас ОХУ, БНХАУ, АНУ болон Энэтхэг улсуудад хамгийн их хэмжээний нөөц оршдог байна. Энэ нь одоогийн үйлдвэрлэлтийн түвшингээр 110 орчим жил дэлхий дахины нүүрсний хэрэглээнд хангалттай хэмжээ юм.

Зураг 7: Дэлхийн нүүрсний нөөц

Бүс нутгаар, 2014 он




Эх сурвалж: BP Statistical Review of World Energy, June 2015

НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ХЭРЭГЛЭЭ

2014 онд дэлхийн хэмжээнд нийт 7,834 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүнээс 44% буюу 3,474 сая тонн нүүрсийг БНХАУ үйлдвэрлэжээ. Дэлхийн нүүрсний хамгийн том үйлдвэрлэгч, импортлогч болон хэрэглэгч улс болох БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2014 онд 3,473 сая тонн байсан нь өмнөх оныхоос 2.9%-р буурсан үзүүлэлт байна.

Зураг 8: Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үйлдвэрлэл ба хэрэглээ



Эх сурвалж: Enerdata, Global Energy Statistical Yearbook, 2015

НҮҮРСНИЙ ҮНЭ

0000066

(Handwritten signature)


66
 ТӨВ ХАМГААГАХ
 ТӨС ХАМГААГАХ
 ТӨС ХАМГААГАХ
 ТӨС ХАМГААГАХ

Зураг 9: Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ



Эх сурвалж: Ашигт малтмалын газар, Статистик мэдээ 2015/XII

0000067



1.13.2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 24: Монгол улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015
Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд						
ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	9,756.6	13,173.8	16,688.4	19,174.2	21,897.6	23,166.8
ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	9,756.6	11,467.7	12,898.9	14,391.4	15,536.6	15,837.7
ДНБ-ний өсөлт, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, хувиар		17.5	12.5	11.6	7.9	2.3
1 хүнд ногдох ДНБ, оны үнээр, мянган төгрөг	3,562.6	4,728.0	5,876.8	6,614.1	7,416.4	-
Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн улсын инфляци, хувиар	13.0	10.2	14.0	11.9	11.0	1.9
Мөнгө M2, тэрбум төгрөг	4,680.0	6,412.3	7,617.3	9,451.0	10,635.8	11,426.1
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, албан ханш, жилийн эцэст	1,257.2	1,396.4	1,392.1	1,659.3	1,888.4	1,995.5
Төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	0.4	-4.8	-6.8	-1.2	-3.7	-5.0
Экспорт, сая ам.доллар	2,908.5	4,817.5	4,384.6	4,272.7	5,774.6	4,669.5
Импорт, сая ам.доллар	3,200.1	6,598.4	6,738.9	6,354.7	5,236.6	3,797.2
Гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-3.0	-13.5	-14.1	-10.9	2.5	3.8
Гадаад валютын улсын нийт албан нөөц сая ам.доллар	2,288.0	2,450.6	4,125.8	2,248.0	1,649.9	1,323.1
Нийгмийн үндсэн үзүүлэлтүүд						
Монгол Улсын хүн ам, оны эцэст, мян.хүн	2,761.0	2,811.7	2,867.7	2,930.3	2,995.9	-
Өрхийн тоо, оны эцэст, мян.өрх	742.3	759.9	768.3	794.1	823.4	-
Эдийн засгийн идэвхитэй хүн ам, мян.хүн	1,147.1	1,124.7	1,151.1	1,198.3	1,206.6	1,164.1
Ажилгүйдлийн түвшин, хувиар	9.9	7.7	8.2	7.9	7.9	8.3
Уул уурхайн салбарын үндсэн үзүүлэлтүүд						
ДНБ-д уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг	2,102.2	2,536.2	2,742.8	2,849.4	3,661.0	3,867.7
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, тэрбум төгрөг	4,987.0	6,185.6	5,723.6	7,651.7	9,299.6	8,714.4
Аж үйлдвэрийн салбарт уул уурхай, олборлох салбар, тэрбум төгрөг	3,097.0	3,752.3	3,839.7	5,217.4	6,388.9	5,858.0
Аж үйлдвэрийн салбарт, нүүрс олборлолтын салбар, тэрбум төгрөг	94.41	155.23	152.41	1,063.01	861.15	776.29
Нүүрсний экспорт, сая ам.доллар	882.00	2,273.01	1,901.77	1,122.03	849.04	555.93
Аж үйлдвэрийн салбарт уул уурхайн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ						
Зэсийн баяжмал (35%-ийн агуулгад шилжүүлснээр), мян.тонн*	357.1	347.4	347.6	533.3	712.0	890.7
Молибдений баяжмал (47%-ийн агуулгад шилжүүлснээр), тонн*	4,677.1	4,163.1	4,050.2	3,869.2	4,254.0	5,441
Алт, кг	6,037.1	5,702.6	5,995.0	8,904.4	11,503.8	14,556*
Хайлуур жоншны баяжмал, мян.тонн	140.7	116.4	157.2	76.4	71.9	230.8*
Төмрийн хүдэр, баяжмал мян.тонн	3,203.2	5,678.3	12,112.1	11,135.9	10,260.5	6,173.4*
Цайрын баяжмал, мян.тонн	112.6	104.7	119.1	104.1	93.2	89.6*
Гянтболдын баяжмал, тонн	19.9	12.6	66.0	-	1,024.2	-
Нүүрс, мян тонн	25,162	32,030	29,926	30,123	25,288	24,148

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
*Ашигт малтмалын газар, Статистик мэдээ 2015/ХИ


0000063



1.13.3. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол улсын уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 16.7 хувь, экспортын орлогын 80 хувийг дангаараа бүрдүүлж буй чухал ач холбогдол бүхий салбар билээ. Уул уурхайн салбарын 2015 оны нийт экспортын хэмжээ 4,067.0 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүнээс 1.5 сая тонн зэсийн баяжмалыг 2,280.1 сая ам.доллараар экспортолсон нь улсын хэмжээний нийт экспортын 48.8 хувь, нүүрсний экспорт 14.4 сая тон буюу 555.9 сая ам.доллар байсан нь нийт экспортын 11.9 хувийг эзэлж байна.

Зураг 10: Монгол улсын эдийн засагт эзлэх уул уурхайн салбарын хэмжээ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.13.4. МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

1.13.4.1. Монгол улсын нүүрсний нөөц

2013 оны байдлаар Монгол улсын нүүрсний геологийн нийт нөөц 175.5 тэрбум тонн бөгөөд үүнээс хайгуулын ажлын үр дүн болон нарийвчилсан судалгааны ажилд үндэслэн баталгаажсан нөөц 26.8 тэрбум тонн байна. Монгол улсын эдийн засгийн төв бүсүүдэд байрлах Багануур, Шивээ-Овоо, Төгрөг нуур, Тэвшийн говь, Цайдам нуур, Налайх, Шарын гол, Нарийн сухайт, Улаан-Овоогийн чулуун нүүрс, Таван толгойн коксжих нүүрсний орд газруудад нүүрсний судлагдсан нөөцийн 90% гаруй хувь нь төвлөрч байна. 2015 оны байдлаар Монгол улсын ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн 18.7 хувийг нүүрсний тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

1.13.4.2. Монгол улсын нүүрсний зах зээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт

Монгол улсын нүүрс үйлдвэрлэлийн хэмжээ 2002 оноос эхлэн экспортын нүүрсний эрэлттэй уялдан нэмэгдсэн. 2009 оноос эхлэн хувийн өмчийн компаниудын хөрөнгө оруулалтаар шинэ нүүрсний уурхайнууд эрчимтэй ашиглалтад орж, Монгол улсын нүүрсний салбарын шинж чанар, хангамж, боловсон хүчин, техник технологи сайжран нүүрсний экспорт нь дотоодын хэрэглээнээсээ даван Монгол улсын эдийн засагт ач холбогдол бүхий салбар болсон.

0000069




Хүснэгт 25: Монгол улсын нүүрсний тэнцэл

Үзүүлэлтүүд (мянган тонн)	2010	2011	2012	2013	2014	2015
Нийлүүлэлт						
Эхний үлдэгдэл	1,344.0	2,874.1	8,883.0	8,857.5	8,124.2	6,555.4
Үйлдвэрлэсэн	25,161.9	32,029.7	29,926.1	30,123.3	25,287.8	24,148.9
Төрийн өмчит уурхай	10,459.5	12,090.3	10,335.6	12,322.2	11,087.5	n/a
Хувийн хэвшлийн уурхай	14,702.4	19,939.4	19,590.5	17,801.1	14,200.3	n/a
Импорт	0.2	0.1	0.3	0.7	1.4	n/a
Нийт бэлэн бүтээгдэхүүн, мянган тонн	26,506.1	34,903.9	38,809.4	38,981.5	33,413.4	30,704.3
Хэрэглээ						
Дулааны цахилгаан станцад хэрэглэсэн	5,533.2	5,410.1	5,800.9	6,374.7	6,650.9	6,980.0
ААНБ болон өрхөд түлшний зориултаар нийлүүлсэн:	1,372.6	1,405.2	1,580.4	1,806.2	1,691.3	1,780.0
Үйлдвэр, барилга	179.6	221.9	336.6	222.7	144.0	n/a
Тээвэр, холбоо	49.5	52.5	42.2	11.3	49.9	n/a
Хөдөө аж ахуй	10.0	8.9	3.7	7.5	8.1	n/a
Орон сууц, нийтийн аж ахуй	614.9	641.3	637.0	787.5	568.4	n/a
үүнээс: өрхөд	612.3	639.7	626.0	783.2	563.6	n/a
Бусад	518.6	427.5	480.8	615.1	532.4	n/a
Нийт хэрэглээ	6,905.8	6,815.3	7,381.3	8,180.9	8,342.2	8,760.0
Дахин боловсруулах үйлдвэрт Экспорт	-	2,578.1	7,047.1	10,082.9	4,590.2	n/a
Тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол	-	53.1	80.1	162.1	388.5	n/a
Эцсийн үлдэгдэл	2,874.1	4,214.5	8,937.6	8,286.3	6,555.4	n/a

Нүүрсний экспортын хэмжээ 2011 онд түүхэн дэх хамгийн өндөр түвшинд 21.3 сая тонн буюу 2.3 тэрбум ам.долларт хүрсэн бол 2015 оны байдлаар 14.4 сая тонн буюу 555.9 сая ам.доллар болсон байна. БНХАУ нь дэлхий хамгийн том нүүрс олборлогч болон хамгийн том нүүрс хэрэглэгч бөгөөд дэлхийн нийт нүүрсний хэрэглээний 50 орчим хувийг дангаараа хэрэглэдэг байна. Монгол Улс 2003 оноос эхлэн БНХАУ-д нүүрс экспортод гаргаж байгаа бөгөөд 2015 оны байдлаар экспортолсон нүүрсний 95 хувь нь БНХАУ руу экспортлогдсон бөгөөд үлдсэн хэсгийг Сингапур, БНСУ, ОХУ, Их Британи улсууд руу нийлүүлжээ.

Нүүрсний салбарт төрийн өмч давамгайлсан "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК, орон нутгийн өмч давамгайлсан "Тавантолгой", "Баянтээг", "Могойнол" ХК-ууд, хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай нүүрс олборлогч, нийт 40 гаруй аж ахуйн нэгжүүд идэвхитэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа ба 2015 оны эцсийн байдлаар нийтдээ 24.15 сая тн нүүрс олборлосон байна.

Зураг 11: Монгол улсын нүүрсний нийлүүлэлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

0003070

Handwritten signature and official stamp of the Mongolian Stock Exchange.

Official stamp of TDB CAPITAL LLC with handwritten signature and the number 70.

Зураг 12: Нүүрсний экспортын хэмжээ, төрлөөр (2015 он)




Эх сурвалж: Ашигт малтмалын газар, Статистик мэдээ 2015/ХII

1.13.4.3. Монгол улсын нүүрсний зах зээлийн эрэлт

Монгол улсын нүүрсний эрэлтийн дийлэнх хэсгийг эрчим хүчний нүүрс эзлэх бөгөөд цөөн тооны томоохон дулааны цахилгаан станцуудын нүүрсний захиалгаас шууд хамааралтай байдаг. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон эрчим хүчний нүүрсний уурхайнууд нь тухайн бүс, орон нутаг болон улсын хэмжээний станцуудыг нүүрсээр хангах зорилгоор байгуулагдсан бөгөөд шинэ дулааны цахилгаан станц ашиглалтад орох, хуучин дулааны цахилгаан станцуудын өргөтгөл, шинэчлэл хийж хүчин чадлаа нэмэгдүүлэхэд нүүрсний эрэлт даган нэмэгддэг. Монгол улсын хувьд эрчим хүчний хэрэгцээгээ бүрэн хангах боломжгүй байгаа бөгөөд эрчим хүчний хэрэглээний 20 орчим хувийг ОХУ болон БНХАУ-аас импортлон ашигладаг.

2015 оны байдлаар Монгол улсын нүүрсний нийт олборлолтын хэмжээ 24.15 сая тонн байсан бөгөөд дотоодын хэрэглээ 8.76 сая тонн, түүнээс дулааны цахилгаан станцуудын хэрэглээ 6.98 сая тонн байна. Монгол Улс нь нүүрсний хэрэгцээгээ 100% дотооддоо олборлон хангадаг.

Зураг 13: Дотоодын нүүрсний хэрэглээ



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ашигт малтмалын газар, Статистик мэдээ 2015/ХII

Улсын хэмжээнд нийт нүүрсний хэрэглээ нь нийт олборлолтоос ойролцоогоор 3 дахин бага байх хандлагатай байна.


0000071



1.13.4.4. Эрчим хүчний зах зээлийн хандлага

Монгол улсын эрчим хүчний салбар нь Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай Улиастайн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Төвийн эрчим хүчний систем гэсэн 4 бие даасан систем болон сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрүүдээс бүрддэг. Үүнээс Төвийн эрчим хүчний систем (ТЭХС) нь хамгийн том систем бөгөөд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон 13 аймгийн төвийг цахилгаанаар хангаж байна.

Зураг 14: Монгол улсын эрчим хүчний систем



Эрчим хүчний системийн хэмжээгээр 2015 онд нийт 4,772.4 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, импортоор 1,436.7 сая кВт.ц цахилгаан эрчим хүч худалдан авч түгээсэн байна. Мөн онд цахилгаан эрчим хүчний нийт хэрэгцээний 76.9 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 23.1 хувийг импортоор авсан байна.

Хүснэгт 26: Монгол улсын томоохон дулаан, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрүүд

Эрчим хүчний систем	Дулаан, цахилгаан станцууд	Хүчин чадал		Ашиглалт анд орсон
		Цахилгаан мВт	Дулаан гкал	
Төвийн эрчим хүчний систем	ДЦС-2	21.5	67	1961
	ДЦС-3	186.0	585	1968
	ДЦС-4	700.0	1373	1983
	Дархан ДЦС	48.0	n/a	1965
	Эрдэнэт ДЦС	28.8	302	1987
	Салхит СЦС	50.0	-	2013
Нийт		1034.3		
Баруун бүсийн эрчим хүчний систем	Дөргөн УЦС	12.0	-	2009
Дорнод бүсийн эрчим хүчний систем	Чойбалсан ДЦС	36.0	n/a	1969
Алтай Улиастайн эрчим хүчний систем	Тайшир УЦС	11.0	-	2007
	Богдын голын УЦС	10.7	-	2009
	Бусад УЦС	14.0	-	-
Орон нутгийн	Даланзадгад ДЦС	48	157	2000
	Багануур ДС	-	200	1980
	Налайх ДС	-	170	1995
Нийт		131.7		

Эх сурвалж: Эрчим хүчний яам, Станцуудын цахим хуудас

0000072

(Handwritten signature and official stamp)

ТН ДН СХ КАНДИДАТ ТҮР ХХИ
72
GABITUM
TDB CAPITAL

Ойрын жилүүдэд улсын хойд хэсэгт томоохон Усан цахилгаан станц барьж байгуулах, нар салхины нөөц ихтэй өмнөд болон зүүн өмнөд хэсэгт салхин парк, томоохон хүчин чадалтай нарны станцуудыг барих төслүүдийг хэрэгжүүлэх талаар хувийн хэвшил, гадаад дотоодын компаниуд ажиллаж байна. Мөн эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох Багануурын 700 мВт ЦС, ДЦС-5, Баруун бүсийн 60 мВт ДЦС, Дорнод бүсийн 100 мВт ДЦС, Бөөрөлжүүтийн ЦС, Тавантолгойн 450 ДЦС төслүүдийн бэлтгэл ажил хийгдэж эхэлсэн ба Амгалан ДС 2015 онд үйл ажиллагаа эхэлсэн.

Түүнчлэн Засгийн газраас “Эгийн голын усан цахилгаан станц”, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 /MegaWatt/-аар нэмэгдүүлэх”, “Улаанбаатар-Мандалговийн 330 киловольтын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих” төслийн хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгийн төвүүдэд дулааны эх үүсвэр, дулааны шугам барих төслийг БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Зураг 15: Үйлдвэрлэсэн цахилгаан дулаан



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Ойрын жилүүдэд Монгол улсад дараах томоохон эрчим хүчний эх үүсвэрүүд ашиглалтанд орох хүлээлттэй байна.

Хүснэгт 27: 2017-2020 онд шинээр баригдах эрчим хүчний эх үүсвэр

Төслийн нэр	Хүчин чадал, МВт	Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая ам.доллар/	Байршил	Ашиглалтанд оруулах хугацаа	Тайлбар
ДЦС-5	450.0	1,200.0	Улаанбаатар хот	2018 он	Концессын гэрээ хийгдсэн
Таван толгойн цахилгаан станц	450.0	1,000.0	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	2018 он	Оюу толгойтой эрчим хүч нийлүүлэх гэрээ хийгдсэн
Тэлмэний цахилгаан станц	100.0	180.0	Завхан аймаг, Тэлмэн сум	2017 он	Концессын гэрээ хийгдсэн
Дорнодын цахилгаан станц	100.0	180.0	Дорнод аймаг, Чойбалсан сум	2017 он	Концессын жагсаалтанд оруулж сонгон

0000073






Багануурын цахилгаан станц	700.0	1,050.0	Улаанбаатар хот, Багануур дүүрэг	2018 он	Концессын гэрээ хийгдсэн
ДЦС-3 ДДХ шинэчилэл	250.0	350.0	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо	2018 он	ТЭЗҮ хийгдсэн ЗГ-ын тогтоол гарсан
Баруун бүсийн ДЦС	60.0	120.0	Засгийн газрын шийдвэр гаргах	2018 он	Улаангомын ДЦС-ын ТЭЗҮ хийгдсэн
Эгийн голын усан цахилгаан станц	315.0	820.0	Булган аймаг, Хутаг өндөр сум	2019-2020 он	ТЭЗҮ шинэчилэн хийгдсэн
Нийт	2,425	4,900.0			

Эх сурвалж: Багануур ХК

Монгол улсын хэмжээнд 2015 оны байдлаар 4,772.4 сая.кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд нийт 6.98 сая тонн нүүрс хэрэглэсэн байна. Монгол улсын цахилгаан эрчим хүчний хэрэгцээ жилд дунджаар 7-10% өсөж байгаа тухай Эрчим хүчний яамнаас мэдэгдсэн бөгөөд Монгол улсын эрчим хүчний эрэлтийн төлөв дараах байдалтай байна.

Зураг 16: Монгол улсын эрчим хүчний эрэлтийн төлөв

сая.кВтц




Эх үүсвэр: УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс

Хэдийгээр улсын эрчим хүчний салбар нь хэвийн тогтвортойгоор ажиллаж, дотоодын эрчим хүчний хэрэглээний дийлэнх хэсгийг өнөөгийн түвшинд найдвартай, тасралтгүй ханган ажиллаж байгаа боловч эдийн засаг өсөхийн хэрээр цахилгаан эрчим хүчний хэрэглээ тасралтгүй нэмэгдэн, эрчим хүчний дутагдалд орох төлөвтэй байна. Цаашид дотоодын нүүрсний томоохон ордуудыг түшиглэн цахилгаан станцуудыг шинээр барьж, ОХУ болон БНХАУ-аас авч буй эрчим хүчний импортыг нөхөх, дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжтой юм.

1.13.4.5. Эрчим хүчний нүүрсний үнэ

Монгол улсын газар нутгийн хэмжээ том, дэд бүтэц сул хөгжсөн зэрэг шалтгааны улмаас дотоодын зах зээлийн хувьд өрсөлдөөний нөхцөл хязгаарлагдмал, нүүрсний үнэ чөлөөт бус зохицуулалттай байна. Эрчим хүчний салбарт нүүрс нийлүүлж буй дотоодын уурхайнуудын нүүрсний борлуулалтын үнэ болон эрчим хүчний салбар төрийн хяналттай, зах зээлийн зарчмаар ажиллаж чадахгүй байгаа нь нүүрсний салбарт ажиллаж буй байгууллагуудыг алдагдалтай ажиллах хүчин зүйлсийн нэг болдог.

0000074



Зураг 17: Эрчим хүчний нүүрсний зохицуулалттай үнэ болон үйлдвэрлэлийн өртөг



Эх сурвалж: Ашигт малтмалын газар, 2014 он

1.13.4.6. Үнэт цаас гаргагчийн зорилтот зах зээл


Багануур, Шивээ-Овоо, Шарын гол зэрэг уурхайнууд нь Монгол улсын дотоодын нүүрсний хэрэгцээний дийлэнхи хувийг олборлож, төвийн эрчим хүчний системийн харъяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах стратегийн ач холбогдол бүхий уурхайнууд бөгөөд тэдгээрийн үйлдвэрлэлийн хэмжээ нь Монгол улсын нийт нүүрсний үйлдвэрлэлийн 30 орчим хувийг бүрдүүлж байдаг.

Эрчим хүчний салбарт гарч буй өөрчлөлт шинэчлэлтийн ажлууд, бодлогын хүрээнд дулааны цахилгаан станцуудын хүчин чадал нэмэгдсэнтэй холбоотойгоор дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлд нийлүүлж буй нүүрсний хэмжээ өссөн нь "Багануур" ХК болон "Шивээ-Овоо" ХК-ийн үйл ажиллагаанд зэрэгээр нөлөөлсөн. Харин "Шарын Гол" ХК нь Дархан, Эрдэнэт, Сэлэнгийн бүс нутгийг нүүрсээр хангадаг бөгөөд 2006-2012 онуудад нүүрсний нөөц ихээхэн багассан, үйлдвэрлэлийн хэмжээ буурсан, хэвийн үйл ажиллагаа алдагдсаны улмаас дээрх бүсийн хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээг хангаж чадахгүй байдалд хүрсэн зэрэг бэрхшээлтэй тулгарсан нь "Багануур" ХК –ийн нийлүүлэлт нэмэгдэхэд нөлөөлсөн.

"Багануур" ХК нь төвийн бүсийн эрчим хүчний станцууд болох Улаанбаатар хотын "ДЦС-4" ТӨХК, "ДЦС-3" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК, "Багануур ДС" ТӨХК-уудад нүүрс нийлүүлж ирсэн бөгөөд эдгээр хэрэглэгчид нь уурхайтай төмөр замаар холбогдсон бөгөөд нүүрс нийлүүлэхэд ямар нэгэн тээврийн хүндрэлгүй тул Багануур уурхай өөрийн зорилтот зах зээл хэмээн тодорхойлдог байна. Үүнээс гадна 2006 оноос Дархан, Эрдэнэт, Сэлэнгийн ДЦС-уудад нүүрс нийлүүлж эхэлсэн ба цаашид уг зорилтот зах зээл нь 2015 онд шинээр ашиглалтанд орсон "Амгалан ДС", 2017-2018 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөж буй "ДЦС-5", "Багануурын ЦС"-уудаар хүрээгээ тэлэх төлөвтэй байна.

0000075





Хүснэгт 28: Зорилтот зах зээлд шинээр орох цахилгаан станцууд

Эрчим хүчний систем	ДЦС	Хүчин чадал		Ашиглалтанд орох
		Мвт	Гкал	
Төвийн эрчим хүчний систем	Амгалангийн ДС	348	300	2015
	ДЦС-5	450		2018
	Багануурын ЦС	700		2018
Нийт		1,498	300	

Эх сурвалж: "Багануур" ХК

Дотоодын нүүрсний хэрэглээний дундаж өсөлт болон цахилгаан дулааны шинэ эх үүсвэрийн ирээдүйн хэрэгцээг тооцсон нүүрсний хэрэглээний таамаглал үзүүлэлтийг Хүснэгт 25-д харуулав.

Хүснэгт 29: Эрчим хүчний нүүрсний зах зээлийн эрэлт (мян.тонн)


ХЭРЭГЛЭГЧ	2016	2017	2018	2019	2020
Одоогийн хэрэглэгчид					
Дулааны цахилгаан станцууд	6,922.7	7,144.2	7,372.8	7,608.7	7,852.2
"ДЦС-2" ХК	200.0	200.0	200.0	200.0	200.0
"ДЦС-3" ХК	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0
"ДЦС-4" ХК	3,600.0	3,600.0	3,600.0	3,600.0	3,600.0
"Эрдэнэт ДЦС" ХК	280.0	280.0	280.0	280.0	280.0
"Дархан ДЦС" ХК	600.0	600.0	600.0	600.0	600.0
"Багануур ДС" ХК	65.0	65.0	65.0	65.0	65.0
Бусад	827.70	1,049.20	1,277.80	1,513.70	1,757.20
Үйлдвэр барилга	253.6	266.3	279.6	293.5	308.2
Тээвэр холбоо	45.0	45.0	45.0	45.0	45.0
Хөдөө аж ахуй	8.0	8.0	8.0	8.0	8.0
Айл өрх	558.2	541.7	502.3	505.6	396.8
Бусад	950.5	1,036.0	1,129.3	1,230.9	1,341.7
Одоогийн хэрэглэгчдийн нийт дүн	8,737.9	9,041.1	9,336.9	9,691.8	9,951.9
Шинэ хэрэглэгчид					
ДЦС-5	-	-	1,800	2,000	2,500
Багануур ДЦС	-	-	1,000	2,400	2,400
Амгалан ДС	650	650	650	650	650
Шингэрүүлэх үйлдвэр	-	-	850	1000	1,300
Нүүрс боловсруулалт	285	395	485	535	700
Шинэ хэрэглэгчдийн нийт дүн	935	1045	4785	6,585	7,550
Нийт дүн	9,672.9	10,086.2	14,121.9	16,276.8	17,501.9
"Багануур" ХК-ийн нийлүүлэх нүүрсний хэмжээ	3,750.0	4,065.0	6,465.0	8,005.0	10,005.0
"Багануур" ХК-ийн зах зээлд эзлэх хувь	39%	40%	46%	49%	57%

Эх сурвалж: "Багануур" ХК

0000076



Зураг 18: Монгол улсын нүүрсний хэрэглээний таамаг



Эх сурвалж: Багануур ХК

0000077



1.14. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, SWOT ШИНЖИЛГЭЭ

Компани нь Монгол улсын нүүрсний хэрэгцээний 43 орчим хувийг дангаараа хангаж ирсэн бөгөөд 2015 оны байдлаар Монгол улсын нийт нүүрсний үйлдвэрлэлийн 15%, дотоодын нүүрсний хэрэгцээний 43%, дотоодын дулааны цахилгаан станцуудын хэрэглээний 53%-ийг хангаж байна.

Зураг 19: “Багануур” ХК-ийн зах зээлд эзлэх байр суурь

Эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Багануур ХК

Хүснэгт 30: Эрчим хүчний нүүрс үйлдвэрлэгч томоохон байгууллагууд

Нэр	Нүүрсний нөөц	Зах зээлийн үнэлгээ, сая төгрөг (2015.12.31)
Багануур ХК	812.0	51,806.67
Таван Толгой ХК	80.0	155,362.34
Шарын гол ХК	146.0	39,175.77
Шивээ овоо ХК	564.1	47,275.49
Адуунчулуун ХК	240.0	3,781.56
Могойн гол ХК	2.0	4,865.73
Баянтээг ХК	25.0	4,519.16

Эх сурвалж: Компануудын цахим хуудас

Хүснэгт 31: SWOT шинжилгээ

Эерэг		Сөрөг
Дотоод	Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Нүүрс боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх түүхий эдийн нөөц болон дэд бүтэцтэй. Стратегийн ач холбогдол бүхий орд газрыг эзэмшдэг. 	<ul style="list-style-type: none"> Нарийн мэргэжлийн, өндөр ур чадвартай ажилтнуудыг тогтоор суурьшилтай ажиллуулах тусгайлсан бодлого байхгүй, хүний нөөцийн эрсдэлийн үнэлгээ, материаллаг бус урамшууллыг сайн хийдэггүй. 	

0000073



- Ажилтнууд ажлын байраа сайжруулах, эрүүл аюулгүй нөхцөлд ажиллах эрмэлзэл, хандлага сайн, эрсдэлийн талаар мэдээлэл өгдөг, "ХАБЭА-г нэн түрүүнд" гэсэн ойлголт ухамсрыг бүх шатанд анхааран ажиллаж хэвшсэн.
- Мэргэжилтэй ажиллах хүчний нөөцтэй, гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох нэгдмэл хүсэл эрмэлзэлтэй, хүний нөөцийн бодлогын бичиг баримттай, богино хугацааны төлөвлөлт хийдэг, хувь хүний хөгжлийн хөтөлбөрийг боловсруулдаг, хүний нөөцийн холбогдох дүрэм журмуудыг мөрддөг.
- Нүүрсний уналаас хамаарсан уурхайн гүндгийрэлт, уулын ажлын хоцрогдол дотоод овоолгын гулсалтаас үүссэн хүндрэл, гүний усны тэжээгдэл ихтэй.
- Тоног төхөөрөмжүүдийн насжилт өндөр, техникийн шинэчлэлийн шаардлагыг бүрэн боловсруулаагүй, дотоод програм хангамжуудын хоорондын уялдаа холбоо муу.
- Судалгааны ажил бага, бодлого боловсруулах арга барил сул.

Гадаад Боломж


- Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хаягдал багатай, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх; уурхайн нөхөн сэргээлтэд "Дүйцүүлэн хамгаалах" механизмыг нэвтрүүлэх, уурхайн төслийг санхүүжүүлэгч банкуудтай ногоон хөгжлийн бодлогыг холбох механизмыг бий болгох; үйлдвэрийн болон ахуйн хаягдал усыг цэвэршүүлэх, дахин ашиглах технологийг нэвтрүүлэх.
- Эрчим хүчний тухай хууль, түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолд заасны дагуу зах зээлийн зарчимд шилжин ажиллах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх; нүүрсний үнийг тодорхойлох аргачлалыг батлах тухай Монгол улсын дэд бүтцийн сайдын тушаалын дагуу нүүрсний өртгөө тооцдог бол өртөг, зардлаа нөхөх хэмжээний үнээр хэрэглэгчдэд нүүрсээ борлуулах.
- Нүүрс боловсруулах, шинэ бүтээгдэхүүн гаргах, техник технологийн шинэчлэлд шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.
- Түүхий эдэд нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэх,
- нүүрсний чанарыг сайжруулан хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих бодлого баримтлах, нүүрс боловсруулах, баяжуулах, дайвар эрдсээ иж бүрэн ашиглах.

Аюул

- Нүүрсний борлуулалтын үнийг Засгийн газраас тогтоож, хяналт тавьдаг, эрчим хүчний салбар төрийн хяналттай, зах зээлийн горимоор ажилладаггүй.
- Сэлбэг материал, түүхий эдийн үнэ байнга өсөх, техник, тоног төхөөрөмж шинэчлэлтийн өртөг өндөр байх.
- Эрчим хүчний зориулалтын нүүрсний талаар баримтлах бодлого, чиглэл тодорхойгүй байх.
- Цөөн тооны төрийн өмчит худалдан авагчдаас хамааран өглөгийн хэмжээ, эргэц нэмэгдэх, мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлөх.
- Хуримтлагдсан өр зээл нэмэгдэх, шинээр хийх хөрөнгө оруулалтын санхүүжилтийг өртөг өндөр зээлээр санхүүжүүлэх.
- Бүтээгдэхүүний борлуулалтаа нэмэгдүүлэхэд төмөр замын тээврийн хүчин чадлаас шууд хамаарах.

0000073





1.15. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

1.15.1. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ

Дэлхийн хамгийн том нүүрс олборлогч болон хэрэглэгч улс болох БНХАУ нь дэлхийн нийт нүүрсний тал орчим хувийг дангаар ашигладаг бөгөөд манай улсын хувьд эрчим хүчний нүүрсний хамгийн том зах зээл төдийгүй газарзүйн байршлын хувьд хамгийн том давуу талыг бий болгодог. Гэсэн хэдий ч БНХАУ-аас эдийн засаг болон уул уурхайн салбарын уналтыг зогсоох үүднээс дотоодын уул уурхайн салбарын олборлолтоо дэмжих бодлогыг хэрэгжүүлснээр зах зээл дээрх импортлогч орнуудын өрсөлдөөн ширүүсэн дэд бүтэц, нүүрсний чанар, боловсруулалт, өртөг болон татварын хувь хэмжээнд анхаарах болсон.

Монгол улсын эрчим хүчний нүүрсний зах зээлийн онцлог нь цөөн тооны томоохон цахилгаан дулааны станцуудын нүүрсний захиалгаас шууд хамаардаг бөгөөд томоохон эрчим хүчний нүүрсний уурхайнууд тухайн бүс, орон нутаг болон улс орны хэмжээний станцуудыг нүүрсээр хангах зориулалтаар байгуулагдсан байдаг.

Төрийн болон орон нутгийн өмчит, хувийн хэвшлийн нүүрс олборлогчид улсынхаа дотоодын нүүрсний хэрэгцээний дийлэнх хувийг хангаж, нийт олборлолтын 60 орчим хувийг экспортод гаргадаг тул дотоодын нүүрсний салбар олон улсын зах зээлээс хамааралтай байна. Хэдийгээр 2002 оноос хойш улсын хэмжээнд нүүрс олборлолт эрчимтэй нэмэгдэж байгаа боловч энэ нь дотоодын зах зээлийн эрэлтээс бус экспортын өсөлтөөс шалтгаалж байна. Тухайлбал, нийт олборлосон нүүрсний 29 хувь буюу 6.98 сая тонн нүүрсийг эрчим хүчний зориулалтаар, 60 хувь буюу 14.4 сая тонн нүүрсийг экспортод, 7 хувь 1.63 сая тонн нүүрсийг орон нутгийн хэрэгцээнд ашиглажээ.

Монгол улсын газар нутаг том, дэд бүтэц сул хөгжсөн зэрэг шалтгааны улмаас дотоодын зах зээлийн хувьд өрсөлдөөний нөхцөл хязгаарлагдмал, нүүрсний үнэ чөлөөт бус төрийн зохицуулалттай байдгаас түлш, эрчим хүчний бодит өртөгт суурилсан үнэ тогтоох асуудал нь улсын нийгэм, эдийн засаг, санхүү, төсөв, төрийн болон хувийн хэвшлийн бизнесийн төлөв байдал, ард түмний амьжиргааны түвшин, төлбөрийн чадвараас шууд хамаарах эрсдэлтэй байдаг.

Гадаад орчны сөрөг нөлөөлөл, ялангуяа түүхий эдийн үнийн бууралт, болон дотоодын эдийн засгийн уналт, гадаадын хөрөнгө оруулалтын огцом бууралт, төсвийн алдагдал, экспортын орлогын бууралт, дотоодын ханшийн уналт зэрэг нь улс орны эдийн засгийн салбаруудыг доройтуулах, ажилгүйдлийг нэмэгдүүлэх, улмаар уул уурхай, үйлдвэрлэлийн салбарыг уналтанд оруулах эрсдэлтэй.


ТӨРИЙН БОДЛОГО, УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-нд зааснаар Улсын Их Хурал нь төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох, төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлийг баталж, түүнд өөрчлөлт оруулах эрхтэй, Засгийн газар нь төрийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг хуульд нийцүүлэх тогтоох, төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг хуульд нийцүүлэн тогтоох эрхтэй байдаг. Мөн тус хуулийн 21 дүгээр зүйлд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилж эрхтэй байна.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын холбогдох шийдвэр, тогтоолын дагуу "Эрдэнэс Монгол" ХХК нь төрийн өмчийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй бол "Монгол Улсын 2016 оны төсвийн

0000080





тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай" 100 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн "Төрийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 5-р тогтоолоор Төрийн өмчийн хорооны эрхэлж байсан чиг үүргийг Сангийн яаманд шилжүүлэхээр болсон байна. Цаашид, дараа дараагийн Улсын Их Хурал, Засгийн газар болон төрийн эрх барих байгууллагаас төрийн өмчийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямарваа нэг улс төрийн бодлого, шийдвэрийн өөрчлөлт гарах эрсдэлтэй.

ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН, ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Улсын Их Хурлаас 2015 онд "Эрчим хүчний тухай хууль", "Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль"-нд нэмэлт өөрчлөлт оруулан, "Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль", "Эрчим хүчний талаас төрөөс баримтлах бодлогын баримт бичиг"-ийг шинээр баталсан. Тус ажлын хүрээнд Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүчний зохицуулалтын ил тод, нээлттэй байдал, хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх ашгийг тэнцвэртэй хангах хүрээнд хэрэглэгчийн үнэ тарифын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн, эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх, чадал болон энергийн тарифын тогтолцоог бий болгох зэрэг зохицуулалтын шинэ арга хэлбэрүүдийг нэвтрүүлсэн. Мөн Улсын Их Хурлын 2014 оны "Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 34-р тогтоол, 2015 оны "Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай" 41-р тогтоол, Эдийн засгийн байнгын хорооны 2015 оны "Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2-р тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс эрчим хүчний салбарын санхүүгийн алдагдлыг бууруулах, эрчим, хүчний үнэ, тарифыг бодит өртөгт хүргэх, үнэ тарифыг чөлөөлөх эхлэлийг тавих, зах зээлийг жишигт нийцүүлэх алхамуудыг хийж эхэлсэн байдаг. Гэсэн хэдий ч дээр дурьдсан Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоолуудад өөрчлөлт орох, эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн жишигт нийцүүлэх ажлыг зогсоох, хойшлуулах хууль эрхүйн орчинд өөрчлөлт орох, Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан дүрэм, журамд өөрчлөлт орох, салбарын хэмжээний нэгдсэн бодлого сул, хэрэгжихгүй байх эрсдэлтэй.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Монголын хөрөнгийн биржээр 2015 онд нийт хийгдсэн гүйлгээний 5.58 хувийг хувьцааны, 93.39 хувийг Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны, 0.93 хувийг Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны, 0.09 хувийг компанийн бондын арилжааны үнийн дүн эзэлсэн ба энгийн арилжааны нийт хувьцааны үнийн дүн 27.3 тэрбум төгрөг болсон байна. Хэдийгээр биржээр дамжин явагдсан арилжааны нийт хэмжээ өссөн ч тус өсөлт нь Засгийн газрын үнэт цаасны арилжаатай холбоотой байсан байна.

Хувьцааны арилжааны ерөнхий үзүүлэлтийг авч үзвэл арилжигдсан хувьцааны нэр төрөл цөөн, арилжааны хэмжээ бага хэвээр байгаа ба үүнд голчлон гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд манай улсын бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, дийлэнх хувьцаат компаниудын засаглал сул, тайлагналын ил тод тогтолцоо төлөвшөөгүй, зах зээл хөрвөх чадвар доогуур байгаа нь нөлөөлжээ. Тухайлбал, нүүрсний салбарын хувьцаануудын уналт үргэлжилсэн хэвээр байгаа нөхцөлд цаашид улсын эдийн засгийн төлөв байдал, хөрөнгө оруулалтын орчин сайжрахгүй тохиолдолд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар сул, хөрөнгө оруулагчдын идэвхи тааруу байх эрсдэлтэй.

0000081



БИЗНЕСИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛ



Компанийн зорилтот зах зээл нь төвийн бүсийн дулааны болон цахилгаан станцууд бөгөөд "ДЦС-4" ТӨХК, "ДЦС-3" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК, "Багануур ДС" ТӨХК-уудад нүүрс нийлүүлэн дотоодын нийт хэрэглээний 43 хувь, дулааны цахилгаан станцуудын хэрэглээний 53 хувийг дангаар хангаж байна.

Эрчим хүчний нүүрсний дотоодын үнийг төрөөс бодлогоор барьдаг ба бүтээгдэхүүний эрэлтээс хамаарсан үнийн зохицуулалт хийгддэггүй бөгөөд Эрчим хүчний зохицуулах хорооноос 2015 онд үнэ тарифын уян хатан, олон төрөлт тогтолцоог нэвтрүүлж, үнэ тарифт зохих зохицуулалтуудыг хийснээр эрчим хүчний салбар анх удаа алдагдалгүй ажиллаж эхэлсэн.

Цаашид, дулааны болон цахилгаан станцууд ашигтай ажиллан, аж ахуйн нэгжүүдийн хоорондын өглөг, авлага буурч, нүүрсний олборлолт нэмэгдэх хүртэл, гадаадын болон дотоодын зээл, тусламж авах, улсын төсвөөс хөнгөлэлттэй санхүүжилт авахгүйгээр үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэмэлт хайгуул хийн нөөцөө нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, уурхайн үйлдвэрлэлт байгль орчин ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, төмөр замын хүчин чадлыг сайжруулах зэрэг хөрөнгө оруулалтуудыг бүрэн хийх боломжгүй байх эрсдэлтэй.

Мөн эдийн засгийн уналт удаан хугацаанд үргэлжилж, дулааны цахилгаан станцууд төлбөрийн чадваргүй болох, хөрөнгө оруулалт татах боломж хумигдан, банкуудаас авах зээлийн хүү нэмэгдэх, хугацаа багасах, импортоор авах тоног төхөөрөмж, сэлбэг материал худалдан авалтын зах зээлийн үнэ валютын ханш, инфляцаас бож нэмэгдэх нь бизнесийн салбарт эрсдэл дагуулна.

ӨРСӨЛДӨГЧТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Улсын хэмжээнд 2015 оны байдлаар төрийн өмчит "Эрдэнэс Таван Толгой" ТӨХК, төрийн өмч давамгайлсан "Багануур" ХК, "Шивээ Овоо" ХК, орон нутгийн өмч давамгайлсан "Таван толгой" ХК, "Баянтээг" ХК, "Могойнол" ХК, хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай "МАК" ХХК, "Чинхуа-Нарийн сухайт" ХХК, "Саус Гоби Сэндс" ХХК, "Шарын Гол" ХК, "Энержи Ресурс" ХХК зэрэг нүүрс олборлодог 40 гаруй аж ахуйн нэгжүүд нийтдээ 24.15 сая тонн нүүрс олборлож, 14.47 сая тонн нүүрс экспортлосон байна.

Харин "Багануур" ХК, "Шивээ Овоо" ХК болон "Шарын Гол" ХК нь улсын дотоодын нүүрсний хэрэгцээний дийлэнх хувийг олборлож, төвийн эрчим хүчний системийн харьяа дулааны цахилгаан станцуудад нийлүүлж байгаа ба тус станцуудад нь дотоодын нийт хэрэглээний 76.9 орчим хувийг эзэлдэг. Дотоодын нүүрсний зах зээл дээрх нийлүүлэлтэд сүүлийн жилүүдэд өөрчлөлт гарсан ба тухайлбал "Шарын Гол" ХК нь Дархан, Эрдэнэт, Сэлэнгийн чиглэлийн дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангадаг бөгөөд нүүрсний нөөц багассан, үйлдвэрлэлийн хэмжээ бууран, хэвийн үйл ажиллагаа нь алдагдсанаар "Багануур" ХК-д нийлүүлэлтээ нэмэгдүүлэх, зах зээл өргөтгөх боломжийг авчирч байсан бол хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орон, технологийн шинэчлэл хийн, олборлолтоо нэмэгдүүлснээр зах зээл дээрх нийлүүлэлтээ хэвийн түвшинд авчирч чадсан байна.

Иймд, нэг талаас төрийн болон орон нутгийн өмчит, хувийн хэвшлийн уурхайнууд хүчин чадлаа өргөтгөн сайжруулах, олборлолтоо нэмэгдүүлэх, дэд бүтцээ бүрэн шийдвэрлэсэн тохиолдолд дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нөгөө талаас дотоодын эрчим хүчний хэрэгцээ, дулааны цахилгаан станцуудын хэрэглээ төвөлөгдсөн хэмжээгээр нэмэгдэхгүй байх нь борлуулалтын өрсөлдөөнийг бий болгох эрсдэлтэй.

Мөн шахмал утаагүй түлшний хэрэглээ, үйлдвэрлэл шинээр бий болох, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн төслүүд амжилттай хэрэгжих нь урт хугацаанд бизнесийн орчин шинэ өрсөлдөөнийг авчрах боломжтой.

0000082





НИЙГМИЙН ЭРСДЭЛ

Улсын уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл төсвийн бүрдүүлэлтэнд голлох үүргийг гүйцэтгэж байгаа энэ үед тухайн салбарын үр өгөөжийг дээшлүүлэхэд ажиллах хүчний нөлөө чухал асуудлын нэг байдаг. Уул уурхайн инженер, техникийн ажилчдын сургалтыг сайжруулах талаар хийсэн судалгаа, судлагдсан байдал хомс байдаг ба хүний нөөцийн асуудал тулгамдаж буй нэг бэрхшээл болсон.

Уул уурхайн салбарт ажиллах мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын байгууллагууд компанийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтыг явуулдаггүй, сургалтын чанар муудсан. Эрдэс баялгийн салбарын дээд боловсролтой мэргэжилтнүүдийг ШУТИС-ийн Геологийн сургууль, Уул уурхайн инженерийн сургууль, Эрдэнэтийн технологийн сургууль, Дарханы технологийн сургууль болон хувийн хэд хэдэн сургууль бэлтгэж байгаа ба гадаадын их дээд сургуулиудад суралцагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа хэдий ч салбарын асар хурдацтай хөгжил, тэлэлтээс шалтгаалан тус салбарт ажиллах дотоодын хүний нөөцийн хэрэгцээ улам нэмэгдэх хандлагатай байгаа нь ажиллах хүчний дутагдалд орох эрсдэлийг бий болгохоор байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРСДЭЛ

Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорх усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлын нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, агаар, ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөллүүд байдаг. Тухайлбал, хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүүрс ба хөрсийг ачиж буулгах, тээвэрлэх зэрэг уурхайлалтын үйл ажиллагааны явцад орчны агаарыг тоосоор бохирдуулах ба уурхайлалтад өртөж эвдэрсэн талбай болон гадаад дотоод овоолгын сул шороо нь салхи шуурганд тоос босох эх үүсвэр болдог бөгөөд орчныг тэр хэмжээгээр бохирдуулдаг.

Уурхайд тэсэлгээ хийх, нүүрсний шаталт явагдах, хүнд даацын машин техникийн хөдөлгүүрээс гарах утаанд угарын хий, азотын дутуу исэл, хүхэрлэг хий, хүхэрт устөрөгч зэрэг хорт хийнүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч хорт хийн бохирдол үүсгэх эрсдэлтэй байдаг. Уурхайн ашиглалтын технологи алдагдах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил хоцрогдож, орон нутгийн байгаль орчин амьдрах орчинд сөрөг нөлөөлөл учруулах нь төслийн үйл ажиллагаанд гарах эрсдэл болно.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ


Багануурын орд газрын 13631А тоот тусгай зөвшөөрөлтэй холбоотой буюу уг зөвшөөрлийн анх олгогдсон талбайгаас хасагдсан 1,181.16 га талбайг хамарсан талбайтай холбоотой маргаан 2008 оноос хойш өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.

Анх 2006 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр "Алтай Голд" ХХК-д АМГТХЭГ /хуучин нэрээр/-ын Геологи уул уурхайн кадастрын албанаас хайгуулын 12164Х тоот, 2007 он 11 дүгээр сарын 15-нд ашиглалтын 12959А тоот тусгай зөвшөөрөл олгосон. Гэвч тус компанийн 12959А тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байсан 13631А тоот тусгай зөвшөөрөлд хамаарах талбайтай давхацсан ба 2008 оны 4 дүгээр сард АМГТХЭГ-аас Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хязгаарын батлагдсан хүрээнд орсон гэх үндэслэлээр "Алтай Голд" ХХК-ийн ашиглалтын холбогдох зөвшөөрлийг хүчингүй болгосон. Харин 2008 оны 6 дугаар сард "Алтай Голд" ХХК нь АМГТХЭГ-ын шийдвэрийг хүчингүй болгуулахаар Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд хандсан бөгөөд 2008 оны 9 сард шүүхээс АМГТХЭГ-ын шийдвэрийг хүчингүй болгож 12959А тусгай зөвшөөрлийг "Алтай Голд" ХХК-д буцаан олгожээ.

2010 оны 9 дүгээр сарын 1-нд "Алтай Голд" ХХК нь 12959А тоот тусгай зөвшөөрлийг "Алтайн Гянт" ХХК-д шилжүүлсэн байна. "Алтайн гянт" ХХК-ийн эзэмшиж байсан 12164Х, 12959А тусгай

0000083





зөвшөөрлүүдийн хувьд Төв аймгийн Баяндэлгэр сумын Баруун хонхор нэртэй газарт олгогдсон байх бөгөөд "Багануур" ХК-ийн 13631А тоот тусгай зөвшөөрөл нь Улаанбаатар хотын Багануур дүүргийн Нарийны тал нэртэй газар олгогдсон боловч эдгээр газрууд нь газар нутгийн хувьд давхцалд оршдог болохоос үүдэн дээрх маргаан дахин үргэлжилсэн.

"Багануур" ХК-аас 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тусгай зөвшөөрлүүдийн талбай давхацсан талаар нэхэмжлэл гарган, тус нэхэмжлэлийг шүүх хүлээн авч 2012 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Захиргааны хэрэг үүсгэх тухай захирамж гаргасан бөгөөд тус хэрэгт хариуцагчаар АМГ-ын Геологи уул уурхайн кадастрын хэлтэс, гуравдагч этгээдээр "Алтайн Гянт" ХХК оролцох болсон байна.

"Багануур" ХК-ийн нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр болсон ба тус шүүхийн шийдвэр хариуцагчийн талд буюу нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл дээрх хоёр компанийн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд үүссэн давхцлын асуудал бүрэн шийдэгдээгүй.

Гэсэн ч "Алтайн гянт" ХХК-ийн 12959А тоот зөвшөөрлийг 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 616 дугаар захирамж гарган Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14, 11.1.15, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4, Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01 тоот албан даалгавар, Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 23-ны 615 өдрийн тушаалын дагуу дээрх тусгай зөвшөөрлийг анх олгохдоо хууль зөрчиж, илт хүчин төгөлдөр бус актаар олгогдсон гэж үзэн хүчингүй болгосон байна.

"Алтайн гянт" ХХК нь 2012 оны 11 дүгээр сараас 2015 оны 6 дугаар сарын хооронд 12959А тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон АМГ-ын шийдвэрийг хүчингүй болгуулахаар холбогдох шүүхэд удаа дараа нэхэмжлэл гаргаж байсан байна. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 7477 тоот шүүгчийн захирамжаар Үнэт цаас гаргагч компанийг тус захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр татан оролцуулахаар шийдвэрлэсэн бөгөөд тухайн хэргийн шүүх хурал нь 2016 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр болж нэхэмжлэгчийн буюу "Алтайн Гянт" ХХК-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Дээрх шийдвэрийг үл зөвшөөрөн "Алтайн Гянт" ХХК-аас Нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр гомдол гаргасан ба давж заалдах шатны шүүхээс гомдлыг хянаж үзээд Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэгчийг хоён хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн гэж үзэн хэргийг хэрэгсэхгүй болгосныг үндэслэлгүй хэмээн дүгнэж анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Монгол улсын Засгийн газар нь 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 392 тоот тогтоолоор Багануур дүүргийн Нарийны талд орших Баруун хонхор L-49-1 нэртэй 1,181.16 га талбайг нөөцөд авсан ба тус талбайд Багануурын орд газрын 430.2 сая тонн нүүрсний нөөц хамаардаг байна.

Компани нь дээрх нийт хугацаанд хэрэг маргаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцож байсан бөгөөд шүүхээр маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа тул энэхүү талбайтай холбоотой тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрсдэл хэвээр байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Компанийн үйл ажиллагаанд нүүрсний уналаас хамаарсан уурхайн гүнзгийрэлт, гүний усны хүндрэл, дотоод овоолгын гулсалт болон дотоод овоолгын багтаамж, тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан, насжилтаас шалтгаалсан эвдрэл, сул зогсолт их гарах болсон зэргээс хамаарсан үйл ажиллагааны эрсдлүүд байна.

0000084



(Handwritten signature)

Уурхайн Уулын 1-р хэсгийн талбайд ашиглалт эрчимтэй явагдаад 38 жил болж байгаа бөгөөд одоогоор 100-125м-ийн гүнд олборлолт явуулж байна. Уурхай гүнзгийрч хөрс хуулалт ихсэх хандлага жилээс жилд нэмэгдэж 2015 оны байдлаар хөрс хуулалтын коэффициент 5.1 м³/тн хүрээд байна.

Уурхайн үйл ажиллагааг саадгүй явуулахын тулд гүний усны түвшинг нүүрсний давхаргаас доош барих шаардлагатай байдаг. Уулын ажил гүнзгийрэх тусам гүний усыг зайлуулахад хүндрэл гарч байна. Ордын уст давхаргын агуулагч чулуулаг нь сул цементлэгдсэн элсэн чулуу, ус үл нэвтрэх аргиллит, алевролитаас тогтдог. Багануурын уурхайн хөрөнгө санхүүгийн хүндрэлээ шалтгаалж бил бүр төлөвлөсөн шүүрүүлэх цооногийн ашиглалтанд оруулж чадаагүйгээс уурхайн хамгийн гүн хэсэг буюу Уулын 1-р хэсэг гүний усны хүндрэлд ороод байна. Гүний усыг зайлуулж чадахгүй байгаагаас үүдэн Уулын 1-р хэсэгт гүний усны хүндрэл үүсч, нээгдсэн нүүрсийг олборлож чадахгүйд хүрэх эрсдэлтэй.

Багануурын уурхайд 1980-аад оны дунд үеэс уурхайн ашиглалтын төсөлд заасан технологийн горимыг нилээд өөрчилснөөс дотоод овоолгын даац хэтрэн үүнээс үүдэн гарсан гулсалт нь уурхайн тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Овоолгын гулсалт нь овоолгын суурийн бэлтгэл ажил ба тэгш бус гадарга, овоолгын багтаамжийн хэтрэлт гүний усны хүндрэлээс үүдэн гарч байна. Үүнээс гадна овоолгын тогтвортой байдал, гулсалт нь цаг хугацаа ба хөрсний чулуулгийн деформацид орох хувийн шинж чанарын хоорондын хамаарлаас шалтгаалж байна. Овоолгын гулсалтаас болж нээгдсэн нүүрс хөрсөнд дарагдах, түрэгдэн дээш гарах зэрэг хүндрэлүүд үүсч, улмаар олборлолтын ажилд бэрхшээл учирч, гулссан хөрсний хэмжээгээр уулын ажил дахин хийх зайлшгүй шаардлага тулгаран цаг хугацаа, эдийн засаг, технологийн төлөвлөөгүй хор хохирлуудад хүргэж байна.

Компанид одоогийн байдлаар ОХУ-д үйлдвэрлэсэн алхагч экскаваторууд ЭШ, шууд утгуурт экскаваторууд ЭКГ, уурхайн дотоод тээвэрт Белаз, АНУ-ын Катерпиллар, Япон улсын Комацу, Англи улсын Терекс зэрэг 45-90 тонн даацтай автосамосвалууд, ерөмдлөгт ОХУ-ын СБР, АНУ-ын Сэндвик фирмийн D-50ks өрмийн машинууд зэрэг уулын үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. Зарим тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан, насжилтаас шалтгаалсан эвдрэл, сул зогсолт их гарах болсон зэргээс хамаарсан хүндрэлтэй асуудлууд тулгараад байна.

1.15.2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компани нь өөрийн боловсруулсан эрсдэлийн удирдлагын тогтолцоогоор дамжуулан үүсч болох эрсдэлүүдийг удирдахаар зорин ажилладаг ба эрсдэлийн удирдлагын бүтэц нь дараах хэлбэртэй байна.


Зураг 20: Эрсдэлийн удирдлагын бүтэц



Компанийн дүрмийн 14.1-д Компанийн хяналтын тогтолцоо нь (i) өмчлөгчийн хяналт, (ii) дотоод хяналт, (iii) хөндлөнгийн аудит гэсэн бүтэцтэй байхаар заасан байна. Өмчлөгчийн аудитыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлдэг ба Компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнадаг байна.

000008





Аудитын хороо нь 5 гишүүнтэй ба дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах.

Дотоод хяналт, шалгалтын алба нь дарга, 2 ажилтантай бөгөөд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тогтмол явуулан, үр дүнг Компанийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулдаг бөгөөд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

- Монгол улсын хууль тогтоомж, дүрэм, журмууд удирдах дээд байгууллагын шийдвэр, Компанийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, гэрээ, эрх зүйн акт, Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрийн биелэлт;
- Хүний нөөцийн бүрдүүлэлт, хөдөлмөрийн сахилга батын зөрчил, ёс зүй, ажлын үр дүн;
- Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналт тавих нэгж, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавих;
- Компанийн удирдлагаас тогтоосон баримт бичгийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын байдал;
- Нүүрсний чанар, байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлтэнд хяналт тавих ажлыг төлөвлөгөөний дагуу хийж байгаа эсэх;
- Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хамгаалалт, санхүү, нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагаа;
- Сонирхлын зөрчлийн баримтууд;
- Хараат болон охин компаниудын үйл ажиллагаа.

Аудитын хороо нь Компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрхзүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох, хянах ажиллагааг явуулах эрсдэлийг бууруулах, удирдамж бодлогыг тодорхойлдог ба Дотоод хяналт, шалгалтын албаны үйл ажиллагаанд үнэлэлт өгч ажилладаг байна.


Компанийн дотоод хяналт, шалгалтын албанаас хийсэн чанарын шинжилгээний үр дүнгээс харахад Компанийн хөрс хуулалтын хоцрогдол, гүний ус шүүрүүлэлтийн хоцрогдол, авто самосвалын хүрэлцээгүй байдал, нүүрсний уналын өнцөг их байх, тоног төхөөрөмжүүдийн насжилт ихэссэн зэргээс шалтгаалсан эрсдэлээс хамгаалах зөв удирдлага нь шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдэх асуудал байна. Цэвэр мөнгөн хөрөнгө хомсдолтой энэ үед хөрөнгө оруулалтыг урт хугацаат зээл болон хувьцааны санхүүжилтээр хийх боломжтой юм.

Уурхайд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга замуудыг Компаниас тодорхойлсон байна.

- Нүүрсний үнийг чөлөөлүүлэх, алдагдалгүй ажиллах хэмжээнд хүргэх саналыг Эрчим хүчний зохицуулах хороонд дахин хүргүүлэх, шийдвэрлүүлэх;
- Дулааны цахилгаан станцуудаас авах авлагын дээд хэмжээ, авлага төлөгдөх эцсийн хугацааг станцуудтай харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоож авлагын дээд хэмжээ, хугацаа хэтэрсэн тохиолдолд нүүрс нийлүүлэхгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Санхүүжилтийн хямд эх үүсвэрийг судлах, толгой компанитай хамтран санал боловсруулсны үндсэн дээр татаас, бага хүүтэй, урт хугацаатай зээл татах саналыг хэрэгжүүлэх;
- Ус шүүрүүлэх станцыг яаралтай гадны эх үүсвэрээр санхүүжүүлэн нүүлгэн шилжүүлэх;
- Валютын ханшийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тул худалдан авалтыг гадаад валютаар хийхгүй байх, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулж байгаа гэрээнд үнийн өөрчлөлт хийх тодорхой нөхцөлүүдийг нарийн тусгах;
- Зуны улиралд алхагч экскаваторуудын фронтыг бэлдэх;

0000086





- Хөрс хуулалтын хоцрогдлыг 1 сая м3 түүнээс доошгүй хэмжээгээр бууруулах арга хэмжээний гүйцэтгэлийн үүргийг гүйцэтгэх үүргийг бууруулах.

0000087





ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

2.1. НЭМЖ ГАРГАХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч	"Багануур" ХК
Бүртгэгдсэн бирж	Монголын Хөрөнгийн Бирж
Хувьцааны код	BAN
Үнэт цаасны бүртгэл	Хувьцаа нэмж гаргах
Нийт хувьцааны тоо	30,844,647 ширхэг
Хувьцааны төрөл	Энгийн
Нэрлэсэн үнэ	100.0 (нэг зуун) төгрөг
Нэмж гаргаж буй хувь	32%
Нэмж гаргаж буй хувьцааны тоо	9,870,287 ширхэг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	26,156,260,550.0 төгрөг
Хувьцааг анхдагч зах зээлд байршуулах	Нэмж гаргаж буй хувьцааг 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр хувьцаа эзэмшиж буй Хувьцаа эзэмшигчдэд эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд санал болгоно. Нэмж гаргаж буй хувьцааны тэргүүн ээлжинд хэрэгжээгүй үлдсэн хэсгийг олон нийтэд санал болгон худалдана.
Тэргүүн ээлжинд санал болгох үнэ	Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд санал болгох үнэ 2,650 төгрөг
Олон нийтэд санал болгох үнэ	Хувьцааг олон нийтэд санал болгох үнэ 2,650 төгрөг байна
Үнэт цаасны арилжаа явуулах арга хэлбэр	Захиалгын бүртгэлийн арга
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт
Андеррайтерын үүрэг	Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгосон үнэт цаасыг худалдан аваагүй нөхцөлд тухайн үнэт цаасыг гэрээгээр тохиролцсон үнээр худалдан авах баталгаа гаргах
Андеррайтер	Ти Ди Би Капитал ҮЦК

000008





2.2. НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ШИЙДВЭР

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 62.1.3 дугаар заалт, Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоол, "Багануур" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6. дахь заалтыг үндэслэн гаргасан "Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 03 тоот тогтоолоор Компани нь нийт 9,870,287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоон/ ширхэг хувьцааг нэмж гарган, Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсэн байна. Мөн өдрийн 05 тоот хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор нэмж гаргасан хувьцааг гаргах, хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд арилжаалах эрхийг, 06 тоот тогтоолоор нэмж гаргасан хувьцааны үнийг тогтоох эрхийг тус тус Компанийн төлөөлөн удирдах зөвлөлд олгосон.

2.3. ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

2.3.1. ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Үнэт цаас эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан хувьцаа эзэмшигчийн дараах эрх эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар Компанийн ТУЗ (байхгүй бол ХЭХ)-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах
- Компанийг татан буугдахад хүрвэл Компанийн тухай хуульд заасан журмын дагуу компанийн ер төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх
- Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах

ХЭХ-аар доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндэслэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компаниас эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй. Үүнд:

- Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх
- ТУЗ-өөс их хэмжээний хэлцлийг санал нэгтэй баталж чадаагүйгээс ХЭХ-аар шийдвэрлэх
- Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөнөөс Компанийн энгийн хувьцаа эзэмшигч, компанийн тухай хуулийн 89.1-д заасан этгээд эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдээр компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах
- Хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй
- Өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжих, захиран зарцуулах
- Компанийн дүрэмд заасан бусад эрх

0000089





2.3.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ээс баталсан журамд заасны дагуу дараах нийтлэг үүрэг хүлээнэ. Үүнд:

- Компанийн тухай хуульд зааснаас доошгүй хараат бус гишүүнтэй байх
- Үнэт цаасны танилцуулгад заасан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх
- Хагас жилийн болон СЗХ-нд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд СЗХ болон МХБ-д хүргүүлэх
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх мэдээллийг СЗХ-оос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх
- ХЭХ-ын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор СЗХ, МХБ-д хүргүүлэх
- Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх
- Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх
- Өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх
- ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг хуваарилах
- Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч дор дурдсан мэдээллийг үнэ төлбөргүйгээр сонирхсон этгээдэд өгөх үүрэгтэй. Үүнд:
 - Үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэл
 - Үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд заасан үнэт цаас гаргах, үнэт цаасыг арилжих журам
 - Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
 - Хороо, хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон болон үнэт цаасыг арилжих журамд нийтэд мэдээлэхээр тусгасан мэдээлэл
- Компанийн тухай хуульд заасан компанийн бусад үүргийг хүлээнэ.

2.3.3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Компани болон хувьцаа эзэмшигч нь дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ
- Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй
- Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.
- Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

0000090





2.4. ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

2.4.1. ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 70 тоот тогтоол, Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 330 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Компанийн 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 03, 05, 06 тоот тогтоолууд, 2016 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолуудын дагуу Компанийн шинээр нэмж гаргаж буй хувьцааг дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаална. 2016 оны 4 дүгээр сарын 11-ний бүртгэлийн өдрөөр компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг санал болгон арилжаалах ба тус эрхийг хэрэгжүүлсний дараа үлдэх хувьцааг олон нийтэд санал болгон арилжаална.

2.4.2. ҮНЭТ ЦААСЫГ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ХЭЛБЭР

Компанийн хувьцааны 32% буюу нийт зарласан хувьцаанаас 9,870,287 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгох бөгөөд дараах хэлбэрээр зах зээлд байршуулна.

Зураг 21: Үнэт цаасыг зах зээлд байршуулах хэлбэр



2.4.3. ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор компанийн нэмж гаргаж буй 9,870,287 ширхэг хувьцааг олон нийтэд нээлттэй арилжихаас өмнө 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар Компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх, тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны үнэд хөнгөлөлт эдлүүлэхгүй байхаар тогтоосон.


Иймд, Компанийн бүртгэлийн өдрөөрх хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалтыг үндэслэн Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 24 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-иас нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журмын дагуу эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах боломжтой.

2.4.4. ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХЫГ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг шийдвэрлэн, нэмэлт хувьцааг гаргах болсонтой холбогдуулан Компанийн 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэн байна.

0000091





Иймд, Компанийн бүртгэлийн өдрөөрх хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь заалтыг үндэслэн Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 25 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмын дагуу шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай хүсэлтийг Компанид хүргүүлнэ.

2.4.5. ҮНЭТ ЦААСЫГ ОЛОН НИЙТЭД АРИЛЖААЛАХ ЖУРАМ

Андеррайтер нь Компанийн нэмж гаргаж буй хувьцааг Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 26 тоот тогтоолоор баталсан "Багануур" ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалах журмын дагуу олон нийтэд арилжаалах үйл ажиллагааг явуулна. Мөн Компанийн нэмж гаргаж буй хувьцааг МХБ-ээр дамжуулан олон нийтэд арилжаалахдаа МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 5 дугаар зүйлд заасны дагуу "Захиалгын үнийн арга"-аар олон нийтэд санал болгоно.

2.4.6. ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ, АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ

Нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгох, анхдагч зах зээлд байршуулах ажлыг дараах дарааллаар зохион байгуулна. Үүнд:

- T-1 буюу анхдагч зах зээлийн арилжааны өмнөх ажлын өдөрт Компанийн бүртгэлийн өдрөөр хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг хүсэлтийн дагуу ҮЦТХТ ХХК-аар дамжуулан гүйцэтгэх буюу нэр заан эзэмшүүлнэ.
- T, T+1 буюу анхдагч зах зээлийн арилжааны өдрүүдэд олон нийтэд санал болгох арилжааг Андеррайтераас тогтоосон өдрүүдэд Монголын хөрөнгийн биржийн арилжааны цагаар явуулна.

Зураг 22: Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц




Олон нийтэд мэдээлэх, танилцуулах аян зохион байгуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалахыг зөвшөөрсөн МХБ болон СЗХ-ны зөвшөөрөл гарсны дараа үнэт цаасыг нийтэд санал болгох тухай нийтэд мэдээлэх, танилцуулах аяныг зохион байгуулах ажлыг эхлүүлнэ. Үнэт цаасыг нийтэд санал болгох стратеги, маркетинг сурталчилгаа хийх, танилцуулах аяныг маркетингийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.


Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаасны захиалгыг үнэт цаасыг олон нийтэд танилцуулж эхэлсэн өдрөөс эхлэн БДК-иудаар дамжуулан авч анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна. Андеррайтер нь хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаа эргүүлэн худалдан авах өдөр, тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх эдлүүлэх өдөр, олон нийтэд хувьцаа санал болгох анхдагч зах зээлийн арилжааг явуулах өдрийг МХБ, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай хамтран тогтоож, СЗХ-оос зөвшөөрөл авсан байх ба тус өдрүүдийн цагийн хуваарийг МХБ-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

0000092



(Handwritten signature)



Зураг 23: Үнэт цаасыг зах зээлд байршуулах төлөвлөгөө



ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦОО

Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хувьцаа эзэмшигч нь дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Хүснэгт 32: Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх хэрэгжүүлэх хугацаа

Гүйцэтгэх ажил	Тасалбар болох сүүлийн огноо
1 "ҮЦТХТ" ХХК-д өөрийн хувьцааны дансаа идэвхижүүлсэн байх	Анхдагч зах зээлийн арилжаа явагдахаас ажлын 2 хоногийн өмнө
2 Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар эрх бүхий шийдвэр гаргуулан хүсэлтээ холбогдох баримтын хамт Компанид хүргүүлэн баталгаажуулах	Анхдагч зах зээлийн арилжаа явагдахаас ажлын 2 хоногийн өмнө
3 Компанийн тухайлан заасан банкин дахь үнэт цаасны төлбөр тооцооны дансанд худалдан авах хувьцааны үнийг холбогдох шимтгэл (үнийн дүнгийн 0.1 хувь)-ийн хамт шилжүүлсэн байх	Анхдагч зах зээлийн арилжаа явагдахаас ажлын 2 хоногийн өмнө

Компани нь тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах хүсэлтээ холбогдох төлбөрийн баримтын хамт ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг гарган "ҮЦТХТ" ХХК-д хүргүүлэн, холбогдох өмчлөх эрхийн бүртгэл буюу нэр заан эзэмшүүлэх гүйлгээг хийлгүүлнэ.


Хувьцаа эзэмшигч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Компанийн заасан банкин дахь үнэт цаасны төлбөр тооцооны дансанд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийн дагуу худалдан авах хувьцааны үнийн дүн болон холбогдох шимтгэлийг шилжүүлэх боломжтой.

Хүснэгт 33: Тэргүүн ээлжийн эрх хэрэгжүүлэхтэй холбоотой хувьцааны мөнгө шилжүүлэх мэдээлэл

Хэнээс	Нэр
Орлого хүлээн авагчийн нэр	"Багануур" ХК
Хүлээн авагчийн банк	Худалдаа, хөгжлийн банк
Дансны дугаар	499241441
Төлбөрийн зориулалт	Хувьцааны үнэ + шимтгэл

0000093





ШИНЭЭР ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ХҮСЭЛТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦОО

Шинээр хувьцаа худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь дараах ажлуудыг гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Хүснэгт 34: Шинээр хувьцаа эзэмшихтэй холбоотой төлбөр тооцоо гүйцэтгэх хугацаа

Гүйцэтгэх ажил	Тасалбар болох огноо
1 БДК-аар дамжуулан "ҮЦТХТ" ХХК-д өөрийн нэрийн дансыг нээлгэсэн эсвэл идэвхижүүлсэн байх	Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө
2 Хувьцаа худалдан авах захиалгаа өөрийн БДК-д өгсөн байх	Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө
3 Хувьцаа худалдан авах төлбөр буюу мөнгөн хөрөнгөө холбогдох шимтгэл (тухайн БДК-ийн шимтгэлийн хамт)-ийн хамт "ҮЦТХТ" ХХК дахь өөрийн нэрийн данс руу шилжүүлсэн байх	Анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс ажлын 1 хоногийн өмнө

"ҮЦТХТ" ХХК болон "Арилжааны төлбөр тооцоо" ХХК нь хувьцааны мөнгөн төлбөр нь бүрэн байршсан хөрөнгө оруулагчдын дансны мэдээллийг МХБ рүү анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө хүргүүлэх ба Андеррайтерын компани нь МХБ-тэй хамтран тус хөрөнгө оруулагчдын захиалгыг нийлүүлэх ажиллагааг анхдагч зах зээлийн арилжаа хаасны дараа явуулан, холбогдох тайлан мэдээг СЗХ -нд хүргүүлнэ.

Мөнгөн хөрөнгө байршуулах

Шинээр хувьцаа худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь өөрийн нэрийн дансандаа мөнгөө байршуулах боломжтой.

Хүснэгт 35: Шинээр хувьцаа эзэмшихтэй холбоотой хувьцааны мөнгө шилжүүлэх мэдээлэл

Хэнээс	Нэр
Орлого хүлээн авагчийн нэр	Нэр
Хүлээн авагчийн банк	Арилжааны төлбөр тооцоо
Дансны дугаар	***** 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (үйлчлүүлдэг БДК-аас лавлах)
Төлбөрийн зориулалт	Хувьцааны үнэ + шимтгэл

Арилжааны шимтгэл

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалгаа өгсөн БДК-д төлөх ба уг шимтгэлд МХБ, Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон БДК-ийн шимтгэлийн нийт дүн багтсан байна. МХБ-ийн гишүүн БДК-уудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.3.1-т заасан "ногдол ашгийн орлого"-ын нийт дүнгээс, 16.8-д заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого"-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан хэмжээгээр албан татвар төлнө.

Валютын ханш

Үнэт цаасны арилжаа нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

0000094



2.5. НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗОРИЛГО



2.5.1. ҮНЭТ ЦААС ГАРГАЖ ХУРИМТЛУУЛСАН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Компани нь улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 43 орчим хувийг дангаар хангадаг тэргүүлэх эрчим хүчний нүүрс олборлогчийн хувьд тасралтгүй өсөн нэмэгдэх нүүрсний хэрэглээг найдвартай хангах үүрэг хүлээж байдаг. Зөвхөн шинээр ашиглалтанд орох Багануурын ЦС-д нүүрс нийлүүлэхийн тулд Компани 2017 оноос 7.5 сая м3, 2018 онд 10.8 сая м3 хөрс хуулалтын ажил хийх шаардлага үүсэж байна. Уг ажлыг гүйцэтгэхийн тулд нэмэлт хувьцаа гарган татан төвлөрүүлсэн хөрөнгөөр тухайн ажилд зайлшгүй шаардагдах техникүүдийг худалдан авах, угсралт туршилтын ажлыг 2016 онд хийж дуусган, 2017 оноос бүрэн хүчин чадлаар ажиллуулахаар төлөвлөсөн.

Хөрөнгө оруулалтаар авах тоног төхөөрөмжийн сонголт, үнийн таамаглалыг Компанийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж буй "Runge Pincok Minarco" компанийн судалгаанд үндэслэн тооцсон.

Хүснэгт 36: Нэмэлт хувьцаанаас төвлөрүүлэх хөрөнгийн эх үүсвэрээр хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

№	Хөрөнгө оруулалтын нэр	х/н	Ажлын хэмжээ	Нэгж үнэ (мян.төг)	Нийт үнэ (мян.төг)	Тайлбар
1	Экскаватор /15м3/	шир	1	8,322,593.60	8,322,593.60	Хүчин чадал өргөтгөл
2	Хөрс тээврийн автосамосвал /100тн/	шир	4	2,331,753.40	9,327,013.70	Хүчин чадал өргөтгөл
3	Нүүрс тээврийн автосамосвал /60тн/	шир	2	1,800,000.00	3,600,000.00	Хүчин чадал өргөтгөл
4	Тэсэлгээний өрмийн машин /224мм/	шир	1	2,750,000.00	2,750,000.00	Хүчин чадал өргөтгөл
5	Гинжит Бульдозер	шир	1	1,930,988.50	1,930,988.50	Хүчин чадал өргөтгөл
6	Туршлага судлах, дадлага сургалт				69,404.20	Хүчин чадал өргөтгөл
НИЙТ ДҮН					26,000,000.00	

Дээр дурьдсан тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэгч эсвэл тэдгээрийн Монгол улс дах дистрибьютор компаниуд (Моннис Майнинг Экуйпмент ХХК, Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК, Трансвест Монголия ХХК, Сандвик Монголия ХХК гэх мэт)-аас худалдан авах боломжтой бөгөөд Компани нь тоног төхөөрөмжийн худалдан авалтын үйл ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу зохион байгуулна.

2.5.2. ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

2.5.2.1. Уулын ажлын төлөвлөлт


Уулын ажлын төлөвлөлтийг Minex программ дээр уурхайн оновчлолыг хийж ордын хүрзэн дэх нөөцөд тулгуурлан хийсэн. Уурхайн ашиглалтын 1-р хэсэг нь 100-125 метрийн гүнд олборлолт явуулж байгаа бөгөөд нүүрсний уналаас хамаарсан уурхайн гүнзгийрэлт, гүний усны хүндрэл, дотоод овоолгын гулсалт болон дотоод овоолгын багтаамж зэргээс хамаарсан хүндрэлтэй олон асуудлуудыг ойрын жилүүдэд шийдвэрлэх зорилгоор уулын ахилтын чиглэлийг хойноос урагш ахихаар өөрчлөн ордын хойд хэсгээс нүүрс олборлолтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Цаашид урт хугацаанд уулын ажлын чиглэлийг хойноос урагш, дан тээвэртэй ашиглалтын системээр нүүрс нээж ашиглагдсан орон зайд автын овоолгыг төлөвлөн нөхөн дүүргэлтийн ажлыг хийж, уурхайн хүчин чадлыг 10.0 сая тоннд хүргэхээр төлөвлөсөн байна. Ашиглалтын 2-р хэсэг нь 55-85 метрийн гүнд олборлолт явуулж байгаа бөгөөд нүүрсний унал харьцангуй бага тул тээвэргүй хөрсний доголыг нэмэгдүүлэх боломжтой. Цаашид тээвэргүй хөрс хуулалтын хэмжээг нэмэгдүүлэх замаар хүчин чадлыг өргөтгөж тээвэргүй тээвэртэй ашиглалтын системээр нүүрс нээх ажлыг хийнэ.



000003




Зураг 24: Уурхайн одоогийн ашиглалтын чиглэл



* Kxx – Хөрс хуулалтын коэффициент

Зураг 25: Уурхайн шинэ төлөвлөлтийн чиглэл



Хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээний төлөв байдлаас харахад 2016-2025 оны хооронд жилийн нүүрсний хэрэгцээ 4.0 сая -10.0 сая тонн орчим байх төлөвтэй байна. Уулын 2-р хэсгээс жил бүр 2.0 сая тонн нүүрс олборлож, үлдсэн хэсэг буюу 8.0 сая тонн нүүрсийг Уулын 1-р хэсгээс олборлолт хийхээр тооцож байна. 2017 оноос хойш Уулын 1-р хэсгийн одоо явуулж байгаа талбайн олборлолтын хэмжээг жил бүр бууруулах ба түүнтэй уялдуулан 2016 оноос хөрс хуулалтыг эхлүүлсэн ордын хойд хэсгээс нээгдэх нүүрсийг жил бүр нэмэгдүүлэн 2020 онд 8.0 сая.тоннд хүргэх төлөвлөгөөтэй.

2017 оноос Уулын 1-р хэсэгт нүүрсний 3-р давхаргыг баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулснаар уурхайгаас гаргаж байгаа нүүрсэнд агуулагдаж буй органик бус механик хольцыг цэвэрлэн, товарын нүүрсний илчлэг чанарыг дээшлүүлж, үлдэгдэл үнслэгийн хэмжээг багасгаж, зохих хэмжээгээр механик хольцонд байгаа фосфор, азот болон бусад хортой элементүүдийн агууламжийг бууруулж байгаа учир нүүрсний илчлэг чанарын стандартаас илүү гарах боломжийг бүрдүүлнэ.

0000096



Багануурын уурхай нь ирэх 10 жилийн хугацаанд нийт 89.2 сая тонн нүүрс олборлож, 275.7 сая.м3 хөрс хуулах ба хөрс хуулалтын дундаж коэффициент 3.1 м³/тн байна. Уурхайн хойд хэсгээс нүүрсний суналын дагуу олборлолт хийж эхэлснээр гүний усны хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх төдийгүй, хөрс хуулалтын коэффициентыг багасгаж, өртөг зардлыг бууруулна.


Хүснэгт 37: Төлөвлөж буй уулын ажлын хэмжээ

Уулын ажлын нэр	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Хөрс хуулалт	мян.м3	20,315	17,926	21,826	26,777	31,479	31,479	31,479	31,479	31,479	31,479
Нүүрс олборлолт	Мян.тонн	3,750	4,233	7,094	8,879	10,879	10,879	10,879	10,879	10,879	10,879
Нүүрс борлуулалт	Мян.тонн	3,750	4,065	6,465	8,005	10,005	10,005	10,005	10,005	10,005	10,005
Хөрс хуулалтын коэф.	м3/тонн	5.4	4.2	3.1	3.0	2.9	2.9	2.9	2.9	2.9	2.9

2.5.2.2. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнд ашигласан таамаглал үзүүлэлтүүд

Улсын хэмжээнд эрчим хүчний болон дулааны хэрэглээ жил ирэх тутам өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор компани өөрийн хүчин чадлаа өргөтгөх зайлшгүй шаардлагатай болоод байна. Компани нь 2016-2025 онд нийт 384 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. Үүнээс 60 орчим хувь буюу 233 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг эхний 5 жилд, үлдэх 151 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг дараагийн 5 жилд хийнэ. Эхний 5 жилд хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй өндөр байгаа нь Компаниас уурхайн хүчин чадлыг жилийн 10 сая тоннд хүргэхээр зорьж буйтай холбоотой бөгөөд цаашид уурхайн хүчин чадал зорилтот түвшинд хүрснээр шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ буурч тогтворжино.

Зураг 26: Төлөвлөгөөт хөрөнгө оруулалтын хэмжээ



Ирэх 10 жилийн хугацаанд шаардлагатай нийт хөрөнгө оруулалтыг Компанийн нэмж гаргах хувьцаанаас татан төвлөрүүлэх хөрөнгө, ирээдүйн хуримтлагдсан ашиг болон хөнгөлөлттэй нөхцөл бүхий дотоодын болон гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Handwritten signature and red circular stamp of the company.

Red rectangular stamp with text: ТН ДН БН КАПИТАЛ УИХ ХХК, 97, 41115204104, ТӨБ КАПИТАЛ

0000097

Компанийн хүлээгдэж буй нүүрсний нийлүүлэлтийн хэмжээ 2017 оноос эхлэн жилд дунджаар 2 сая тонноор нэмэгдэж, 2020 он гэхэд 10.0 сая тоннд хүрэхээр байна. Нүүрсний нийлүүлэлт нэмэгдэх нь 2018 оноос Багануурын цахилгаан станц, 2019 оноос Дулааны V цахилгаан станц, 2020 оноос Шингэрүүлсэн түлшний үйлдвэр ашиглалтанд орохоор хүлээгдэж буйтай холбоотой.

Хүснэгт 38: 2016-2025 оны нүүрсний борлуулалтын таамаг хэмжээ (мянган тонн)


Хэрэглэгчийн нэр	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Бүгд
Дулааны цахилгаан станцууд (Станцын үнэ)											
ДЦС IY	1,635.0	1,200.0	1,450.0	1,450.0	1,450.0	1,450.0	1,450.0	1,450.0	1,450.0	1,450.0	14,435.0
ДЦС IY баяжуулсан		500.0	500.0	500.0	500.0	500.0	500.0	500.0	500.0	500.0	4,500.0
ДЦС III	1,253.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0	13,403.0
ДЦС II	229.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	2,479.0
Дарханы ДЦС	112.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	1,012.0
Эрдэнэтийн ДЦС		50.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	850.0
Багануур ДС	62.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	647.0
Амгалан ДС	100.0	150.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	2,250.0
Жижиглэнгийн худалдан авагчид (Жижиглэнгийн үнэ)											
Багануур Илч	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	1,000.0
УБТЗ ХНН	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	500.0
Шингэрүүлсэн түлш					2,000.0	2,000.0	2,000.0	2,000.0	2,000.0	2,000.0	12,000.0
Бусад	209.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	2,459.0
Шинээр ашиглалтанд орох үйлдвэрүүд (Концессын үнэ)											
ДЦС-5				540.0	540.0	540.0	540.0	540.0	540.0	540.0	3,780.0
Багануурын ЦС			1,000.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	11,500.0
Багануур ЦС баяжуулсан			1,000.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0	11,500.0
Нийт дүн	3,750.0	4,065.0	6,465.0	8,005.0	10,005.0	10,005.0	10,005.0	10,005.0	10,005.0	10,005.0	82,315.0

Дулааны цахилгаан станцуудад борлуулж буй нүүрсний үнийг Эрчим хүчний зохицуулах хороо хянаж, тогтоож байна. 2018 оноос Багануурын ЦС-ын эхний блок ашиглалтанд орж эхлэхэд нийт борлуулах нүүрсний 31 хувийг тус станцад худалдахаар төлөвлөж байна. 2020 он гэхэд тус станц бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх бөгөөд жилд 3 сая тонн нүүрс худалдан авна. Багануурын ЦС болон 2019 онд ашиглалтанд орох ДЦС-5 -д компани концессын үнээр нүүрс нийлүүлэх ба 2020 онд ашиглалтанд орох шингэрүүлсэн түлшний үйлдвэр, УБТЗ ХНН, бусад жижиглэнгийн худалдан авагчдад жижиглэнгийн үнээр нүүрс борлуулна. Нүүрс борлуулах "станцын үнэ"-ийн өсөлтийг жилийн 1.5%, "жижиглэнгийн үнэ"-ийн өсөлтийг жилийн 2%-аар тооцсон бөгөөд "концессын үнэ"-ийн өсөлтийг станцын үнийн өсөлт болон долларын ханшийн өөрчлөлт, инфляци, UFA индекс ашиглан тооцсон.

Зураг 27: Нүүрс борлуулах үнийн төсөөлөл



0000098




Нүүрсний илчлэгийн дундаж хэмжээг төсөөллийн хугацаанд тогтмол байхаар тооцоолсон баяжуулалтын нүүрсний стандарт илчлэг нь 3360 ккал/Кг, гүйцэтгэлээрх илчлэг нь 3450 ккал/ Кг, илчлэг нь 3918 ккал/ Кг байхаар төсөөлөв.

Хүснэгт 39: 2016-2025 оны нүүрсний борлуулалтын таамаг дүн (сая төгрөг)

Хэрэглэгчийн нэр	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Бүгд
Дулааны цахилгаан станцууд (Станцын үнэ)											
ДЦС IY	46,085.1	50,606.2	58,626.2	59,506.7	60,400.3	61,307.4	62,226.1	63,162.6	64,111.2	65,073.9	591,107.8
ДЦС III	35,317.6	38,623.7	39,204.1	34,593.9	35,113.9	35,641.6	36,177.2	36,720.9	37,272.7	37,832.6	366,498.6
ДЦС II	6,397.5	7,090.0	6,248.9	6,343.8	6,440.1	6,537.8	6,637.0	6,737.7	6,839.9	6,943.6	66,216.2
Дарханы ДЦС	3,067.3	2,781.0	2,444.6	2,462.5	2,521.0	2,560.1	2,599.8	2,640.1	2,680.9	2,722.4	26,499.8
Эрдэнэтийн ДЦС	-	1,428.0	2,519.6	2,557.5	2,596.0	2,635.1	2,674.8	2,715.1	2,755.9	2,797.4	22,679.5
Багануур ДС	618.4	1,862.9	1,644.2	1,668.9	1,693.9	1,719.3	1,745.1	1,771.3	1,797.9	1,824.8	16,546.8
Амгалан ДС	2,823.7	4,299.0	6,323.9	6,416.8	6,515.1	6,612.8	6,712.0	6,812.7	6,914.9	7,018.6	60,451.3
Жижиглэнгийн худалдан авагчид (Жижиглэнгийн үнэ)											
Багануур Илч	3,662.6	3,735.9	3,810.6	3,886.8	3,964.5	4,043.8	4,124.7	4,207.2	4,291.3	4,377.2	40,104.5
УБТЭ ХНН Шингэрүүлсэн түлш	1,831.3	1,867.9	1,905.3	1,943.4	1,982.3	2,021.9	2,062.3	2,103.6	2,145.7	2,188.6	20,052.2
Бусад	7,654.8	9,339.6	9,526.4	9,717.0	9,911.3	10,109.5	10,311.7	10,516.0	10,728.3	10,942.9	96,759.6
Шинээр ашиглалтанд орох үйлдвэрүүд (Концессын үнэ)											
ДЦС-5	-	-	-	19,146.0	17,447.9	16,285.4	15,163.1	14,082.9	13,046.9	12,057.1	137,229.1
Багануур Повер	-	-	66,867.9	103,481.0	106,788.3	110,229.4	113,610.4	117,537.7	121,417.8	125,457.8	865,590.2
Нийт дүн	107,658.5	121,634	199,122	251,746	334,665	342,580	350,740	359,153	367,830	376,780	2,811,909

Компанийн нүүрс борлуулалтын хэмжээ 2017 оноос эхлэн жилд дунджаар 2 сая тонноор нэмэгдэж буйтай холбоотойгоор борлуулалтын орлого жил бүр дунджаар 70 тэрбум төгрөгөөр нэмэгдэн, 2020 он гэхэд 334.7 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Мөн Амгалангийн ДС, Багануурын ДЦС, ДЦС-5, Шингэрүүлсэн түлшний үйлдвэр шинээр ашиглалтанд орсноор нийт борлуулалтад эзлэх хуучин станцуудын борлуулалтын хувь хэмжээ буурч 2018 онд 56%, 2020 онд 32%-д хүрнэ. Ингэснээр компанийн борлуулалтын орлого нь станцын үнээс хамаарах хамаарал буурах боломжтой болно.

Зураг 28: Борлуулалтын орлогын эзлэмж




00000000



Handwritten signature in black ink.

Зураг 29: Борлуулалтын орлогын таамаглал



Компанид 1996-2002 оны хооронд "Монгол нүүрс" төслийн хүрээнд хэрэгжсэн Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны зээлээр хөрөнгө оруулалт хийснээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдээгүй байна. Тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа хэтэрч, насжилт өндөр болсноос өртөг зардлын хэмжээ жилээс жилд нэмэгдэх болсон. Мөн ордын уурхайлалтын чиглэлээс хамааран хөрс хуулалтын дундаж коэффициент 5.1 м³/тн байгаа нь нэгж бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн нэг юм. 2016 оноос тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлт хийгдэж, уурхайлалтын чиглэл өөрчлөгдөн, нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтанд орсноор Компанийн нүүрсний өртөг буурч, цаашид тогтворжих хандлагатай байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт эзлэх голлох зардлууд нь хөрс тээвэрлэлт, нүүрс бутлалт, ачилт, засвар үйлчилгээ болон өрөмдлөг тээсэлгээ байдаг.

Зураг 30: Компанийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн бүтэц




0000300

Handwritten signature and red circular stamp of the company.

100
Handwritten signature and red rectangular stamp.

Төсөөллийн хугацааны эхний жилүүдэд компани алдагдалтай ажиллах хэдий ч 2020 онд санхүүгийн үр дүнгийн үзүүлэлт сайжирч 28 гаруй тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар хүлээгдэж байна. Энэ нь цэвэр ашгийн 9 орчим хувь болох бөгөөд цаашид цэвэр ашгийн борлуулалтын орлогод эзлэх хувь тасралтгүй нэмэгдэж 17 орчим хувьд хүрэхээр байна. Санхүүгийн үр дүнгийн үзүүлэлт ийнхүү сайжирч байгаа нь нэг талаас шинэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхлэн эрчим хүчний нүүрсний хэрэгцээ огцом нэмэгдэх, нөгөөтэйгүүр компани шаардлагатай хэмжээнд тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийн, баяжуулах технологийг нэвтрүүлж, бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжтой болохтой холбоотой юм.

Зураг 31: Ашгийн таамаглал



Компани нь 2020 оноос ашигтай ажиллаж эхлэхээр таамаглаж байгаа бөгөөд 2021 оноос эхлэн өмнөх жилийн цэвэр ашгийн 10 хувийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар төлөвлөж байна. Төсөөллийн хугацаанд компани нийт 20 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тооцоологдсон байна.

2.5.2.3. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

0000101






Хүснэгт 40: Төсөвлөсөн орлогын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Нийт
Борлуулалтын орлого	107,658.5	121,634.3	199,121.6	251,746.3	334,664.9	342,580.4	350,740.0	359,153.2	367,829.8	376,760.1	2,811,909.1
Жилийн өсөлтийн хувь	6.0%	13.0%	63.7%	26.4%	32.9%	2.4%	2.4%	2.4%	2.4%	2.4%	2.4%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(97,528.3)	(108,867.1)	(161,820.1)	(211,866.7)	(244,498.6)	(245,128.6)	(244,895.5)	(242,635.0)	(240,182.3)	(237,965.1)	(2,055,387.3)
Нийт ашиг	10,130.2	12,767.2	17,301.5	39,879.6	90,166.4	97,451.7	105,844.5	116,518.2	127,647.5	138,815.0	766,521.8
Жилийн өсөлтийн хувь	66.2%	26.0%	35.5%	130.5%	126.1%	8.1%	8.6%	10.1%	9.6%	8.7%	8.7%
Нийт ашигийн хувь	9%	10%	9%	16%	27%	28%	30%	32%	35%	37%	37%
Бусад орлого	955.9	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	6,375.2
Удирдлагын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Элэгдлийн өмнөх ашиг	11,086.1	13,368.3	17,903.6	40,481.7	90,768.5	96,053.9	106,446.7	117,120.4	128,249.6	139,417.1	752,897.0
Элэгдэл	(18,728.8)	(24,103.6)	(29,040.9)	(33,976.1)	(39,395.2)	(42,342.7)	(42,766.1)	(43,193.7)	(43,625.7)	(44,061.9)	(361,234.6)
Хорогдол	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Элэгдлийн дараах ашиг	(7,642.6)	(10,734.3)	(11,137.3)	(6,506.6)	(51,373.4)	(55,711.2)	(63,680.6)	(73,926.6)	(84,824.0)	(95,355.2)	(401,662.4)
Жилийн өсөлтийн хувь	(345.4%)	(40.5%)	(3.8%)	(158.4%)	(689.7%)	(8.4%)	(14.3%)	(16.1%)	(14.5%)	(12.7%)	(12.7%)
Э/Ө ашигийн хувь	(7.1%)	(8.8%)	(5.6%)	(2.6%)	(15.4%)	(16.3%)	(16.2%)	(20.6%)	(23.0%)	(25.3%)	(25.3%)
Үйл ажиллагааны бус орлого, зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Санхүүгийн орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Санхүүгийн зардал	(3,553.1)	(6,498.3)	(7,646.1)	(11,097.4)	(14,180.1)	(13,614.6)	(12,277.2)	(11,159.8)	(10,100.6)	(9,258.7)	(99,385.7)
Татварын өмнөх ашиг	(11,196.7)	(17,232.6)	(18,783.3)	(4,991.8)	(37,193.2)	(42,096.6)	(51,403.4)	(62,766.9)	(74,823.5)	(86,096.5)	(302,276.6)
Орлогын албан татварын зардал	0.0	0.0	0.0	0.0	(6,848.3)	(10,074.1)	(12,400.8)	(15,241.7)	(18,180.9)	(21,074.1)	(95,820.0)
Цэвэр ашиг	(11,196.7)	(17,232.6)	(18,783.3)	(4,991.8)	(28,344.9)	(32,022.4)	(39,002.5)	(47,525.1)	(56,342.6)	(65,022.4)	(216,456.6)
Цэвэр ашигийн хувь	(10.4%)	(14.2%)	(9.4%)	(1.6%)	(8.5%)	(9.3%)	(11.1%)	(13.2%)	(15.3%)	(17.3%)	(17.3%)



0000102



Хүснэгт 41: Төсөвлөсөн мөнгөн урсгалын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Нийт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН УРСГАЛ											
Борлуулалтын орлого	107,658.5	121,634.3	199,121.6	251,746.3	334,664.9	342,580.4	350,740.0	359,153.2	367,829.8	376,780.1	2,811,909.1
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(97,528.3)	(108,867.1)	(181,820.1)	(211,866.7)	(244,498.6)	(245,128.6)	(244,895.5)	(242,635.0)	(240,162.3)	(237,965.1)	(2,055,387.3)
Нийт ашиг	10,130.2	12,767.2	17,301.5	39,879.6	90,166.4	97,451.7	105,844.5	116,518.2	127,647.5	138,815.0	756,521.8
Бусад орлого	955.9	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	602.1	6,375.2
Эзлэгдлийн өмнөх ашиг	11,086.1	13,369.3	17,903.6	40,461.7	90,766.5	98,053.9	106,446.7	117,120.4	128,249.6	139,417.1	762,897.0
Ажлын капиталын өөрчлөлт	(6,305.0)	(4,000.0)	(3,000.0)	(2,500.0)	(1,000.0)	-	-	-	-	-	(16,805.0)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ МӨНГӨН УРСГАЛ	4,781.1	9,369.3	14,903.6	37,981.7	89,768.5	98,063.9	106,446.7	117,120.4	128,249.6	139,417.1	746,092.0
Санхүүгийн зардал	(3,553.1)	(6,498.3)	(7,646.1)	(11,097.4)	(14,180.1)	(13,614.6)	(12,277.2)	(11,159.8)	(10,100.5)	(9,258.7)	(99,385.7)
Орлогын албан татварын зардал	-	-	-	-	(8,848.3)	(10,074.1)	(12,400.8)	(15,241.7)	(18,160.9)	(21,074.1)	(85,820.0)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН УРСГАЛ	1,228.1	2,871.0	7,257.6	26,884.3	66,740.1	74,365.1	81,768.6	90,718.9	99,968.3	109,084.3	560,886.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН УРСГАЛ											
Хөрөнгө оруулалтын	(47,175.5)	(35,908.8)	(42,462.3)	(51,093.3)	(56,001.5)	(29,475.2)	(30,202.5)	(31,890.8)	(30,089.5)	(29,686.4)	(383,985.9)
Цэвэр мөнгөн урсгал	26,000	-	-	-	-	(2,834.6)	(3,202.2)	(3,900.3)	(4,752.5)	(5,634.3)	(20,323.8)
Энгийн хувьцаа	-	-	-	-	-	-	-	-	-	-	26,000.0
Ногдол ашиг	-	-	-	-	-	(2,834.6)	(3,202.2)	(3,900.3)	(4,752.5)	(5,634.3)	(20,323.8)
САНХҮҮГИЙН МӨНГӨН УРСГАЛ											
Богино хугацаат зээл	(4,410.0)	-	-	-	-	-	-	-	-	-	(4,410.0)
Урт хугацаат зээл	(1,423.0)	18,306.1	23,827.6	25,316.4	18,747.2	(15,978.8)	(14,269.1)	(10,140.3)	(7,497.2)	(1,681.2)	35,207.7
Одоо байгаа	(11,423.0)	(11,673.9)	(5,126.0)	(2,535.4)	(2,535.4)	(2,535.4)	(1,822.3)	(1,109.2)	(1,109.2)	(1,109.2)	(40,978.8)
Шинэ	10,000.0	29,980.0	28,953.5	27,851.8	21,282.6	(13,443.4)	(12,446.9)	(9,031.1)	(6,368.0)	(572.0)	76,186.5
САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН УРСГАЛ	(5,833.0)	18,306.1	23,827.6	25,316.4	18,747.2	(15,978.8)	(14,269.1)	(10,140.3)	(7,497.2)	(1,681.2)	30,797.7
ЦЭВЭР МӨНГӨН УРСГАЛ	(25,780.4)	(14,781.7)	(11,377.2)	1,107.4	29,485.7	26,076.6	34,094.7	44,787.6	57,629.1	72,082.5	213,374.3





2.6. НЭМЭЛТ ХУВЬЦААНЫ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

"Үндэсний Реалти" ХХК нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйцэтгэж, үр дүнг 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр "Хөрөнгийн үнэлгээний тайлан" болон "Бизнесийн үнэлгээний тайлан"-аар хүргүүлсэн байна.

Хөрөнгийн үнэлгээг хийхдээ Монгол улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон Үнэлгээний Олон Улсын Стандартыг мөрдлөг болгон ашигласан. Үүнд:

- YОУСтандарт 101 - Үнэлгээний ажлын хамрах хүрээ,
- YОУСтандарт 102 – Хэрэгжилт,
- YОУСтандарт 103 - Тайлагнал,
- YОУСтандарт - Биет бус хөрөнгө,
- YОУСтандарт 220 – Үйлдвэрийн шугам, тоног төхөөрөмж,
- YОУСтандарт 230 – Үл хөдлөх өмч,
- YОУСтандарт 310 – Бизнесийн үнэлгээ,
- YОУСтандарт, Техникийн баримт бичиг 1 – Хорогдуулсан мөнгөн гүйлгээ,
- YОУСтандарт, Техникийн баримт бичиг 2 – Биет хөрөнгийг өртгийн хандлагаар үнэлэх.

Хөрөнгийн үнэлгээний зориулалт

Компанийн нэмэлт хувьцааг зах зээлд гарган арилжаалахаар төлөвлөж байгаатай холбоотойгоор компанийн бизнесийн үнэлгээнд, түүн дундаа цэвэр хөрөнгийн аргаар тооцсон бизнесийн үнэлгээнд мэдээлэл болгон ашиглах зориулалтаар энэхүү хөрөнгийн үнэлгээг хийсэн болно. Хөрөнгийн үнэлгээ нь бизнесийн үнэлгээний зориулалтаар хийгдсэн бөгөөд хөрөнгийн үнэ цэнэ нь зах зээлийн үнэ цэнийн сууриар илэрхийлэгдсэн тул бизнесийн үнэлгээнд ашиглахаас бусад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгах гэх мэт бусад зориулалтаар хэрэглэгдэхгүй.


Хүснэгт 42: Хөрөнгийн үнэлгээний үр дүн

д/д	Дансны нэр	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэлгээ (мянган төгрөг)		
				Орлуулалтын өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
Үндсэн хөрөнгө						
1	Орон байр	114	114	57,177,789.6	23,460,175.7	33,717,613.9
2	Байгууламж	216	216	37,215,931.8	21,876,086.6	15,339,845.2
3	Дамжуулах байгууламж	55	70	6,326,905.4	4,197,575.1	2,129,330.3
4	Эд хогшил	1,696	6,028	2,847,565.0	1,259,988.2	1,587,576.8
5	Ажлын машин	214	325	4,090,966.4	2,193,691.8	1,897,274.6
6	Хүчний машин	305	389	261,940,782.6	188,330,894.4	73,609,888.2
7	Тээврийн хэрэгсэл	85	85	5,290,028.9	2,363,219.6	2,926,809.3
8	Бусад үндсэн хөрөнгө	29	29	65,159.7	43,035.5	22,124.2
9	Холбооны хэрэгсэл	176	263	191,430.0	122,791.1	68,638.9
10	Хэмжих хэрэгсэл	113	115	772,184.4	470,184.0	302,000.4
		3,003	7,636	375,918,743.9	244,317,642.1	131,601,101.8
Биет бус хөрөнгө						
11	Програм хангамж	25	340	452,769.7	137,782.9	314,986.8
12	Газар эзэмших эрх	2	2	-	-	656,858.4
		27	342	452,769.7	137,782.9	971,845.2
Нийт дүн		3,028	7,978	376,371,513.5	244,455,425.0	132,572,946.9

Компанийн зэх зээлийн үнэ цэнийн сууриар илэрхийлэгдсэн үндсэн хөрөнгийн үнэ цэнэ 132.6 тэрбум төгрөг байхаар тооцоологдсон бөгөөд үүнд бусад хөрөнгийн болон орд газрын үнэ цэнэ

000010;





100.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэн, 123.2 тэрбум төгрөгийн өр төлбөр хасагдсанаар цэвэр хөрөнгийн өдөр аргаар тооцсон үнэ цэнэ 105.9 тэрбум төгрөг болсон байна.

Хүснэгт 43: Бизнесийн үнэлгээний үр дүн

д/д	Үнэлгээний арга	Тухайлсан үнэ цэнэ (мянган төгрөг)	Ач холбогдолын хувь	Жинлэсэн үнэлгээ (мянган төгрөг)
1	Цэвэр хөрөнгийн арга	105,916,964.9	0.15	15,887,544.7
2	Цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох арга	43,044,280.5	0.45	19,369,926.2
3	Арилжааны үнийн харьцуулалтын арга	58,425,129.0	0.40	23,370,051.6
Бизнесийн үйл ажиллагааны үнэ цэнэ				58,627,522.6


Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний үнэлгээний өдрөөрх бизнесийн үйл ажиллагааны үнэ цэнийг 58,627,522.6 мянган төгрөг болохыг тодорхойлсон.

Бизнесийн үнэлгээ хийсэн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компанийн энгийн хувьцааны тоо 20,974,360 ширхэг бөгөөд нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг 2795.20 төгрөг байхаар тооцож гаргасан байна.

Тус тайланд үндэслэн Компанийн ТУЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 29 тоот тогтоолоор Компанийн нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгох үнийг 2,650 төгрөгөөр тогтоосон байна.

0000105





ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

3.1 АНДЕРРАЙТЕР

АНДЕРРАЙТЕРЫН ТАНИЛЦУУЛГА

"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь Худалдаа, хөгжлийн банкны 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани бөгөөд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулахаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан, Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн байгууллага юм.

Хөрөнгийн зах зээлд эзлэх байр суурь, амжилттай хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдээс хуримтлуулсан туршлага, олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа, мэргэжлийн өндөр түвшний туршлагатай хамт олондоо тулгуурлан төрийн болон хувийн томоохон аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлж буй стратегийн ач холбогдол бүхий төслүүдэд зориулан санхүүжилт татах, гадаад, дотоодын хөрөнгийн бирж дээр үнэт цаас гаргах ажлыг нь зохион байгуулах, IPO гаргах бэлтгэл үеийн санхүүжилт татах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлэн ажиллаж байна.

"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь байгуулагдсан цагаасаа эхлэн харилцагчиддаа 170 орчим сая ам.долларын санхүүжилтийг бие даан, 3.1 тэрбум ам.долларын санхүүжилтийг олон улсын хөрөнгө оруулалтын банкуудтай хамтран амжилттай татан төвлөрүүлж өгсөн бөгөөд Монголын хөрөнгийн бирж дээр 2015 онд нийт 128.4 орчим тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийж, арилжааны хэмжээгээр дотоодын хөрөнгийн зах зээлийн 23.5 хувийг дангаар эзэлж байна. Мөн өдрөөс өдөрт хөгжин өөрчлөгдөж буй дэлхийн санхүүгийн зах зээлийн орчинд, харилцагчдынхаа хүсэл сонирхолд тулгуурласан өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг зорин ажиллаж, Монголын хөрөнгийн биржтэй шууд холболт хийгдсэн "Ти Ди Би Брокер" онлайн арилжааны системийг амжилттай нэвтрүүлсэн нь компанийн зорилгодоо хүрэх томоохон алхамуудын нэг болсон юм. Тус компанийн мэргэжлийн, хөдөлмөрч хамт олны хичээл зүтгэл болон зах зээлд ялгарахуйц бүтээгдэхүүн үйлчилгээний үр дүнд компанийн нэр хүнд, амжилт улам бүр нэмэгдэж, салбартаа тэргүүлэгч шилдэг байгууллагуудын нэг болоод байна.

АНДЕРРАЙТЕРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч болон "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн хооронд "Андеррайтерын болон зөвлөх үйлчилгээний гэрээ"-ээр хөрөнгийн зах зээлд нэмж үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн андеррайтерийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгээр хангах, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, гэрээгээр тохирсон хөлсийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Тус гэрээний дагуу "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ээс баталсан дүрэм журмуудад зааснаас гадна дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.
- Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

Үнэт цаас гаргагчийн хувьд гэрээний дагуу үйлчилгээг гүйцэтгүүлэхийн тулд Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон ажилтанд шаардагдах ажлын зөвшөөрөл, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, материалыг цаг алдалгүй, нэн даруй гаргаж өгөх болон гаргуулахад туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

0000106



3.2. АУДИТЫН БАЙГУУЛЛАГА



АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

"Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК нь Монгол Улсын Сангийн яамнаас аудит, татвар болон зөвлөгөө өгөх үйлчилгээг Монгол Улсад эрхлэх зөвшөөрөл авч 2001 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Эрнст энд Янг нь дэлхийн 140 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг, 215,000 гаруй ажилтантай олон улсын аудитын компани юм. Монгол Улс болон дэлхийн бусад орнуудаас хуримтлуулсан туршлагадаа түлгүүрлэж Монгол Улсын бизнес, эдийн засгийн хөгжлийг дэмжин ажилладаг. Монгол Улсын уул уурхай, банк, худалдаа болон үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг томоохон компаниуд аудит болон бизнесийн зөвлөгөө авахаар тус компанийг сонгон хамтран ажилласаар ирсэн байна.

"Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлагналд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэхэд нь хамгийн түрүүнд тусалсан байгууллага юм. СТОУС-ын олон сургалтыг анхлан зохион байгуулж, дотоодын олон байгууллагуудтай шилжилтийн үед нь хамтарч ажилласан байна. Тус компани нь Монгол Улсад бүртгэлтэй анхны олон улсын компани ба одоогоор 90 гаруй ажилтантай.

2013 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 190 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллагаар бүртгүүлсэн байна.


АУДИТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргач болон "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК нарийн хооронд 2016 оны 2 дугаар сарын 23-ны өдөр үзэглэсэн Аудитын гэрээт ажлын захидлаар "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК нь Компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн талаарх дүгнэлтийг Монгол улсын Компанийн тухай хуулийн 94-р зүйл, Монгол улсын Иргэний хуулийн 343-р зүйлд тус тус заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд гаргаж өгөх, "Багануур" ХК нь гүйцэтгэх ажилтай холбогдох үнэн зөв мэдээллийг өгөх, Аудитын байгууллагын ажилтнуудыг ажиллах нөхцөл боломжоор хангах, гэрээний дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Аудитын үйлчилгээ үзүүлэгч нь Аудитын олон улсын стандарт, Аудитын тухай Монгол улсын хууль, Аудитын гэрээт ажлын захидлаар хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж, захиалагчийн ажлыг хүлээлгэн өгнө. Тус захидлаар Аудын байгууллага нь хууль тогтоомж, стандартад нийцсэн хөндлөнгийн хараат бус дүгнэлтийг боловсруулах, дүгнэлтийнхээ үнэн зөв байдалд баталгаа өгөх, түүнтэй холбогдон гарсан хариуцлагыг хүлээх үүрэгтэй байна.

Харин Үнэт цаас гаргагчийн удирдлагууд нь аудитын олж тогтоосон буруу тайлангуудыг засахын тулд санхүүгийн тайландаа залруулга хийх, худал хуурмаг мэдээллээр хангахгүй байх, аудитын дүгнэлтээр тайланд засвар оруулсан, хуурамч тайлан гаргаж өгсөн тохиолдолд хууль тогтоомжоор тогтоосон хариуцлага хүлээхээр байна. Мөн дараах үүргийг хүлээж байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв танилцуулах
- Санаатайгаар эсвэл алдааны улмаас бий болсон аливаа буруу мэдээлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх боломжийг олгоход шаардлагатай дотоод хяналт зэргийг тодорхойлох гэх мэт



0000107

3.3. ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА



ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

"Үндэсний реалти" ХХК нь 2007 оны 09 дүгээр сарын 13-нд үүсгэн байгуулагдсан ба Монгол улсын Сангийн яамнаас хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн №19 тоот гэрчилгээ олгосны үндсэн дээр хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааг эрхэлж эхэлсэн. 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтэд тус байгууллагын дүрмийн дагуу гишүүн байгууллагаар элсэн орж тусгай зөвшөөрөл авсан бөгөөд бизнес, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжийн үнэлгээ хийх №007 тоот тусгай зөвшөөрөлтэй.

2012 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 261 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний байгууллагаар бүртгүүлсэн байна.

Тус компанийн эрхэм зорилго нь хөрөнгийн үнэлгээний салбарт нэр хүнд бүхий тэргүүлэгч компани болох явдал бөгөөд компанийн зорилгод хөрөнгийн үнэлгээний ажлыг олон улсын стандарт, онол, практик, туршлагын дагуу Монгол улсын хууль, журамд нийцүүлэн мэргэжлийн түвшинд, чанартай хийж гүйцэтгэх, компанийн үнэлгээчдийн мэргэжлийн үр чадварыг олон улсын түвшинд хүргэх, судалгаа шинжилгээг тасралтгүй хийх, хөрөнгийн үнэлгээний зах зээлд өөрийн байр суурийг бэхжүүлэх зэрэг багтдаг байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгийн үнэлгээ хийх бөгөөд үнэлгээний ажлын зориулалт, зорилгоос хамаарч холбогдох мэргэжлийн дагуу нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн шинжилгээ, татвар, барилгын төсөв зохиох зэрэг чиглэлээр зөвлөх үйлчилгээнүүдийг бусад хамтран ажиллагч байгууллагуудтай гэрээний үндсэнд хамтарч хийж гүйцэтгэж байна.

Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ
- Хөдлөх хөрөнгийн буюу машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, эд хогшлын үнэлгээ
- Бизнесийн үнэлгээ
- Санхүүгийн тайлангийн шинжилгээ хийх
- Бизнес төлөвлөгөө, төсөв, төсөл зохиох
- Хөрөнгийн үнэлгээтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэл, санхүү, татварын гэх мэт зөвлөгөө өгөх
- Хөрөнгийн үнэлгээтэй холбоотой сургалт, сурталчилгааны ажил явуулах
- "Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт"-тэй мэргэжлийн хамтын ажиллагаа


ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Үнэт цаас гаргагч болон "Үндэсний Реалти" ХХК нарын хооронд байгуулсан "Хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийх гэрээ"-ээр хөрөнгийн зах зээлд нэмж үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн үнэлгээчнээр оролцох, Олон улсын үнэлгээний стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмын дагуу үнэт цаас гаргахад шаардлагатай Компанийн хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэх, Үнэт цаас гаргагчийн зүгээс ажлыг хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Тус гэрээний дагуу "Үндэсний Реалти" ХХК нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд зааснаас гадна дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- Олон Улсын Үнэлгээний Стандартад нийцүүлэн хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийх аргыг сонгох
- Хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийхэд шаардлагатай баримт, мэдээллээр хангахыг үйлчлүүлэгчээс шаардах
- Үйлчлүүлэгч хөрөнгийн ба бизнесийн үнэлгээнд шаардлагатай мэдээллээр хангаагүй, үнэлгээчний хараат бус байдалд илтэд нөлөөлсөн, гэрээнд заасан ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй бол хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийхээс татгалзах

0000100





- Гүйцэтгэгч нь хөрөнгийн ба бизнесийн үнэлгээний ажлыг Олон Улсын Үнэлгээний Стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол улсын хууль тогтоомж, болон бусад холбогдох заавар аргачлалын дагуу хараат бус, шударга хийж гүйцэтгэх
- Хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ хийх явцдаа үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдээс авсан баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах
- Үйлчлүүлэгчийн хүсэлтээр хөрөнгийн ба бизнесийн үнэлгээний тайланд тайлбар өгөх

Үнэт цаас гаргагчийн хувьд тус гэрээгээр гүйцэтгэгч байгууллагаас гаргаж өгсөн хөрөнгийн ба бизнесийн үнэлгээний тайлантай танилцах, тайлан хуульд нийцээгүй гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй байхаас гадна үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, хөрөнгийн бодит байдалтай танилцах, хэмжилт хийх боломжийг олгох, компанийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх зэрэг үндсэн үүргүүдийг хүлээж байна.

3.4. ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

"Жи Ти Эс Адвокатс" ХХН нь анх 1999 онд "Жи Ти Эс Партнерс" ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь Монголд хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг анхдагч болсон бөгөөд хожим нэрээ өөрчлөн "Жи Ти Эс Адвокатс" ХХК болсон. 2012 онд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас баталсан бөгөөд тус хуулийн шаардлагын дагуу "Жи Ти Эс Адвокатс" ХХК нь 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдөр "Өмгөөллийн Жи Ти Эс Адвокатс" хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл болон өөрчлөн зохион байгуулагдаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн.

2013 оны 5-р сарын 24-ний өдөр батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15-р зүйл болон 24.3-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11-р сарын 6-ны өдрийн 45-р тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх журам"-д заасны дагуу "Жи Ти Эс Адвокатс" ХХН нь Санхүүгийн зохицуулах хороонд 2014 оны 3-р сард дахин бүртгүүлж, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрхээ баталгаажуулсан болно.

Тус нөхөрлөл нь дотоод, гадаадын хувь хүн болон хуулийн этгээдүүдэд банк, санхүү, хөрөнгийн зах зээл, эрчим хүч, уул уурхай, дэд бүтэц, худалдаа, гадаадын хөрөнгө оруулалт, маргаан шийдвэрлэх, хөдөлмөр эрхлэлт, компанийн эрх зүйн чиглэлээр Монгол улсын хууль тогтоомжийн талаар хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг. 2008 оноос хойш Монгол Улсын Засгийн Газар, Хөгжлийн Банк болон бусад хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдээс олон улсын хөрөнгийн зах зээлд гаргасан үнэт цаасны хэлцэлд гадаад, дотоодын андеррайтерт Монголын хуулийн зөвлөгөө өгч ажиллаж ирсэн арвин туршлагатай.

"Жи Ти Эс Адвокатс" ХХН-д Монгол улсын нэр хүнд бүхий хуулийн сургууль төдийгүй АНУ, Европ болон Азийн орнуудад суралцсан, мэргэшсэн хуульчид ажилладаг. Энэ нь гадаад, дотоодын үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагыг мэдэрч, тэдгээрт нийцсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд илүү дөхөмтэй байдгийн зэрэгцээ бусдаас ялгарах гол онцлог давуу тал болдог байна. Нөхөрлөл нь өндөр мэдлэгтэй, олон жилийн туршлагатай, ажилдаа нарийн мэргэшсэн, ажилсаг хуульчдаас бүрдсэн хамгийн амжилттай ажиллаж буй Монголын хуулийн фирм гэдгээрээ олон улсад танигдсан. Тиймээс ч Ази Номхон Далайн Танхим хэмээх нэр хүндтэй байгууллагаас олгодог Бизнесийн эрх зүйн тэргүүлэх фирм хэмээх шагналыг 2011 оноос хойш жил бүр тасралтгүй хүртсээр байна.

0000100



ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ



Үнэт цаас гаргагч, Андеррайтер болон "Жи Ти Эс Адвокатс" ХХН-ний хооронд 2016 оны 2 дугаар сарын 24-ний өдөр байгуулагдсан "Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ"-ээр хөрөнгийн зах зээлд нэмж үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд Үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.2.2 дахь хэсэгт заасан асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Компани нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон СЗХ-ноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал
- Компанийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх
- Бусадтай байгуулсан бөгөөд одоо хүчин төгөлдөр байгаа худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн, гэрээ болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх
- Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах цуцлагдах аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр Компанийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх
- Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх
- Андеррайтерийн бэлтгэсэн үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх
- Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох
- Компанийн хувьцаа гаргах үйл ажиллагаатай холбогдох Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хууль зүйн үндэслэлийг хянах, зөвлөгөө өгөх

00001



МОНГОЛЫН ХӨРӨНГӨЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
... он ... сар ... өдөр

IX
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 02




EY
Building a better
working world

УЛААНБААТАР ХОТ. "БАЛАНС" ХЭВЦЭАТ КОМПАНИ
2008572
УГМ0000
84822 9111

ТИ ДН БИ КАПИТАЛ ҮЦК ХХК
1115204134
TDB CAPITAL LLC

0000111



**БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ
ОХИН КОМПАНИУД
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)**

**Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан
2015 оны 12 дугаар сарын 31**

0000112



**БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД**



АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3 - 4
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН	8 - 9
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	10 – 58

0000113



БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

**КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**



ЗАХИРЛУУД

- | | |
|---------------|-------------------------|
| Б. Ариунболд | ТУЗ-н дарга |
| Д. Болд | ТУЗ-н гишүүн |
| М. Хуягбаатар | ТУЗ-н гишүүн |
| Г. Мэргэнбаяр | ТУЗ-н гишүүн |
| Д. Нарангэрэл | ТУЗ-н гишүүн |
| Д. Артаг-Уул | ТУЗ-н гишүүн |
| Л. Оюунчимэг | ТУЗ-н гишүүн |
| Д. Цэрэнбадам | ТУЗ-н гишүүн |
| О. Банзрагч | ТУЗ-н гишүүн |
| М. Отгонбаяр | Гүйцэтгэх захирал |
| Ч. Очирлхам | Санхүү эрхэлсэн захирал |

АЛБАН ХАЯГ

- Монгол Улс, Улаанбаатар хот,
Багануур дүүрэг, өөрийн байр

ХАРИЛЦАГЧ БАНКУУД

- Голомт Банк ХХК
Хас Банк ХХК
Худалдаа Хөгжлийн Банк ХХК
Хаан Банк ХХК
Капитал Банк ХХК
Төрийн банк ХХК
Хөгжлийн банк ХХК

АУДИТОР


- Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн Нягтлан Бодогчид

0000114 1



БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭДЭГДЭЛ



Багануур ХК (цаашид "Компани" гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ийн гүйцэтгэх захирал М.Отгонбаяр, миний бие энэхүү тайлангийн 5-58 дүгээр хуудсанд үзүүлсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

М. Отгонбаяр
Гүйцэтгэх захирал

Монгол улс, Улаанбаатар хот
Огноо: 2016.04.26



0000115





Building a better
working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Багануур ХК болон түүний охин компаниудын хувьцаа эзэмшигчдэд

Бид **Багануур ХК** (цаашид "Компани" гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)–ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайлан, өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь удирдлагын хариуцлага байдаг.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага бөгөөд бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудаторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаардаг. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан хязгаарлалттай дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

0000116





Building a better working world



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Багануур ХК болон түүний охин компаниудын хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл

Санхүүгийн тайлангийн тодруулга 22-т үзүүлснээр Группийн уурхайн нөхөн сэргээлтийн санд 1,105,833 мян. төг (2014 онд 1,106,683 мян.төг) бүртгэсэн. Групп уурхайн талбар ба түүнтэй холбогдох үйлдвэрлэлийн барилга байгууламжуудыг буулгаж нөхөн сэргээхтэй холбогдон ирээдүйд гарах зардлуудаар *Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 37* ("НББОУС 37") -ын дагуу сан байгуулах шаардлагатай. Нөхөн сэргээлтийн сан нь ирээдүйд гарахаар хүлээгдэж буй зардлуудын өнөөгийн үнэ цэнийг харуулж байх ёстой. Гэвч Групп 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх уурхайн нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг барагдуулах дэлгэрэнгүй үнэлгээг хийгээгүй ба шаардлагатай уурхайн нөхөн сэргээлтийн санг бүртгээгүй байсан. НББОУС 37-ын шаардлагын улмаас гарах үр нөлөөг бид тооцоолох боломжгүй юм.

Хязгаарлалттай дүгнэлт

"Хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл" хэсэгт тайлбарласан асуудлын нөлөөллүүдийг эс тооцвол бидний дүгнэлтээр 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг СТОУС-уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

ПЕТР МАРКИ
Захирал

Монгол Улс, Улаанбаатар хот


Огноо: **2016 .04. 2 6**

0000117



БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

**ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**




	Тодруулга	2015 мян.төг	2014 мян.төг
Борлуулалтын орлого	4	101,597,119	90,914,261
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5	(95,500,788)	(70,289,307)
Нийт ашиг		6,096,331	20,624,954
Бусад орлого	6	6,030,504	5,458,725
Удирдлагын зардал	7	(5,404,212)	(4,712,467)
Бусад зардал	8	(3,608,603)	(2,487,086)
Санхүүгийн зардал	9	(4,564,383)	(5,070,242)
Хараат компани дахь ашгийн хувь	15	73,340	62,201
Татварын өмнөх ашиг		(1,377,023)	13,876,085
Орлогын албан татварын зардал			
Тайлант жилийн	10	3,217,776	(3,249,007)
Хойшлогдсон		87,869	53,693
		3,305,645	(3,195,314)
Тайлант жилийн татварын дараах ашиг		1,928,622	10,680,771
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		1,928,622	10,680,771
Нэгж энгийн хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашиг (нэгж хувьцаа/төгрөг)	10	92	509



Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно


БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31




ХӨРӨНГӨ	Тодруулга	2015 мян.төг	2014 мян.төг
Эргэлтийн бус хөрөнгүүд			
Уурхайн хөрөнгө	12	36,056,665	24,943,049
Үндсэн хөрөнгө	13	68,560,209	74,371,120
Биет бус хөрөнгө	14	305,256	19,745
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	15	274,044	160,633
Хойшлогдсон татварын хөрөнгө	10	1,292,681	1,204,812
		<u>106,488,855</u>	<u>100,699,359</u>
Эргэлтийн хөрөнгүүд			
Бараа материал	16	14,009,665	14,638,434
Урьдчилж төлсөн зардал ба бусад авлагууд	17	1,900,218	3,531,153
Дансны авлага	18	8,757,079	9,903,323
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19	6,180,440	3,115,309
		<u>30,847,402</u>	<u>31,188,219</u>
НИЙТ ХӨРӨНГӨ		<u>137,336,257</u>	<u>131,887,578</u>
ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨРҮҮД			
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа	20	2,097,436	2,097,436
Хуримтлагдсан ашиг		12,015,922	10,087,300
		<u>14,113,358</u>	<u>12,184,736</u>
Урт хугацаат өр төлбөрүүд			
Засгийн газрын тусламж	21	25,921,662	28,802,632
Сан	22	1,374,486	1,106,983
Ажилчдын тэтгэврийн сан	23	9,547,436	8,014,022
Зээл	24	15,257,382	24,761,651
		<u>52,100,966</u>	<u>62,685,288</u>
Богино хугацаат өр төлбөрүүд			
Дансны болон бусад өглөг	25	44,732,150	32,808,861
Зээллэг	24	23,917,296	18,563,619
Засгийн газрын тусламж	21	2,461,293	2,487,861
Орлогын албан татварын өглөг		11,194	3,157,213
		<u>71,121,933</u>	<u>57,017,554</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨРҮҮД		<u>123,222,899</u>	<u>119,702,842</u>
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨРҮҮД		<u>137,336,257</u>	<u>131,887,578</u>

Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31



	Энгийн хувьцаа мян.төг (Тод.20)	Хуримтлагд сан ашиг мян.төг	Нийт мян.төг
2014 оны 1 дүгээр р сарын 1-нд Тайлант жилийн дэлгэрэнгүй орлого	2,097,436 —	(593,471) 10,680,771	1,503,965 10,680,771
2014 оны 12 дугаар сарын 31-нд Тайлант жилийн дэлгэрэнгүй орлого	2,097,436 —	10,087,300 1,928,622	12,184,736 1,928,622
2015 оны 12 дугаар сарын 31-нд	2,097,436	12,015,922	14,113,358



Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



0000120

БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**



Тодруулга	2015 мян.төг	2014 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
Татварын өмнөх ашиг	(1,377,023)	13,876,085
<i>Тайлант хугацааны ашгийг цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулах мөнгөн бус гүйлгээний залруулгууд</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	13 23,074,284	8,794,631
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	8 63,077	131,136
Санхүүгийн зардал	9 4,619,292	5,194,390
Засгийн газрын тусламжийн хорогдуулга	21 (3,090,896)	(3,215,753)
Тайлант хугацаанд нэмэгдсэн тэтгэврийн сангийн зардал	23 1,722,167	1,571,638
Дансны авлага болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын буцаалт	6 (9,914)	(271,133)
Уурхайн хөрөнгийн шавхагдал	12 755,777	216,362
Хүүний орлого	9 (54,909)	(124,148)
Валютын ханшийн бодит бус гарз (олз) –цэвэр	6, 8 (16,639)	138,742
Нийгмийн хөгжлийн сангийн зардал	22 268,653	–
Найдваргүй авлагын зардал	8 9,950	129,556
Хараат компани дахь ашгийн хувь	15 (73,340)	(62,201)
Бусад авлага данснаас хасалт	8 –	26,931
Биет бус хөрөнгийн хорогдуулга	14 78,938	12,721
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	25,969,417	26,418,957
Ажлын капиталын өөрчлөлтүүд:		
Бараа материалын (өсөлт) бууралт	635,240	(1,985,618)
Дансны авлагын (өсөлт) бууралт	1,146,208	(4,630,312)
Урьдчилж төлсөн зардал болон бусад авлагын (өсөлт) бууралт	1,702,692	(1,448,501)
Дансны болон бусад өглөгийн өсөлт	11,923,289	9,701,063
Үйл ажиллагаанаас орсон мөнгөн урсгал	41,376,846	28,055,589
Төлсөн хүү	(3,166,270)	(3,021,563)
Тэтгэврийн сангийн хэрэгжилт	23 (188,753)	(846,170)
Хүлээн авсан хүүний орлого	9 54,909	124,148
Хараат компаниас хүлээн авсан ногдол ашиг	15 –	62,201
Орлогын албан татвар төлөлт	–	(131,466)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	38,076,732	24,242,739



Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

0000121

БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

БҮРТГЭВ 01
ОН ... сар ... өдөр

ОН ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 02

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

	Тодруулга	2015 мян.төг	2014 мян.төг
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа			
Уурхайн хөрөнгийн нэмэгдэл	12	(11,875,864)	(13,171,567)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	13	(17,326,450)	(8,833,905)
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын өсөлт	15	(40,071)	—
Биет бус хөрөнгийн худалдан авалт	14	(364,449)	(13,231)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		—	76,094
Бусад эргэлтийн бус хөрөнгийн бууралт		—	850,596
Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн хөдөлгөөн	22	(1,150)	(33,300)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн урсгал		(29,607,984)	(21,125,313)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан зээл	24	5,843,972	5,000,000
Эргэн төлсөн зээл	24	(11,264,228)	(14,812,173)
Санхүүгийн үйл ажиллагаанаас (-нд зарцуулсан) орсон цэвэр мөнгөн урсгал		(5,420,256)	(9,812,173)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) өсөлт			
Валютын ханшийн цэвэр өөрчлөлт		3,048,492	(6,694,747)
1 дүгээр сарын 1-ний байдлаарх мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		16,639	1,851
12 дугаар сарын 31-ний байдлаарх мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		3,115,309	9,808,205
Мөнгөн бус гүйлгээ			
	Тодруулга	2015 мян.төг	2014 мян.төг
Уурхайн хөрөнгийн капиталжуулалт	12, 21	—	4,570,555

2014 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд Компанийн нүүрсний нөөцийн геологийн судалгааг гуравдагч этгээд гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны өртөг 4.57 тэрбум төгрөг бөгөөд Уурхайн хөрөнгөнд бүртгэгдсэн (Тодруулга 12-г харна уу). Гэрээний дүн Засгийн газрын тусламжаар санхүүжигдэн (Тодруулга 21-г харна уу) гүйцэтгэгч талд шууд төлөгдсөн.



Хавсаргасан тодруулга нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



00001??



1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Багануур ХК ("Компани") нь Монгол улсад нүүрсний хайгуул, хөгжүүлэлт болон үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

Компани нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй, Монгол Улсад байгуулагдсан, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм. Компанийн албан хаяг Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэгт өөрийн байранд байрладаг.

Компанийн хамгийн том 2 хувьцаа эзэмшигчдийг доор харуулав. Үүнд:

1. Эрдэнэс Монгол ХХК	15,730,770 ширхэг	75%
2. Монголиан Нэшнл Коал Корпорэйшн ХХК	4,416,668 ширхэг	21%

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 26 - ний өдрийн тогтоолоор Компанийн 2015 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн болно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Групп нь уурхайн талбарыг нөхөн сэргээлтийн сангийн дүнг тооцох, үнэлэхдээ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-37 (НББОУС-37) "Сан, болзошгүй өр төлбөр ба хөрөнгө"-ын шаардлагыг дагаж мөрдөөгүйг эс тооцвол Толгой компанийн санхүүгийн тайлангууд болон Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУС)-аас баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн байна.

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Эдгээр санхүүгийн тайлангуудын дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Группийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр, мянганы орноор толилуулсан.

Нэгтгэлийн үндэслэл

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд орсон охин компаниуд:

Охин компаниуд	Үндсэн байршил	Үйл ажиллагаа	Эзэмшлийн хувь	
			2015	2014
Багануур Сувилал ХХК	Монгол Улс	Амралт сувилал	100	100
Багануур Илч ХХК	Монгол Улс	Нүүрс борлуулалт	100	100

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь жил тус бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Группийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ. Охин компаниудын санхүүгийн тайлангуудыг нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлогуудыг ашиглан Толгой компанитай ижил тайлант жилүүдээр бэлтгэсэн.

00001.23





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД**

2.1 **Тайлан бэлтгэх үндэслэл**

Нэгтгэлийн үндэслэл

Групп хүлээн авагчаас хувьсах өгөөжийг хүлээн авах эрхтэй болсон ба өөрийн эрх мэдлийг ашиглан тэдгээр өгөөжид нөлөөлөх чадвартай байгаа үед хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө хүлээн авагч компанийг хянаж байна гэж үзнэ. Тодруулбал дараах шаардлагуудыг бүгдийг нь хангаж байгаа тохиолдолд Групп хөрөнгө хүлээн авагч компанийг хянаж байна гэж үзнэ. Үүнд:

- Хөрөнгө хүлээн авагч компанид эрх мэдэлтэй байх (өөрөөр хэлбэл, хөрөнгө хүлээн авагч компанийн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх өнөөгийн чадварыг олгох хүчин төгөлдөр эрхтэй байх)
- Хөрөнгө хүлээн авагч компани дахь өөрийн хувь оролцооноос хувьсах өгөөж хүртэх эрхтэй байх
- Хөрөнгө хүлээн авагч компани дахь өөрийн эрх мэдлийг ашиглан өөрт ногдох өгөөжид нөлөөлөх чадвартай байх

Групп нь хөрөнгө хүлээн авагч компанийн саналын эсвэл өөр бусад төсөөтэй эрхүүдийн олонхоос бага хувийг эзэмшиж байгаа тохиолдолд Групп хөрөнгө хүлээн авагч компанид эрх мэдэлтэй байгаа эсэхээ үнэлэхдээ холбогдох бүх баримт, нөхцөл байдлыг авч үзнэ. Үүнд:

- Хөрөнгө хүлээн авагч компанийн саналын эрхийг эзэмшдэг бусад талуудтай хийсэн гэрээт зохицуулалтууд
- Бусад гэрээт зохицуулалтуудаас үүсэх эрхүүд
- Группийн саналын эрхүүд ба болзошгүй саналын эрхүүд

Хэрэв баримт, нөхцөл байдал нь нэг эсвэл гурваас дээш хяналтын элементэд өөрчлөлт орсныг харуулж байвал Групп хөрөнгө хүлээн авагч компанид эрх мэдэлтэй байгаа эсэхээ дахин үнэлж үзнэ. Охин компанийг нэгтгэх үйл ажиллагаа нь Групп охин компани хяналтаа тогтоосон үед эхлэх ба хяналтаа алдах үед зогсоно. Тайлант жилд худалдан авсан болон худалдсан охин компанийн хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардлыг Групп хяналт тавьсан өдрөөс эхлэн уг хяналтыг зогсоох хүртэлх хугацааны нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд оруулж тайлагнасан. Тайлант жилийн хугацаанд худалдан авсан эсвэл борлуулсан охин компанийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг Групп охин компанид хяналтаа тогтоосон өдрөөс хяналтаа алдсан өдөр хүртэлх хугацааны нэгтгэсэн ашиг, алдагдал, бусад дэлгэрэнгүй орлогын тайланд толилуулна.





2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл (Үргэлжлэл)

Нэгтгэлийн үндэслэл (Үргэлжлэл)

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг Группийн Толгой компанийн хувьцаа эзэмшигчид болон жижиг хувьцаа эзэмшигчдэд (энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийг алдагдалтай болгоход хүргэх байсан ч хамаагүй) хувь тэнцүүлэн хуваарилна. Шаардлагатай үед Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой охин компаниудын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг нийцүүлэх үүднээс тэдгээр охин компаниудын санхүүгийн тайлангуудыг залруулга хийнэ. Нэгтгэсэн тайлангуудыг гаргахдаа Группийн гишүүдийн хооронд хийсэн гүйлгээтэй холбоотой үүссэн хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө, орлого, зардал, мөнгөн гүйлгээнүүдийг нийт дүнгээр нь устгана.

Хяналтаа алдахгүйгээр охин компанийн хувь эзэмшилд өөрчлөлт орсон тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн өөрийн хөрөнгийн аргаар бүртгэнэ. Хэрэв Групп охин компани дахь хяналтаа алдвал:

- Охин компанийн хөрөнгө (гүүдвиллыг оролцуулан) болон өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрнө
- Хяналтын бус багцын бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө
- Эздийн өмчид бүртгэгдсэн хуримтлагдсан хөрвүүлэлтийн зөрүүг үл хүлээн зөвшөөрнө
- Хүлээн авсан дүнгийн бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрнө
- Эзэмшиж үлдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрнө

Өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн бүрэлдэхүүн хэсгийн толгой компанийн хувийг Групп холбогдох хөрөнгө эсвэл өр төлбөрийг шууд худалдсан бол шаардагдах байсан, тохирох байдлаар орлого, зардлын данс эсвэл хуримтлагдсан ашиг руу дахин ангилна.

2.2 Үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадвар

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн богино хугацаат өр төлбөр нь эргэлтийн хөрөнгөөс 40,274,531 төгрөгөөр илүү бүртгэгдсэн байна.

Группийн хувьд тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар нь ирээдүйд ашигтай ажиллах чадвар болон эерэг мөнгөн урсгалаас хамаарна. Эрдэнэс Монгол ХХК нь Компани өр төлбөрөө удирдах болох тэдгээрийг төлж чадахгүйд хүрсэн тохиолдолд Компанид санхүүгийн дэмжлэг үзүүлснээр Компани нь тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвартай гэж үзэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлдсэн болно.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД**

2.3 **Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлтүүд**

Шинэ болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд болон тайлбарууд

2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон доорх СТОУС-уудаас бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил болно:

- | | |
|---|--|
| • НББОУС 19 Нэмэлт өөрчлөлт | <i>Ажилчдын Тэтгэвэр Тэтгэмж – Тодорхойлсон тэтгэмжийн төлөвлөгөө; Ажилчдын хувь оролцоо</i> |
| • СТОУТХ 15 | <i>Үл хөдлөх хөрөнгө баруулах гэрээ</i> |
| • Жил бүрийн сайжруулалт (2010 – 2012 Цикл) | <i>2013 оны 12 сард гаргасан СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд</i> |
| • Жил бүрийн сайжруулалт (2011 – 2013 Цикл) | <i>2013 оны 12 сард гаргасан СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд</i> |

Дээр дурдсан стандартууд болон тайлбарууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад томоохон өөрчлөлт үзүүлээгүй бөгөөд Компанийн санхүүгийн гүйцэтгэл болон санхүүгийн байдалд нөлөө үзүүлээгүй.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргасан өдөр, дараах стандартууд болон тайлбарууд батлагдаж гарсан боловч эдгээр санхүүгийн тайлангуудад хэрэгжиж эхлээгүй байсан:

- | | |
|--|---|
| • СТОУС 9 (2010 онд гарсан) | <i>Санхүүгийн хэрэглүүр³</i> |
| • СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт | <i>Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж; Нэгтгэсэн тайлан бэлтгэхгүй байх тохиолдол¹</i> |
| • СТОУС 10 болон НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт | <i>Хөрөнгө оруулагч, хараат болон хамтарсан компани хоорондын борлуулалт болон хөрөнгийн хувь оролцоо</i> |
| • СТОУС 11 Нэмэлт өөрчлөлт | <i>Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог бүртгэх¹</i> |
| • СТОУС 12 Нэмэлт өөрчлөлт | <i>Орлогын албан татвар: Бодит бус зардалд хойшлогдсон хөрөнгө хүлээн зөвшөөрөлт 2</i> |
| • СТОУС 14 | <i>Зохицуулалтын хойшлогдсон данснууд 5</i> |
| • СТОУС 15 | <i>Харилцагчтай байгуулсан гэрээний дагуух орлого 3</i> |
| • СТОУС 16 | <i>Түрээс 4</i> |
| • НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт | <i>Толилуулгын санаачлага 1</i> |
| • НББОУС 7 Нэмэлт өөрчлөлт | <i>Толилуулгын санаачлага²</i> |
| • НББОУС 16 ба НББОУС 38 Нэмэлт өөрчлөлт | <i>Үндсэн Хөрөнгө, Биет бус хөрөнгө – Элэгдэл хорогдол тооцох зөвшөөрөгдөх аргыг тохируулах¹</i> |





2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (Үргэлжлэл)

- НББОУС 16 ба НББОУС 41 Нэмэлт өөрчлөлт *Хөдөө аж ахуй: Үрт ургамал¹*
- НББОУС 27 Нэмэлт өөрчлөлт *Тусдаа санхүүгийн тайлан- Тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн арга¹*
- Жил бүрийн сайжруулалт (2012 – 2014 Цикл) *2014 оны 9 сард гаргасан СТОУС-уудад орсон өөрчлөлтүүд¹*

¹ 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

² 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

³ 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

⁴ 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

⁵ СТОУС-уудыг анхлан хэрэглэж байгаа байгууллагын 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи жилийн санхүүгийн тайлангуудад хүчин төгөлдөр үйлчлэх учраас Группд хэрэглэгдэхгүй.

Удирдлага энэхүү стандарт болон тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөх нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж тооцож байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

(а) Нэгдсэн хяналттай бизнесийн нэгдэл

Нэгдсэн хяналттай бизнесийн нэгдлүүдийг нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан бүртгэнэ. Нэгдэж буй байгууллага эсвэл бизнесүүдийн цэвэр хөрөнгийг хяналт тогтоож байгаа талуудын бүртгэлийн дүнг ашиглан нэгтгэнэ. Худалдан авсан байгууллага эсвэл бизнесийн хөрөнгө, өр төлбөрийг хянаж буй талын санхүүгийн тайланд тусгасан бүртгэлийн дүнгээр бүртгэх ёстой. Бизнесийн нэгдэл бүр дээр Групп нь худалдагдсан компани дахь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь оролцоог бодит үнэ цэнээр нь эсвэл худалдагдсан компанийн тодорхойлох боломжтой хөрөнгөөс ногдох хувиар нь хэмжих үү гэдгийг сонгоно. Худалдан авалттай холбоотой зардлуудыг гарсан үед зардлаар хүлээн зөвшөөрч, удирдлагын зардалд багтаана.

Нэгдсэн хяналттай бизнесийн нэгдлийн үед гүүдвилл эсвэл худалдагдсан компанийн тодорхойлох боломжтой хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрүүдийн цэвэр бодит үнэ цэнэ дэх худалдан авагчийн хувь оролцоо нь өртгөөс давсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй (хянаж буй тал эсвэл талуудын хувь оролцоо хэвээрээ байгаа тохиолдолд).

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын харьцуулсан үзүүлэлтүүдийг байгууллага эсвэл бизнесүүд нь өмнөх тайлангийн өдөр (нэгдэж буй байгууллага эсвэл бизнесүүд нь энэ өдөр анх удаа нэгдсэн хяналт дор орж ирсэн биш л бол) аль хэдийн нэгдсэн байсан юм шигээр толилуулна.

0000127 14





2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(а) Нэгдсэн хяналттай бизнесийн нэгдэл (Үргэлжлэл)

Нэгдэж буй байгууллага эсвэл бизнес нэг бүрийн толилуулсан хамгийн эртний өдөр (харьцуулсан үзүүлэлтийн өдөр хамаарна)-өөс хойших эсвэл нэгдэж буй байгууллага эсвэл бизнесүүд нь хянаж буй талын нэгдсэн хяналт дор анх орсон өдөр (нэгдсэн хяналттай нэгтгэлийн өдөр хамаарахгүй)-өөс хойших хугацааны (харьцуулахад энэ хугацаа нь богино бол) үр дүнг нэгтгэсэн орлогын тайланд багтаан толилуулна. Нэгтгэсэн орлогын тайлан нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад бүртгэсэн жижиг хувьцаа эзэмшигчдэд хамаарах ашиг, алдагдлыг тооцож үзэх ёстой.

(б) Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргыг ашиглан бүртгэнэ. Хараат компани гэж Групп онцгой нөлөөтэй компанийг хэлнэ. Онцгой нөлөө гэж санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод оролцох эрхийг хэлнэ.

Өмчийн аргыг ашиглах үед хараат компани дахь хөрөнгө нь санхүүгийн байдлын тайлан дахь өртөг дээр худалдан авалтын дараах хараат компанийн цэвэр хөрөнгө дэх Группийн хувьцааны өөрчлөлтийг нэмсэнтэй тэнцүү байна. Хараат компанитай холбоотой бүртгэгдсэн гүүдвилл нь хөрөнгө оруулалтын дүнд багтах бөгөөд дангаар нь үнийн бууралт хэмжихгүй мөн хорогдуулахгүй.

Дэлгэрэнгүй орлогын тайланд хараат компанийн үйл ажиллагааны үр дүнг Группд хувь эзэмших хэмжээгээр нөлөөлнө. Хараат компанийн өмчид шууд өөрчлөлт орсон үед Групп энэхүү өөрчлөлтийг өөрийн хувь эзэмших хэмжээгээр хүлээн зөвшөөрөн, шаардлагатай тодруулгыг өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайландаа тусгана.

Групп болон хараат компани хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн аливаа ханшийн бодит бус ашиг, алдагдал нь хараат компани дахь ашиг сонирхолд нэмэгдэж устгагдана.

Хараат компанийн ашгаас хүртэх хувийг дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайлангаас харж болно. Энэ нь хараат компанийн, толгой компанийн хувь эзэмшигчдэд хамааралтай, татвар болон хараат компанийн хяналтын бус багц эзэмшигчдийн хувийн дараах ашиг болно.

Хараат компанийн санхүүгийн тайланг Группийн тайлангийн хугацаатай нэг хугацаанд бэлтгэнэ. Шаардлагатай бол, хараат компанийн нягтлан бодох бүртгэлийн дүрмийг Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд тохируулга хийж болно.

Өмчийн аргыг хэрэглэсний дараа, Группийн хамтарсан компанид хийсэн хөрөнгө оруулалтад нэмэлт алдагдал бүртгэх шаардлагатай эсэхийг Групп тодорхойлно. Группийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт нь үр дүнгүй болсныг батлах бодит нотолгоо байгаа эсэхийг Групп санхүүгийн тайлант өдөр бүр тодорхойлно.

Хэрэв тийм нотолгоо байгаа бол уг хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх дүн, бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр алдагдлын дүнг тооцож, уг дүнг дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайлангийн 'хараат компанийн ашгийн хувь' д хүлээн зөвшөөрнө.

0000128

15





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(б) **Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт (Үргэлжлэл)**

Хараат компани дахь мэдэгдэхүйц нөлөөллөө алдсаны дараа Групп үлдсэн хөрөнгө оруулалтаа бодит үнээр тооцож хүлээн зөвшөөрнө. Уг нөлөөллөө алдсаны дараах дансны үнэ, үлдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ болон хөрөнгө борлуулсны орлогын зөрүүг ашиг, алдагдлын дансанд хүлээн зөвшөөрнө.

(в) **Эргэлтийн (богино хугацааны) болон эргэлтийн бус (урт хугацааны) ангилал**

Групп хөрөнгө болон өр төлбөрүүдийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно. Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй
- Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг
- Хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөр нь эргэлтийн бус хөрөнгө өр төлбөр хэлбэрээр ангилагдсан.

(г) **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрд өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь орлого, үр дүнгийн тайланд тусгана. Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан бодит үнэ цэнээр илэрхийлдэг.





2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(г) Үндсэн хөрөнгө (Үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар, дараах ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ. Үүнд:

Ангилал	Жил
Барилга	10 - 60
Машин, тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл	5 – 30
Тавилга, эд хогшил	10
Компьютер ба бусад хөрөнгүүд	3

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлттэй холбогдон үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа ба элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

(д) Уурхайн хөрөнгө

(i) Уурхайн хөгжүүлэлт

Гүйцэтгэсэн ажил нь хөрөнгийн ирээдүйн хөгжүүлэлтийг дэмжих болон хөгжүүлэлт хийх зохих зөвшөөрлийг авсан даруйд гүйцэтгэлийн зардлыг "Хойшлуулсан хайгуул ба үнэлгээний хөрөнгө"-с "Уурхайн хөрөнгө"-н дэд ангилал болох "Уурхайн бүтээн байгуулалт" -д шилжүүлэн бүртгэнэ.

Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг шилжүүлэн бүртгэсний дараа уурхай барьж байгуулахад гарсан зардлуудыг "Уурхайн бүтээн байгуулалт" дансанд бүртгэнэ. Эдгээр зардал нь уурхайн хөгжүүлэлтийн шатанд хүдэр борлуулсны цэвэр орлого болох бөгөөд уурхайн хөгжүүлэлтийн салшгүй нэгэн хэсэг юм. Хөрөнгийн төлөвлөгөөг шинжлэхэд гарсан аливаа зардлыг шинжилгээний явцад, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн борлуулснаас олсон орлогыг хассан дүнгээр капиталжуулна. Бүтээгдэхүүн борлуулсны орлого нь шалгалтын явцад гарсан зардлаас илүү байвал, илүү гарсан дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(д) **Уурхайн хөрөнгө**

(ii) *Хөрс хуулалтын хөрөнгө*

Групп бүтээн байгуулалт болон үйлдвэрлэлийн үе шатан дахь үйл ажиллагааны явцад хөрс хуулалтын (хөрс гаргалт) зардлыг гаргадаг ба энэ нь уул уурхайн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Үйлдвэрлэлийн үе шат эхлэхээс өмнө гарсан бүтээн байгуулалтын үе шатны хөрс хуулалтын зардал (бүтээн байгуулалтын үе шатны хөрс хуулалт) нь уурхайг байгуулахад гарсан зардлаар тооцогдон капиталжигдах бөгөөд уурхайн ашиглалтын хугацаанд үйлдвэрлэлийн нэгж аргаар хорогдоно. Бүтээн байгуулалтын үе шатанд гарсан хөрс хуулалтын зардлын капиталжуулалт нь уурхайг зориулалтын дагуу ашиглаж эхлэх үед бүрэн зогсоно.

Үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалтын үйл ажиллагаа нь бараа материалын үйлдвэрлэл болон ирээдүйд олборлох хүдрийн биетэд хүрэх замыг бэлдэх гэсэн хоёр өгөөжийг бий болгодог. Үйлдвэрлэлийн хугацаанд хүртсэн үр өгөөжийг бараа материалын хэлбэрээр хүртсэн тохиолдолд үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалтын зардал нь тухайн бараа материалыг үйлдвэрлэхэд гарсан өртгөөр бүртгэгдэнэ. Хэрэв хөрс хуулалтын үйл ажиллагааны үр дүнд хүртэх өгөөж нь ирээдүйд олборлох хүдрийн биетэд хүрэх замыг бэлдсэн тохиолдолд тухайн хөрс хуулалтын зардлыг дараах шалгууруудыг хангасан тохиолдолд эргэлтийн бус хөрөнгө хэсэгт хөрс хуулалтын хөрөнгөөр ангилан бүртгэнэ:

- а) Ирээдүйд хүртэх өгөөж нь (хүдрийн биетэд хүрэх замыг бэлдэх) тодорхой болсон үед;
- б) Ирээдүйд олборлохоор бэлдсэн хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсгийг найдвартай тодорхойлсон үед;
- в) Холбогдох зардлыг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд

Эдгээр шалгууруудыг хангаагүй тохиолдолд үйлдвэрлэлийн шатны хөрс хуулалтын зардал нь орлого үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардлаар бүртгэгдэнэ.

Групп хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлоход уурхайн үйл ажиллагаа хариуцсан тусгай мэргэжилтэнтэй уурхайн ажлын төлөвлөгөө дээр нарийн дүн шинжилгээ хийдэг. Хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсэг нь нийт хүдрийн биетийн зөвхөн нэг хэсэг бөгөөд уурхай нь хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж болно. Уурхай бүрийн төлөвлөгөө, хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох явц нь дараах хүчин зүйлсээс хамаарч өөр хоорондоо ялгаатай байдаг. Үүнд: ашигт малтмалын бүтээгдэхүүний нэр төрөл, хүдрийн биетийн геологийн онцлог шинж чанарууд, газар зүйн байршил болон санхүүжилтийн асуудлууд багтана.

Хөрс хуулалтын хөрөнгө нь анх өртгөөр хэмжигдэх бөгөөд ирээдүйд олборлох хүдрийн биетэд хүрэх замыг бэлдэх хөрс хуулалтын ажиллагаатай шууд холбоотой гарсан зардлын хуримтлал болон хуваарилагдаж ирсэн хөрс хуулалтын үйл ажиллагаатай шууд холбоотой үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлууд орно. Хэрэв үйлдвэрлэлийн хөрс хуулалтын ажиллагааны явцад тухайн хөрс хуулалтын ажиллагаатай холбоогүй ямар нэг ажлыг хийж гүйцэтгэсэн тохиолдолд холбогдох зардлууд нь хөрс хуулалтын хөрөнгө дансанд бүртгэгдэхгүй.

0000131





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(д) **Уурхайн хөрөнгө (Үргэлжлэл)**

(ii) *Хөрс хуулалтын хөрөнгө (Үргэлжлэл)*

Хэрэв үйлдвэрлэсэн бараа материалын өртөг болон хөрс хуулалтын хөрөнгийг тусад нь тодорхойлох боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлийн хөрс хуулалтын зардлыг үйлдвэрлэсэн бараа материал болон хөрс хуулалтын хөрөнгөнд үйлдвэрлэлийн тусгай хэмжүүрээр хуваарилна. Хүдрийн биетийн тодорхой болсон бүрэлдэхүүн хэсгийг тооцоход энэхүү үйлдвэрлэлийн хэмжүүрийг ашигладаг бөгөөд энэ нь гүйцэтгэсэн нэмэлт хөрс хуулалтын үйл ажиллагааны ирээдүйд авчрах үр өгөөжийг тодорхойлж өгдөг. Групп бүрэлдэхүүн хэсэг бүрд гүйцэтгэхээр төлөвлөж буй хөрс хуулалтын тоо хэмжээг бодитоор үйлдвэрлэсэн хүдрийн биетийн тоо хэмжээтэй харьцуулдаг.

Хөрс хуулалтын хөрөнгийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд "Хөрс хуулалтын хөрөнгө" ангиллаар толилуулна. Энэ нь мөнгөн эх үүсвэрүүдийн нэг хэсэгт тооцогдох ба тухайн хөрөнгийн дансны үнэ цэнэ ирээдүйд нөхөгдөх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн хөрөнгөнд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг шалгана.

Хөрс хуулалтын хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараагаар хөрс хуулалтын үйл ажиллагааны үр дүнд олборлох нөхцөл боломжийг бий болгосон хүдрийн биетийн тодорхой бүрэлдэхүүн хэсгийн ашиглах хугацааны дагуу үйлдвэрлэлийн нэгж аргыг ашиглан хорогдуулна. Тодорхой болсон хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсгийн ашиглах хугацааг бодитой болон боломжтой нөөц букуу эдийн засгийн хувьд үр өгөөжийг өгөх нөөцийн хэмжээгээр тодорхойлно. Хөрс хуулалтын хөрөнгийн нийт өртгөөс хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр бүртгэнэ.

(е) **Биет бус хөрөнгө**

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнесийн нэгдлээр олж авсан биет бус хөрөнгийг нэгдлийн өдрөөрх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт (ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно) болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Капиталжуулсан хөгжүүлэлтийн өртгөөс бусад дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийг капиталжуулахгүй ба холбогдох зардлыг гарсан тайлант жилийнх нь орлого үр дүнгийн тайланд тусгана.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(е) **Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)**

Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба биет бус хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орж буй шинж тэмдэг байгаа үед үнэ цэнийн бууралтыг үнэлж үзнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй бөгөөд жил бүр тусгайлан эсвэл мөнгөн хөрөнгө үүсгэгч нэгжийн түвшинд үнэ цэнийн тестийг гүйцэтгэнэ. Хэрэв тодорхойгүй хугацаатай гэдэг нь бодитой биш бол тодорхойгүй ашиглалтын хугацааг тодорхой ашиглалтын хугацаатай болгож өөрчилнө.

Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарз нь цэвэр борлуулалтын орлого болон хөрөнгийн бүртгэлийн үнийн зөрүүгээр хэмжигдэх ба олз, гарзыг биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед орлого, зардлын дансанд бүртгэнэ.

Группийн биет бус хөрөнгө нь компьютерийн программ хангамж байна. Компьютерийн программ хангамжийг хүлээгдэж буй нэгээс (1)- гурван (3) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

(ё) **Бараа материал**

Нүүрсний овоолго, эд материал, хэрэглээний эд зүйлс болон сэлбэг хэрэгсэл нь биет байдлаар хэмжигдэж тооцоологддог бөгөөд өртөг эсвэл цэвэр хүлээн зөвшөөрөгдөж болох үнэ цэнийн аль багаар нь үнэлэгддэг. Цэвэр хүлээн зөвшөөрөгдөж болох үнэ цэнэ нь энгийн бизнесийн үйл ажиллагаан дахь борлуулалтын үнээс борлуулахад бэлэн эцсийн бүтээгдэхүүнийг бэлтгэхэд гарсан зардлыг хассан дүнгээр тодорхойлогддог.

Өртгийг жигнэсэн дундаж аргаар тодорхойлох ба өртөгт худалдан авалтын шууд зардлууд, материалыг эцсийн бүтээгдэхүүн болгон хувиргахад гарсан элэгдэл, хорогдол гэх мэт тогтмол болон хувьсах зардлуудын багтана.

Хуучирсан бараа материалд байгуулах сангийн хэмжээг тухайн хөрөнгийн төрлийг харгалзан тодорхойлно. Хуучирч муудсан бараа материалын санг байгуулахад байнгын шалгалт хийгддэг.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(ж) **Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Гүүдвиллээс бусад санхүүгийн бус хөрөнгүүд

Үнэ цэнийн бууралтын аливаа нэг шинж тэмдэг илрэх үед хөрөнгийн бүртгэлийн дүнгүүд үнэ цэнийн бууралт агуулж буй эсэхийг шалгадаг. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн бол хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно. Хөрөнгийн нөхөгдөх дүн нь хөрөнгийн бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба түүний бүртгэлийн дүн хоёрын аль өндөр нь байна.

Хөрөнгө нь бусад хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгөөс хамааралгүйгээр мөнгөн урсгалыг бий болгохгүй байвал хөрөнгө нэг бүрийн нөхөгдөх дүнг тодорхойлно.

Хэрэв бусад хөрөнгөөс хамааралтайгаар мөнгөн урсгалыг бий болгож байвал тухайн хөрөнгө хамаарагдах бэлэн мөнгөний урсгал үүсгэгч нэгж ("БМУҮН") нэг бүрийн нөхөгдөх дүнг тодорхойлдог. БМУҮН нь салангид тодорхойлогдсон мөнгөн орох урсгалын хамгийн бага түвшинг заадаг ба энэ нь Групп өөрийн санхүүгийн хөрөнгүүдийг газар зүйн байршил эсвэл лицензээр нь ангилж үнэлэхэд хүргэдэг. Хэрэв санхүүгийн бус хөрөнгийн бүртгэлийн дүн нь нөхөн төлөгдөх дүнгээсээ хэтэрсэн бол хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн нөхөн төлөгдөх дүн (хөрөнгийн бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба түүний ашиглалтын дүн хоёрын аль өндөр нь байна) хүртэл нь бууруулж, зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.


Үргэлжлэн явагдаж байгаа үйл ажиллагаатай холбоотой үнэ цэнийн бууралтын гарзыг зохих (үнэ цэнэ нь буурсан хөрөнгийн ажиллагаанд хамаарагдах) зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Үүнд өмнө нь дахин үнэлж, дахин үнэлгээний зөрүүг нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгүүд хамаарахгүй бөгөөд энэ тохиолдолд, үнэ цэнийн бууралтын гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд, өмнөх дахин үнэлгээний дүн хүртэлх хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

Тайлагналын едөр бүр, өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээ хийдэг.

Хэрвээ тийм шинж тэмдэг илэрвэл, Групп нөхөгдөх дүнг таамаглана. Өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг тодорхойлогдоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг нөхөн төлөгдөх дүн хүртэл нь буцаана. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөнд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүн (элэгдэл/хорогдлыг хассан цэвэр дүн)-ээс хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(3) **Санхүүгийн хөрөнгө**

(i) *Анх хүлээн зөвшөөрөх болон хэмжилт*

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба авлага, дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр ангилсан үүсмэл хэрэглүүр гэж ангилна. Санхүүгийн хөрөнгүүдийг анхлан бодит үнэ цэнээр нь бүртгэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх гэж ангилаагүй санхүүгийн хөрөнгүүдийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлуудыг нэмж бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн бүх хэвийн худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр (Групп хөрөнгийг худалдан авах эсвэл зарах үүрэг хүлээсэн өдөр) хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн хэвийн худалдан авалт, борлуулалт гэж зах зээлийн зохицуулалт, эсвэл жишгээр голдуу тогтоогдсон хугацаанд хөрөнгийг хүргэж өгөхийг шаарддаг, санхүүгийн хөрөнгийн худалдан авалт, борлуулалтыг хэлнэ.

Группийн санхүүгийн хөрөнгөнд мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага болон бусад авлагууд багтах бөгөөд бүгд хорогдуулсан өртгөөрөө хэмжигддэг.

(ii) *Дараах үеийн хэмжилт*

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт нь доор дурдсан ангиллаас шалтгаална:

Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхтэй зах зээлд бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр бүхий үүсмэл санхүүгийн хэрэглүүр биш санхүүгийн хөрөнгө юм. Анхны хэмжилтээс хойш санхүүгийн хөрөнгийг дараах үеүдэд үнэ цэнийн бууралтыг хассаны дараах үр ашигт хүүний арга (ҮАХА) ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон зардал, шимтгэлийг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүний хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад орлого"-д багтана. Үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад зардал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(iii) *Үл хүлээн зөвшөөрөлт*

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(з) **Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)**

(iii) *Үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)*

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Групп нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл (а) Групп нь хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл (б) Групп нь тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Групп хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Группийн уг хөрөнгөнд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Групп холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө.

Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Групп ийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Группийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(iv) *Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Групп санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурах эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтад орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(3) **Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)**

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна.

Хүүний орлогыг санхүүгийн орлогын нэг хэсэг болгон орлого, зардлын дансанд бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл Группд шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайлангийн санхүүгийн зардал дансны кредитэд бүртгэнэ.

(и) **Санхүүгийн өр төлбөр**


(i) *Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө.

Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Группийн санхүүгийн өр төлбөрүүдэд зээллэг, хуримтлуулж тооцсон хүү, дансны болон бусад өр төлбөр орно. Бүх санхүүгийн өр төлбөрүүд нь зээл ба зээллэг гэж ангилагдсан.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(и) **Санхүүгийн өр төлбөр (Үргэлжлэл)**

(ii) *Дараа үеийн хэмжилт*

Санхүүгийн өр төлбөрүүдийн хэмжилт доор дурдсан ангиллаас хамаарна:

Зээл ба зээллэг

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүд, хүүний өглөг, дансны болон бусад өглөгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед болон үр ашигт хүүг ашиглан хорогдуулах үеийн олз, гарзыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох зээл олголтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэл, холбоотой зардлуудыг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүний хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайлангийн санхүүгийн зардалд багтана.

(iii) *Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

(й) **Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх**

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр нэгтгэсэн тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(к) **Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ**

Хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд зохих журмын дагуу хийгдэж буй гүйлгээний үед хөрөнгө борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ цэнэ гэнэ. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээний таамаглалд үндэслэдэг. Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд

Групп үндсэн болон давуу зах зээлд оролцох боломжтой байх ёстой.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоох үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцоно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэд хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж эсвэл хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглах зах зээлийн өөр нэг оролцогчид хөрөнгийг борлуулснаар эдийн засгийн өгөөжийг бий болгох зах зээлийн оролцогчийн чадварыг харгалзаж үзнэ.


Групп тухайн нөхцөлд тохирох үнэлгээний техникүүдийг ашиглах ба уг нөхцөл нь бодит үнэ цэнийг хэмжихэд шаардагдах хангалттай мэдээлэлтэй, холбогдох ажиглаж болохуйц орцуудыг дээд зэргээр, ажиглах боломжгүй орцуудыг хамгийн багаар ашиглана.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит үнэ цэнийн түвшинд дараах байдлаар ангилсан ба ангилахдаа бодит үнэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

- Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ,
- Түвшин 2 - шууд болон шууд бусаар ажиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх үнэлгээний техникүүд
- Түвшин 3 - ажиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй үнэлгээний техникүүд

Групп нэгтгэсэн санхүүгийн тайланд байнгын сууриар хүлээн зөвшөөрдөг хөрөнгө болон өр төлбөрүүдийн хувьд тайлант үе бүрийн эцэст ангиллыг дахин үнэлж (бүхлээрээ бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод суурилан) үзсэнээр түвшний хоорондын шилжилт гарсан эсэхийг тодорхойлдог. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ, тэдгээрийг хэрхэн хэмжсэн тухай дэлгэрэнгүйг Тодруулга 30-д толилуулсан.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(л) **Бэлэн мөнгө болон банкин дахь данс**

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан дээр тусгасан бэлэн мөнгө болон банкин дахь харилцахын дансанд банкинд байршуулсан болон гар дээрх бэлэн мөнгө, орно. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн зорилгоор, дээр тодорхойлсноор бэлэн мөнгө болон банкин дахь харилцах, хадгаламж дахь бэлэн мөнгө болон богино хугацаатай хадгаламжийг банкны овердрафтын үлдэгдлийг багтаахгүйгээр оруулсан.

(м) **Засгийн газрын тусламж**

Засгийн газрын засгийн газрын тусламжийг хүлээн авах нь тодорхой болсон ба дагалдах бүх нөхцөлүүдэд нийцнэ гэж үзэж байгаа үед хүлээн зөвшөөрнө. Засгийн газрын тусламж нь зардлын зүйлтэй холбогдож байгаа үед засгийн газрын тусламжийг нөхөн олгох хандлагатай зардлуудтай тааруулахад шаардагдах хугацааны туршид орлогоор хүлээн зөвшөөрнө. Засгийн газрын тусламж нь хөрөнгөтэй холбогдож байгаа үед үүнийг холбогдох хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид тэнцүү хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрнө. Засгийн газрын тусламж нь зах зээлийн хүүнээс доогуур хувиар эсхүл татаас хэлбэрээр олгогдсон бол түүнийг зээлийн бодит үнэ цэнэ болон нэрлэсэн дүнгийн зөрүүгээр хэмжигддэг.

(н) **Өөрийн хөрөнгө**

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан жилд өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг.

Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөнөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

Нэрлэсэн үнээс илүү гарч буй хувь оруулсан дүнг "Хувьцааны урамшуулал" гэнэ. Хувьцааны урамшуулал нь мөн хувь эзэмшигчдийн нэмж оруулсан хөрөнгөөс үүснэ.





2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(о) Сан

Ерөнхий

Групп д өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Групп нь байгуулсан сангийн зарим хэсгийг эсвэл бүгдийг нь нөхөн төлбөрт зарцуулахаар хүлээж байгаа үед (жишээ нь: даатгалын гэрээний үед), нөхөн төлбөр хийх нь бодитой болсон үед л зөвхөн нөхөн төлбөрийг тусдаа хөрөнгө болгон хүлээн зөвшөөрнө. Аливаа сантай холбоотой зардлыг орлого үр дүнгийн тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн үзүүлэх нөлөөлөл нь материаллаг байгаа үед, сангийн хэмжээг тухайн өр төлбөрт хамаарах эрсдэлүүдийг тусгасан (хэрэв зохистой бол), өнөөгийн татварын өмнөх хувь хэмжээг хэрэглэн бууруулна. Бууруулах аргыг хэрэглэж байгаа үед, цаг хугацааны улмаас санд гарсан өсөлтийг санхүүгийн зардлаар орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Нөхөн сэргээлтийн сан

Групп нь хуул ёс зүйн үүрэг хариуцлагын дагуу үүссэн тайлант хугацааны үйл ажиллагаанд хамаарах газар нутгийг нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлын зардлын өнөөгийн үнэ цэнийг тооцон бүртгэдэг. Нөхөн сэргээх үйл ажиллагаанд татан буулгах, бүтцийг шилжүүлэх, уурхайг нөхөн сэргээх, үйл ажиллагааны хэрэгслүүдийг татан буулгах, үйлдвэр болон хаягдлын талбайг хаах, нөхөн сэргээх, хөндөгдсөн газруудын хөрсийг сайжруулах, нөхөн ургамалжуулах зэрэг ажил орно.

Хайгуул болон уурхайн газарт хөрөнгө бий болгох болон хөрс, хүрээлэн буй орчныг бусниулах үед үүрэг хариуцлага үүсдэг. Өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхөд, уурхайн хөгжүүлэлт болон бүтээн байгуулалтад оролцож буй хэмжээгээр нь холбогдох уурхайн хөрөнгийн бүртгэлийн дүнг тооцсон зардлын өнөөгийн үнэ цэнийн дүнгээр капиталжуулан өсгөнө. Бууруулсан өр төлбөр нь өнөөгийн зах зээлийн үнэлгээ болон өр төлбөрийн эрсдэлийг тусгасан хөнгөлөлтийн хувь хэмжээнд суурилсан өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлтөөр өснө.

Үе үеийн бууралтын хувийг буцаасан хэмжээг орлого, зардлын дансанд санхүүгийн зардлаар хүлээн зөвшөөрнө. Нэмж сүйтгэсэн хэмжээ болон нөхөн сэргээлтийн зардлын өөрчлөлтийг гарсан үед нь холбогдох хөрөнгө болон нөхөн сэргээлтийн өр төлбөрт нэмэгдэл болон зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хаагдсан болон олборлолт дууссан газрын хувьд тооцсон зардлын өөрчлөлтийг орлого, зардлын дансанд даруй хүлээн зөвшөөрнө.



2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(о) Сан (Үргэлжлэл)

Компанийн нийгмийн харуцлагын сан

Групп нь олон нийтийн болон байгаль орчны хөгжлийн үйл ажиллагаанд зориулан Группийн ирээдүйн нийгмийн хөгжлийн санг бүртгэдэг. Уг санг бүртгэхдээ төлөвлөгөөт борлуулалтаас давсан бодит борлуулалтын хувь хэмжээ, дайвар болон шинэ бүтээгдэхүүний борлуулалт ба түрээсийн орлого зэрэг дээр тулгуурлана.

(ө) Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Группд орох нь тодорхой болсон болон найдвартайгаар хэмжих боломжтой болсон хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнэ эсвэл авлагыг хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын татварыг суутгасан дүнгээр хэмжинэ. Өмчлөлтэй холбоотой томоохон эрсдэл, өгөөж, өмчлөлийн гэрчилгээг худалдан авагчид шилжүүлсэн үед барааны борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө. Групп нь ихэнх түрээсийн гэрээнд гол үүрэг хүлээгч байдаг тул бүх орлогын хэлцлийн гол оролцогч байх бөгөөд мөн бараа материалын болон зээлийн эрсдэлд өртдөг.

Нүүрсний борлуулалт

Нүүрсний борлуулалтыг өмчлөх эрх худалдан авагчид нь шилжсэн үед үүсч байгаа өмчлөлтэй холбоотой томоохон эрсдэл, өгөөж нь шилжсэн үед хүлээн зөвшөөрнө. Энэ нь ихэнхдээ бүтээгдэхүүн биетээр галт тэрэг, конвейер эсвэл өөр бусад тээвэрлэгч механизмд ачигдах үед үүснэ.

Хүүний орлого


Хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн бүх хэрэглүүр болон борлуулахад бэлэн гэж ангилсан хүү тооцдог санхүүгийн хөрөнгийн хувьд, хүүний орлогыг шаардлагатай үед санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн бүртгэлийн дүнтэй цэвэршүүлсэн богино хугацааны буюу санхүүгийн хэрэглүүрийн таамагласан хугацаанд тооцоолсон, ирээдүйд хүлээж авах буюу төлөх мөнгөн урсгалын бууруулсан хүүний түвшинг ашигласан үр ашигт хүүний аргад үндэслэн хүлээн зөвшөөрнө. Хүүний орлогыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардалд бүртгэнэ.

Түрээсийн орлого

Үйл ажиллагааны түрээс гэж ангилсан түрээснээс олсон орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

Бусад орлого

Бусад орлого нь Группийн хэвийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд энэ нь группд эдийн засгийн үр өгөөж авчрах магадлалтай мөн тооцоологдох боломжтой болсон үед хүлээн зөвшөөрнө.



2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(п) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардал

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад эдийн засгийн өгөөжийн гадагшлах урсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардлыг гарсан үед нь дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайланд хүлээн зөвшөөрнө.

(р) Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Группийн ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(iii) Бусад тэтгэвэр тэтгэмж

Тодруулга 23-т толилууснаар Групп ажилчдыг тэтгэвэрт гарах үед нэг удаагийн төлбөрийг олгодог. Тэтгэвэрт гарах үед олгох ажилчдын тэтгэмжийг ажил үйлчилгээ гүйцэтгэж буй хугацаанд хүлээн зөвшөөрнө. Нөөцийг ажилласан хугацаан дээр суурилан ирээдүйд гарахаар тооцсон зардлын өнөөгийн үнэ цэнээр бүртгэнэ.

(с) Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(с) **Татвар (Үргэлжлэл)**

Цэвэршүүлэх хууль ёсны эрхтэй бөгөөд Групп нь цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа эсвэл хөрөнгийг борлуулсан даруйдаа ер төлбөрийг барагдуулах гэж байгаа тохиолдолд л одоо байгаа татварын хөрөнгө, ер төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрнө. Удирдлага нь татварын тайланд хэрхэн тусгах талаар татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахаар тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг бөгөөд шаардлагатай тохиолдолд сан байгуулдаг.

Хойшлогдсон орлогын албан татвар

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, ер төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Тайлан тэнцлийн арга"-ыг ашиглан хойшлогдсон орлогын албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон орлогын албан татварын ер төлбөрийг доор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хойшлогдсон орлогын албан татварын ер төлбөр нь гүүдвлиийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, ер төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,

Түр зөрүү нь охин, хараат болон хамтарсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед

Доор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:



2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(с) Татвар (Үргэлжлэл)

Хойшлогдсон орлогын албан татвар (Үргэлжлэл)

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;
- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөөгүй, хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв тайлант хугацааны татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, орлогод суурилсан татварууд нь орлогын албан татварын шинж чанартай үед НББОУС 12-д заасны дагуу бүртгэнэ. Засгийн газрын агентлагаас ногдуулсан ба төлөх дүн нь үйлдвэрлэсэн тоо хэмжээ эсвэл орлогын хувь хэмжээ дээр суурилсан бус харин түр зөрүүнүүдийг тохируулсны дараах татвар ногдох орлого дээр суурилсан үед НББОУС 12-ын дагуу бүртгэнэ. Ийм зохицуулалтуудын үед өөр татварын хэлбэрүүдийн хувьд өнөөгийн ба хойшлогдсон татваруудыг дээр дурдсаны дагуу бүртгэнэ. Эдгээр шаардлагуудыг хангахгүй байгаа, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтаас үүссэн үүргүүдэд тайлант хугацаанд сан байгуулж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт оруулна. Группд ногдсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь эдгээр шаардлагуудыг хангахгүй байгаа учраас орлогын албан татварын нэг хэсэг гэж авч үзэхгүй.



2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(с) Татвар (Үргэлжлэл)

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авлагын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

(т) Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо анхны өдрийн гэрээний агуулга дээр үндэслэнэ. Гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг, хэдийгээр уг эрхийг гэрээнд тодорхой заагаагүй байсан ч, үнэлж үзэх шаардлагатай.

Групп түрээслэгч

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайланд түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн түрээс нь Группийн түрээсэлж байгаа хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотой бараг бүх эрсдэл, өгөөжийг түрээслэгчээс олж авсныг санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү хэмжээгээр хөрөнгө ба өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн дүн юм. Түрээсийн хамгийн бага төлбөрийг санхүүгийн зардал болон өр төлбөрийн үлдэгдлийг бууруулах дүнд хуваарилна. Санхүүгийн зардлыг өр төлбөрийн үлдэгдэл дүнд тогтмол хуваарь бүхий хүүний түвшинг тогтоохын тулд түрээсийн хугацаа бүрд хуваарилдаг. Болзошгүй түрээс нь тухайн гарсан тайлант хугацаанд зардлаар бүртгэнэ.

Групп түрээслүүлэгч

Түрээслүүлэгч нь хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байгаа түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Үйл ажиллагааны түрээсийн гэрээг анх байгуулахад гарсан шууд зардлуудыг түрээслэсэн хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмэх ба түрээсийн хугацаанд түрээсийн орлогыг зөвшөөрөхтэй адил аргаар хүлээн зөвшөөрнө.





2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)

(у) Гадаад валютын хөрвүүлэлт

Группийн санхүүгийн тайланг Группийн үйл ажиллагааны болон толилуулгын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Бүх зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ. Түүхэн өртгөөр хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг тэдгээрийн анхны гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(ү) Зээлийн өртөг

Хөрөнгө худалдан авалт, барилга байгууламж, үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээллэгийн зардлуудыг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулах бөгөөд эдгээр нь тухайн хөрөнгийг зориулалтаар нь ашиглах болон борлуулахад бэлэн болох хүртэл (шаардлага хангасан хөрөнгө) нэлээд хугацаа шаарддаг. Зээллэгийн зардалд аж ахуй нэгжийн зээлийн эх үүсвэртэй холбоотой гарсан хүүний болон бусад зардлууд орно.

Төслийг тусгайлан санхүүжүүлэхээр санхүүжилт авсан үед капиталжуулсан дүн нь зээллэгийн бодитоор гарсан зардлыг илэрхийлнэ. Төслийг тусгайлан санхүүжүүлэхээр зээлсэн мөнгөнөөс богино хугацаанд мөнгө илүү гарах үед уг мөнгөөр түр зуурын хөрөнгө оруулалт хийж олсон орлогыг мөн капиталжуулж, нийт капиталжуулсан зээллэгийн зардлаас хасна. Төслийг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа мөнгө нь ерөнхий зээллэгийн нэг хэсгийг бүрдүүлж байгаа үед капиталжуулсан дүнг тайлант хугацаанд Группийн холбогдох ерөнхий зээллэгт хамаарах жигнэсэн дундаж хүүг ашиглан тооцоолно.

Зээллэгийн бусад бүх зардлуудыг тэдгээрийн гарсан тайлант хугацааны орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

(ф) Болзошгүй үйл явдлууд

Санхүүгийн нэгтгэсэн тайланд болзошгүй өр төлбөрүүдийг хүлээн зөвшөөрдөггүй. Эдийн засгийн үр өгөөж агуулсан эх үүсвэр гадагшаа урсах боломжгүй биш л бол эдгээр өр төлбөрийн талаар санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулга хийж өгнө. Санхүүгийн нэгтгэсэн тайланд болзошгүй хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрдөггүй гэхдээ эдийн засгийн өгөөж орж ирэх нь магадлалтай болсон үед санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

(х) Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Тайлант хугацааны эцэс дэх Группийн санхүүгийн байдлын талаар нэмэлт мэдээллийг хангаж өгөх тайлант хугацааны дараах үйл явдлууд (залруулах үйл явдлууд)-ыг санхүүгийн нэгтгэсэн тайлангуудад тусгана. Залруулга шаардахгүй, материаллаг хэмжээтэй, тайлант хугацааны дараах үйл явдлуудыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулж өгнө.





2. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

2.4 **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (Үргэлжлэл)**

(ц) **Холбоотой талуудын гүйлгээ**

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилгоор, доорх шаардлагуудыг хангасан үед тухайн тал нь Группийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (а) Холбоотой тал нь шууд эсвэл шууд бусаар нэг болон түүнээс дээш зуучлагчдаар дамжуулан Группийг хянах чадвартай эсвэл нөгөө талынхаа санхүү ба үйл ажиллагааны шийдвэрт томоохон нөлөө үзүүлэх чадвартай, эсвэл хамтын хяналтанд байлгадаг бол;
- (б) Групп болон талууд нэг хяналтанд байдаг бол;
- (в) Тал нь Группийн гол удирдах ажилтан эсвэл гол удирдах ажилтны гэр бүлийн ойрын гишүүн, эсвэл эдгээр хүмүүсийн хяналт, хамтын хяналт эсвэл томоохон нөлөөлөл доор байх нэгж, байгууллага бол;
- (г) Тал нь (а)-д дурдсан талын гэр бүлийн ойрын гишүүд эсвэл эдгээр хүмүүсийн хяналт, хамтын хяналт эсвэл томоохон нөлөөлөл доор байдаг байгууллага бол;
- (д) Тал нь Групп болон Группийн холбоотой тал болох ямар нэг аж ахуй нэгжийн ажилчдад олгосон ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө

Гэр бүлийн ойрын гишүүд гэдэг нь тухайн хувь хүний Групптэй харьцах харилцаанд нөлөө үзүүлэх буюу нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

Засгийн газрын хяналтандаа байлгадаг бусад байгууллагуудтай бизнесийн хэвийн үйл ажиллагааны харилцаатай үед тэдгээрийн холбоотой талуудад хамруулж үздэггүй.


3. **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД**

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх ажил нь удирдлагаас тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр, тайлант үеийн орлого, зардалд тайлагнасан дүнд нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг. Төсөөлөл, ойролцоолсон тооцооллуудыг байнга шалгаж үздэг ба эдгээр нь удирдлагын туршлага ба ирээдүйн үйл явдлын талаарх хүлээлт (тухайн нөхцөлд зохистой гэж үзэж байгаа) гэх мэт бусад хүчин зүйлүүд дээр суурилдаг. Гэхдээ эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг дүнтэй залруулга хийхэд хүргэж болно.

Тайлан тэнцлийн өдрийн байдлаар хийгдсэн, дараагийн тайлант жилд хөрөнгийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болзошгүй тооцооллуудын тодорхой бус байдлын ирээдүйн болон бусад томоохон эх үүсвэрүүдийн талаарх гол төсөөллүүдийг доор дурдав.

Групп нь тооцоолол төсөөллийн параметруудийг Санхүүгийн тайлан бэлтгэх явцад үндэслэн гаргадаг. Одоогийн санхүүгийн байдал ба ирээдүйн хөгжлийн төсөөлөл нь зах зээлийн өөрчлөлт эсвэл Группийн удирдлагаас үл хамааран өөрчлөгдөж болно. Ийм өөрчлөлтүүд тохиолдсон даруйд төсөөлөл хэсэгт тусгагдана.





3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Уурхайн хөгжүүлэлтийн зардал

Уурхайн хөрөнгийг түүний бодит насжилтын хязгаар болон эдийн засгийн чадвар хоёрыг харгалзан жил бүр үнэлдэг. Энэ нь нөхөн төлөгдөх нөөц болон ирээдүйн хөрөнгийн зардлуудын тооцооллуудыг үнэлж үзэхийг шаарддаг.

Уурхайн хөгжүүлэлтийн зардал (үргэлжлэл)

Хэрэв шинэ мэдээлэл олдвол, хийсэн тооцоолол, төсөөллүүд өөрчлөгдөж болно. Үйл ажиллагаа нь зогссон уурхайн хөгжүүлэлтийн хөрөнгө нь данснаас хасагддаг ба тухайн хугацааны дэлгэрэнгүй орлогын тайланд бусад зардлаар тайлагнана. Группийн капиталжуулсан уурхайн хөгжүүлэлтийн хөрөнгийн бүртгэлийн дүнг Тодруулга 11-т толилуулсан болно

Нүүрсний нөөц

Нүүрсний нөөц нь Группийн уурхайн өмчөөс эдийн засгийн болон хууль ёсны дагуу гарган авах боломжтой нүүрсний тооцоолсон дүн юм. Групп нүүрсний нөөцийн хэмжээ, гүн, хэлбэрийн талаарх геологийн тоо баримттай холбоотой мэдээллүүдийг зохих мэргэжилтэн, мэдээлэл дээр үндэслэн нүүрсний нөөцийг тооцоолсон бөгөөд тоо баримтыг хөрвүүлэхэд геологийн нарийн үнэлэмж шаардана. Нөхөн төлөгдөх нөөцийн тооцоолол нь нүүрсний нөөцийн хэмжээ болон чанарыг тооцоход шаардлагатай геологийн төсөөлөл, үнэлэмжээс гадна гадаад валютын ханш, өргөн хэрэглээний барааны үнэ, ирээдүйн өөрийн хөрөнгийн шаардлага, үйлдвэрлэлийн зардал гэх мэт хүчин зүйлсэд үндэслэсэн. Нөөц тооцооллын өөрчлөлт нь үйлдвэр, тоног төхөөрөмжийн бүртгэлийн дүн, уурхайн нөхөн сэргээлтийн нөөц, хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө болон элэгдэл, шавхагдлын зардлын хүлээн зөвшөөрөлтөд нөлөө үзүүлж болно.

Уурхайн нөхөн сэргээлтийн сан

Сангийн хэмжээг тодорхойлоход олон хүчин зүйл нөлөөлдөг тул нөхөн сэргээлтийн санг тодорхойлоход томоохон үнэлэмж, тооцоолол хийхийг шаарддаг. Үүнд нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны цар хүрээ болон өртөг, технологийн өөрчлөлт, зохицуулалтын өөрчлөлт болон хөнгөлөлтийн хувийн өөрчлөлт зэрэг орно. Эдгээр тодорхойгүй байдлын улмаас ирээдүйд гарах бодит зардал нь одоогийн тооцсон зардлаас өөр байж болно. Санхүүгийн нэгтгэсэн тайланд ирээдүйн тооцсон зардлын өөрчлөлтийг уурхайн хөгжүүлэлтийн хөрөнгө болон уурхайн нөхөн сэргээлтийн санд залруулга хийж, хүлээн зөвшөөрнө. Уурхайн нөхөн сэргээлтийн тооцсон санг Тодруулга 22-т толилуулсан.





3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөрс хуулалтын зардал

Групп ил уурхайн бүтээн байгуулалт ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хөрс хуулалтын зардлыг гаргадаг. Үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалтын үйл ажиллагаа нь (хөрс хуулалтын зардал) тайлант хугацааны бараа материалын үйлдвэрлэл болон ирээдүйд олборлох хүдрийн биетэд хүрэх замыг бэлдэх гэсэн хоёр үр өгөөжийг бий болгодог. Эдгээр хөрс хуулалтын үйл ажиллагааны үед гарч буй зардлын хэсэг нь бараа материалын өртгөөр бүртгэгдэх бол нөгөө хэсэг нь тогтсон шалгууруудыг хангасан тохиолдолд хөрс хуулалтын хөрөнгө болж бүртгэгдэнэ. Бүтээн байгуулалтын үе шатны хөрс хуулалтын үйл ажиллагааг үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалтын үйл ажиллагаанаас ялгаж үйлдвэрлэлийн үе шатны хөрс хуулалт нь бараа материалыг үйлдвэрлэж байгаа эсвэл хөрс хуулалтын хөрөнгийг бий болгож буй эсэхийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай.

Групп уурхайн хөрс хуулалтын үйл ажиллагаатай уялдуулан хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлдог. Тогтоогдож болох бүрэлдэхүүн хэсэг гэдэг нь хөрс хуулалтын үйл ажиллагааны явцад ирээдүйд олборлохоор бэлдсэн хүдрийн биетийн тусгай хэсгийг хэлнэ. Эдгээр бүрэлдэхүүн хэсгийг олж тогтооход нарийн үнэлэмж шаардлагатай. Уурхайн төлөвлөгөө дээр үндэслэн уурхай бүрийн үйл ажиллагааг энэхүү үнэлэмжээр дүгнэнэ. Уурхай бүрийн төлөвлөгөө, хүдрийн биетийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох явц нь дараах хүчин зүйлсээс хамаарч өөр хоорондоо ялгаатай байдаг. Үүнд: ашигт малтмалын бүтээгдэхүүний нэр төрөл, хүдрийн биетийн геологийн онцлог шинж чанарууд, газар зүйн байршил болон санхүүжилтийн асуудлууд багтана. Хөрс хуулалтын хөрөнгийг Тодруулга 12-т тусгав.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Удирдлага үнэ цэнэ бууралтын ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд бэлэн мөнгө бий болгогч нэгж бүрийг жил болгон үнэлдэг. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнд албан ёсоор тооцоолол хийдэг ба энэ нь бодит үнээс борлуулах өртгийг хассан дүн ба хөрөнгийн ашиглалтын үнийн аль ихээр тодорхойлогдоно. Бодит үнэ цэнийг мэдээлэлтэй, зөвшөөрсөн талууд бизнесийг хэвийн үйл ажиллагааны гүйлгээний үед хөрөнгийг худалдан авах дүнгээр тодорхойлно. Эдгээр үнэлгээ нь урт хугацааны өргөн хэрэглээний барааны үнэ, хорогдуулалтын хувь хэмжээ, ирээдүйн капиталын хэрэгцээ шаардлага, хайгуулын боломж ба үйл ажиллагааны гүйцэтгэл зэрэг тооцоолол, төсөөлөл ашиглахыг шаарддаг.

Үйл ажиллагааны мөнгөн нэгжийг тодорхойлох

Группд хамаарах, холбогдох нөхцөл байдлын эдийн засгийн агуулга дээр үндэслэн Группийн үйл ажиллагааны мөнгөн нэгж нь Монгол төгрөг байна гэж тодорхойлсон. Группийн үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн үндсэн орчны мөнгөн нэгж нь монгол төгрөг ба энэ нь гол зардлуудын төлбөр хийгддэг мөнгөн нэгж юм.





3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бараа материалын үнэ цэнийн бууралтыг тооцоолох

Групп нь ашиглагдахгүй удсан бараа материалд сан байгуулах шаардлагатай үед ашиглагдахгүй удсан эсвэл борлуулах боломжгүй болсон бараа материал байгаа эсэхийг шалгадаг. Эдгээр шалгалт нь удирдлагыг тухайн бараа материал, бүтээгдэхүүний ирээдүйн эрэлтийг үнэлэхийг шаарддаг. Энэхүү үнэлэмж, төсөөлөлд гарах өөрчлөлтүүд нь бараа материалын үнэлгээнд өөрчлөлт оруулж болно.

Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтыг тооцоолох

Групп нь ирээдүйд авлагаас учрах боломжит алдагдлын хэмжээгээр үнэ цэнэ бууралтын сан байгуулдаг. Энэхүү сангийн дүн нь удирдлагын түүхэн авлага цуглуулах туршлага болон бусад эргэн төлөлтөнд нөлөөлөхүйц хүчин зүйлүүдийн үнэлэмжээс шалтгаална. Тиймээс аль ч тайлант хугацаанд бүртгэсэн үнэ цэнийн бууралтын зардал нь тухайн жилийн үнэлэмж, тооцоолол болон төсөөллөөс хамааран өөрчлөгдөж байдаг.

4. ОРЛОГО БОЛОН СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ

Группийн үйл ажиллагаа нүүрс олборлолт гэсэн нэг салбарт төвлөрдөг бөгөөд бүх хөрөнгө нь Монгол улсад байршдаг. Орлого нь гол төлөв Монгол улсын засгийн газрын хувь оролцоо бүхий Монгол улсад байршилтай худалдан авагчдаас орж ирдэг.

5. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

	2015 мян.төг	2014 мян.төг
Үйл ажиллагаанд ашигласан сэлбэг хэрэгсэл (Тод.16)	22,574,884	19,539,802
Цалин хөлс, урамшуулал	21,660,374	15,917,403
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тод.13)	20,013,210	8,427,641
Түлшний зардал	15,417,540	14,946,281
Ашиглалтын зардлууд	5,314,125	4,059,794
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	2,916,603	2,121,614
Татварын зардал	2,839,231	2,348,721
Ажилчдын тэтгэврийн сангийн зардал (Тод.23)	1,392,714	1,270,981
Хөрс хуулалтын хөрөнгийн шавхагдал (Тод.12)	755,777	216,362
Бусад	2,616,330	1,440,708
	95,500,788	70,289,307



6. БУСАД ОРЛОГО

	2015 мян.төг	2014 мян.төг
Засгийн газрын тусламжийн хорогдуулга (Тод.21)	3,090,896	3,215,753
Бусад үйл ажиллагааны орлого	1,528,725	533,307
Зочид буудал, ресторан бусад үйлчилгээний орлого	1,211,489	1,293,803
Түрээсийн орлого	163,649	136,751
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз- цэвэр	16,639	-
Дансны авлага болон бусад авлагын үнэ цэнийн бууралтын буцаалт (Тод.17,18)	9,914	271,133
Бусад орлого	9,192	7,978
	<u>6,030,504</u>	<u>5,458,725</u>

7. УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2015 мян.төг	2014 мян.төг
Цалин хөлс, урамшуулал	2,213,960	2,902,385
Ажилчдад үзүүлсэн бусад урамшуулал	777,738	87,490
Борлуулалтын зардал	651,067	460,674
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол (Тод.13,14)	485,472	379,711
Ажилчдын тэтгэвэр (Тод.23)	329,453	300,657
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	284,828	230,207
Бусад	661,694	351,343
	<u>5,404,212</u>	<u>4,712,467</u>

8. БУСАД ЗАРДАЛ

	2015 мян.төг	2014 мян.төг
Зочид буудал, ресторан бусад үйлчилгээний зардал	2,084,823	1,915,244
Үйл ажиллагааны бус зардал	873,485	8,958
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тод.13)	63,077	131,136
Дансны авлага болон бусад авлагын үнэ цэнийн бууралт (Тод.17,18)	9,950	129,556
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз- цэвэр	-	138,742
Бусад авлага данснаас хассаны гарз (Тод.17)	-	26,931
Бусад	577,268	136,519
	<u>3,608,603</u>	<u>2,487,086</u>





9. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ - ЦЭВЭР

	2015 мян.төг	2014 мян.төг
Хүүний зардал	4,619,292	5,194,390
Хүүний орлого	(54,909)	(124,148)
	<u>4,564,383</u>	<u>5,070,242</u>

10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР


	2015 мян.төг	2014 мян.төг
Тайлант жилийн орлогын албан татвар		
Тайлант жилийн үр дүнд суурилсан	(21,685)	(3,249,007)
ЭЗИТБ тухай хуулийн дагуу чөлөөлөгдсөн албан татварын дүн	3,239,461	—
Хойшлогдсон орлогын албан татвар	<u>87,869</u>	<u>53,693</u>
	<u>3,305,645</u>	<u>(3,195,314)</u>

Групп тайлант жилийн орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын албан татварын зардлыг тооцдог. Групп 3 тэрбум (2014 онд 3 тэрбум) төгрөг хүртэлх ашгаас 10% (2014 онд 10%), 3 тэрбум (2014 онд 3 тэрбум) төгрөгөөс дээш ашгаас 25% (2014 онд 25%)-ийн орлогын албан татвар төлдөг.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг 2015 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын албан татварын зардалд хэрхэн тохируулсныг доор үзүүлэв. Үүнд:

	2015 мян.төг	2014 мян.төг
Татварын өмнөх ашиг	<u>1,377,023</u>	<u>(13,876,085)</u>
10%-ийн орлогын албан татвар (2014: 25%)	137,702	(3,469,021)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	(51,069)	(192,400)
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын нөлөө	-	27,951
Татвар ногдохгүй орлогын нөлөө	991	67,783
10% -аас 25% -ийн татварын түвшний өөрчлөлтийн нөлөө	-	455,193
Хойшлогдсон татварын хөрөнгийн хөдөлгөөн дэх 25% -аас 10% -ийн татварын түвшний өөрчлөлтийн нөлөө	7,232	(80,540)
Түр зөрүүний нөлөө	(28,672)	(4,280)
Татварын өршөөлийн өгөөж	<u>3,239,461</u>	<u>—</u>
	<u>3,305,645</u>	<u>(3,195,314)</u>





10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хойшлогдсон татвар

Дараах хүснэгтэд санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд тусгагдсан хойшлогдсон татварын хөрөнгө болон орлогын албан татварын зардалд гарсан өөрчлөлтийг харууллаа:


	Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан		Дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайлан	
	2015 мян.төг	2014 мян.төг	2015 мян.төг	2014 мян.төг
<i>Хойшлогдсон татварын хөрөнгө :</i>				
Татварын суурьтай харьцуулсан үндсэн хөрөнгийн бүртгэлээрх элэгдлийн илүүдэл	839,322	426,360	412,961	256,835
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй алдагдал	(1,664)	14,059	(15,723)	14,059
Шилжүүлсэн алдагдлын ашиглалт	154,003	—	154,003	(272,823)
Ажилчдын тэтгэвэр тэтгэмж	981,609	801,402	180,207	72,547
Татварын жилээс урт хугацаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн элэгдлийн өгөөж	(680,589)	(37,009)	(643,579)	(16,925)
Цэвэр хойшлогдсон албан татварын хөрөнгө	<u>1,292,681</u>	<u>1,204,812</u>	<u>87,869</u>	<u>53,693</u>

11. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Нэгж хувьцаанд ногдох ашгийг тооцоолохдоо Группийн тухайн жилийн цэвэр ашгийн дүнг тухайн жилийн энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж тооцно.

	Компани	
	2015 мян.төг	2014 мян.төг
Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилагдах цэвэр ашиг (мян.төг)	1,928,662	10,680,771
Энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	20,974	20,974
Нэгж энгийн хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашиг (мян.төг)	92	509





12. УУРХАЙН ХӨРӨНГӨ

2015 оны 12 дугаар сарын 31-нээр	Уурхайн хөгжүүлэлт мян.төг	Хөрс хуулалтын хөрөнгө мян.төг	Нийт мян.төг
Өртөг			
1 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	4,840,275	20,321,549	25,161,824
Нэмэгдсэн	-	11,875,864	11,875,864
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,840,275	32,197,413	37,037,688
Элэгдэл, шавхагдал			
1 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	-	(218,775)	(218,775)
Тайлант жилд зардалд хүлээн зөвшөөрсөн (Тод.5)	(31,029)	(724,748)	(755,777)
Тухайн жилд бараа материалд шилжүүлсэн	-	(6,471)	(6,471)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	(31,029)	(949,994)	(981,023)
Дансны цэвэр дүн	4,809,246	31,247,419	36,056,665

2014 оны 12 дугаар сарын 31-нээр	Уурхайн хөгжүүлэлт мян.төг	Хөрс хуулалтын хөрөнгө мян.төг	Нийт мян.төг
Өртөг			
1 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	71,700	7,348,002	7,419,702
Нэмэгдсэн	4,768,575	12,973,547	17,742,122
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	4,840,275	20,321,549	25,161,824
Элэгдэл, шавхагдал			
1 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	-	-	-
Тайлант жилд зардалд хүлээн зөвшөөрсөн (Тод.5)	-	(216,362)	(216,362)
Тухайн жилд бараа материалд шилжүүлсэн	-	(2,413)	(2,413)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	(218,775)	(218,775)
Дансны цэвэр дүн	4,840,275	20,102,774	24,943,049

Хөрс хуулалтын хөрөнгөнд Группийн хөрс хуулалттай холбоотой гарсан элэгдлийн зардал, цалин хөлс, түлш шатахуун, гэрээний төлбөрүүд болон бусад зардлууд багтсан болно. Хөрс хуулалтын хөрөнгийн нэмэгдэл нь олборлолт хийгдээгүй 6,390,982 м3 (2014 7,231,221 м3) талбайн хуулсан хөрсний хэмжээгээр нэмэгдсэн.

Уурхайн хөгжүүлэлтийн нэмэгдэлд геологийн үйлчилгээний төлбөр 2014 онд 4,570,555 мянган төгрөг багтсан (Тод.21).

0000156




БАГАНУУР ЖК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД - 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Барилга		Машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл		Тавилга эд хогшил		Компьютер		Дуусаагүй барилга		Нийт	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2015 оны 12 дугаар сарын 31-нээр												
Өртөг												
2015.01.01-ний үлдэгдэл	25,806,082	99,137,258	1,554,513	1,381,018	28,636	127,907,507						
Нэмэгдсэн	1,750,872	14,048,676	1,397,005	129,897		17,326,450						
Шилжүүлсэн		28,636							(28,636)			
Данснаас хассан (Тод. 8)	(579,151)	(453,551)	(125,113)	(459,279)		(1,617,094)						
2015.12.31-ний үлдэгдэл	26,977,803	112,761,019	2,826,405	1,051,636		143,616,863						
Хуримтлагдсан элэгдэл												
2015.01.01-ний үлдэгдэл	10,008,137	41,591,562	913,082	1,023,606		53,536,387						
Тайлант жилд байгуулсан (Тод. 5, 7)	1,612,142	20,869,150	451,554	141,438		23,074,284						
Данснаас хассан (Тод. 8)	(544,880)	(439,835)	(117,335)	(451,967)		(1,554,017)						
2015.12.31-ний үлдэгдэл	11,075,399	62,020,877	1,247,301	713,077		75,056,654						
Дансны цэвэр дүн												
2015.12.31-ний үлдэгдэл	15,902,404	50,740,142	1,579,104	338,559		68,560,209						



0000157

БАГАНУУР ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛЛУУД - 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31


13. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Барилга		Машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл		Тавилга эд хогшил		Компьютер		Дуусаагүй барилга		Нийт	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Өртөг												
2014.01.01-ний үлдэгдэл	21,903,297	92,818,948	1,450,214	1,321,769	1,912,256	119,406,484						
Нэмэгдсэн	2,305,364	6,320,423	119,785	59,697	28,636	8,833,905						
Шилжүүлсэн	1,912,256	-	-	-	(1,912,256)	-						
Худалдсан	(77,243)	-	(11,846)	-	-	(89,089)						
Данснаас хассан (Тод. 8)	(237,592)	(2,113)	(3,640)	(448)	-	(243,793)						
2014.12.31-ний үлдэгдэл	25,806,082	99,137,258	1,554,513	1,381,018	28,636	127,907,507						
Хуримтлагдсан элэгдэл												
2014.01.01-ний үлдэгдэл	9,090,199	34,093,815	764,209	919,187	-	44,867,410						
Тайлант жилд байгуулсан (Тод. 5, 7)	1,032,230	7,505,021	152,513	104,867	-	8,794,631						
Худалдсан	(651)	-	-	-	-	(651)						
Данснаас хассан (Тод. 8)	(113,641)	(7,274)	(3,640)	(448)	-	(125,003)						
2014.12.31-ний үлдэгдэл	10,008,137	41,591,562	913,082	1,023,606	-	53,536,387						
Дансны цэвэр дүн												
2014.12.31-ний үлдэгдэл	15,797,945	57,545,696	641,431	357,412	28,636	74,371,120						

Засгийн газрын тусламжаар санхүүжигдсэн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нь 1,039,892 мян.төг (2014: 1,039,892 мян.төг) (Тод. 21).
2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,795,239 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө Тодруулга 24-т үзүүлэнээр Монгол улсын Хөгжлийн Банк, Хаан банк болон Голомт банкны зээлийн барьцаанд бүртгэлтэй байсан. (2014: 27,506,790 мян. төг)



0000152



14. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Програм хангамж мян.төг	Бусад биет бус хөрөнгө мян.төг	Нийт мян.төг
2015 оны 12 дугаар сарын 31-нээр			
Өртөг			
1 дүгээр сарын 1	149,305	1,600	150,905
Нэмэлт	364,449	-	364,449
Данснаас хассан	(46,691)	-	(46,691)
12 дугаар сарын 31	467,063	1,600	468,663
Хорогдол			
1 дүгээр сарын 1	(130,945)	(215)	(131,160)
Тухайн жилд байгуулсан (Тод.7)	(78,831)	(107)	(78,938)
Данснаас хассан	46,691	-	46,691
12 дугаар сарын 31	(163,085)	(322)	(163,407)
Цэвэр дансны дүн			
12 дугаар сарын 31	303,978	1,278	305,256

	Програм хангамж мян.төг	Бусад биет бус хөрөнгө мян.төг	Нийт мян.төг
2014 оны 12 дугаар сарын 31-нээр			
Өртөг			
1 дүгээр сарын 1	136,074	1,600	137,674
Нэмэлт	13,231	-	13,231
12 дугаар сарын 31	149,305	1,600	150,905
Хорогдол			
1 дүгээр сарын 1	(118,331)	(108)	(118,439)
Тухайн жилд байгуулсан (Тод.7)	(12,614)	(107)	(12,721)
12 дугаар сарын 31	(130,945)	(215)	(131,160)
Цэвэр дансны дүн			
12 дугаар сарын 31	18,360	1,385	19,745


15. ХАРААТ КОМПАНИ ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Групп 1996 онд Монгол улсад бүртгэлтэй цахилгаан машин, тоног төхөөрөмж засварын үйл ажиллагаа эрхэлдэг Мон-Цахим ХХК-ийн 46%-ийг эзэмшсэн.

0000159

46





15. ХАРААТ КОМПАНИ ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хараат компани дахь хөрөнгө оруулалтын хөдөлгөөнийг доорх хүснэгтэнд үзүүлэв:

	2015 мян.төг	2014 мян.төг
Хөрөнгө оруулалтын өртөг	67,049	67,049
Хуримтлагдсан цэвэр ашгийн хувь		
1 дүгээр сарын 1	93,584	93,584
Цэвэр ашгийн хувь	73,340	62,201
Хүлээн авсан ногдол ашиг	-	(62,201)
Бусад	40,071	-
12 дугаар сарын 31	206,995	93,584
12 дугаар сарын 31-нээрх нийт хөрөнгө оруулалт	274,044	160,633

Хараат компанийн хураангуйлсан санхүүгийн мэдээллийг доор үзүүлэв:

	2015 мян.төг	2014 мян.төг
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгө	922,942	949,621
Эргэлтийн бус хөрөнгө	572,944	238,958
Богино хугацаат өр төлбөр	(585,241)	(670,456)
Урт хугацаат өр төлбөр	(75,999)	-
Цэвэр хөрөнгө (өр төлбөр)	834,646	518,123
Дэлгэрэнгүй орлогын тайлан		
Орлого	1,400,229	1,529,512
Цэвэр ашиг	159,436	135,219
Компанид ногдох тайлант жилийн ашгийн хувь	73,340	62,201


16. БАРАА МАТЕРИАЛ

	2015 мян.төг	2014 мян.төг
Жигнэсэн дундаж өртгөөр		
Нүүрс	1,053,808	817,911
Сэлбэг хэрэгсэл	16,641,630	17,648,065
Хэрэглээний эд зүйлс	1,188,380	1,179,222
Бусад	495,001	362,390
	19,378,819	20,007,588
Үнэ цэнийн бууралтын сан	(5,369,154)	(5,369,154)
	14,009,665	14,638,434

Бараа материалын үнэ цэнийн бууралтын сан 5,369,154 мян.төг (2014: 5,369,154 мян.төг) нь хуучирсан сэлбэг хэрэгсэлд хамаарна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хүлээн зөвшөөрсөн бараа материалын өртөг 22,574,884 мян.төг болно. (2014: 19,539,802 мян.төг) (Тод: 5)

0000160





17. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР БОЛОН БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

	2015 мян.төг	2014 мян.төг
Урьдчилж төлсөн зардал	248,776	1,826,233
Гуравдагч этгээдээс авах авлага	1,461,403	1,544,302
Ажилдал олгосон урьдчилгаа	397,065	169,576
Холбоотой талаас авах авлага (Тод. 26)	136,620	83,314
НӨАТ-н авлага	-	352,012
Бусад	188,548	87,910
	<u>2,432,412</u>	<u>4,063,347</u>
Үнэ цэнийн бууралтын сан	(532,194)	(532,194)
	<u>1,900,218</u>	<u>3,531,153</u>

Урьдчилж төлсөн зардалд гол төлөв бэлтгэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, компаниудад төлсөн урьдчилгаа, урьдчилж төлсөн даатгалын төлбөр болон түлш худалдан авалт зэрэг нь хамаарна. Гуравдагч этгээдээс авах авлага нь орон нутгийн худалдан авагчидтай хийсэн баталгаагүй, хүүгүй болон урьдчилан төлөх төлбөрийн нөхцөлгүй гүйлгээнүүд болно.

Холбоотой талаас авах авлага нь Группийн холбоотой талуудад худалдсан сэлбэг хэрэгсэл бөгөөд барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх тогтмол нөхцөлгүй болно.

Нэмэгдсэн Өртгийн Албан Татварын авлага нь Группийн худалдан авалт болон борлуулалтын ажил гүйлгээнээс үүссэн.


Групп нь 26,931 мян.төгрөгийн бусад авлагыг 2014 онд данснаас шууд хассан (Тод.8).

Доорх хүснэгтэд Группийн урьдчилж гарсан зардал болон бусад эргэлтийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулгын хөдөлгөөнийг харуулсан болно:

	2014 мян.төг	2013 мян.төг
1 дүгээр сарын 1	532,194	520,531
Тайлант жилд байгуулсан (Тод. 8)	-	55,863
Үнэ цэнэ бууралтын буцаалт (Тод. 6)	-	(44,200)
	<u>532,194</u>	<u>532,194</u>

0000161





18. ДАНСНЫ АВЛАГА

	2014 мян.төг	2013 мян.төг
Дансны авлага:	8,875,662	10,021,870
Үнэ цэнэ бууралтын хасагдуулга	(118,583)	(118,547)
	<u>8,757,079</u>	<u>9,903,323</u>

Дансны авлагууд нь хүүгүй ба тохиолдол тус бүрээс хамааран ерөнхийдөө 30 хоногийн хугацаатай байна. Эдгээр авлагуудыг тэдгээрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ болох нэхэмжлэхийн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Групп төрийн өмчит байгууллагуудаас томоохон хэмжээний авлагуудтай бөгөөд удирдлагын зүгээс эдгээр нь эрсдэлгүй гэж үзэж байна.

2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх дансны авлагын насжилтын тайлан нь дараах байдалтай байна:

	Нийт мян.төг	Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтанд ороогүй мян.төг	30-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтанд ороогүй мян.төг	Хугацаа хэтэрч, үнэ цэнийн бууралтанд орсон мян.төг
2015 оны 12 дугаар сарын 31	<u>8,875,662</u>	<u>8,757,079</u>	—	<u>118,583</u>
2014 оны 12 дугаар сарын 31	<u>10,021,870</u>	<u>9,903,323</u>	—	<u>118,547</u>

Группийн дансны авлагын үнэ цэнийн бууралтын өөрчлөлт нь дараах байдалтай байна:

	2015 мян.төг	2014 мян.төг
1 дүгээр сарын 1	118,547	271,787
Тайлант жилд байгуулсан (Тод. 8)	9,950	73,693
Үнэ цэнийн бууралтын буцаалт (Тод. 6)	(9,914)	(226,933)
	<u>118,583</u>	<u>118,547</u>

Тайлагналын өдөр дангаар үнэ цэнийн бууралттай гэж тодорхойлсон дансны болон бусад авлагууд нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, эргэн төлөх хугацаа нь хэтэрсэн зээлдэгч нартай холбоотой. Эдгээр авлагууд нь ямар нэгэн барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй эсвэл зээлийн нөхцөлийн сайжруулалтгүй болно.

0000162





19. БЭЛЭН МӨНГӨ БА БАНКИН ДАХЬ ХАРИЛЦАХ

	2015 мян.төг	2014 мян.төг
Бэлэн мөнгө	5,848	20,914
Банкны харилцах дахь мөнгөн хөрөнгө	6,174,592	3,094,395
	6,180,440	3,115,309

Банкны харилцах дахь мөнгөн хөрөнгө нь тогтмол хүүтэй Монгол төгрөг болон Америк долларын данснаас бүрдэнэ. Группийн банкны харилцах дансан дахь мөнгөн хөрөнгөөс олсон хүүний орлого нь 54,909 мян.төг (2014: 124,148 мян.төг) болно (Тод.6).

20. ХУВЬЦААТ КАПИТАЛ БА НӨӨЦ

	2015 мян.төг	2014 мян.төг
Энгийн хувьцаа – Нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй		
Гаргасан болон бүрэн төлөгдсөн – 20,974,360 ширхэг хувьцаа	2,097,436	2,097,436

Энгийн хувьцаа эзэмшигчид нь ногдол ашиг зарласан үед түүнийг авах болон компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд эзэмшиж буй хувьцааныхаа тоотой тэнцүү саналын эрхтэй оролцоно. Бүх энгийн хувьцаа нь компанийн үлдэх хөрөнгөнд хувь тэнцүүлэн тэгш байна.

21. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАМЖ

Жилийн эцсийн байдлаарх Засгийн газрын тусламж нь доорхоос бүрдэж байна.

	2015 мян.төг	2014 мян.төг
Үндсэн хөрөнгө худалдан авалт	5,765,083	6,908,964
Уурхайн хөрөнгө худалдан авалт	4,541,255	4,570,555
Сангийн яамнаас авсан зээл-1 МОГ-2854	12,675,313	13,370,765
Сангийн яамнаас авсан зээл-2 МОН-П4	5,401,304	6,269,189
Дулааны 3-р цахилгаан станцаас авсан зээл /Зээл-1/	–	131,761
Дулааны 3-р цахилгаан станцаас авсан зээл /Зээл-2/	–	39,259
	28,382,955	31,290,493

Засгийн газрын тусламж нь үндсэн хөрөнгө худалдан авалт, геологын хайгуулын үйлчилгээний төлбөр болон эрдэс баялагын салбар болон засаглалыг сайжруулахтай холбогдон Сангийн яам болон Дулааны Цахилгаан Станцуудаас бага хүүтэй авсан зээлүүдээс үүссэн. Дансны хөдөлгөөнийг доор харуулав:

0000163





21. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2015 оны 12 дугаар сарын 31-нээр	Уурхайн хөрөнгө мян. төг	Үндсэн хөрөнгө мян. төг	Бага хүүтэй зээл мян. төг	Нийт мян. төг
Өртөг				
1 дүгээр сарын 1	4,570,555	6,908,964	19,810,974	31,290,493
Хүлээн авсан	—	—	183,358	183,358
Тухайн жилийн хорогдол (Тод.6)	(29,300)	(1,143,881)	(1,917,715)	(3,090,896)
12 дугаар сарын 31	<u>4,541,255</u>	<u>5,765,083</u>	<u>18,076,617</u>	<u>28,382,955</u>
Богино хугацаат	—	1,143,881	1,317,412	2,461,293
Урт хугацаат	4,541,255	4,621,202	16,759,205	25,921,662
2014 оны 12 дугаар сарын 31-нээр				
Өртөг				
1 дүгээр сарын 1	—	8,052,845	21,820,646	29,873,491
Хүлээн авсан	4,570,555	—	62,200	4,632,755
Тухайн жилийн хорогдол (Тод.6)	—	(1,143,881)	(2,071,872)	(3,215,753)
12 дугаар сарын 31	<u>4,570,555</u>	<u>6,908,964</u>	<u>19,810,974</u>	<u>31,290,493</u>
Богино хугацаат	—	1,143,881	1,343,980	2,487,861
Урт хугацаат	4,570,555	5,765,083	18,466,994	28,802,632

22. САН

	2015 мян.төг	2014 мян.төг
Сан:		
Уурхайн нөхөн сэргээлтийн сан	1,105,833	1,106,983
Компаний нийгмийн хариуцлагын сан	268,653	—
	<u>1,374,486</u>	<u>1,106,983</u>

Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу уурхайн талбар хөндөгдөх үед нөхөн сэргээхтэй холбогдох ирээдүйд гарах зардлуудаар сан байгуулахыг шаарддаг. Гэвч групп тус тооцооллыг 1999 оноос хойш шинэчлээгүй байна.

Групп нь олон нийтийн болон байгаль орчны хөгжлийн үйл ажиллагаанд зориулан Группийн ирээдүйн нийгмийн хөгжлийн санг бүртгэдэг. Уг санг бүртгэхдээ төлөвлөгөөт борлуулалтаас давсан бодит борлуулалтын хувь хэмжээ, дайвар болон шинэ бүтээгдэхүүний борлуулалт ба түрээсийн орлого зэрэг дээр тулгуурлана.





23. АЖИЛЧДЫН ТЭТГЭВРИЙН САН

Групп ажилчдаа тэтгэвэрт гарах үед салбарт ажилласан жилийн тоог тухайн үеийн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 дахинтай тэнцэх хэмжээнд үржүүлж нэг удаагийн тэтгэмж олгодог.

Групп нь ажилчдыг төлөөлөн үйлдвэрчний эвлэлийн хороотой тэтгэврийн дараах хөтөлбөрийн нөхцөлийг тохиролцон тогтмол хугацаанд хэлэлцдэг. Энэхүү хөтөлбөр нь санхүүжигдээгүй болно.

Сангийн хөдөлгөөнийг доорхи хүснэгтэнд харуулав:

	2015 мян. төг	2014 мян. төг
1 дүгээр сарын 1	8,014,022	7,288,554
Тайлант хугацаанд нэмэгдсэн (Тод. 5,7)	1,722,167	1,571,638
Олгосон төлбөр	(188,753)	(846,170)
12 дугаар сарын 31	<u>9,547,436</u>	<u>8,014,022</u>

Ажилчдын тэтгэврийн сангийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход бууруулсан хувь хэмжээ 12% (2014: 12%) болон цалингийн инфляцийн түвшин 10% (2014: 10%)-ийг ашигласан.

24. ЗЭЭЛ

	2015 мян.төг	2014 мян.төг
Богино хугацаат		
Барьцаатай:		
Банкны зээл	8,333,193	6,136,983
Бусад	-	1,191,023
Барьцаагүй:		
Сангийн Яамнаас авсан зээл	15,584,103	11,235,613
	<u>23,917,296</u>	<u>18,563,619</u>
Урт хугацаат		
Барьцаатай:		
Банкны зээл	6,476,429	11,784,682
Барьцаагүй:		
Сангийн Яамнаас авсан зээл	8,780,953	12,976,969
	<u>15,257,382</u>	<u>24,761,651</u>
Нийт	<u>39,174,678</u>	<u>43,325,270</u>

0000165





24. ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Барьцаагүй зээл – Сангийн Яам

МОГ-2854

МОГ-2854 зээлийг 1996 оны 5 дугаар сарын 24-нд Монгол Улсын Засгийн Газраар (Сангийн Яам) дамжуулан Олон улсын хөгжлийн Ассоциациаас авсан. Анхны гэрээний дүн 23,800,000 ам. доллар (26.5 тэрбум төгрөг). Монгол Улсын Засгийн Газар тухайн зээлийг Багануурын уурхайн сэргээн босголтонд зориулсан бөгөөд 2010 оны Засгийн Газрын 72-р тогтоолын дагуу Компани болон Сангийн Яам зээлийг төгрөгт хөрвүүлэхээр тохиролцож 2012 онд гэрээг дахин үйлдсэн байдаг. Зээл нь эрдэс баялагын салбарын хөгжил болон тус салбарын засаглалыг сайжруулах зорилгоор жилийн 1.7%-ийн хүүтэй олгогдсон. Зээл нь 2031 онд бүрэн төлөгдөж дуусна.

МОН-П4

МОН-П4 зээлийг 1997 оны 5 дугаар сарын 24-нд Монгол Улсын Засгийн Газраар (Сангийн Яам) дамжуулан Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Агентлагаас авсан. Гэрээний анхны дүн 5.827 тэрбум Япон йен (19.6 тэрбум төгрөг) байсан. Монгол Улсын Засгийн Газар тус зээлийг Багануурын уурхайн сэргээн босголтонд зориулсан бөгөөд 2010 оны Засгийн газрын 72-р тогтоолын дагуу Компани болон Сангийн Яам зээлийг төгрөгт хөрвүүлэхээр тохиролцож гэрээг 2012 онд дахин үйлдсэн. Зээл нь эрдэс баялагын салбарын хөгжил болон тус салбарын засаглалыг сайжруулах зорилгоор жилийн 1.7%-ийн хүүтэй олгогдсон. Зээл 2031 онд бүрэн төлөгдөж дуусна.

Барьцаатай зээл – Банкны зээл

Монгол Улсын Хөгжлийн банкны зээл

Багануур ХК 2013 оны 4 дүгээр сард Монгол Улсын Хөгжлийн банкнаас 18.3 тэрбум төгрөгийн зээл авсан. Зээл нь Монгол Улсын Засгийн Газрын 10 дугаар тогтоолын дагуу уурхайн машин, тоног төхөөрөмж худалдан авалтыг санхүүжүүлэх, Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон. Зээл 5 жилийн дараа буюу 2018 онд төлөгдөж дуусах бөгөөд, жилийн 9.6% (2013: 9.6%)-ийн хүүтэй ба уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно.

Хаан банкны зээл

Багануур ХК 2014 оны 8 дугаар сарын 22-нд 2 тэрбум төгрөгийн зээлийг Хаан Банкнаас авсан. Тус зээл нь 12 сарын хугацаатай, 19.2%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан бөгөөд 2015 онд бүрэн төлөгдөж дууссан ба 2015 оны 8 дугаар сарын 22-нд үргэлжлүүлэн 4 тэрбум төгрөгийн зээл авсан. Тус зээл нь 12 сарын хугацаатай, 19.2%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно.

Голомт банкны зээл

Багануур ХК 2015 оны 7 дугаар сарын 4-нд 2 тэрбум төгрөгийн зээлийг Голомт Банкнаас авсан. Тус зээл нь 12 сарын хугацаатай, 21.6%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно.


Барьцаатай зээл – Банкны зээл (үргэлжлэл)

Худалдаа Хөгжлийн Банкны

Багануур ХК 2014 оны 7 дугаар сарын 4-нд 3 тэрбум төгрөгийн зээлийг Худалдаа Хөгжлийн Банкнаас авсан. Зээл нь 12 сарын хугацаатай, 19.2%-ийн хүүтэй бөгөөд уурхайн машин, тоног төхөөрөмжөөр баталгаажсан болно. 2015 онд тус зээлийг бүрэн барагдуулсан.

0000166





24. ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Барьцаатай зээл – Бусад зээл

Дулааны 3-р Цахилгаан Станцаас авсан зээл

Багануур ХК 2013 оны 9 дүгээр сарын 27-нд Дулааны 3-р Цахилгаан Станцаас 6.9 тэрбум төгрөг, 2013 оны 9 дүгээр сарын 6-нд Дулааны 4-р Цахилгаан станцаас 9.9 тэрбум төгрөгийн зээлүүдийг авсан. Зээлүүд нь 12 сарын хугацаатай, жилийн 4.5%-ийн хүүтэй, борлуулалтын орлогоор баталгаажсан болно. Эдгээр зээлүүд нь 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр бүрэн төлөгдөж дууссан.

25. ДАНСНЫ БОЛОН БУСАД ӨГЛӨГ

	2015 мян.төг	2014 мян.төг
Дансны өглөг	26,610,567	17,845,138
Холбоотой талд өгөх өглөг (Тод. 26)	10,966,615	10,967,375
Цалингийн өглөг	3,345,658	1,410,457
ХХОАТ-н өглөг	956,205	591,699
ЭМНДШ-ийн өглөг	893,223	1,297,220
Бусад татварын өглөг	1,655,743	485,732
Бусад	304,139	211,240
	<u>44,732,150</u>	<u>32,808,861</u>

Дансны өглөгүүд нь хүүгүй, ерөнхийдөө 30-аас 60 хоногийн хугацаанд эргэн төлөгддөг.

Засгийн газрын тогтоолын дагуу, толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК компанийн зарим татварын өрийг барагдуулсан. Эдгээрт өглөгт тогтсон төлөх хугацаа болон хүү байхгүй юм.

26. ХОЛБООТОЙ ТАЛЫН ТОДРУУЛГА

Дараах хүснэгтэнд холбоотой талуудтай тайлант жилд хийсэн нийт ажил гүйлгээний дүнгүүд болон 2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ээрх балансын үлдэгдэлтэй холбогдох мэдээллүүдийг толилуулав.

	Холбоотой талаас авах авлага		Холбоотой талд өгөх өглөг	
	2015 мян.төг (Тод.17 ба 18)	2014 мян.төг	2015 мян.төг (Тод.25)	2014 мян.төг
Толгой Компани: Эрдэнэс Монгол ХХК	–	–	(10,161,840)	(10,161,840)
Холбоотой талууд: Шивээ Овоо ХК	136,620	83,314	–	–
Хараат Компани: Мон-Цахим ХХК	–	–	(804,775)	(805,535)
	<u>136,620</u>	<u>83,314</u>	<u>(10,966,615)</u>	<u>(10,967,375)</u>

0000167





26. ХОЛБООТОЙ ТАЛЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2015 мян.төг	2014 мян.төг
Гол удирдах албан тушаалтнуудад олгосон олговор:		
Цалин, урамшуулал болон бусад олговрууд	278,946	184,025
Нийгмийн даатгалын шимтгэл	32,254	24,444
	<u>311,200</u>	<u>208,469</u>

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний нөхцөлүүд

Холбоотой талд төлөх өглөг болон авах авлагын нөхцөлүүдийг Тодруулга 17 ба 25-д тайлбарлагдсан болно. Хараат компаниас авсан машин засвар болон катерингийн 1,413,891 (2014: 1,454,985 мян. төгрөг)-ийн үйлчилгээ нь хоорондоо харилцан хамааралгүй талуудын хоорондох ажил гүйлгээний нөхцөл дээр суурилан хийгддэг болно. Холбоотой талуудаас авах авлага эсхүл төлөх өглөгүүдэд ямарваа нэг батлан даалт хийгдээгүй. Групп 30,418 мян. төгрөгийг (2014: 30,418 мян. төгрөг) холбоотой талуудаас авах авлагын үнэ цэнийн бууралтаар бүртгэсэн (Тод. 17). Энэхүү үнэ цэнийн бууралтын үнэлгээ нь жил бүр холбоотой талуудын санхүүгийн байдал болон тэдгээрийн үйл ажиллагаагаа явуулж буй зах зээлийг үнэлэх байдлаар хийгддэг.

27. АМЛАЛТУУД

	2015 мян.төг	2014 мян.төг
Ашиглалтын лицензын төлбөр	<u>34,643</u>	<u>24,174</u>

28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД

Группийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Группийн ханшийн тэгшитгэлийн өөрчлөлт, хүүний хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүдийг удирдахын зэрэгцээ Группийн хөгжлийг дэмжих санхүүгийн хүрэлцэхүйц баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог. Группийн үйл ажиллагаа нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр батлагдсан бодлогоор тодорхойлогддог бөгөөд энэ нь өндөр эрсдэлтэй ажил гүйлгээнд хэрэглэгдэхгүй.

Групп нь дансны болон бусад авлага, касс ба банкны үлдэгдэл, дансны болон бусад өглөг гэх мэт өөрийн үйл ажиллагаанаас бий болдог олон төрлийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдтэй. Мөн Группд өөрийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн хүүтэй зээлүүд болон хөрөнгө оруулалтууд бий.

Группийн санхүүгийн хөрөнгө, өр төлбөр эсвэл ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж болохуйц гол эрсдэлүүд нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл, хүүний түвшний эрсдэл, төлбөр төлөх чадварын эрсдэл болон зээлийн эрсдэл зэрэг байна. Группийн удирдлага доор үзүүлсэн эрсдэл тус бүрийг удирдах, хяналт тавих хийгээд түүний бодлогыг хянаж баталдаг:

0000153





28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(а) Өргөн хэрэглээний барааны үнийн болон зах зээлийн эрсдэл

Группийн улсын хэвшлийн байгууллагуудад борлуулж буй нүүрсний үнийг дэлхийн зах зээл дээрх өөрчлөлтүүдээс хамаарахгүйгээр Монгол Улсын Засгийн Газар зохицуулдаг.

Тайлагналын өдрийн байдлаар Группд эдгээр эрсдэлийг удирдах ямар нэгэн бодлого байхгүй байсан бөгөөд удирдлагын зүгээс Группийн өргөн хэрэглээний барааны үнийн болон зах зээлийн эрсдэлд орох эрсдэлийн түвшин бага байна гэсэн итгэлтэй байна.

(б) Хүүний түвшний эрсдэл

Зах зээлийн хүүний түвшинд өөрчлөлт орсноос шалтгаалан санхүүгийн хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн урсгалын бодит үнэ цэнэ хэлбэлзэх эрсдэл нь хүүний эрсдэл юм. Группийн эзэмшиж буй тогтмол хүүтэй банкны дансны өглөгт өөрчлөлт орох үед зах зээлийн эрсдэлтэй учирдаг. Тайлагналын өдрийн байдлаар, Групп хүүний түвшний эрсдэлийг хэмжих мэдрэмжийн шинжилгээг хийгээгүй байсан нь Группд хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр байхгүй байсантай холбоотой юм.

(в) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь талууд дуусгавар хугацаа нь болоход үүргээ биелүүлж чадаагүйгээс үүсэх гарз юм. Зээлийн эрсдэл нь бизнесийн салшгүй нэг хэсэг ба дуусгавар хугацаанд харилцагчид болон бусад талууд үүргээ гүйцэтгэж чадаагүйгээс эсвэл зах зээлийн сөрөг нөхцөл байдлын үед зээлийн эрсдэлд ордог.

Групп зөвхөн улсын хэвшлийн, нийтэд танигдсан, төлбөрийн чадвар бүхий байгууллагуудад борлуулалт хийдэг. Зээлээр худалдаа хийх хүсэлтэй харилцагчид нь зээлийн баталгаажуулалтын горимд хамрагдах нь группийн бодлого юм. Мөн авлагын үлдэгдэл нь хугацааны туршид хянагдаж байдаг.

Групп нь дараах санхүүгийн хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийг ил болгодог:

- Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө- групп нь дотоодын нэр хүндтэй банкуудтай харилцдаг учир өртөх нь бага.
- Авлага - Групп нь авлага цуглуулалтын эрсдэлд өртдөг.


(д) Төлбөрийн чадварын эрсдэл

Групп нь өөрийн бүх эргэн төлөлт ба санхүүжилтийн хэрэгцээ хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд өөрийн үйл ажиллагааны мөнгөн урсгал ба санхүүжилтийг идэвхитэй удирддаг. Групп нь өөрийн төлбөрийн чадварын зохистой ерөнхий удирдлагын хүрээнд ажлын капиталын шаардлагуудыг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг байршуулдаг.

Дараах хүснэгтэд Группийн санхүүгийн өр төлбөрүүдийн гэрээний бууруулаагүй дүнг дуусгавар хугацаагаар нь ангилан харуулав.

0000169





28. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(д) Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

2015:

	Төлөхөд бэлэн байгаа мян.төг	1 жилийн дотор мян.төг	1 жилээс дээш мян.төг	Нийт мян.төг
Зээл:				
Үндсэн төлбөр	25,042,981	6,510,969	25,505,618	57,059,568
Хүү	191,728	1,429,522	3,563,439	5,184,689
Дансны ба бусад өглөг	26,914,706	14,312,273	—	41,226,979
	<u>52,149,415</u>	<u>22,252,764</u>	<u>29,069,057</u>	<u>103,471,236</u>

2014:

	Төлөхөд бэлэн байгаа мян.төг	1 жилийн дотор мян.төг	1 ээс дээш жил мян.төг	Нийт мян.төг
Зээл:				
Үндсэн төлбөр	12,678,423	11,268,670	36,824,831	60,771,924
Хүү	4,093,913	2,429,917	7,482,367	14,006,197
Дансны ба бусад өглөг	18,056,378	12,377,832	—	30,434,210
	<u>34,828,714</u>	<u>26,076,419</u>	<u>44,307,198</u>	<u>105,212,331</u>



29. КАПИТАЛЫН УДИРДЛАГА

Группийн капиталын удирдлагын зорилгоор, капиталд зарцуулсан капитал, хөрвөх нөхцөлтэй хувьцаа, хувьцааны урамшуулал болон эздийн өмчид хуваарилагдах бусад бүх капиталын нөөцийг оруулна. Группийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь өөрийн бизнесийг дэмжих ба хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Групп өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдалд орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Групп капиталынхаа бүтцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэгсэл гаргах замуудыг ашигладаг байна. 2015 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн капиталын удирдлагын зорилт болон бодлого, үйл явцад өөрчлөлт гараагүй болно

0000170





30. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖИЛТ

Түвшнүүдийн хоорондох шилжилт

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдийн хувьд бодит үнэ цэнийн 1-ээс 3 түвшний хооронд ямар нэг шилжилт байхгүй.

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдээгүй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ
Санхүүгийн хэрэглүүрт бодит үнэ цэнээрээ хараахан бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан аргачлал болон төсөөллийг доор дурдав:

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүд

Группийн тогтмол хүүтэй санхүүгийн өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг тооцохдоо Монгол улс дахь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрүүдийн санал болгож буй зах зээлийн хүүтэй харьцуулдаг.

Санхүүгийн тайлангуудад бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй Группийн санхүүгийн хэрэглүүрүүдийн дансны үнэ болон бодит үнэ цэнийг харьцуулж харуулав.

	2015 мян.төг	2014 мян.төг
Бодит үнэ цэнэ	37,399,016	40,632,245
Дансны үнэ	24 39,174,678	43,325,270

Дансны үнэтэй ойролцоо бодит үнэ цэнэтэй санхүүгийн хэрэглүүр

Урт хугацаат зээллэгийг эс тооцвол Группийн 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүд нь бүгд нэг жилээс бага хугацаанд дуусгавар болох буюу богино хугацаатай байна. Дээр дурдсан бодит үнэ цэнийн үнэлгээнд үндэслэсэн, эдгээр богино хугацаат санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн өдрөөрх тооцоолсон бодит үнэ цэнэ нь санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд үзүүлсэн бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо байна. Урт хугацаат зээллэг нь зах зээлийн үнэлгээтэй ойролцоо хүүний хувиар тооцогддог учир бодит үнэ цэнэ нь бүртгэлийн дүнтэй ойролцоо байдаг.

32. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.


0000171





Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com



2016.04.28

Багануур ХК-ийн үнэт цаасны танилцуулгын 47-51 болон 111-171 дүгээр хуудсуудад тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалтай нийцэж байгаа болно.

Хүндэтгэсэн,

Г.АЛТАНСУХ
Гүйцэтгэх захирал

0000171





БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“БАГАНУУР” ХК

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх

Захиалагч :


**М.Отгонбаяр
Гүйцэтгэх захирал
“Багануур” ХК**


Тайланг бэлтгэсэн :

**Р.Батжаргал МҮ
Б.Наранбаатар, МҮ
П.Баянсан, МҮ**

**Үндэсний Реалти ХХК
Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн Үндэстний гудамж 6/7
2016 он**

0000173





ГАРЧИГ

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ОБЪЕКТИЙН ТАНИЛЦУУЛГА.....

 Үйлчлүүлэгч байгууллагын талаарх мэдээлэл.....4

 Үнэлгээний байгууллагын талаарх мэдээлэл.....4

 Бизнесийн үнэлгээний хугацаа.....4

 Үнэлэх бизнес.....4

 Үнэлгээний мөнгөн нэгж.....4

 Үнэ цэнийн суурь.....4

ХОЁР. "БАГАНУУР" ХК-ИЙН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ..... **5**

 Бизнесийн үнэ цэнийн тодорхойлолт.....5

 Бизнесийн үнэлгээний зорилго.....5

 Бизнесийн үнэлгээний зориулалт.....5

 Үнэлгээнд мөрдсөн Олон Улсын Стандарт.....5

ГУРАВ. БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ..... **6**

 Бизнесийн үнэлгээнд мөрдсөн арга, хандлага.....6

 Бизнесийн үнэлгээний мэдээллийн эх сурвалж.....7

ДӨРӨВ. КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ..... **8**

 Компанийн тодорхойлолт.....8

 Компанийн түүх.....8

 Компанийн хувьцааны төрөл ба хувьцаа эзэмшигчид.....10

 Компанийн үндсэн үйл ажиллагаа.....11

 Компанийн удирдлага, бүтэц зохион байгуулалт.....12

 Бизнесийн үнэлгээнд хамаарах орчны нөхцөл байдлын шинжилгээ (SWOT).....12

ТАВ. САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ..... **14**

 Байгууллагын санхүүгийн чадавхийг үнэлэх.....14

 Ашигт ажиллагааны шинжилгээ.....16

 Зах зээлийн идэвхижилийн шинжилгээ.....17

ЗУРГАА. "БАГАНУУР" ХК-ИЙН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ..... **18**

 Өртгийн хандлагын аргаар тооцсон бизнесийн үнэлгээ.....18

 Багануурын уурхайн ордын үнэлгээ.....25

 Ордын мэдээлэл.....25


 Ордын нөөц.....25

 Ордын үнэлгээ.....26


 Орлогын хандлагын аргаар тооцсон бизнесийн үнэлгээ.....30

 Зах зээлийн хандлагын аргаар тооцсон бизнесийн үнэлгээ.....34

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ..... **38**



ДОЛОО. ХАРИУЦЛАГА ХЯЗГААРЛАХ НӨХЦЛҮҮД
НАЙМ. ҮНЭЛГЭЭЧДИЙН ГАРГАСАН БАТАЛГАА
ЕС. ХАВСРАЛТ




- Хавсралт 1. ММҮИ-институтын гишүүн байгууллагын гэрчилгээ41
- Хавсралт 2. "Багануур" ХК-ийн аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээ42
- Хавсралт 3. "Үндэсний реалти" ХХК-ийн аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээ43
- Хавсралт 4. Хөрөнгийн үнэлгээчний тусгай зөвшөөрлийн гэрчилгээ44

Хөрөнгийн үнэлгээний "Үндэсний Реалти" ХХК

0000175





НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ОБЪЕКТИЙН ТАНИЛЦУУЛГА

Үйлчлүүлэгч байгууллагын талаарх мэдээлэл

Аж ахуйн нэгж байгууллагын нэр : "БАГАНУУР" ХК

Улсын бүртгэлийн дугаар : 9010001045
Регистрийн дугаар : 2008572
Гүйцэтгэх захирал : М.Отгонбаяр
Үйл ажиллагааны үндсэн чиглэл : Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах

Үндсэн бус үйл ажиллагаа: Алтны шороон ордыг ашиглах, цайны газар, гадаад худалдаа

Үйлчлүүлэгчийн хаяг : Багануур хот, 2-р хороо, уурхайчин, өөрийн байр-00

Холбоо барих Утас: 976-012121130
Факс: 976-012121130
И-мэйл:

Үнэлгээний байгууллагын талаарх мэдээлэл

Үнэлгээний ажлыг гүйцэтгэгч : "Үндэсний реалти" ХХК
Гүйцэтгэх захирал Б.Наранбаатар

Гүйцэтгэгч байгууллагын : Регистр №5164702,
Үнэлгээний тусгай зөвшөөрөл №019

Үнэлгээчид : Р.Батжаргал - Мэргэшсэн үнэлгээчин, МНБ, Аудитор
П.Баянсан - Мэргэшсэн үнэлгээчин
Б.Наранбаатар - Мэргэшсэн үнэлгээчин, МНБ, Аудитор

Бизнесийн үнэлгээний хугацаа

Бизнесийн үнэлгээний өдөр: 2015.12.31
Бизнесийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгсөн: 2016.04.26

Үнэлэх бизнес

"Багануур" ХК-ийн бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон.

Үнэлгээний мөнгөн нэгж

Бизнесийн үнэлгээний дүнг Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн.

Үнэ цэнийн суурь

Бизнесийн үнэлгээг ҮОУС-ын шаардлагын дагуу зах зээлийн үнэ цэнийн суурийг хэрэглэсэн. Зах зээлийн үнэ цэнэ нь нээлттэй зах зээл дээр төсөөлж буй арилжаагаар хүрч болох хамгийн их магадлал бүхий үнийн илэрхийлэл юм.

Хөрөнгийн үнэлгээний "Үндэсний Реалти" ХХК

0000176



ХОЁР. "БАГАНУУР" ХК-ИЙН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ



Бизнесийн үнэ цэнийн тодорхойлолт

Бид "Багануур" ХК-ийн 100 хувийн өмчийн бизнесийн үнэлгээг энэ тайланд тусгагдсан үнэлгээний өдрөөр тасалбар болгон Олон улсын үнэлгээний стандарт, арга хандлага, аргачлалын дагуу бие даасан хараат бус байдалд хийж гүйцэтгэлээ.

Бизнесийн үнэлгээг өртгийн хандлагаар үнэлэхэд тухайн компанийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийг өнөөгийн зах зээлийн үнээр илэрхийлэх шаардлагатай учир хөрөнгийн үнэлгээний тайланг тусдаа тайлан бэлтгэж хүргүүлсэн болно. Энэхүү тайланд компанийн хөрөнгийн тодорхойлолт, үнэлгээ, хөрөнгө эзэмших, өмчлөх эрхийн баримт бичгүүдийг хавсаргасан.

Энэхүү бизнесийн үнэлгээний тайлангийн нэгдсэн дүгнэлт хэсэгт дурьдсаны дагуу 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар "Багануур" ХК-ийн өөрийн хөрөнгийн бизнесийн үнэ цэнийг **58,627,522.6 (Тавин найман тэрбум зургаан зуун хорин долоон сая таван зуун хорин хоёр мянга зургаа зуу)** мянган төгрөгөөр, нэгж энгийн хувьцааны үнэ цэнийг **2795.20** төгрөг гэж тодорхойллоо. (Дэлгэрэнгүйг нэгдсэн дүнгэлтээс үзнэ үү)

Бизнесийн үнэлгээний зорилго

Бидний зорилго "Багануур" ХК нь хөрөнгийн бирж дээр хувьцаа нэмж гаргах болсонтой холбоотойгоор компанийн бизнесийн өнөөгийн үнэ цэнэ буюу нэгж энгийн хувьцааны зах зээлийн өнөөгийн үнэлгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тодорхойлох, нэгж энгийн хувьцааны анхны үнийн саналын үндэслэлийг гаргахад энэхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

Бидний хийсэн бизнесийн үнэлгээний зорилго нь "Зах зээлийн үнэ цэнэ"-ийг тодорхойлох юм. Зах зээлийн үнэ цэнэ нь үнэлгээ хийгдсэн өдрөөр компанийн хувьцааг худалдах болон худалдан авах холбоогүй талууд аль аль нь ямар нэгэн дарамт шахалтгүй, хариуцлагатай, мэдээлэлтэй, тооцоо судалгаатай байж зохистой маркетинг хийсний дараагаар хийгдэх ажил гүйлгээгээр өмчийг солилцож болох үнэ гэсэн утгаар илэрхийлэгдэнэ.

Бизнесийн үнэлгээний зориулалт

Энэхүү бизнесийн үнэ цэнэ, үнэлгээний тайланг "Багануур" ХК нь Монгол улсын хөрөнгийн зах зээлд нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой үйл ажиллагаанд зориулан бэлтгэсэн ба Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, "Багануур" ХК, андерайтерын компани "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-д хүргүүлнэ.

Үнэлгээнд мөрдсөн Олон Улсын Стандарт

Бизнесийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон Үнэлгээний Олон Улсын Стандартыг мөрдлөг болгон ашиглалаа. Үүнд:

- ҮОУСтандарт 101 Үнэлгээний ажлын хамрах хүрээ
- ҮОУСтандарт 102 Хэрэгжилт
- ҮОУСтандарт 103 Тайлагнал
- ҮОУСтандарт Биет бус хөрөнгө
- ҮОУСтандарт 310 – Бизнесийн үнэлгээ
- ҮОУС, Техникийн баримт бичиг 1 – Хорогдуулсан мөнгөн гүйлгээ
- ҮОУС, Техникийн баримт бичиг 2 – Биет хөрөнгийг өртгийн хандлагаар үнэлэх



ГУРАВ. БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Бизнесийн үнэлгээнд мөрдсөн арга, хандлага



ҮОУС-ын Хамрах хүрээ болон "ҮОУС 200 Бизнес ба бизнесийн хувь оролцоо"-ийн Үнэлгээний арга хандлагад заасны дагуу бизнесийн үнэлгээг хийхдээ зах зээлийн харьцуулалтын ба орлогын хандлагыг түлхүү ашигладаг. Харин зах зээлийн мэдээлэл хомс, ашиг орлогыг үндэслэлтэй тооцоолох боломж муу, бизнес нь шинээр эхэлж байгаа, татан буугдаж байгаа зэрэг тохиолдлуудад өртгийн хандлагын аргыг хэрэглэхийг зөвлөдөг.

Зах зээлийн хандлага.

Тухайн бизнесийг зах зээл дээр арилжигдсан ижил төстэй бизнес, бизнесийн хувь оролцоо, үнэт цааснууд болон ижил төстэй бизнесийн хувьцаатай холбоотой ажил гүйлгээнүүдтэй харьцуулдаг.

Зах зээлийн харьцуулалтын хандлагад дараах үндсэн гурван мэдээллийг ашигладаг.

- Ижил төстэй бизнесийн хувь оролцооны арилжаалагдсан хөрөнгийн зах зээлийн мэдээлэл /Шарын гол ХК, Шивээ-Овоо ХК/
- Бизнес бүхэлдээ худалдаалагдсан тухай зах зээлийн мэдээлэл
- Тухайн бизнесийн хувьцааны өмнөх үеийн арилжааны мэдээлэл

Бидний хийсэн бизнес үнэлгээнд ижил төстэй бизнесүүдийн мэдээлэл /үржүүлэгч/ болон "Багануур" ХК-ийн хувьцааны арилжааны мэдээллийг ашиглан зах зээлийн хандлагаар үнэлгээг хийсэн.

Орлогын хандлага.

Бизнесийн ирээдүйн ашиг эсвэл мөнгөн гүйлгээг тооцоолж капиталжуулах хувь ба хорогдуулгын хувийг ашиглан ирээдүйн мөнгөн урсгалын дүнг өнөөгийн үнэ цэнэд хувиргах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог арга юм.

Компанийн хувьд дунд хугацааны төсөв, төлөвлөгөө, орлого зардлын тооцоог боловсруулан ТУЗ-өөр батлуулсан тул бизнесийн үнэлгээг орлогын хандлагаар тооцоход энэхүү мэдээлэлд суурилсан.

Дунд ба урт хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу компани хүчин чадлаа нэмэгдүүлэх зорилтын дагуу нэмэлт хөрөнгө оруулалт хийснээр үйлдвэрлэлт, борлуулалтын өсөлт, тогтворжилт, орлого зардлын хэтийн төлөвийг судлан үзэж ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолсон.

Орлогын хандлагаар бизнесийн үнэ цэнийг тооцохын тулд ирээдүйн мөнгөн урсгалыг тодорхойлох, хорогдуулах ба капиталжуулах хувийг тодорхойлох, бизнесийн үлдэгдэл үнэ цэнийг тодорхойлж ирээдүйн мөнгөн урсгалуудыг хорогдуулгын хувиар өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэн үнэлгээг тодорхойлсон.

Өртгийн хандлага.

Компанийн бизнест ашиглагдаж буй хөрөнгүүдийн зах зээлийн үнийг тодорхойлдог. Практикт компани нь шинээр байгуулагдаж байгаа, татан буугдаж байгаа, өөрчлөн зохион байгуулагдаж байгаа, тохиолдлуудад тухайн бизнесийн өртгийг тодорхойлоход энэ хандлагыг хэрэглэдэг.

Өртгийн хандлагын аргаар бизнесийн үнэлгээг хийхдээ цэвэр хөрөнгийн өртгийн аргыг ашигласан. Энэ аргын дагуу компанийн хөрөнгүүдийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлж төлбөл зохих өр төлбөрийн дүнг хассанаар өөрийн хөрөнгөд ноогдох үнэ цэнэ үлдэнэ.



Бизнесийн үнэлгээний мэдээллийн эх сурвалж



Бизнесийн үнэлгээнд дараах мэдээллийн эх үүсвэрийг ашиглалаа. Үүнд:

- "Багануур" ХК-ийн 2014, 2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлан,
- "Багануур" ХК-ийн 2015.12.31-нээр үндсэн хөрөнгийн үнэлгээний тайлан
- "Багануур" ХК-ийн ТУЗ-өөр батлагдсан дунд хугацааны бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, ойрын ирээдүйн орлого, зарлагын прогноз
- Орд газрыг ашиглах ТЭЗҮ
- Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлийн лиценз
- "Багануур" ХК-ийн хийсэн судалгааны материалууд
- Монголын хөрөнгийн биржийн вэб хуудас дахь хувьцаат компаниудын талаарх мэдээлэл
- Монголын хөрөнгийн биржийн хувьцааны ханшны ба тархалтын мэдээ,
- Өрсөлдөгч компаниуд, салбарын мэдээ, мэдээллүүд
- Сангийн яам, Монгол банкны вэб хуудас
- Статистикийн газрын мэдээлэл
- Үнэт цаас гаргагчид зориулсан мэдээлэл,
- Монгол улс ба дэлхийн нүүрсний салбарын талаарх судалгааны материалууд
- "Багануур" ХК-ийн удирдлагын зүгээс гаргаж өгсөн байгууллагын талаарх мэдээллүүд
- Зах зээлийн холбогдох бусад мэдээ, мэдээллүүд

Дээрх мэдээллийг ашиглан Үнэлгээний Олон Улсын Стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн арга, хандлага, аргачлал, арга зүйг үндэслэн бизнесийн үнэлгээний ажлыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн



ДӨРӨВ. КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Компанийн тодорхойлолт

"Багануур" ХК-ийн улсын бүртгэлийн дугаар №9010001045, аж ахуйн нэгж байгууллагын регистрийн дугаар №2008572, Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар №0204141, №0204140, №000305426, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ байхгүй бөгөөд Улаанбаатар хотын Багануур дүүрэгийн 3-р хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн барилга, байгууламжид үйл ажиллагаагаа явуулдаг.

Компанийн үндсэн үйл ажиллагаа эрчим хүчний нүүрс олборлох, борлуулах үйл ажиллагаа юм.

Компанийн түүх

1978 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Бага гүн нуурын зүүн дэнжид уурхайн анхны гэр баригдаж, мөн оны 3 дугаар сарын 1-нд анхны тэсэлгээ хийгдсэнээр жилд 300.0 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтай Багануурын нүүрсний уурхайг барьж байгуулах их ажил өрнөн 1978 оны 9 дүгээр сарын 2-нд уурхайг улсын комисс хүлээн авч ашиглалтанд оруулж анхныхаа нүүрсийг гаргаснаар Багануурын нүүрсний уурхай байгуулагдсан түүх эхэлдэг.

1978 оны 10 дугаар сарын 4-нд Багануур Багахангайн төмөр замын хөдөлгөөнийг нээж, 1978 оны 12 дугаар сард Улаанбаатар-Багануурын 220 кВт-ын өндөр хүчдэлийн шугамыг ашиглалтад оруулснаар уурхай барьж байгуулах үндсэн нөхцлүүд хангагдаж, Багануурын түлшний иж бүрэн цогцолборыг босгох эхний алхмууд амжилттай биелэгдсэн байна.

1983 оны 7 дугаар сарын 3-нд ЭШ 15/90 алхагч экскаватор ашиглалтанд орсноор уурхайн эхний ээлжийг ашиглалтад оруулах нөхцлийг бүрдүүлж, 1982 оны 12 дугаар сарын 17-нд жилд 1.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай эхний ээлжийн тоног төхөөрөмж, барилга байгууламжуудыг ашиглалтад оруулсан. 1985 онд 20 м3 багтаамж бүхий шанагатай аварга том ЭШ 20/90 экскаваторыг ашиглалтад оруулсан нь уурхайн нүүрс гаргалт жил ирэх тутам нэмэгдэхэд томоохон нөлөө болсон бөгөөд 1987 оны 12 дугаар сарын 29-нд уурхай жилд 2.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай болсон байна.

1989 оны 1 дүгээр сарын 31-нд Багануурын уурхай жилд 4.0 сая тонн нүүрс олборлох хүч чадалтай II ээлжийн эхний ээлж, 1992 оны 1 дүгээр сарын 25-нд 2 дахь ээлжийн эхний байгууламжийг барьж дуусган улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.

Багануурын үйлдвэрлэлийн хэмжээ 1990 оноос эхлэн жил дараалан буурч үүнийг дагаад хөрс хуулалтын хэмжээ ч буурч, төмөр замаар тээвэрлэх хөрсний ажлын явц хангалтгүй болсноос алхагч экскаваторуудын фронтыг хангаж чадахгүйд хүрч, уурхайн санхүү хүндэрч, эрчим хүчний байгууллагууд уурхай хоёрын дунд асар их өр үүсч, сэлбэг материалын нийлүүлэлт буурсан бөгөөд уурхайн удирдлага, олон улсын төслийн группүүдтэй хамтран ажиллаж уурхайн ирээдүйн автомашины тээврээр хуулах хөрсийг эрчимжүүлэх зорилгоор Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 32 тоннын даацтай өөрөө буулгагч автомашин, 320 морины хүчтэй бульдозерыг 1992 оны 2 дугаар сард, АНУ-ын Олон улсын хамтын ажиллагааны тусламжийн хөрөнгөөр 1993 онд бульдозер, 6 м3 шанагатай ачигч, автогрейдер зэрэг тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч ашиглалтад оруулсан нь уурхайн хөрс хуулах ажлыг эрчимжүүлэн хүндрэлээс гарах, дэлхийн тэргүүний техник нэвтрэх үндэс суурийг тавьсан чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Багануурын уурхайг Монгол улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссын шийдвэрээр төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болгон өөрчлөх шийдвэр гарч 1994 онд "Багануур" ХК-ийг үүсгэн байгуулсан.



1993 оноос Япон улсын засгийн газрын гадаадтай хамтран ажиллах нийгэмлэгийн хийсэн Монгол улсын нүүрсний салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, 1994 онд Дэлхийн банкны хийсэн төвийн районы нүүрсний хангамжийг сайжруулах судалгааны үр дүнгээр Багануурын уурхайд урт хугацааны хөнгөлттэй зээл олгож хамтын санхүүжилтээр уурхайг шинэчлэх төсөл хэрэгжүүлэх ажил 1995 онд эхэлсэн. "Монгол нүүрс" төсөл нь Монгол улсын нүүрсний үйлдвэрлэлийн бууралтыг зогсоож, Багануурын уурхайн нүүрс олборлолтыг жилд 4.0 сая тоннд хүргэх, төвийн хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээг найдвартай хангахын тулд Багануурын уурхайн уул, тээврийн болон бусад тоног төхөөрөмжийг шинэчлэх, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, санхүүгийн хувьд бүрэн бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, боловсон хүчний менежментийг сайжруулах, урт хугацааны туршид хүрээлэн буй орчныг тогтвортой хамгаалах боломжтой арга, горимоор ажиллуулах, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх зорилготойгоор 1996-2002 оны хооронд хэрэгжсэн. Төслийн хүрээнд Катерпиллар маркийн 90 тоннын даацтай CAT-777 хөрс тээврийн автосамосвал, Комацу маркийн 40 тоннын даацтай HD-405 нүүрс тээврийн автосамосвал, нүүрс бутлан ачих зориулалттай технологийн дамжлага, гинжит болон дугуйт бульдозер, автогрейдер, Терекс маркийн зам усалгааны машин, D50KS өрмийн машин болон дугуй засварын багаж тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, байгаль орчны шинжилгээний иж бүрэн лаборатори зэрэг нь дагалдах сэлбэг хэрэгслийн хамт орж ирсэн.



1998 оноос хөрс хуулалтын төмөр замын системийг бүрэн өөрчилж, автотээврийн системд шилжүүлснээр уурхайн автаар тээвэрлэх хөрсний хэмжээ 2-2.6 дахин нэмэгдсэн байна. Багануурын уурхайг өргөтгөн шинэчлэх "Монгол нүүрс" төслийн техникийн тусламжийн хүрээнд АНУ-ын "Норвест" корпораци уурхайн уулын ажлын байдалд иж бүрэн судалгаа явуулж, 2017 он хүртэлх урт хугацааны төлөвлөлтийг хийж гүйцэтгэсэн нь үйлдвэрлэлийн бодит боломжийг тооцоход чухал ач холбогдолтой ажил болсон. Түүнчлэн Австралийн Артур андерсэн компанитай хамтран компанийн санхүү, бүртгэлийн ажлыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад шилжүүлж, иж бүрэн программ хангамж, сүлжээг бий болгосноор үйлдвэрлэлийн өртөг зардлыг хэсэг, нэгж бүрээр тогтмол хянаж, дүгнэлт хийх боломжтой болсон. Мөн дан ганц уурхайн үйл ажиллагааг тогтворжуулаад зогсохгүй дулааны цахилгаан станцууд, түүнчлэн Монгол улсын түлш эрчим хүчний салбарын тогтвортой байдлыг хангаж өгснөөрөө маш чухал ач холбогдолтой төсөл болсон. "Монгол нүүрс" төсөл хэрэгжсэнээр өндөр хөгжилтэй орны шинэ дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг ашиглах болсон нь Багануурын уурхай төдийгүй нүүрсний салбарт анх удаа хэрэгжсэн том шинэчлэлт, онцлог үйл явдал байсан төдийгүй орчин үеийн техник, тоног төхөөрөмж дээр ажиллах, түүнийг оншлох засварлах чадварлаг боловсон хүчинтэй болж чадсанд төслийн томоохон ач холбогдол оршино.

Мөн уг төслийн хүрээнд 1999 онд уул уурхайн салбарт анх удаа уурхайн үйл ажиллагааны явцад эвдэрч гэмтсэн хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд ихээхэн анхаарч ажиллан нөхөн сэргээлтийн ажлыг бэлчээрийн зориулалттайгаар хийж өнөөдрийн байдлаар жилд 160 гаруй га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийсэн бөгөөд үүнд жилд 350.0-400.0 сая төгрөг зарцуулж байна.

2004 онд уурхайн хамт олон гадаад орчиндоо зохицох, бүх шатны удирдлагын арга барилыг өөрчилж, үйл ажиллагааны шинэлэг түвшинд хүрэхээр "Өөрчлөлтийн менежмент" хөтөлбөрийг Үндэсний бүтээмж хөгжлийн төв, Азийн бүтээмжийн байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн "Бүтээмжийн шагнал", Монгол улсын бүтээмжийн хөдөлгөөний манлайлагч байгууллага, олон улсын "Загвар компани"-ийн гэрчилгээ олгосон нь уурхайчдыг идэвхижүүлсэн томоохон дэмжлэг болсон байна.

2006-2009 онд ЭКГ-8и, ЭКГ-10и, ЭШ-20/90 экскаваторуудын цахилгаан удирдлага болох хагас дамжуулагчийн аналог системийг орчин үеийн дэвшилтэт технологи програмчлагдсан тоон системд шилжүүлсэн нь экскаваторын удирдлагын уян хатан байдлыг сайжруулж, бүтээмжийг 20-80% хүртэл нэмэгдүүлсэн юм. Энэхүү өөрчлөлт нь анх удаа Багануурын уурхайд хийгдсэн бөгөөд техникийн хүчин чадлыг ихээхэн нэмэгдүүлсэн ажил болсон. 2009-2010 онд "Монгол улсыг хөгжүүлэх сан"-ийн хөрөнгө оруулалтаар 12.3 тэрбум төгрөгөөр техник, тоног төхөөрөмжийн






шинэчлэлтийг хийн хөрс хуулалтын экскаватор 1 ширхэг, хөрс тээврийн 100 тоннын даацтай 2 ширхэг автосамосвал худалдан авч ашиглалтанд оруулсан байна.

2013-2015 онд нийт 25.4 тэрбум төгрөгийн техник технологийн шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба жилд 3.6-3.8 сая тонн нүүрс олборлон борлуулж, хүчин чадлынхаа 90-95%-ийг ашиглан үйл ажиллагаагаа явуулж байна. 2015 онд уурхай 3.7 сая тонн нүүрс борлуулан, 19.3 сая м3 хөрс хуулж нийт 29.8 сая м3 уулын цулын ажил хийсэн үзүүлэлттэйгээр ажиллаж байна.

Компанийн хувьцааны төрөл ба хувьцаа эзэмшигчид

"Багануур" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийг доорх схемээр харууллаа.




№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь (%)	Хувьцааны тоо (ширхэг)	Үйл ажиллагааны чиглэл
1	Эрдэнэс Монгол ХХК	75.00	15,730,770	Стратегийн ач холбогдол бүхий ордыг болон улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж, нөөцийг тогтоосон ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх
2	"Монголиан Нэшнл Коал Корпорэйшн" ХХК	21.06	4,416,668	Уул уурхай
3	Бусад 4774 хувьцаа эзэмшигчид	3.94	826,922	
Нийт		100.00	20,974,360	

"Багануур" ХК-ийн охин болон хараат компаниуд

№	Нэр	Эзэмшил (%)	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг
1	"Багануур сувилал" ХХК	100%	Сувилал, зочид буудал, амралтын газар, зоогийн газар, хүнсний дэлгүүр, мал аж ахуй	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1-р хороо, Нацагдоржийн гудамж, Багануур сувилалын байр
2	"Багануур Илч" ХХК	100%	Нүүрс борлуулах, худалдааны зуучлал, гадаад худалдаа зочид буудал, цайны газар	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, Хаедар судлалын баруун талд
3	"Монцахим" ХХК	46%	Нүүрсний болон бусад үйлдвэрлэлийн зориулалт бүхий цахилгаан машин, тоноглолын засварын үйлчилгээ	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн хэсэг, "Багануур" ХК-ийн байр





Компанийн үндсэн үйл ажиллагаа

"Багануур" ХК нь анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа Дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор ажиллаж эхэлснээс хойш 38 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани нь Монгол улсын нүүрсний хэрэгцээний 55 орчим хувийг дангаараа хангаж ирсэн бөгөөд 2015 оны 2-р сарын 9-нд 100.0 сая.тн дахь нүүрсээ олборложээ. Компани нь эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагуудад нүүрс нийлүүлэхээс гадна 0-200 мм бутармагтай нүүрсийг хэрэглэгчдэд нийлүүлдэг.

Компанийн үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал нь 4.0 сая.тн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч жилд 3.6-3.8 сая.тн нүүрсийг олборлож, 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулж байна. Уурхайн үйлдвэрлэлийн талбайд иж бүрэн механикжсан нүүрсний уурхай, нүүрсийг буталж, ангилан ялгаж, ачих хоёр ширхэг технологи дамжлага, уул-тээврийн тоног төхөөрөмжийн үйлчилгээний машин засварын газрууд, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн механикжсан агуулахын аж ахуй, кислород компрессорын станц ажиллаж үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж байна.

Уурхай нь байгуулагдсанаасаа хойш анхны төсөл болох ЗХУ-ын ГИПРОШАХТ институтын боловсруулсан төслийг мөрдлөг болгон ажиллаж байсан ба 1995 оноос техник технологийн шинэчлэл хийх, хөрс хуулалтын хоцрогдлыг арилгах, нүүрс олборлолтыг тогтворжуулах зорилгоор "Монгол нүүрс" төслийг хэрэгжүүлэн уурхайн өмнө тулгарч байсан олон хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэсэн.


2014 онд Олон улсын хөгжлийн ассоциациас Монгол улсын Засгийн газарт үзүүлсэн зээлийн тусламжаар Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд Багануурын нүүрсний ордын нэмэлт хайгуул, нөөцийн тодотгол тооцооны ажлыг "Эрдгео" ХХК болон "Норвест" корпораци хийж гүйцэтгэсэн байна. Уг хайгуулын ажлын үр дүнд орд газрын нөөц 290 сая тонноор нэмэгдэж, 2015 оны 1дүгээр сарын 1-ний байдлаар, ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэнээр нийт орд талбайн хэмжээнд тооцоолсон нүүрсний нөөц 812 сая тонн болсон бөгөөд олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нүүрсний нийт нөөц 839 сая тонн болж нэмэгдсэн байна. Компани 2015 оноос эхлэн Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар уурхайн хаалт хүртэлх урт хугацааны ТЭЗҮ боловсруулж байгаа бөгөөд 2016 онд тус ТЭЗҮ-ийг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Мөн уурхайн хөрс, нүүрс тээвэрлэлтийн зардлыг багасгах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг сайжруулах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон 2014-2018 он хүртэлх компанийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уурхай 1978 онд анх байгуулагдсанаас хойш 2015 он хүртэлхи буюу 37 жилийн хугацаанд нийт 103.1 сая.тн нүүрс олборлон борлуулж, 359.1 сая.м3 хөрс хуулалтын ажлыг хийсэн. Үүнээс тээвэргүй хөрс хуулалт 162.9 сая.м3, төмөр замаар 24.2 сая.м3, 171.9 сая.м3 авто тээвэртэй хөрс хуулалтын ажлыг хийсэн байна. Мөн хөрс шидэлтийн ажлыг 107.8 сая.м3, инженерийн ажил 28.4 сая.м3, нөхөн сэргээлтийн ажил 9.4 сая.м3, 8.8 сая.м өрөмдлөгийн ажлыг хийж 663.5 сая.м3 уулын цулын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Уурхайн сүүлийн 5 жилийн уурхайн ажлын хэмжээг доорх хүснэгтэд үзүүлээ.

Уулын ажлын үзүүлэлт	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015
Нүүрс гаргалт	м.тн	3,253.3	3,541.6	3,876.7	3,617.1	3,731.2
Нүүрс борлуулалт	м.тн	3,263.8	3,541.6	3,824.5	3,683.3	3,747.0
Хөрс хуулалт	м.м3	15,453.3	15,259.8	18,640.5	17,269.3	19,135.7
Нийт уулын цул	м.м3	26,398.2	26,590.7	30,566.5	29,363.8	30,855.6






Компанийн удирдлага, бүтэц зохион байгуулалт

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, компанийн ерөнхий удирдлага болон бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл ба гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

Компанийн зохион байгуулалтын ерөнхий бүтцийг дараах схемээр харууллаа.




Бизнесийн үнэлгээнд хамаарах орчны нөхцөл байдлын шинжилгээ (SWOT)

Компани нь бидний дараах хэсэгт авч үзсэн өөрийн давуу тал, боломж дээрээ тулгуурлан хөрөнгийн санхүүжилтийг шийдвэрлэн техник, технологио шинэчлэн, үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж, бүтээгдэхүүний гарц, чанарыг сайжруулан, нэгжийн өртөг зардлыг хямдруулж, үйлдвэрлэлт борлуулалтыг нэмэгдүүлэн зах зээлд эзлэх байр сууриа өсгөх боломжтой байна.

Мөн түүнчлэн Монгол улсын засгийн газрын мөрийн хөтөлбөр, бодлогод хүн амыг орон сууцжуулах, уул уурхай, аж үйлдвэрийн цогцолборыг байгуулах, Багануур дүүрэгт шинээр цахилгаан станц барихаар зорилт тавьж байгаа нь компанийн зорилтот зах зээлийг улам өргөжүүлэх бололцоог олгож байна.






Дотоод орчин	<p>Давуу тал (Strengths)</p> <ul style="list-style-type: none"> Орд газрыг ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Төмөр зам, авто зам, холбоо, интернэт, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны системд бүрэн холбогдсон байршил сайтай. Стратегийн ач холбогдол бүхий орд газар эзэмшдэг, бүтээгдэхүүний чанар сайн, гол гол цахилгаан станцуудыг нүүрсээр хангадаг Үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашигладаг Өөрийн өмчлөлийн контор, үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжтай, өөрийн эзэмшлийн газартай ба материаллаг бааз сайтай Мэргэшсэн ажилчид, ажиллагсад нь олон жил ажилласан туршлагатай Компани нь олон жилийн түүхтэй, бүтээгдэхүүн нь зах зээлд борлуулахад бэрхшээл багатай 	<p>Сул тал (Weaknesses)</p> <ul style="list-style-type: none"> Нүүрсний үнийг төрөөс тогтоож өгдөг тул бизнесийн орлогод сөргөөр нөөлдөг Эдийн засгийн хямрал, компани алдагдалтай ажилладаг зэрэг шалтгаанаас ноогдол ашиг хуваарилж чадахгүй байх, улмаар хөрөнгийн зах зээл дээр компанийн хуьцааны үнэ ханш унах Уурхайн тоног төхөөрөмжүүд хуучирсан, засварын өртөг өндөр, шинэчлэхэд хөрөнгө оруулалт ихээр шаарддаг Банкны зээлээр санхүүжилт ихээр хийдэг нь капиталын зардал өсөх, санхүүгийн тогтворгүй байдалд хүргэх, өрийн дарамт үүсэх Нүүрсний уналтаас хамаарсан уурхайн гүнзгийрэлт, дотоод овоолгын гулсалт, гүний усны тэжээгдэл ихтэй
--------------	---	--

Гадаад орчин	<p>Боломж (Opportunities)</p> <ul style="list-style-type: none"> Томоохон нүүрс хэрэглэгчидтэй, Багануур дүүрэгт шинээр цахилгаан станц баригдахаар болж байгаа Техник, технологийн шинэчлэлийг хийснээр үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх Хүчин чадлыг нэмэгдүүлснээр бүтээгдэхүүний нэгжид ноогдох өртөг буурна Нэгжид ноогдох өртөг буурч, бүтээгдэхүүний чанар дээшилснээр өрсөлдөх чадвар сайжирна Дутуу шаталтаас үүсэх нүүрсхүчлийн хийн ялгаралт эрс буурч экологийн цэвэр үйлдвэрлэл явуулах боломжтой Эрчим хүчний тухай хууль, түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолд заасны дагуу зах зээлийн зарчимд шилжин ажиллах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх; нүүрсний үнийг тодорхойлох аргачлалыг батлах тухай Монгол улсын дэд бүтцийн сайдын тушаалын дагуу нүүрсний ертгөө тооцдог бол өртөг, зардлаа нөхөх хэмжээний үнээр хэрэглэгчдэд нүүрсээ борлуулах Нүүрс боловсруулах, шингэрүүлсэн түлш гаргах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж бүтээгдэхүүний эрчим хүч гаргахаас бусад зориулалтаар ашигласнаар олборлолт, борлуулалт өсөх 	<p>Бэрхшээл (Threats)</p> <ul style="list-style-type: none"> Техник, технологио шинэчлэх, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутагдалтай байх. Банкны зээлийн хүү ихээр хуримтлагдсан Бүтээгдэхүүнээ борлуулахад төмөр замын тээврийн хүчин чадлаас хамааралтай байх Шинэ барилга, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь төлөвлөж буй хугацаанаас хойш ашиглалтад орох, нийлүүлэгдэх, тасалдах Бүтээгдэхүүний үнийг төрөөс тогтоодог нь дотоод эх үүсвэрээр хуримтлал бий болгох, хөрөнгө оруулалт шинэчлэлт хийх боломжийг бууруулах, Сэлэг, материал, түүхий эдийн үнийн өсөлт өндөр, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд өртөг өндөртэй, уулын ажлын техникүүдийг худалдан авахад хугацаа их шаардагддаг
--------------	--	--





ТАВ. САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ

"Багануур" ХК-ийн 2014, 2015 оны санхүүгийн тайланд "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК санхүүгийн тайлангийн аудит хийсэн. Энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээллийг ашиглан дараах чиглэлээр шинжилгээ хийж холбогдох харьцаа, үзүүлэлтүүдийг тооцож үнэлэлт, дүгнэлт өглөө. Үүнд :

1. Байгууллагын санхүүгийн чадавхийг үнэлэх
2. Хөрөнгө, капиталын өгөөж, ашигт ажиллагааны шинжилгээ
3. Зах зээлийн идэвхижилийн шинжилгээ

Байгууллагын санхүүгийн чадавхийг үнэлэх

Компанийн санхүүгийн чадавхийг үнэлэхийн тулд:

- а. Хөрөнгө капиталын байдал,
- б. Төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлын

үзүүлэлтүүдийг тооцож үзлээ.

А. Хөрөнгө капиталын байдал - Хөрөнгө капиталын бүтэц бүрэлдэхүүн


Үзүүлэлт /сая.төг/	Тайлангийн дүн		Бүтэц		Өөрчлөлт		дүнд эзлэх хувь
	2014	2015	2014	2015	дүн	хувь	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,115.3	6,180.4	2.4%	4.5%	3,065.1	98.4%	56.3%
Дансны авлага	9,903.3	8,757.1	7.5%	6.4%	(1,146.2)	-11.6%	-21.0%
Бараа материал	14,638.4	14,009.7	11.1%	10.2%	(628.7)	-4.3%	-11.5%
УГЗардал ба бусад авлагууд	3,531.2	1,900.2	2.7%	1.4%	(1,631.0)	-46.2%	-29.9%
Эргэлтийн хөрөнгийн дүн	31,188.2	30,847.4	23.6%	22.5%	(340.8)	-1.1%	-6.3%
Уурхайн хөрөнгө	24,943.1	36,056.7	18.9%	26.3%	11,113.6	44.6%	204.0%
Үндсэн хөрөнгө	74,371.1	68,560.2	56.4%	49.9%	(5,810.9)	-7.8%	-108.6%
Биет бус хөрөнгө	19.7	305.3	0.0%	0.2%	285.6	1449.7%	5.2%
Хараат компанид оруулсан ХО	160.6	274.0	0.1%	0.2%	113.4	70.6%	2.1%
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,204.8	1,292.7	0.9%	0.9%	87.9	7.3%	1.6%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,699.4	106,488.9	76.4%	77.5%	5,789.5	5.7%	106.3%
Нийт хөрөнгийн дүн	131,887.6	137,336.3	100.0%	100.0%	5,448.7	4.1%	100.0%
Дансны болон бусад өглөг	32,808.9	44,732.2	24.9%	32.6%	11,923.3	36.3%	218.8%
Зээллэг	18,563.6	23,917.3	14.1%	17.4%	5,353.7	28.8%	98.3%
Засгийн газрын тусламж	2,487.9	2,461.3	1.9%	1.8%	(26.6)	-1.1%	-0.5%
Орлогын албан татварын өглөг	3,157.2	11.2	2.4%	0.0%	(3,146.0)	-99.6%	-57.7%
Богмио хугацаат өр төлбөрийн дүн	57,017.6	71,121.9	43.2%	51.8%	14,104.3	24.7%	258.9%
Зээл	24,761.7	15,257.4	18.8%	11.1%	(9,504.3)	-38.4%	-174.4%
Засгийн газрын тусламж	26,802.6	25,921.7	21.8%	18.9%	(2,880.9)	-10.0%	-52.9%
Сан	1,107.0	1,374.5	0.8%	1.0%	267.5	24.2%	4.9%
Ажилчдын тэтгэврийн сан	8,014.0	9,547.4	6.1%	7.0%	1,533.4	19.1%	28.1%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	62,685.3	52,101.0	47.5%	37.9%	(10,584.3)	-16.9%	-194.3%
Нийт өр төлбөрийн дүн	119,702.8	123,222.9	90.8%	89.7%	3,520.1	2.9%	64.6%
Энгийн хувьцаа	2,097.4	2,097.4	1.6%	1.5%	0.0	0.0%	0.0%
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	10,087.3	12,015.9	7.6%	8.7%	1,928.6	19.1%	35.4%
Нийт эздийн өмчийн дүн	12,184.7	14,113.4	9.2%	10.3%	1,928.7	15.8%	35.4%
ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН	131,887.5	137,336.3	100%	100%	5,448.8	19%	100%

Компанийн нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувийн жин 22%-23%, харин удаан гүйлгээт хөрөнгийн хувийн жин 76%-77% тай байна. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд нийт 2014 онд 90,8%, 2015 онд 89,7%-тай байна. Энэ нь зээлийн эх үүсвэрийг ихээр дайчилж ашигладагтай холбоотой байна.

Хөрөнгийн үнэлгээний "Үндэсний Реалти" ХХК

0000183





2014-2015 онд үндсэн хөрөнгө 5,810.9 сая төгрөгөөр буурсан боловч уурхайн хөрөнгийн дүнг 11,113.6 сая төгрөгөөр нэмж тооцоолсон нь хөрөнгийн дүн өсөхөд голлон нөлөөлжээ. 2015 онд урт хугацаат зээлийн төлөлт их хийгдсэн боловч дансны өглөг 11,923.3 сая төгрөг, богино зээллэг 5,343.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эх үүсвэрийн дүн өсөхөд голлон нөлөөлжээ.

Санхүүжилтийн эх үүсвэрийн бүтэц

Компанийн эргэлтийн хөрөнгө 2014 онд 31,188.2 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 57,017.6 сая төгрөг, ажлын капитал (25,829.4) сая төгрөг байгаа нь эргэлтийн хөрөнгийг тогтвортой эх үүсвэр (УХӨ ба ЭЗӨ)-ээр санхүүжүүлж чадахгүй, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай байгааг илэрхийлж байна.

Мөн эргэлтийн хөрөнгө 2015 онд 30,847.4 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 71,121.9 сая төгрөг, ажлын капитал (40,274.5) сая төгрөг байгаа нь эргэлтийн хөрөнгийг тогтвортой эх үүсвэр дутагдалтай байгааг илэрхийлж байна.

Эргэлтийн бус хөрөнгө 2014 онд 100,699.4 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр нь өөрийн хөрөнгө 12,184.7 сая төгрөг, урт хугацаат өр 62,685.3 сая төгрөг ба үлдэгдэл 25,829.4 сая төгрөгийг богино хугацаат өрөөр санхүүжүүлсэн байна. Энэ дүн 2015 онд 40,274.5 сая төгрөг байна. Энэ нь компанийн эргэлтийн бус хөрөнгийг богино хугацааны эх үүсвэрээр санхүүжүүлж байгааг харуулж байна. Эргэлтийн бус хөрөнгийг харьцангуй тогтвортой эх үүсвэрээр санхүүжүүлэх нь санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварт чухал юм.

б. Төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдал


Байгууллагын төлбөрийн чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийн системийг ашиглан тооцооллыг хийж 2014 он ба 2015 оны дүнг зохистой нормтой харьцуулж үзлээ.

Үзүүлэлт	Тооцох журам	Төлбөрийн чадварын шинжилгээ			Зохистой норм (дундаж)
		2014	2015	Өөрчлөлт	
Төлбөрийн чадварын шинжилгээ					
1 Эргэлтийн хөрөнгийн харьцаа	ЭХ : БХӨ	0.55	0.43	(0.11)	0.08
2 Төлбөрийн ойрын боломж	ТХХ : БХӨ	0.23	0.21	(0.02)	0.8 - 1.0
3 Төлбөрийн өнөөгийн боломж	Мх : БХӨ	0.05	0.09	0.03	0.2-0.3
4 Ажлын капитал /мян.төг/	ЭХ - БХӨ	(25,829.40)	(40,274.50)	(14,445.10)	эерэг
5 Өөрийн эргэлтийн капитал /мян.төг/	БК - УГХ	(25,829.40)	(40,274.50)	(14,445.10)	эерэг
6 Эх үүсвэрийн квот	ГК : ӨК	9.82	8.73	(1.09)	<=1
7 Хүүтэй зээл төлбөрийн хувь хэмжээ	Зээл : ГК	0.62	0.55	(0.08)	буурч байх

Үзүүлэлт	Тооцох журам	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ			Зохистой норм (дундаж)
		2014	2015	Өөрчлөлт	
Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ					
1 Өөрийн капиталын оролцоо	Кө=ӨК : НХ	9%	10%	0.01	>=50%
2 Гадны капиталын оролцоо	Кг=ГК : НХ	91%	90%	(0.01)	<=50%
3 Байнгын капиталын оролцоо	Кб=БК : НХ	57%	48%	(0.09)	>50%
4 Санхүүгийн хараат байдлын коэф	Кх=НХ : ӨК	10.82	9.73	(1.09)	
5 Өөрийн харьцаа /квота/	ГК : ӨК	9.82	8.73	(1.09)	<=1



Ашигт ажиллагааны шинжилгээ



Компанийн ашигт ажиллагааг шинжилэхийн тулд орлогын тайлангийн үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчдийн сонирхдог харьцааны үзүүлэлтүүдийг тооцож үзлээ.

Орлого, үр дүнгийн бүтэц, динамикийн шинжилгээ


Үзүүлэлт /сая.төг/	Тайлангийн дүн		Хувийн жин		Өөрчлөлт	
	2014	2015	2014	2015	2014	2015
Борлуулалтын орлого	90,914.3	101,597.1	100%	100%	10,682.80	12%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(70,289.3)	(95,500.8)	-77%	-94%	(25,211.50)	36%
Нийт ашиг	20,625.0	6,096.3	23%	6%	(14,528.70)	-70%
Бусад орлого	5,458.7	6,030.5	6%	6%	571.80	10%
Удирдлагын зардал	(4,712.5)	(5,404.2)	-5%	-5%	(691.70)	15%
Бусад зардал	(2,487.1)	(3,608.6)	-3%	-4%	(1,121.50)	45%
Санхүүгийн зардал	(5,070.2)	(4,564.4)	-6%	-4%	505.80	-10%
Хараат компани дахь ашгийн хувь	62.2	73.3	0%	0%	11.10	18%
Татварын өмнөх ашиг	13,876.1	(1,377.0)	15%	-1%	(15,253.10)	-110%
Орлогын албан татварын зардал	(3,195.3)	3,305.6	-4%	3%	6,500.90	-203%
Тайлант жилийн татварын дараах ашиг	10,680.8	1,928.6	12%	2%	(8,752.20)	-82%
Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0%	0%	0.00	0%
Татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого	10,680.8	1,928.6	12%	2%	(8,752.20)	-82%
Нэгж энгийн хувьцаанд ногдох ашиг	509.0	92.0			(417.00)	-82%

2015 оны жилийн эцсийн дэлгэрэнгүй орлогын тайланд хийгдсэн орлого, үр дүнгийн бүтэц, динамикийн шинжилгээнээс харахад борлуулалтын орлогын 94 хувийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг эзлэх бөгөөд үлдэх 6 хувийг нийт ашиг бүрдүүлж байна. Тайлант жилд татварын дараах нийт дэлгэрэнгүй орлогын борлуулалтын орлогод эзлэх хэмжээ 2 хувь байв. 2014 онтой харьцуулахад борлуулалтын орлогын дүн 10.7 тэрбум төгрөгөөр буюу 12 хувиар нэмэгдсэн байна.

Хөрөнгө капиталын өгвөжийн шинжилгээ

№	Үзүүлэлт	Тооцох журам	2014	2015	өөрчлөлт
Бүтээгдэхүүний ашиг олох чадвар					
1	Борлуулалтын орлогоор	ҮАЦА/БО	15%	-3%	-18%
2	Борлуулалтын өртгөөр	ҮАЦА/ББӨ	12%	-8%	-20%
3	Нийт эргэлтээр	(ТӨЦА+Эн)/БО	39%	20%	-19%
Нийт хөрөнгийн өгөөж					
1	Нийт хөрөнгийн	ХТӨЦА/НХ	7%	-4%	-11%
2	Өөрийн хөрөнгийн	ТДЦА/ӨК	88%	14%	-74%
3	Үйлдвэрлэлийн капиталын	ХТӨА/(ҮХ+ЭХ)	8%	-6%	-14%





Компанийн 2014 он, 2015 оны санхүүгийн тайлангийн мэдээллээс ашигт ажиллагааны шинжилгээг хийж үзвэл 2014 онд борлуулалтын орлогын нэг төгрөг тутмаас 15 мөнгөний үйл ажиллагааны ашиг олж байна. Бүтээгдэхүүний ашиг олох чадварын үзүүлэлт 2015 онд буурч алдагдалтай болсон байна. 2015 онд компани үндсэн үйл ажиллагаанаасаа алдагдалтай ажиллажээ. Энэхүү ашигт ажиллагааны бууралт нь байгууллагын төлбөрийн чадвар муудах, хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдах сөрөг талтай.

Хөрөнгө, капиталын хувьд өгөөжийг тооцож үзвэл 2015 онд үндсэн үйл ажиллагаанаас алдагдалтай ажилласан учир нийт хөрөнгийн, өөрийн хөрөнгийн, үйлдвэрлэлийн капиталын өгөөжийн үзүүлэлтүүд буурсан байна.

Зах зээлийн идэвхижилтийн шинжилгээ

Хувьцаат компанийн хөрөнгийн зах зээл дээр аль хир идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг вэ, компанийн зах зээлийн үнэлэмж ямар байгааг үнэлж үзэхийн тулд хөрөнгө оруулагчид дараах үзүүлэлтүүдийг тооцож өөрсдийн үнэлэлт дүгнэлтээ өгдөг.

Зах зээлийн идэвхижил буюу хувьцааны шинжилгээний үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Тооцох журам	2014	2015	өөрчлөлт
1	Гүйлгээнд байгаа хувьцааны дундаж тоо	жигнэсэн дундаж	20,974,360	20,974,360	0.00
2	Зах зээлийн үнэлгээ	Хтоо*ханш	74,417.0	51,806.7	(22,610.36)
3	Хувьцааны зах зээлийн дундаж үнэ	жилийн дундаж	3,814.00	2,687.00	(1,127.00)
4	Хувьцааны нэгжид ноогдох ашиг	ТДЦА/Х тоо	509.23	91.95	(417.28)
5	Зарласан ноогдол ашиг	НоА/Х тоо	0.00	0.00	0.00
6	Хувьцаагаарх хөрөнгө оруулалтын өгөөж	НоА/ЗЗҮ	0.00	0.00	0.00
7	Хувьцааны үнэлэмж	ЗЗҮ/ХННА	7	27	20
8	Ноогдол ашиг олголтын хувь	НоА/ТДЦА	0.00	0.00	0.00
9	Хувьцааны бүртгэлийн үнэ	ӨК/Х тоо	580.93	672.89	91.96
10	Хувьцааны ханшийн коэффициент	ЗЗҮ/БҮ	128.10	76.99	(51.11)

Компани 2014, 2015 онуудад хувьцаа нэмж гаргаагүй бөгөөд гүйлгээнд байх хувьцааны тоо жил бүр 20,974,360 ширхэг байна. Хувьцааны зах зээлийн үнийн талаарх мэдээллийг Хөрөнгийн биржийн мэдээллийн сангаас авлаа.

Хувьцааны үнэлэмжийн коэффициент 2014 онд 7 гарсан үзүүлэлт нь хөрөнгө оруулагчид нэгж хувьцаанд ноогдох ашгаас 7 дахин их хөрөнгийг компанид өгч ашиглуулахад бэлэн байна гэсэн утгатай бөгөөд компанийн зах зээлийн үнэлэмж муу биш байгааг харуулж байна. Хувьцааны үнэлэмжийн үзүүлэлт 2015 онд 27 болж өссөн байна.

Компани ноогдол ашиг хуваарилж, төлж байгаагүй учир хувьцаагаарх хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох боломжгүй байлаа.

2014 онд нэгж энгийн хувьцааны бүртгэлийн үнэ 580.93 төгрөг, 2015 онд 672.89 төгрөг болж өссөн нь хуримтлагдсан ашиг өссөнтэй холбоотой байна.

Гэвч хувьцааны ханшийн коэффициент 2015 онд 76.99 болж 51.11-ээр буурсан нь зах зээл дээр хувьцааны ханш уналтаас шалтгаалсан байна.



ЗУРГАА. "БАГАНУУР" ХК-ИЙН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ



Өртгийн хандлагын аргаар тооцсон бизнесийн үнэлгээ

Бизнесийн үнэлгээний өртгийн хандлагыг тухайн бизнес харьцангуй шинэ, компани өөрчлөн зохион байгуулагдаж байгаа, татан буугдаж байгаа, дампуурж байгаа зэрэг тохиолдолуудад ихэвчлэн хэрэглэнэ гэж ҮОУС-д заасан байдаг.

Өртгийн хандлагын өргө нь тухайн бизнесийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох замаар үнэлгээг хийдэг. Өөрөөр хэлбэл бизнесийг зогсоож байгаа нөхцөлд уг бизнесийн үнэ цэнэ нь тухайн бизнест ашиглагдаж буй хөрөнгийн үнэ цэнээс ихгүйгээр илэрхийлэгдэнэ гэсэн төсөөлөлд үндэслэдэг.

Өртгийн хандлагаар бизнесийн үнэлгээг тооцохдоо цэвэр хөрөнгийн аргыг ашигласан.

Цэвэр хөрөнгийн арга

Энэхүү цэвэр хөрөнгийн аргын гол агуулга нь компанийн хөрөнгө ба түүний эх үүсвэрийг зах зээлийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлж, үүнээс өр төлбөрийг хассан дүн буюу цэвэр хөрөнгийг тодорхойлох явдал юм. Бид тус компанийн 2015 оны 12 сарын 31-ны өдрөөрх аудитлагдсан санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн мэдээлэлд үндэслэв.

1. Эргэлтийн хөрөнгө

а. Мөнгөн хөрөнгө.

"Багануур" ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх нэгтгэсэн аудитлагдсан баланс дээр нийт мөнгөн хөрөнгийн дүн 6,180,440.0 мянган төгрөг байгаа ба үүнээс касс дахь бэлэн мөнгө 5,848.0 мянган төгрөг, замд яваа мөнгө 230,000.0 мянган төгрөг, харилцах дансан дахь мөнгө 5,944,592.0 мянган төгрөг байна. Мөнгөн хөрөнгийн дүнг тохируулга хийлгүүгээр нийт 6,180,440.0 мянган төгрөгөөр авлаа.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Касс дахь бэлэн мөнгө	5,848	3,000	634	2,214	5,848
Замд яваа мөнгө	230,000	230,000			230,000
Харилцах данс	5,944,592	5,858,848	25,344	60,399	5,944,592
Дүн	6,180,440	6,091,848	25,979	62,613	6,180,440

б. Дансны авлага.


Зээлээр хийгдсэн борлуулалтын дүн нь төлөгдөх хугацаандаа байгаа тул зах зээлийн үнийг балансын дүнгээр буюу нийт 8,757,079.0 мянган төгрөгөөр тооцлоо.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Дансаарх авлага	8,875,662	8,430,764	207,145	237,752	8,875,662
Авлагын хасагдуулга	(118,583)	(96,374)	(3,730)	(18,479)	(118,583)
Дүн	8,757,079	8,334,390	203,415	219,274	8,757,079

в. Бусад авлага.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бусад авлагын хэсэгт тайлант хугацаанд найдваргүй авлага нэмж байгуулаагүй тул хугацаа хэтэрсэн авлага байхгүй гэж үзэн дансны үнээр нь тохируулга





хийлгүйгээр бусад авлагын дүнг нийт 1,651,442.0 мянган төгрөгөөр зах зээлийн үнээр авч үнэлгээнд орууллаа. Бусад авлагын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд үзүүлээ.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Авлагын хасагдуулга	(532,194)	(532,194)			(532,194)
Ажилчдаас авах авлага	89,365	9,369	6,095	73,901	89,365
Хувь хүмүүсээс авах авлага	307,701	227,262	77,321	3,117	307,701
Байгууллагаас авах авлага	1,461,403	1,320,520	140,883		1,461,403
Холбоотой талын авлага	136,620	136,620			136,620
Нөхөн сэргээлтийн авлага	22,500	22,500			22,500
АНБОУАТ авлага	87,609	80,401	7,111	97	87,609
Агаарын бохирдлын авлага	9,221	9,221			9,221
Бусад авлага	69,218		68,696	522	69,218
Дүн	1,651,442	1,273,699	300,107	77,637	1,651,442

г. Дараа тайлан

Дараа тайлангаар олгосон бэлэн мөнгө нь богино хугацаанд мөнгө зарцуулсан тайланг гаргаж тооцоо хийх тул үлдэгдэл дүнгээр 248,776.0 мянган төгрөгөөр үнэлгээнд авсан.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Дараа тайлан	248,776	233,665	13,643	1,467	248,776
Дүн	248,776	233,665	13,643	1,467	248,776

д. Бараа материал.


Нэгтгэсэн баланс дахь материаллаг нөөцийн үлдэгдэл 14,009,665.0 мянган төгрөг байна. Бараа материалын данс бүртгэлээс эдгээр материалын насжилтыг тодорхойлох боломжгүй учир цаг хугацааны тохируулга хийх боломжгүй байлаа. Тайлант хугацаанд ашиглагдахгүй удсан бараа материалын үлдэгдэлд үнэ цэнийн бууралт нэмж тооцоолоогүй байна.

Мөн эдгээр сэлбэг, хангамжийн материалууд нь компанийн үндсэн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд бүгд ашиглагддаг, харьцангуй түргэн эргэлтэд ордог тул балансын дүнд төдийлөн өөрчлөлт орохгүй гэж үзлээ.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Дуусаагүй үйлдвэрлэл	112,286			112,286	112,286
Бэлэн бүтээгдэхүүн	1,053,809	890,380	163,428.65		1,053,809
Бусад бүтээгдэхүүн	52,660		28,139.80	24,520	52,660
Түлш	1,188,380	1,188,243	137.80		1,188,380
HYUNDAI сэлбэг	71,658	71,658			71,658
AA материал	187,746	187,746			187,746
Belaz сэлбэг	23,947	23,947			23,947
Сэлбэг хэрэгсэл	908,039	908,039			908,039
Засварын сэлбэг	855,957	855,957			855,957
CAT сэлбэг	943,730	943,730			943,730
Komatsu сэлбэг	1,777,695	1,777,695			1,777,695
Өрмийн сэлбэг	64,195	64,195			64,195
SBR-160 өрмийн сэлбэг	250,639	250,639			250,639
Тос, тосолгооны материал	457,850	457,102	36.36	712	457,850
TEREX сэлбэг	386,992	386,992			386,992
ТЭМ сэлбэг	204,419	204,419			204,419
Үйлчилгээний сэлбэг	38,534	38,534			38,534

0000191





Цахилгааны сэлбэг	2,291,618	2,291,618			2,291,618
ЭКГ сэлбэг	8,178,611	8,178,611			8,178,611
Тэсрэх бодис	94,127	94,127			94,127
Хүчилтөрөгч, газ	4,256	4,256			4,256
Хангамжийн материал	192,639		22,711,15	169,927	192,639
Маль амьтан	39,033			39,033	39,033
Үнэ цэнийн бууралт хасагдуулга	(5,369,154)	(5,369,154)			(5,369,154)
Дүн	14,009,665	13,448,734	214,454	346,478	14,009,665

е. Эргэлтийн хөрөнгийн дүн.

"Багануур" ХК-ийн 2015 оны 12 сарын 31-ний байдлаар бизнесийн үнэлгээний өртгийн хандлагын аргад ашиглах зорилгоор эргэлтийн хөрөнгийн зах зээлийн үнийн дүнг тохируулга хийлгүйгээр балансын дүн **30,847,402.7** мянган төгрөгөөр авлаа.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Мөнгөн хөрөнгө	6,180,440	6,091,848	25,979	62,613	6,180,440
Дансны авлага	8,757,079	8,334,390	203,415	219,274	8,757,079
Бусад авлага	1,651,442	1,273,699	300,107	77,637	1,651,442
Дараа тайлан	248,776	233,665	13,643	1,467	248,776
Бараа материал	14,009,665	13,448,734	214,454	346,478	14,009,665
Дүн	30,847,402.7	29,382,336	757,598	707,469	30,847,402.7

2. Удаан гүйлгээт хөрөнгө

а. Үндсэн хөрөнгө.

Манай компанийн үнэлгээчид "Багануур" ХК-ийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хийж хөрөнгийн үнэлгээний тайланг тусад нь бэлтгэн хүргүүлсэн.

Хөрөнгийн үнэлгээ хийсэн тухай.

"Багануур" ХК-ийн үндсэн хөрөнгийг барилга, байгууламж, болон хөдлөх хөрөнгө, үүнд машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө, бусад үндсэн хөрөнгө гэсэн ангилалаар үнэлэв. Үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдсан 11 дансны ангиллаарх 3028 нэр төрлийн 7976 ширхэг хөрөнгүүдийг хөрөнгийн үнэлгээнд хамруулсан.

"Багануур" ХК-ийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг хөрөнгийн үнэлгээний олон улсын практикт хэрэглэдэг нийтлэг арга, хандлагуудыг ашиглан тодорхойлсон. Зах зээлийн үнэ цэнийн суурийг үндэслэн дараах арга хандлагуудыг ашиглалаа.


ӨРТГИЙН ХАНДЛАГА. Худалдан авагч хөрөнгөнд түүнтэй ижил төрлийн ашиглалт бүхий хөрөнгийг худалдан авах, барьж босгоход гарах өртгөөс илүүг төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчимд үндэслэн үнэ цэнийг тогтоодог хандлага юм.

Өртгийн хандлагын дагуу тухайн хөрөнгийн нөхөн орлуулах /сэргээн босгох/ өртгөөс түүний ашиглалтын хугацаанд бий болсон элэгдлийг хасч үнэ цэнийг тодорхойлдог.

ЗАХ ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛАЛТЫН ХАНДЛАГА. Тухайн хөрөнгийн үнэ цэнийг нээлттэй зах зээлд саяхан борлогдсон үнэлэгдэж буй хөрөнгөтэй адил болон ижил төстэй хөрөнгийн борлуулалтын үнийг ашиглан харьцуулан тогтоодог.



ОРЛОГЫН ХАНДЛАГА. Үнэлэгдэж буй хөрөнгийн ашиглагдах хугацаандаа бий болгох орлогыг тооцоолж капиталжуулах замаар буюу ирээдүйн мөнгөн урсгалыг өнөөгийн үнэ цэнэд хувиргах замаар үнэ цэнийг тогтоодог хандлага юм.



Компани нь уул уурхайн олборлолт, үйлдвэрлэл явуулдаг, тусгай зориулалтын хөрөнгүүд ашиглагддаг, ихэнхи хөрөнгүүд нь идэхитэй зах зээлд арилжигддаггүй, зах зээлийн үнийн мэдээлэл хомс, төрийн хамгаалттай бүсэд үйл ажиллагаа явуулдаг, уурхайн хөрөнгүүдийг бүхэлд нь болон хэсэгчлэн түрээслэж орлого олох боломжгүй зэрэг нөхцлүүдийг харгалзан үзэж Зах зээлийн харьцуулалтын хандлага ба Өртгийн хандлагын арга буюу элэгдэл тооцсон орлуулах өртгийн аргыг хөрөнгийн үнэлгээнд ашиглалаа.

Хөрөнгийн үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бичиг баримт, мэдээллийг цуглуулж барилга, байгууламж, тоног төхөөрөмжүүдийн иж бүрдэл, чанар, ашиглалтын байдалтай газар дээр нь очиж, биечлэн танилцаж, шаардлагатай хэмжилтүүдийг хийж, үнэлгээний ажилд холбоотой тооцооллуудыг хийсэн. Мөн компанийн инженер, техникийн ажилчдын саналыг авч хөрөнгүүдийн цаашид ашиглах хугацааг тогтоосон.

Түүнчлэн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, түүний гэрээ, барилгын зураг төсөл зэрэг холбогдох бичиг баримтад үндэслэн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.

ӨРТГИЙН ХАНДЛАГЫН АРГА

Өртгийн хандлагын аргаар нөхөн орлуулах өртгөөс ашиглагдсан хугацаанд хамаарах хуримтлагдсан биет элэгдэл /үнэлгээчин тооцоолсон/-ийг хасаж тодорхойлсон үлдэгдэл өртгийг хийц, ашиглалт, чанар байдал, засвар сайжруулалт зэргийг харгалзан үзэж итгэлцүүр буюу коэффициентээр зохицуулалт хийж өнөөгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлдог.

Нөхөн орлуулах /Нөхөн сэргээх/ өртөг



Барилгын хувьд нөхөн сэргээх өртөг нь барилгыг одоогийн загвар, хийц, материалаар өнөөдөр барьж байгуулахад гарах зардлын дүн юм. Нөхөн сэргээх /орлуулах/ өртгийг барилгын хүчин чадал буюу талбайг нэгж хүчин чадлын үнэлгээгээр үржүүлж тодорхойлсон.

Барилгын нөхөн сэргээх өртгийг тооцохдоо нэгж хүчин чадлын үнэлгээг дараах 2 хувилбараар тооцлоо. Үүнд:

а. *Батлагдсан төсөвт өртөг.* Барилгын төсөвт өртгийн батлагдсан нормативын дагуу нөхөн сэргээх өртгийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоол "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай", ЗТБХБЯ-ны сайдын 2011 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 29 дүгээр тушаалын хавсралт "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм", Барилга Хот Байгуулалтын сайдын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 36 дугаар тушаалын хавсралт "Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн 2014, 2015 оны индекс"-г тус тус ашигласан.

Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр туслах чанартай баригдсан жижиг объектууд болох тусгайлан ашиг орлого олох боломжгүй барилга байгууламжийн нөхөн сэргээх өртгийг тооцохдоо дээрх батлагдсан үндсэн барилгын нэгж үнийн 30-80%-иар, 2013-2015 онуудад шинээр баригдсан үндсэн хийц бүтээцийн хувьд ижил төстэй барилгуудын төсөвт өртөг болон зах зээлийн арилжааны үнэ зэрэгт инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсэх, барилгын өндрийн итгэлцүүр, барилгын үндсэн хийц бүтээцийн чанар байдалд өгсөн үнэлгээг харгалзан үнийг өсгөх, бууруулах зохицуулалт хийж тооцсон.





б. Зах зээлийн дундаж үнэ. Хөрөнгийн үнэлгээний зорилго нь хөрөнгүүдийн зах зээлийн үнийг тодорхойлох явдал юм. Иймд үнэлгээний дүнг шалгах зорилгоор нөхөн орлуулах, нөхөн сэргээх өртгийг батлагдсан төсөвт өртгөөс гадна зах зээлийн үнийн мэдээлэлд үндэслэн тооцоолсон.

Компанийн барилга байгууламжийн зах зээлийн үнэлгээг хийхэд уг барилгуудтай ижил төстэй барилгын мэдээлэл хомс байв. Иймд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр захиргаа, удирдлагын оффис, иргэний болон үйлчилгээний барилга, орон сууцны барилгуудын зах зээлийн дундаж үнийг Улаанбаатар хотоос Багануур зэрэг алслагдсан дүүргүүдэд 2016 онд худалдахаар зарлагдсан зарим мэдээг төвийн хэвлэлүүд, "unegui.mn", "osmo.mn", "zuuch.mn" шэх мэт хөрөнгө зуучийн вэб сайтуудаас цуглуулж, газар, зориулалтын тохируулга хийж, зах зээлийн дундаж үнийг тодорхойлж, үнэлэгдэж буй хөрөнгө тус бүр дээр байршил, зориулалт, чанар байдлын итгэлцүүрээр зохицуулалт хийж зах зээлийн дундаж үнэ ханшийг тодорхойлсон. .

Тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн хувьд орлуулах өртгийг тооцохдоо зах зээлийн үнийн мэдээлэл болон валютын ханшийн өөрчлөлтийг ашигласан.

Ашиглалтын хугацаа

Барилгын үнэлгээг хийхдээ олон улсад ашиглагддаг Маршал Свифтийн нормыг өөрийн орны нөхцөлд тохируулан засварлаж, барилгын үндсэн хийц бүтээц, зориулалтаас хамаарч ашиглалтын норматив хугацааг сонгон авсан. Маршал Свифтийн аргачлалд барилгыг хийцээс нь хамааруулан А, В, С, D, S гэсэн 5 ангилалд хуваан шаиглалтын жилийг ялгаатай тогтоож өгсөн байдаг.

Хөрөнгийн үнэлгээнд мөрдсөн ашиглалтын хугацааг дараах байдлаар сонгон авсан.



Үзүүлэлт		Тохируулга хийгдсэн элэгдэл тооцох		нормт хугацаа, жилээр /Маршал ба Свифт/				
		жил	хувь	A	B	C	D	S
Барилга								
1	Захиргааны барилга	60	1.6%	60	60	55	50	50
2	Засварын барилга	60	1.6%	55	55	50	45	45
3	Агуулах / тоосго, блок/ склад,гражи	36	2.7%	60	60	55	50	50
4	Туслах зориулалтын барилгууд	36	2.7%	50	50	45	40	40
5	Үйлдвэр, машин механизмын засвар үйлчилгээний	60	1.6%	55	55	50	45	45
6	Бизнесийн үл хөдлөх /оффис, зочид буудал/	60	1.6%	60	60	55	50	50
7	Үйлдвэрлэлийн бус зориулалттай бусад барилга /спорт заал, эмнэлэг сувилал/	60	1.6%	50	50	45	40	40
8	Зөөврийн, хөнгөвчилсөн бүтээцтэй жижиг барилга	20	6.6%			45	40	40
9	Контейнер	20	6.6%				20	

№	Хөрөнгийн ангилал	Норматив нас	Элэгдэл хувь
1	Бусад угсармал хөнгөвчилсөн хийцийн байшин	20	5.0%
2	Дэд станцын тоног төхөөрөмж	25	4.0%
3	Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам	15	6.6%
4	Дулааны шугам	35	2.6%
5	Уурхайн бусад инженерийн байгууламж	21	4.7%
6	Халаалтын болон хэрэглээний усны шугам	21	4.7%
7	Агуулах сав, резервуар	20	5.0%
8	Төмөр зам, бүх төрлийн цистерн, зорчигчийн тавцан,	25	4.0%

Тоног төхөөрөмж болон бусад хөрөнгүүдийн хувьд ашиглалтын хугацааг үйлдвэрлэгчийн тогтоосон нормативт хугацаа, НББ-ийн бодлогод мөрдөж буй хугацааг харгалзан үзэж хөрөнгө тус бүр дээр тодорхойлсон.

Биет элэгдэл





Биет элэгдэл нь ашиглалтын ба байгалийн хүчин зүйлсээс барилга байгууламжийн өртөг хэрхэн буурахыг илэрхийлнэ. Биет элэгдлийг тооцоолохдоо нөхөн орлуулах өртгийн дүнг үнэлгээчний тооцоолсон элэгдлийн хувиар үржүүлж тооцсон.

Биет элэгдлийн хувь

Биет элэгдлийн хувь тухайн хөрөнгийн үр ашигтай ашигласан хугацааг түүний нийт ашиглах боломжит хугацаанд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно. Ашиглалтын нормативт хугацаа хэтэрсэн хөрөнгийн хувьд үр ашигтай ашиглах хугацаа нь ашигласан хугацаа ба цаашид ашиглах хугацааны нийлбэр байна. Ашиглалтын хугацаа дуусаагүй, харьцангуй шинэ хөрөнгийн хувьд ашиглах боломжит болон ашиглалтын нормативт хугацаа нь адил байна.

Зах зээлийн үнэ цэнэ

Өртгийн хандлагын аргаар барилга тус бүрийн нөхөн сэргээх /нөхөн орлуулах/ өртгөөс тооцоолсон элэгдлийг хасаж тухайн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон.

ЗАХ ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛАЛТЫН ХАНДЛАГА

Зах зээлийн харьцуулалтын хандлагын арга нь ижил байрлалд, ижил төстэй, ашигт чанартай, зэрэгцүүлэгдэхүйц хөрөнгүүдийн зах зээл дээр зарж борлогдсон мэдээлэлд үндэслэн нэгж хүчин чадал /м.кв/-ын зах зээлийн дундаж үнийг ашиглан үнэлгээг тодорхойлдог.

"Багануур" ХК-ийн барилга байгууламжийн зах зээлийн үнэлгээг зах зээлийн харьцуулалтын хандлагаар үнэлэхэд Багануур хотод уг барилгуудтай ижил төстэй барилгын зарагдсан тухай зах зээлийн мэдээлэл хомс байв.

Гэвч үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр захиргаа, удирдлагын оффис, иргэний болон үйлчилгээний барилга, орон сууцны барилгуудын зах зээлийн дундаж үнийг Улаанбаатар хотоос Багануур зэрэг алслагдсан дүүргүүдэд 2016 онд худалдахаар зарлагдсан зарим мэдээг "unegui.mn", "osmo.mn", "zuuch.mn" гэх мэт интернет мэдээллийн сайтуудаас цуглуулж, газар, зориулалтын тохируулга хийж, зах зээлийн дундаж үнийг тодорхойлж, үнэлэгдэж буй хөрөнгө тус бүр дээр байршил, зориулалт, чанар байдлын итгэлцүүрийг тооцон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон.

Бизнесийн үнэлгээний өртгийн хандлагаар компанийн үндсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг дараах байдлаар тооцооллоо.


Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Орон байр	7,016,523	33,717,614	309,044	185,034	34,211,692
Дамжуулах байгууламж	1,436,580	2,129,330	-	-	2,129,330
Байгууламж	7,449,302	15,339,845	-	-	15,339,845
Тавилга эд хогшил	1,579,101	1,587,577	49,437	135,153	1,772,167
Ажлын машин	1,698,315	1,897,275	15,831	236,528	2,149,634
Хүчний машин	46,602,860	73,609,888	-	-	73,609,888
Тээврийн хэрэгсэл	2,438,969	2,926,809	-	-	2,926,809
Бусад тоног төхөөрөмж	27,676	22,124	3,386	6,798	32,309
Холбооны хэрэгсэл	42,741	68,639	-	-	68,639
Хэмжих хэрэгсэл	268,144	302,000	-	-	302,000
Дүн	68,560,209	131,601,102	377,697	563,514	132,542,313

Цэвэр хөрөнгийн аргын тооцоололд ашиглах үндсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг 132,542,313.0 мянган төгрөгөөр тодорхойллоо.

Б. Бусад удаан гүйлгээт хөрөнгө

"Багануур" ХК-ийн нэгтгэсэн тайланд тусгагдсан бусад удаан гүйлгээт хөрөнгөд уурхай хөгжүүлэлтийн хөрөнгө, хөрс хуулалтын хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтууд хамаарч байна.





Эдгээр хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд өртгийн аргаар бүртгэсэн байна. Уурхай хөгжүүлэлтийн хөрөнгө болон хөрс хуулалтын хөрөнгүүд нь уурхайн ашиглалтын явцад хорогдуулга тооцох замаар бүтээгдэхүүний өртөгт шингэдэг, санхүүгийн тайланд өртгөөрөө илэрхийлэгддэг. Бизнесийн үнэлгээнд өртгийн хандлагаар компанийн цэвэр хөрөнгийг тооцоолоход эдгээр хөрөнгүүдийн зах зээлийн үнэ цэнийг тэдгээрийн балансын дүнгээр авлаа.

Цэвэр хөрөнгийн аргад ашиглах дээрх хөрөнгүүдийн зах зээлийн үнэ цэнийг дараах байдлаар авлаа.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Уурхай хөгжүүлэлтийн хөрөнгө	4,809,247	4,809,247			4,809,247
Хөрс хуулалтын хөрөнгө	31,247,419	31,247,419			31,247,419
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,292,681	1,292,681			1,292,681
Мон-Цахимд ХО	274,044	274,044			274,044
Дүн	37,623,390	37,623,390			37,623,390

3. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөд программ хангамж, газар эзэмших эрхийг хамруулж үнэлгээг хийсэн.

Программ хангамжийн үнэлгээг хийхдээ өртгийн хандлагын аргыг ашиглан үнэлсэн ба тооцоо, судалгаа хөрөнгийн үнэлгээний тайланд харуулсан. Програм хангамжийн зах зээлийн үнэлгээг 316,842.0 мянган төгрөгөөр тооцсон.

Газар эзэмших эрхийг үнэлэхдээ асгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үнэлгээний тойргийн хуваарь", "Хот тосгон, бусад суурины газрын зэрэглэл, тэдгээрийн нэг га-ийн суурь үнэлгээ", БХБС-ын 2015 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал"-ыг үндэслэл болгон үнэлсэн. Хөрөнгийн үнэлгээний тайланд газар эзэмших эрхийн зах зээлийн үнэ цэнийг 656,858.0 мянган төгрөгөөр тооцсон.

4. Ордын үнэлгээ

Өртгийн хандлагын үнэлгээнд ашигласан ордын үнэлгээг энэ хэсгийн төсгөлд тусд нь үнэлгээг хийсэн болно.

Өртгийн хандлагаар тооцсон бизнесийн үнэлгээний дүгнэлт

Өртгийн хандлагын цэвэр хөрөнгийн аргаар бизнесийн үнэ цэнийн тооцооллыг дараах хүснэгтэд харууллаа.

Дансны нэр	Нэгтгэсэн СТ дүн	Багануур ХК	Багануур Илч ХХК	Багануур Сувилал ХХК	Зах зээлийн үнэ
Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ	137,336,258	199,578,673	1,136,070	1,273,342	201,988,086
БХӨ	71,121,935	-	-	-	71,121,935
УХӨ	52,100,966	-	-	-	52,100,966
Дүн	123,222,900	-	-	-	123,222,900
Цэвэр хөрөнгө					78,765,185
Орд					27,151,780
Өртгийн хандлагаар бизнесийн үнэлгээ					105,916,965

Бидний хийсэн тооцоо, судалгаагаар компанийн өртгийн хандлагаар тооцсон бизнесийн цэвэр үнэ цэнийг 2015 оны 12-р сарын 31-ны байдлаарх зах зээлийн үнэ цэнийг **105,916,965.0** мянган төгрөгөөр тодорхойллоо.





Багануурын уурхайн ордын үнэлгээ

Ордын мэдээлэл

Багануурын хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн хойш 130 км, Төв аймгийн Баяндэлгэр сумын төвөөс зүүн зүгт 15 км зайтай, Тавансувайн хөндийд, Хэрлэн голын сав газарт оршдог. Мааньт өртөөтэй 80 км төмөр замаар холбогдсон ба Улаанбаатараас Дорнодын чиглэлд тавигдсан асфальт бетон хучилттай авто зам дайран өнгөрдөг. Засаг захиргааны хувьд Нийслэлийн Багануур дүүрэгт харъяалагдана. Багануурын нүүрсний орд нь газарзүйн хувьд хойд өргөрөгийн 41039'45", баруун уртрагийн 108017'50" солбилцолд оршино.

Багануурын хүрэн нүүрсний орд нь Төв Монголын атираат мужид Хангай-Хэнтийн газарзүйн дүүрэгт, грабен-синклиналь структурт оршино. Энэхүү грабен-синклиналь нь Хангай-Хэнтийн атираат тогтолцоо, Төв Монголын эртний өргөгдөл хоёрын заагийн дагуу Адаацагийн гүний хагаралын бүсэд 20 км өргөнтэй, 200 км урттай, Цагаанцав, Шинэхудаг, Хөхтээг горизонтуудад ангилагддаг доод цэрдийн контраст вулканын ба нүүрс агуулсан терриген формацаар дүүргэгдсэн хожуу мезозойн эх газрын рифтоген структур болно.

Багануурын орд газрын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	
Эзэмшил газрын хэмжээ	3597.11 га
Ордын нийт нүүрсний нөөц	812.0 сая.тн /2015 оны 1 сарын 1-ны байдлаар/
Ордын талбай	14*5 км
Нүүрсний үндсэн давхаргын тоо	3
Хөрсний дундаж зузаан	80 метр
Нүүрсний үнслэг	дунджаар 17.5%
Нүүрсний ажлын чийг	дунджаар 37.5%
Нүүрсний хүхрийн агуулга	дунджаар, шатах массдаа 0.73%
Нүүрсний илчлэг	3360 кКал/кг
Нүүрсний хувийн жин	1.23-1.31 тн/м3
Хөрсний хувийн жин	1.95-2.25 тн/м3
Гүний усны ундарга	1100 м3/цаг

Орд газарт хийгдсэн хайгуулын ажлууд

Багануурын нүүрсний ордын хайгуулын ажил дараах гурван үе шаттайгаар явагдсан байна. Үүнд:

- Хайгуулын үе шат: Хайгуулын ажлыг 1974-1975 онд явуулж ордын хил хязгаарыг тогтоон, эхэлж ашиглах талбайд нарийвчилсан хайгуулын ажлыг явуулсан.
- Гүйцээх хайгуулын үе шат: Гүйцээх хайгуулын ажлыг 1988-1989 онд явуулж, ордын хэмжээнд 1,200 м түвшин хүртэлх гүнд нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэсэн.
- Нэмэлт хайгуулын үе шат: Нэмэлт хайгуулын ажлыг 2014 онд явуулж ордын хэмжээнд 960 м түвшин хүртэлх гүнд нүүрсний давхаргуудыг АМХЭГ-ын даргын 1998 оны 2-р сарын 18-ны өдрийн 27 тоот тушаалаар баталсан "Ашигт малтмалын нөөц, баялгийн ангиллын түр заавар" болон олон улсын хэмжээнд мөрдөж байгаа журам стандартад нийцүүлэн судалж, нөөцийн тодотгол тооцоог хийсэн.

Багануурын ордын хэмжээнд 2014 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:


Ордын нөөц

Багануурын орд газрын тусгай зөвшөөрлийн эзэмшил

Хөрөнгийн үнэлгээний "Үндэсний Реалти" ХХК

0000197





Багануурын уурхайн орд газрын нийт талбайн хэмжээ нь 4,778 га бөгөөд Багануурын хүрэн нүүрсний ордод 1974-1975 онд, 1988-1989 онд, 2014 онуудад нийт 3 удаа хайгуулын ажил хийгдэж, нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын санд бүртгэж авсан байна. Тус ордод улсын төсвийн хөрөнгөөр 1974-1975 онд хийсэн хайгуулын ажлын үр дүнд ордын нийт нөөцийг 599.8 сая тонн гэж тогтоон улмаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн бол 1988-1989 онд хийсэн гүйцээх хайгуулын ажлын үр дүнд ордын нийт нөөцийг 708.2 сая тонн гэж тогтоон 1989 оны ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна. Харин 2014 онд "Эрдгео" ХХК болон АНУ-ын "Норвест" корпорацийн хамтарсан багаас нэмэлт хайгуулын ажлыг хийн ордын нүүрсний нийт нөөцийг 812 сая тонноор тогтоон ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн. Үүнээс "Багануур" ХК-ийн эзэмшлийн MV-001371 тусгай зөвшөөрлийн талбайд 340 сая тонн, MV-013631 тусгай зөвшөөрлийн талбайд 41.8 сая тонн нийт 381.8 сая тонн буюу Багануурын ордын нөөцийн 47 хувь нь Компанийн тусгай зөвшөөрлүүдийн талбайд ногдож байна. Үлдсэн 53 хувь буюу 430.2 сая тонн нөөц нь MV-013631 тусгай зөвшөөрлийн анх олгогдсон талбайгаас хасагдсан, "Алтайн гянт" ХХК-ийн эзэмшиж байгаад 2012 оны 10 дугаар 23-ны өдөр Ашигт малтмалын газрын даргын 615, 616 тоот тушаалуудаар хүчингүй болгосон 12959А тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд ногдож байна. Тус талбайг буюу Багануур дүүргийн Нарийны талд орших Баруун хонхор L-49-1 нэртэй 1181.16 га талбайг Монгол улсын Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 392 тоот тогтоолоор нөөцөд авсан байна.

Үнэт цаас гаргагч нь дараах Хүснэгтэд дурьдагдсан Ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн бүртгэгдсэн эзэмшигч байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн анхны хүчинтэй хугацаа нь 30 жил байх бөгөөд тус бүр 2 удаа сунгуулах боломжтой юм.

"Багануур" ХК-ийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл			
Үзүүлэлт	Ашиглалт	Ашиглалт	Ашиглалт
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-001371	MV-013630	MV-013631
Байршил	УБ хот, Багануур дүүрэг, Нарийний тал	УБ хот, Багануур дүүрэг, Нарийний тал	УБ хот, Багануур дүүрэг, Нарийний тал-1
Талбайн хэмжээ	1,444.06 га	12.24 га	2,140.81 га
Тусгай зөвшөөрлийн хугацаа	30 жил 1998.10.09-2028.10.09	30 жил 2008.05.01-2038.05.01	30 жил 2008.05.01-2038.05.01

Уурхайн ашиглалт

Уурхай 1978 онд анх байгуулагдсанаас хойш 2015 он хүртэлх буюу 37 жилийн хугацаанд нийт 103.1 сая.тн нүүрс олборлон борлуулж, 359.1 сая.м3 хөрс хуулалтын ажлыг хийсэн. Үүнээс тээвэргүй хөрс хуулалт 162.9 сая.м3, төмөр замаар 24.2 сая.м3, 171.9 сая.м3 авто тээвэртэй хөрс хуулалтын ажлыг хийсэн байна. Мөн хөрс шидэлтийн ажлыг 107.8 сая.м3, инженерийн ажил 28.4 сая.м3, нөхөн сэргээлтийн ажил 9.4 сая.м3, 8.8 сая.м өрөмдлөгийн ажлыг хийж 663.5 сая.м3 уулын цулын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Сүүлийн 5 жилийн уурхайн ажлын хэмжээ


Уулын ажлын үзүүлэлт	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2015
Нүүрс гаргалт	м.тн	3,253.3	3,541.6	3,876.7	3,617.1	3,731.2
Нүүрс борлуулалт	м.тн	3,263.8	3,541.6	3,824.5	3,683.3	3,747.0
Хөрс хуулалт	м.м3	15,453.3	15,259.8	18,640.5	17,269.3	19,135.7
Нийт уулын цул	м.м3	26,398.2	26,590.7	30,566.5	29,363.8	30,855.6

Ордын үнэлгээ

Харилцаа үйлдвэрийн "Үндэсний Ресурс" ХХК

0000192





Багануурын уурхайн ордын "Багануур" ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөлийн MV-00137 (30 жил), MV-013630 (30 жил), MV-013631 (30 жил) дугаар бүхий гурван лицензэд хамаарах орд газрыг биет бус шинжтэй хөрөнгө гэж үзэн ордын үнэлгээг хийхдээ дараах арга зүйг баримталлаа


Өртгийн хандлагын арга. Өртгийн хандлагын дагуу ордыг хайгуул хийх, ТЭЗҮ-ийг боловсруулж нөөцийг тогтоон батлуулан олборлолтын шатанд шилжих хүртэлх хийгдсэн геологи хайгуул, судалгаа шинжилгээний ажилд зарцуулсан ажлын хэмжээ, зардлын тооцоог өнөөгийн үнэ ханш, үнэ цэнээр илэрхийлэх ажил хийгдэнэ.

Бидний хувьд Багануурын уурхайн хайгуул, судалгааны ажлын цар хүрээ, хэмжээг үндэслэлтэй тодорхойлох боломжгүй байгаа учир өртгийн аргаар ордыг үнэлэхээс татгалзлаа.

Зах зээлийн хандлага. Эрчим хүчний нүүрсний орд газрын ашиглалтын лицензийг худалдсан тухай баталгаатай зах зээлийн мэдээлэл байхгүй байгаа нөхцөлд орд газрыг зах зээлийн харьцуулалтын аргаар үнэлэх боломжгүй гэж үзлээ.

Орлогын хандлага. Ордын үнэлгээг хийхдээ цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулах аргыг хэрэглэдэг. Орд газрыг эзэмших эрх (тусгай зөвшөөрөл)-ийг олж эзэмшсэнээр бизнес эрхлэгчид бий болох ашиг орлогын хэмжээгээр энэхүү биет бус шинжтэй хөрөнгийн эрхийн үнэлгээг тодорхойлно. Өөрөөр хэлбэл энэхүү ордыг бүхэлд нь ашиглаж дуусах хүртэл бизнес эрхлэгчийн ирээдүйд олж болох ашиг орлогыг үндэслэлтэй тооцоолсны үндсэн дээр ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлно.





Ордын үнэлгээ -Цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулах арга

Ордыг үнэлэхдээ компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, төсөл, төлөвлөгөөнд үндэслэн ирээдүйн мөнгөн урсгалыг таамагласан. Мөнгөн урсгалыг таамаглахдаа ирэх 5 жилийг хамруулан үзлээ.


Ордын үнэлгээнд хорогдуулах цэвэр мөнгөн урсгал нь төсөвлөсөн орлогын тайлангийн үзүүлэлт татварын дараах цэвэр ашиг байна. Бизнесийн үнэлгээнд хамаарах цэвэр мөнгөн гүйлгээ нь бизнест бий болох хөрөнгийн хэмжээг харуулдаг бол ордын үнэлгээнд хамаарах мөнгөн урсгал нь бизнесээс олох ашгийн хэмжээг харуулдаг.

Ордын эзэмших эрхийг худалдан авагч, хөрөнгө оруулагч нь тухайн ордоос олох ашгийн хэмжээнээс ихгүй үнээр эзэмших эрхийг худалдан авна гэсэн төсөөлөлд үндэслэн энэхүү үнэлгээг хийлээ.

Ордод хамаарах ирээдүйн мөнгөн урсгалын таамаглал

Төсөөлөл						
Үзүүлэлт /сая.төг/	2016	2017	2018	2019	2020	2021
Орлого	107,658.5	121,634.3	199,121.6	251,746.3	334,664.9	342,580.4
Жилийн өсөлтийн хувь	6.0%	13.0%	63.7%	26.4%	32.9%	2.4%
Борлуулалтын зардал	(97,528.3)	(108,867.1)	(181,820.1)	(211,866.7)	(244,498.6)	(245,128.6)
Нийт ашиг (алд)	10,130.2	12,767.2	17,301.5	39,879.6	90,166.4	97,451.7
Жилийн өсөлтийн хувь	66.2%	26.0%	35.5%	130.5%	126.1%	8.1%
Ашгийн хувь	9%	10%	9%	16%	27%	28%
Бусад орлого	955.9	602.1	602.1	602.1	602.1	602.1
Борлуулалтын бусад зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Элэгдлийн өмнөх ашиг	11,086.1	13,369.3	17,903.6	40,481.7	90,768.5	98,053.9
Элэгдэл	(18,728.8)	(24,103.6)	(29,040.9)	(33,976.1)	(39,395.2)	(42,342.7)
Хорогдол	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Элэгдлийн дараах ашиг	(7,642.6)	(10,734.3)	(11,137.3)	6,505.6	51,373.4	55,711.2
Жилийн өсөлтийн хувь	455.0%	40.5%	3.8%	(158.4%)	689.7%	8.4%
Э/д ашгийн хувь	(7.1%)	(8.8%)	(5.6%)	2.6%	15.4%	16.3%
Олборлолтын бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хүүгийн орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хүүгийн зардал	(3,553.1)	(6,498.3)	(7,646.1)	(11,097.4)	(14,180.1)	(13,614.6)
Татварын өмнөх ашиг	(11,195.7)	(17,232.6)	(18,783.3)	(4,591.8)	37,193.2	42,096.6
Татвар	0.0	0.0	0.0	0.0	(8,848.3)	(10,074.1)
Цэвэр ашиг	(11,195.7)	(17,232.6)	(18,783.3)	(4,591.8)	28,344.9	32,022.4
Цэвэр ашгийн хувь	(10.4%)	(14.2%)	(9.4%)	(1.8%)	8.5%	9.3%





Ордын үнэлгээний тооцоолол

Хорогдуулгын хувь		1	2	3	4	5	6
Дискаунтын хувь	16%	0.8621	0.7432	0.6407	0.5523	0.4761	0.4104
	18%	0.8475	0.7182	0.6086	0.5158	0.4371	0.3704
	20%	0.8333	0.6944	0.5787	0.4823	0.4019	0.3349
Капиталжуулах хувь	13.6%						
	15.6%						
	17.6%						
Үнэ цэнийн тооцоолол							
Мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ	16%	(10,389.0)	(9,651.5)	(12,806.6)	(12,033.7)	(2,536.0)	13,495.4
	18%	(11,412.6)	(9,487.9)	(12,376.2)	(11,432.1)	(2,368.4)	12,389.8
	20%	(12,265.8)	(9,329.7)	(11,967.1)	(10,870.0)	(2,214.4)	11,391.2
Үлдэх өртөг	13.6%						240,412.8
	15.6%						209,659.3
	17.6%						185,881.4
Үлдэх өртгийн өнөөгийн үнэ цэнэ	16%	98,675.6					
	18%	77,664.4					
	20%	62,251.3					
Ордын үнэ цэнэ	16%	88,286.5	хэрэгжих магадлал 0.1	жигнэсэн дүн 8,828.7			
	18%	66,251.8	0.1	6,625.2			
	20%	49,985.5	0.6	39,988.4			
Ордын үнэ цэнэ			55,442.3				
Операторт ноогдох үнэ цэнийн бууралтын хувь	49%		26,087.0				
	Орд эзэмшигчид ноогдох үнэ цэнэ	51%		27,151.8			

"Багануур" ХК-ийн эзэмшиж буй гурван ширхэг ашиглалтын тусгай зөвшөөрлийн эзэмших эрхийн биет бус хөрөнгийн үнэлгээ 55,442.3 сая төгрөгөөр тооцоологдоо. Энэ нь уг ордыг ашиглах эрхийг олж авснаар ирээдүйд хөрөнгө оруулагчийн олж авах боломжит ашгийн дүн юм.



Лиценз эзэмшигч нь энэхүү үнэ цэнээр эзэмших эрхээ худалдах боломжгүй нь тодорхой. Иймд энэ дүнгийн тодорхой хувиар лицензийг худалдах боломжтой гэж үзсэн.

Лицензийг зарсан нөхцөлд үнэ цэнийн хэдэн хувийг хөрөнгө оруулагч, худалдан авагчид санал болгох боломжтойг тодорхойлохдоо нэмэлт хувьцаа гаргах ажлын хүрээнд компанийн өмчийн төр ба хувийн хэвшлийн өмчлөлийн харьцааг 51 ба 49 хувь байхаар төлөвлөж буйг үндэслэн ордын үнэлгээг тодорхойллоо.

Бидний хийсэн тооцоо судалгаагаар "Багануур" ХК-ийн гурван ширхэг ашиглалтын тусгай зөвшөөрлийн эзэмших эрхийг 27,151.8 сая төгрөг байхаар тодорхойллоо.

Энэхүү үнэлгээний дүн нь лицензийг зарж, худалдах бус зөвхөн "Багануур" ХК-ийн өртгийн хандлагаарх бизнесийн үнэ цэнийг тооцох тооцоонд ашиглагдана.





Цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулах арга

Компанийн ирээдүйн ашиг, орлогод суурилсан бизнесийн үнэлгээний арга нь бизнесийн боломжит ашигт үндэслэн бизнесийн үнэ цэнийг тооцдог нилээд бодитой арга юм. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагч нар нь тухайн байгууллага аль хир их хөрөнгөтэй вэ гэдгээс илүүтэйгээр тухайн бизнесээс ирээдүйд олж болох орлого, ашиг, өгөөжийг сонирхож байдаг. Ийм ч учраас энэ арга нь хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхолыг илүүтэй тусгасан ач холбогдол ихтэй арга юм.

Энэ аргын дагуу бид бизнесийн ирээдүйн ашиг, мөнгөн урсгалыг бизнесийн эрсдлийг тооцож үзсэн дискаунтын буюу хорогдуулгын хувиар хорогдуулан тооцож бизнесийн өнөөгийн үнэлгээ, үнэ цэнийг тодорхойлдог.

Бизнесийн үнэлгээ гаргахдаа дараах үе шаттайгаар тооцоо, судалгааг хийдэг. Үүнд :

1. Ирээдүйн мөнгөн урсгалыг урьдчилан таамаглах
2. Хорогдуулгын хувийг тооцох
3. Ирээдүйд бизнесийн үлдэх үнэ цэнийг тодорхойлох
4. Бизнесийн үнэ цэнийг тооцох

1. Ирээдүйн мөнгөн урсгалыг урьдчилан таамаглах

Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр батлагдсан дунд хугацааны бизнес төлөвлөгөө, төсөлд үндэслэн дараах төсөөллүүдийг хийсэн.

2016-2020 оны борлуулалтын төлөвлөгөө

Хэрэглэгчийн нэр	Хэм.нэгж	жил 1 Дес 2016	жил 2 Дес 2017	жил 3 Дес 2018	жил 4 Дес 2019	жил 5 Дес 2020
1 ДЦС IY	мян.тн	1,635.0	1,200.0	1,450.0	1,450.0	1,450.0
ДЦС IY баяжуулсан	мян.тн		500.0	500.0	500.0	500.0
2 ДЦС III	мян.тн	1,253.0	1,350.0	1,350.0	1,350.0	1,350.0
3 ДЦС II	мян.тн	229.0	250.0	250.0	250.0	250.0
5 Дарханы ДЦС	мян.тн	112.0	100.0	100.0	100.0	100.0
6 Эрдэнэтийн ДЦС	мян.тн	-	50.0	100.0	100.0	100.0
7 Багануур ДС	мян.тн	62.0	65.0	65.0	65.0	65.0
8 Амгалан ДС	мян.тн	100.0	150.0	250.0	250.0	250.0
10 Багануур Илч	мян.тн	100.0	100.0	100.0	100.0	100.0
11 УБТЗ ХНН	мян.тн	50.0	50.0	50.0	50.0	50.0
12 Шингэрүүлсэн түлш	мян.тн					1,000.0
13 Шингэрүүлсэн түлш	мян.тн					1,000.0
14 Бусад	мян.тн	209.0	250.0	250.0	250.0	250.0
15 ДЦС-5	мян.тн				540.0	540.0
16 Багануур Повөр	мян.тн			1,000.0	1,500.0	1,500.0
Багануур Повөр баяжуулсан	мян.тн			1,000.0	1,500.0	1,500.0
Нийт дүн	мян.тн	3,750.0	4,065.0	6,465.0	8,005.0	10,005.0





2016-2020 оны борлуулалтын орлогын төлөвлөгөө


	Үзүүлэлт	Хэм.нэгж	жил 1	жил 2	жил 3	жил 4	жил 5
			Дес 2016	Дес 2017	Дес 2018	Дес 2019	Дес 2020
Станцын үнэ							
1	Үнэ	төг	27,500.0	27,912.5	28,331.2	28,756.2	29,187.5
2	Стандарт илчлэг	ккал/кг	3,360.0	3,360.0	3,360.0	3,360.0	3,360.0
3	1ккал/Кг-ийн үнэлгээ	төг	8.18	8.31	8.43	8.56	8.69
Жижиглэнгийн үнэ							
1	Үнэ	төг	36,626.0	37,358.6	38,105.7	38,867.9	39,645.2
2	Стандарт илчлэг	ккал/кг	3,360.0	3,360.0	3,360.0	3,360.0	3,360.0
3	1ккал/Кг-ийн үнэлгээ	төг	10.90	11.12	11.34	11.57	11.80
Концессын үнэ							
1	Үнэ	төг	30,000.0	31,440.0	32,949.1	34,530.7	36,188.2
2	Стандарт илчлэг	ккал/кг	3,360.0	3,360.0	3,360.0	3,360.0	3,360.0
3	1ккал/Кг-ийн үнэлгээ	төг	8.93	9.36	9.81	10.28	10.77
1	ДЦС IV	сая.төг	46,085.1	50,606.2	58,626.2	59,506.7	60,400.3
2	ДЦС III	сая.төг	35,317.8	38,623.7	39,204.1	34,593.9	35,113.9
3	ДЦС II	сая.төг	6,397.5	7,090.0	6,248.9	6,343.8	6,440.1
5	Дарханы ДЦС	сая.төг	3,067.3	2,781.0	2,444.6	2,482.5	2,521.0
6	Эрдэнэтийн ДЦС	сая.төг	-	1,428.0	2,519.6	2,557.5	2,596.0
7	Багануур ДС	сая.төг	618.4	1,862.9	1,644.2	1,668.9	1,693.9
8	Амгалан ДС	сая.төг	823.7	4,299.0	6,323.9	6,418.8	6,515.1
10	Багануур Илч	сая.төг	3,662.6	3,735.9	3,810.6	3,886.8	3,964.5
11	УБТЗ ХНН	сая.төг	1,831.3	1,867.9	1,905.3	1,943.4	1,982.3
12	Шингэрүүлсэн түлш	сая.төг	-	-	-	-	39,645.2
13	Шингэрүүлсэн түлш	сая.төг	-	-	-	-	39,645.2
14	Бусад	сая.төг	7,654.8	9,339.6	9,526.4	9,717.0	9,911.3
15	ДЦС-5	сая.төг	-	-	-	19,146.0	17,447.9
16	Багануур Повер	сая.төг	-	-	66,867.9	103,481.0	106,788.3
	Нийт дүн	сая.төг	107,658.5	121,634.3	199,121.6	251,746.3	334,664.9
17	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	955.9	602.1	602.1	602.1	602.1
	Нийт орлого	сая.төг	108,614.4	122,236.4	199,723.8	252,348.4	335,267.1

Компанийн хүчин чадал ашиглалтын түвшинг харгалзан үзэж жил бүрийн борлуулалтын төлөвлөгөөг гаргасаны үндсэн дээр хэрэглэгч тус бүрээр нүүрсний борлуулалтын орлогыг тооцооллоо.

Мөнгөн урсгалын төсөөлөл

Компанийн ирээдүйн мөнгөн урсгалыг төсөөлөхдөө ирэх 5 жилийг хамруулж үзсэн. Энэ нь ҮОУС-ийн шаардлагатай нийцдэг. Мөн хөрөнгө оруулалт хийх, хүчин чадлаа нэмэгдүүлсэнээр ойрын таван жилд компанийн үйлдвэрлэлт, борлуулалт, хүчин чадал ашиглалт тогтворжино, илүү урт хугацаанд төсөөлөлт, төсөөллийг үндэслэлтэй хийхэд хүндрэлтэй гэсэх нөхцлүүдийг харгалзан үзэж ирээдүйн мөнгөн урсгалыг төсөөлсөн.





Компанийн 2016-2020 оны мөнгөн урсгалын төсөөллийг доорх хүснэгтэд харууллаа. он сар өдөр

Үзүүлэлт	хэм.нэгж	жил 1	жил 2	жил 3	жил 4	жил 5
		12/31/2016	12/31/2017	12/31/2018	12/31/2019	12/31/2020
Хөрс, хуулалт	мян.м3	20,315	17,926	21,826	26,777	31,479
Нүүрс гаргалт	мян.тн	3,750	4,233	7,094	8,879	10,879
Нүүрс борлуулалт	мян.тн	3,750	4,065	6,465	8,005	10,005
АШИГ, АЛДАГДАЛ						
Нийт орлого	сая.төг	108,614.4	122,236.4	199,723.8	252,348.4	336,267.1
Борлуулалтын зардал	сая.төг	(101,081.4)	(115,365.5)	(189,466.2)	(222,964.1)	(258,678.7)
Элэгдлийн зардлын өмнөх ашиг	сая.төг	7,533.1	6,871.0	10,257.6	29,384.3	76,588.4
Элэгдлийн зардал	сая.төг	(18,728.8)	(24,103.6)	(29,040.9)	(33,976.1)	(39,395.2)
Татварын өмнөх ашиг	сая.төг	(11,195.7)	(17,232.6)	(18,783.3)	(4,591.8)	37,193.2
Хуримтлагдсан алдагдал	сая.төг	0.0	(11,195.7)	(28,428.3)	(47,211.6)	(51,803.4)
Татварын хувь	сая.төг	10%	10%	10%	10%	10%
Татвар	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	(8,848.3)
Татварын дараах ашиг	сая.төг	(11,195.7)	(17,232.6)	(18,783.3)	(4,591.8)	28,344.9
Ногдол ашиг			0.0	0.0	0.0	0.0
МӨНГӨН УРСГАЛ						
Элэгдлийн өмнөх ашиг	сая.төг	7,533.1	6,871.0	10,257.6	29,384.3	76,588.4
Татварын өглөг	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	(8,848.3)
Авлагаас	сая.төг	1,300.0	1,000.0	1,000.0	500.0	
Зээл	сая.төг	10,000.0	35,908.8	42,462.3	51,093.3	56,001.5
Хувьцаа	сая.төг	26,000.0				
Ногдол ашиг	сая.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгө оруулалтаар х/авалт	сая.төг	(47,175.5)	(35,908.8)	(42,462.3)	(51,093.3)	(56,001.5)
Зээлийн төлөлт /хуучин/	сая.төг	(15,833.0)	(11,673.9)	(5,126.0)	(2,535.4)	(2,535.4)
Зээлийн төлөлт /шинэ/	сая.төг	0.0	(5,928.8)	(13,508.8)	(23,241.5)	(34,719.0)
Бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр	сая.төг	(7,605.0)	(5,000.0)	(4,000.0)	(3,000.0)	(1,000.0)
Цэвэр мөнгөн урсгал	сая.төг	(25,780.4)	(14,731.7)	(11,377.2)	1,107.4	29,485.7
Хуримтлагдсан мөнгөн урсгал	сая.төг	(25,780.4)	(40,512.1)	(51,889.3)	(50,781.9)	(21,296.2)

2. Хорогдуулгын хувийг тооцох

Хорогдуулгын хувийг тооцохдоо өөрийн хөрөнгийн хувьд Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвар (CAPM)-ыг ашигласан. Нийт хорогдуулгын хувийг тооцохдоо капиталын жигнэгдсэн дундаж өртгийг тооцох аргыг ашиглалаа.

Капиталын жигнэгдсэн дундаж өртгийн арга- Энэхүү арга нь хөрөнгийн эх үүсвэр болох гадны болон өөрийн капиталын зардлын хувийг тэдгээрийн балансад эзлэх хувийн жингээр жигнэж хорогдуулгын хүүг тооцдог арга юм.

Өөрийн капиталын хувьд капиталын зардлыг тооцохдоо $R_o = R_f + b(R_m - R_f)$ томъёог ашигласан бол гадны капиталын хувьд $R_L = r(1-t)$ гэсэн томъёогоор капиталын хувийг тооцлоо. Харин компанийн нийт капиталын зардлын хувийг тооцохдоо жигнэгдсэн дундажийн $R = R_o * W_o + R_L * W_L$ гэсэн томъёогоор тооцоог хийлээ.





Жигнэгдсэн дундаж хүүг тооцохдоо эрсдлийн түвшинг харгалзан b-коэффициентийг эрсдэл бага (0,8), эрсдэл дунд зэрэг (1,0), эрсдэл ихтэй (1,2) гэж гурван хувилбараар тооцож үзлээ.

Үзүүлэлт	Эрсдэл		
	бага	дунд	их
Өөрийн хөрөнгө :			
Эрсдэлгүй хүүгийн хувь-Засгийн газрын бонд	R _f	14.00	14.00
Зах зээлийн дундаж хүү	R _m	13.30	13.30
b- бета коэффициент	b	0.80	1.00
Өөрийн капиталын зардлын хувь	R_o	13.44	13.30
Зээлийн хөрөнгө :			
Зээлийн хүү хувь	r	5.40	5.40
Татварын хувь	t	0.10	0.10
Гадны капиталын зардлын хувь	R_L	4.86	4.86
Өөрийн капитал/Нийт хөрөнгө	W _o	0.10	0.10
Өөрийн капитал/Нийт хөрөнгө	W _L	0.90	0.90
Жигнэгдсэн дундаж капитал өртөг	R	5.72	5.70
Макро эдийн засгийн эрсдэл		1.00	1.00
Улс төрийн эрсдэл		2.00	3.00
Хууль эрх зүйн орчны эрсдэл		1.00	1.00
Салбарын эрсдэл		1.00	2.00
Өрсөлдөгчийн эрсдэл		1.00	1.00
Байгаль орчны эрсдэл		1.00	1.00
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрсдэл		1.50	1.50
Үйл ажиллагаатай холбоотой эрсдэл		2.00	2.00
Нийт эрсдлийн нэмэгдэл		10.50	12.50
Нийт хорогдуулгын хувь		16.22	18.20
Үнэлгээнд ашигласан хорогдуулгын хувь		16.00	18.00

Жигнэсэн дундаж капиталын өртгөөр тооцоход хорогдуулгыг хүүний хувь бодит байдлаас бага гарч буй тул үнэлгээчдийн зүгээс үнэлгээнд нөлөөлж болох эрсдлүүдийг тооцож нэмсэн.

Эндээс бизнесийн үнэлгээний тооцоололд хорогдуулгын хувийг **16-20** хувь байхаар сонгон авлаа.

3. Бизнесийн үлдэх өртгийг тооцох

Бизнесийн үлдэгдэл өртгийг тодорхойлохдоо бизнесийн хэтийн төлөвийг тооцоолсон үеийг дуусах хүртэл бизнес нь орлогыг үргэлжлүүлэн авчирна гэсэн таамаглал дээр үндэслэдэг. Компанийн эзэмшигчид өөрчлөгдөхгүй гэсэн таамаглал дээр үндэслэн бизнесийн үлдэгдэл өртгийг Гордоны загварыг ашиглан тооцсон.

Компанийн 5 жилийн дараах бизнесийн үлдэгдэл өртгийг Гордоны загварын дагуу дараах томъёогоор тооцдог.

$$\text{Үлдэгдэл өртөг} = \frac{\text{Сүүлийн жилийн цэвэр мөнгөн гүйлгээ} \cdot (1+d)}{R-d}$$

R - Капиталчлах хувь (хорогдуулах хувь) d - урт хугацааны орлогын өсөлтийн хувь

Бидний хийж байгаа бизнесийн үнэлгээнд компани 2020 оноос үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажиллах учир дараа дараагийн жилүүдэд орлогын өсөлт хувийг 2.4 хувь байхаар тооцлоо.

4. Бизнесийн үнэ цэнийн тооцоолол

"Багануур" ХК-ийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, үнэлгээчний хийсэн төсөөлөл, таамаглалуудад үндэслэн ҮОУС болон Техникийн баримт бичиг "Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга"-д үндэслэн бизнесийн үнэ цэнийн тооцооллыг хийснийг доор харууллаа.





"Багануур" ХК-ийн 2015 оны 12 сарын 31-нээрх орлогын хандлагаарх бизнесийн үнэ цэнийн тооцоолол

Үзүүлэлт	хувь	Жил						
		12/30/2015	12/31/2016	12/31/2017	12/31/2018	12/31/2019	12/31/2020	1/1/2021
Үлдэх үнэ цэнэ								222,071.6
								193,594.8
								171,591.2
Капиталжуулах хувь	13.6%							
	15.6%							
	17.6%							
Үлдэх үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ		105,731.2						
		84,622.1						
		68,958.7						
Дискаунт хувь	16.0%		0.8621	0.7432	0.6407	0.5523	0.4761	
	18.0%		0.8475	0.7182	0.6086	0.5158	0.4371	
	20.0%		0.8333	0.6944	0.5787	0.4823	0.4019	
Таамаглаж буй хугацааны мөнгөн урсгалын ӨҮЦ		(25,811)	(22,224)	(10,948)	(7,289)	612	14,039	
		(25,893)	(21,848)	(10,580)	(6,925)	571	12,888	
		(25,914)	(21,484)	(10,230)	(6,584)	534	11,850	
Орлогын хандлагаарх бизнесийн үнэ цэнэ	16.0%	79,919.8						
	18.0%	58,729.3						
	20.0%	43,044.3						
Бизнесийн үнэ цэнэ		43,044.3						

Дүгнэлт

Бизнесийн прогнозыг үнэлж үзэхдээ эрсдлийн түвшинг харгалзан дискаунтын хувийг 16%, 18%, 20%-ийн түвшинээр үнэлж тус бүрд нь үнэлгээг гаргаж үзлээ. Бизнесийн төсөөлөл нь өөрдрөг байдлаар хийгдсэн, төлөвлөсөн хүчин чадалд хүрч ажиллахад олон хүчин зүйл, эрсдэл нөлөөлж байгааг харгалзан дискаунтын хувь 20% байхаар сонгон авлаа.

Бидний хийсэн ирээдүйн мөнгөн урсгалын төсөвт суурилсан тооцсон орлогын хандлагаарх бизнесийн үнэ цэнэ нь 2015 оны 12-р сарын 31-ны өдрөөр 43,044,300.0 мянган төгрөгөөр тодорхойллоо.

Зах зээлийн хандлагын аргаар тооцсон бизнесийн үнэлгээ


Зах зээлийн хандлага нь тухайн бизнесийг зах зээл дээр арилжигдсан ижил төстэй бизнес, бизнесийн хувь оролцоо, үнэт цаас болон ижил төстэй бизнесийн арилжаатай холбоотой ажил гүйлгээтэй харьцуулдаг. Зах зээлийн хандлагаар үнэлэх эхний алхам нь нээлттэй зах зээлд саяхан борлогдсон үнэлэгдэж буй бизнестэй адил болон ижил төстэй бизнесийн борлуулалтын үнийг авч үзэх явдал юм.

Хэрэв хэд хэдэн ажил гүйлгээ гарсан бол адил болон ижил төстэй бизнесийн борлуулалтын үнийн жагсаалт, саналыг авч үзэн эдгээр мэдээллийн харилцан холбоог тогтоон шинжилж үзсэн байх ёстой. Энд мөн өөр өөр хэлцэл эсвэл ажил гүйлгээний агуулгын болон үнэ цэнийн суурийн ялгаа, хийгдэж буй үнэлгээнд дэвшүүлэн авч хэрэглэсэн таамаглалуудын ялгааг гаргахын тулд тохируулга хийх шаардлагатай байж болно.

"Багануур" ХК-ийн бизнес үнэлгээг энэхүү хандлагаар хийхэд дараах хүндрэлүүд гарч байна. Үүнд:

1. Ижил төстэй бизнесийг зах зээл дээр худалдсан, худалдан авсан ажил гүйлгээ хийгдээгүй.
2. Жишиг компанитай холбоотой мэдээллийн олдоц муу, найдвартай бус байна.





Хэдий ийм ч "Зах зээлийн хандлага"-аар бизнесийн үнэ цэнийг дараах хувилбаруудаар тооцож тэндээсээ сонголт хийв.

Хувилбар 1. Хувьцааны үнэ ханш болон тоо хэмжээ

Хувилбар 2. Өрсөлдөгч буюу жишиг компанийн үржүүлэгчийг ашиглан тус тус тооцов.

Хувилбар 1. Хувьцааны үнэ ханш болон тоо хэмжээг ашиглан тооцоол:

Үнэлэгдэж буй компанийн хувьцааны арилжааны сүүлийн 6 сар¹ болон сүүлийн 52 долоо хоногийн² мэдээллийг ашиглан үнэлгээг хийлээ. Ингэхдээ:

1. Арилжаалагдсан хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн жинлэсэн дундаж ханш
2. Арилжаалагдсан хувьцааны сүүлийн 52 долоо хоногийн арифметик дундаж ханш
3. Арилжаалагдсан хувьцааны сүүлийн 6 сарын жинлэсэн дундаж ханш
4. Арилжаалагдсан хувьцааны сүүлийн 6 сарын жинлэсэн арифметик дундаж ханш
5. 2015 оны 12 сарын 31-ны буюу үнэлгээний өдрөөрх хувьцааны хаалтын ханш гэсэн 5 төрлийн ханшийн мэдээ болон гаргасан хувьцааны тоог ашиглан компанийн нээлттэй зах зээлийн үнэлгээг тооцож, сонголт хийлээ. /Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралт ...-аас харна уу./

Зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнийн тооцоолол/Хувилбар 1/

Үзүүлэлт	Хувьцааны ханш	Зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнэ
2015-12-31-ний өдрийн хаалтын ханш	2,470	51,806,669,000
Сүүлийн 6 сарын дундаж ханш, жинлэсэн	2,786	58,425,129,000
Сүүлийн 6 сарын дундаж ханш, арифметик	2,776	58,215,035,000
Сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, жинлэсэн	2,687	56,353,263,000
Сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханш, арифметик	2,643	55,441,509,000

Эх үүсвэр: МХБ-ийн арилжааны мэдээг энэхүү тооцоололд ашиглав.

Дээрх 5 үнэлгээнээс сүүлийн 6 сарын жинлэсэн дундаж ханшид үндэслэн тооцсон үнэлгээг сонгохыг бодитой гэж үзлээ. Ийнхүү хувилбар 1 буюу хувьцааны ханшийн мэдээг ашиглаж тооцсон зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнэ **58,425,129,0** мянган төгрөг буюу саячилбал: 58,425.0 сая /Тавин найман тэрбум дөрвөн зуун хорин таван сая төгрөг/ болохоор байна.

Хувилбар 2. Өрсөлдөгч буюу жишиг компанийн үржүүлэгчийг ашиглан тооцоол:

Өнөөдөр манай улсад нүүрсийг эрчим хүчний үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн хэлбэрээр ашигладаг. Улсын хэмжээний цахилгаан дулаан үйлдвэрлэлийн 90 гаруй хувийг зөвхөн нүүрс ашиглан үйлдвэрлэдэг. Өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 5 хувьцаат компани, хувийн өмчинд тулгуурласан 25 компани, аж ахуй нэгж, 30 гаруй нүүрсний орд газарт нүүрс олборлох тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. "Багануур", "Шивээ-Овоо" зэрэг төрийн өмч давамгайлсан хувьцаат компаниуд нь Монгол улсын нүүрсний хэрэгцээний 60 хувийг олборлож, төвийн эрчим хүчний системд харьяалагддаг дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангадаг, стратегийн ач холбогдолтой уурхайнууд юм.

Монголын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг компаниудын дотроос "Багануур" ХК-ийн өрсөлдөгч компаниар Шарын гол болон Шивээ-Овоо ХК-ийг сонгож авч харьцуулах боломжтой гэж

¹ Санхүүгийн салбарын хөрөнгийн өргөтгөл "Бизнес үнэлгээний үнэмлэхүйтэй холбоотойгүй" 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 224/240 тоот тушаалыг тогтвортой болгох тухай шийдвэр

² Бизнес үнэлгээний үнэмлэхүйтэй холбоотойгүй

0000207



бид үзсэн. Учир нь эдгээр компаниуд нь уул уурхайн салбар, түүн дотроо эрчим хүчний нүүрс олборлох, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн өмчит компаниуд тул үндсэн үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүнээ нийлүүлдэг зах зээл, ашиглаж буй техник, технологи, дэд бүтцийн хувьд зэрэгцүүлэх боломжтой гэж үзсэн.

"Багануур" ХК-ийг салбар дахь өрсөлдөгч компанитай харьцуулсан судалгаа


№	Харьцуулах үзүүлэлтүүд	Багануур	Өрсөлдөгч буюу жишиг компаниуд	
			Шарын гол	Шивээ-Овоо
А. Үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой харьцуулалт				
1	Үүсэн байгуулагдсан он	1978	1965	1990
2	Байршил	УБ хот, Багануур дүүрэг	Дархан-Уул аймаг, Шарын гол сум	Говьсүмбэр аймаг, Шивээ-Овоо сум
3	Нүүрс нийлүүлэх бүс	Төвийн	Төвийн	Төвийн
4	УБ-аас орших зай/км-ээр/	120	240	265
5	Компанийн өмчлөлийн хэлбэр	Төрийн өмч давамгайлсан	100% хувийн өмчийн	Төрийн өмч давамгайлсан
6	Үйл ажиллагааны чиглэл	Нүүрс олборлох, борлуулах	Нүүрс олборлох, борлуулах	Нүүрс олборлох, борлуулах
7	Уурхайн нөхцөл	Ил уурхай	Ил уурхай	Ил уурхай
8	Голлох харилцагчид	УБ: ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, Эрдэнэт, Дархан, Багануур-ын ДЦС-ууд	Эрдэнэт, Дарханы ДЦС-ууд	УБ: ДЦС-4
9	Нүүрсний ордын нийт нөөц, сая тн	798.3	374.0/146.0	600.0
10	Жилийн хүчин чадал, сая тн	4	0,9	2
Б. Бүтээгдэхүүнтэй холбоотой харьцуулалт				
1	Бүтээгдэхүүний нийлүүлдэг зах зээл	Дотоодын зах зээл	Дотоодын зах зээл	Дотоодын зах зээл
2	Нүүрсний зориулалт	Эрчим хүч	Эрчим хүч	Эрчим хүч
3	Нүүрсний марк	Б3	Б3	Б2
4	Нүүрсний илчлэг	3200-3600 ккал/кг	3600-4000 ккал/кг	3000-3100 ккал/кг
5	2015 онд олборлосон нүүрсний хэмжээ, мян.тн	3,731.2	749,7	1,737.0
6	2015 онд борлуулсан нүүрсний хэмжээ, мян.тн	3,747.0	707,3	1,819.0
В. Хувьцаатай холбоотой харьцуулалт				
1	МХБ-д бүртгүүлсэн огноо	2/16/1994	7/14/1994	2/13/1995
2	Хувьцааны төрөл	Энгийн	Энгийн	Энгийн
3	Нийт гаргасан хувьцааны тоо	20,974,360.0	10,231,389.0	13,419,101.0
4	Төрийн мэдэлд буй хувьцааны тоо	15,730,770.0	-	12,077,191.0
5	Төрийн өмчийн эзлэх хувь	75%	0%	90%
6	Хувьцаа арилжаалсан өдрийн тоо, 2015 онд	127	109	64
7	Хувьцаа арилжааны идэвхи, %-иар, 2015 онд	50	43	25

Үнэлэгдэж буй болон жишиж буй компанийн үржүүлэгчээр хэд хэдэн үзүүлэлтийг сонгож болох ч үнэлгээний зориулалт, бодит байдлыг илэрхийлэх чадвар, үнэлгээний суурь, төлөөлөх чадвар зэргийг харгалзан дараах 5 үзүүлэлтийг сонгон авч зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнийг хувилбар 2-оор тооцов.

Үүнд:

1. Үнэ цэнэ/Олборлож буй нүүрсний хэмжээ
2. Үнэ цэнэ/Борлуулж буй нүүрсний хэмжээ
3. Үнэ цэнэ/Борлуулалтын орлого
4. Үнэ цэнэ/Нийт хөрөнгө





Зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнийн тооцоолол/Хувилбар 2/


Үржүүлэгч	Зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнэ		
	Жишиг компанийн дундажаар тооцвол	Шарын гол ХК-ийг жишиг болговол	Шивээ-Овоо ХК-ийг жишиг болговол
Үнэ/Олборлосон нүүрсний харьцаагаар тооцвол	177,487,347.9	244,018,588.8	118,829,749.4
Үнэ/Борлуулсан нүүрсний харьцаагаар тооцвол	181,951,612.9	259,741,849.3	113,951,887.4
Үнэ/Борлуулалтын орлогын харьцаа	188,332,655.9	176,920,310.1	155,409,080.9
Үнэ/Нийт хөрөнгийн харьцаагаар тооцвол	90,189,024.6	94,481,579.4	80,789,257.8

Эдгээр үнэ цэнүүдээс үнэ ба борлуулалтын орлогын харьцааг ашиглаж тооцсон үнэ цэнийг сонгохыг үндэслэлтэй гэж үзлээ. Иймд 2-р хувилбараар тооцсон зах зээлийн жишиг үнийн хандлагаарх үнэ цэнийг 113,951,887,4 мянган төгрөг буюу саячилбал 113,952.0 (Нэг зуун арван гурван тэрбум, есөн зуун тавин хоёр) сая төгрөг болж байгааг тогтоов.

Дүгнэлт

Бидний хийсэн тооцоо, судалгаагаар үнэлгээний 1-р түвшний орц мэдээлэл буюу нээлттэй компанийн зах зээл дээрх арилжааны үнийн мэдлээлэлд суурилсан хувилбар буюу 1-р хувилбараар тооцоолсон зах зээлийн хандлагаарх бизнесийн үнэ цэнийг сонгохыг үндэслэлтэй гэж үзэв. Ингэснээр зах зээлийн хандлагаарх үнэ цэнийг 58,425,129 мянган төгрөг буюу саячилбал 58,425.1 (Тавин найман тэрбум дөрвөн зуун хорин таван) сая төгрөг болж байгааг тогтоов.





БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

"Багануур" ХК-ийн бизнесийн үнэлгээг дээрх 3 аргыг ашиглан холбогдох судалгаа, тооцооллыг хийж арга тус бүрээр гарсан үр дүнг толилуулж байна.

Компанийн бизнесийн үнэлгээний зорилго, зориулалтаас хамаарч үнэлгээний арга сонголт, үр дүн, давуу болон дутагдалтай талуудыг шинжилж үзээд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох аргаар хийсэн бизнесийн үнэлгээнд 45 хувийн ач холбогдол өглөө.

Өртгийн хандлагын аргаар үнэлгээг хийхдээ тухайн бизнесийн үйл ажиллагаа нь өөрчлөн зохион байгуулагдах, татан буугдахгүй цаашид үргэлжилэх учир цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээнд 15 хувийн ач холбогдол өглөө.

Зах зээлийн харьцуулалтын хандалгын аргаар хийсэн үнэлгээнд 40 хувийн ач холбогдол өгч нэгдсэн үнэлгээний дүнг тодорхойллоо.

/мянган төгрөгөөр/

	Үнэлгээний арга	2015.12.31	Ач холбогдлын хувь	Тооцсон дүн
1	Цэвэр хөрөнгийн арга	105,916,964.9	0.15	15,887,544.7
2	ЦМГ хорогдуулан тооцох арга	43,044,280.5	0.45	19,369,926.2
3	Арилжааны үнийн харьцуулалтын арга	58,425,129.0	0.40	23,370,051.6
	Бизнесийн үнэ цэнэ			58,627,522.6
4	Хувьцааны тоо			20,974,360
5	Нэгж хувьцааны үнэ цэнэ /төг/			2,795.20

Бидний хийсэн бизнесийн үнэлгээний ажил, тооцоо, судалгаа, шинжилгээний дүнд гарсан үр дүнг "Багануур" ХК-ийн 100 хувийн өмчийн бизнесийн өнөөгийн үнэ цэнийг ойролцоогоор **58,627,522.6 (Тавин найман тэрбум зургаан зуун хорин долоон сая таван зуун хорин хоёр мянга зургаа зуу)** мянган төгрөгөөр тогтоох нь зүйтэй гэж үзэж байна. Энэ үнэлгээ нь компанийн энгийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр нийтэд худалдах суурь үнийг тодорхойлоход зориулагдаж байгаа болно.

Бизнесийн үнэлгээ хийсэн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр "Багануур" ХК-ийн гүйлгээнд байгаа энгийн хувьцааны тоо 20,974,360 ширхэг бөгөөд нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг **2795.20 төгрөг** байхаар тооцож гаргалаа.



ДОЛОО. ХАРИУЦЛАГА ХЯЗГААРЛАХ НӨХЦЛҮҮД



Бид Үнэлгээний Олон Улсын Стандартын шаардлагыг хангах түвшинд үнэлгээний тайланг бэлтгэлээ. Энэхүү тайлангаар тус компанийн бизнес үнэлгээний талаарх "Үндэсний реалти" ХХК-ийн үнэлгээчдийн бизнесийн үнэлгээний ажлыг гүйцэтгэх явцдаа цуглуулж, шинжилж, тооцоолсон мэдээлэл, судалгааныхаа хураангуйг толилуулж байна.

Үнэлгээний тайлан нь тухайн компанийн нэгж энгийн хувьцааны үнэ цэнийн тухай үнэлгээчний мэргэжлийн санал, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

"Багануур" ХК нь хөрөнгийн зах зээл дээр нэмж хувьцаа гаргахаар төлөвлөж нэгж энгийн хувьцааны өмөөгийн үнэ цэнийг тогтоох зорилгоор энэхүү бизнесийн үнэлгээг хийлгэсэн тул энэхүү тайланг дээрх зорилгын дагуу ашиглахыг зөвлөж байна. Захиалагч болон зайлшгүй мэдэх үүрэгтэй этгээдээс бусад хүмүүст энэхүү бизнесийн үнэлгээний тайланг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр дэлгэх, ашиглуулахыг хориглоно.

Үнэлгээний санал, дүгнэлт нь энэхүү үнэлгээний тайланг бэлтгэсэн цаг үе хүртэлх хугацаанд бидэнд ирүүлсэн мэдээллийн бодит байдалд үндэслэсэн тул энэ өдрөөс хойш компанийн хөрөнгөд орох аливаа өөрчлөлтийг гүйцэтгэгч хариуцахгүй болно.

Захиалагчаас үнэлгээний тайланг ашиглан бусад хуулийн этгээдтэй хийсэн хэлцлээс захиалагч болон түүний түншид учирч болох аливаа хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй, олох ашгийг хуваалцахгүй болно.

Бидний ойлгож байгаагаар тайланд дурьдагдсан бүх мэдээллүүд үнэн зөв найдвартай эх сурвалжаас авч ашигласан хэдий ч мэдээлэл, бусдын хийсэн тооцоо зэргийн талаар баталгаа өгч чадахгүй юм.

Гүйцэтгэгчийн боловсруулсан файл, ажлын тайлан, баримт бичгүүд нь түүний өмч байх бөгөөд 5-аас доошгүй жил хадгална.

Үнэлгээчид нь гол төлөв санхүү эдийн засгийн мэргэжлийн хүмүүс байсныг хэлэх нь зүйтэй бөгөөд

тухайн үнэлгээ хийж буй бизнесийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх аюулгүй байдал, бохирдол, хор нөлөө зэрэг зүйлс нь Мэргэжлийн хяналтын байгууллагын шаардалагад нийцэж байгаа эсэхэд хариуцлага хүлээхгүй.

Тайланд дурьдсан үнэлгээ нь эдийн засгийн болон бусад нөхцөл байдалд үүсэн гарч болох урьдчилан мэдэх боломжгүй өөрчлөлтөөс шалтгаалан эцсийн дүнд материаллаг байдлаар нөлөөлж болно. Тийм учраас тайланд дурьдсан үнэлгээ нь бодит амьдрал дээр хэрэгжинэ гэсэн амлалт гаргаагүй болно.

Захиалагчийн бизнесийн нууц, өмчлөх эрх, материаллаг бааз, хүчин чадал зэрэг мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүргийг үнэлгээчид хүлээнэ.



НАЙМ. ҮНЭЛГЭЭЧДИЙН ГАРГАСАН БАТАЛГАА



1. "Багануур" ХК-ийн бизнесийн үнэлгээний ажлыг "Үндэсний Реалти" ХХК-ийн мэргэшсэн үнэлгээчид хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Р.Батжаргал. 2010 оны 280 тоот тушаалаар олгогдсон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн эрхийн №071200086 тоот гэрчилгээтэй. СЗХ-ны Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэний 2015 оны 15/04 тоот гэрчилгээтэй.

Б.Наранбаатар. Сангийн сайдын 2009 оны 248 тоот тушаалаар олгогдсон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн эрхийн №091100152 тоот гэрчилгээтэй. СЗХ-ны Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэний 2013 оны 13/16 тоот гэрчилгээтэй.

П.Баянсан. Сангийн сайдын 2010 оны 280 тоот тушаалаар олгогдсон хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн эрхийн №071200062 тоот гэрчилгээтэй. СЗХ-ны Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэний 2015 оны 15/05 тоот гэрчилгээтэй.

2. "Үндэсний Реалти" ХХК нь Сайнгийн сайдын олгосон Хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн №19 тоот тусгай зөвшөөрөлтэй бөгөөд гэрчилгээг үнэлгээний тайлангийн хавсралтад хавсаргав.

3. Үнэлгээний тайланд тусгагдсан судалгаа, тооцоо, шинжилгээ, дүгнэлтүүд нь үнэлгээчдийн үнэлгээний ажлыг гүйцэтгэх явцад олж авсан тоо, мэдээлэл, баримтуудыг боловсруулсны үндсэн дээр гаргасан хараат бус, мэргэжлийн санал, дүгнэлт юм.

4. Үнэлгээчид нь "Багануур" ХК-ийн хөрөнгө, капиталын байдалтай газар дээр нь үзэж танилцсан, компанийн өмч, хөрөнгийн өнөөгийн болон ирээдүйн байдалд хувийн сонирхолгүй болно.

5. Үнэлгээчид нь үнэлгээний ажлын хөлсийг бизнесийн үнэлгээний үнийн дүнгээс хамааралгүйгээр тогтоосон, бизнесийн үнэлгээний ажил нь гадны нөлөө, дарамт шахалтаас ангид хийгдсэн.

Бизнесийн үнэлгээний тайланг бэлтгэсэн :

Р.Батжаргал /Мэргэшсэн үнэлгээчин/
Б.Наранбаатар /Мэргэшсэн үнэлгээчин/
П.Баянсан /Мэргэшсэн үнэлгээчин/



БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН



Хөрөнгийн үнэлгээний "Үндэсний Реалти" ХХК


ЗӨВШӨӨРЧ ХҮЛЭЭН АВСАН

"Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирал



М.Отгонбаяр
2016 оны 04-р сарын 26-ний өдөр





Хавсралт 4. Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

САНГИЙН ЯАМ Салбарын газрын 2010 оны 10 дугаар сарын 3-д гарсан хувьцаа

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 071200066

Иргэний ургийн нэр: Монгол
 Иргэний овог нэр: Рэнгчи овогтой Батжаргал
 Иргэний үнэмлэхний дугаар: УБ9213097
 Иргэний бүртгэлийн дугаар: Ш/Ж31030874
 Үнэлгээний гэрчилгээний дугаар: _____
 Иргэний хаяг: 3Б Баянхат 5-р хороо 10-р хороотой 50-9 тоот
 Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2010/12/20-ны өдрийн 280 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дaхь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД  С.БАЯРЦОГТ
УЛААНБААТАР ХОТ

САНГИЙН ЯАМ Салбарын газрын 2010 оны 10 дугаар сарын 3-д гарсан хувьцаа

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 091100752

Иргэний ургийн нэр: Монгол
 Иргэний овог нэр: Батжаргал овогтой Улаанбаатар
 Иргэний үнэмлэхний дугаар: Ш/Ж 78120175
 Иргэний бүртгэлийн дугаар: _____
 Үнэлгээний гэрчилгээний дугаар: _____
 Иргэний хаяг: ХБ Чингэлтэй дүүрэг 5-р хороо 54-26 тоот
 Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2012/12/07-ны өдрийн 155 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дaхь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД  Ч УЛААН
УЛААНБААТАР ХОТ

0000216



САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 071200062

Монголийн эрдэмтэн эдийн засагчид Шинэий
Монголийн ордонд нэр Шүрэн-Очиловтосын Батбаяр
Монголын үндэслэлчдийн дэргэд 369127580
Монголийн бүртгэлийн дэргэд 0M77041514
Үндэслэлчдийн гэрчилгээний дүгнэлт
Монголийн ордонд 3А багцаарх 14-дүрээр их төлбөрүү 192-12 жилийн
Зөвшөөрөл олгосон шийдвэр, өлгөөр Сангийн сайдын 2010/12/24-ны өрнөгийн 280-төмөр тэмдэгт

Энэхүү зөвшөөрөл нь олгосон жөзөл сунгасан адрөөс хойш 3 жилийн дугаард өмнө талгад өрнө үйлчилнэ
Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дүрээр зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай
зөвшөөрлийг хуульд зааснаас бусад гэрчилгээнд зүйлсэд хураагдах, болгогдох, барьцаалах зэрэг зэрчилгээний үйл болно.

САНГИЙН САЙД

С.БАЯРСОНГОТ

УЛААНБААТАР ХОТ



ГЭРЧИЛГЭЭ

№. 15/04

Ренчин овогтой Багжаргал нь

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдэд зориулсан "Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт" сэдэвт 34 пайгийн сургалтад хамрагдаж төгссөн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

Сургалтад хамрагдахыг сэдвүүд:

- Санхүүгийн зах зээлийн зохицуулалт
- Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт
- Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт
- Бизнесийн үнэлгээний асуудлууд

СЭХХорооны ажлын албаны дарга,
Б.Багдариулт

ГҮЙЦЭГЛЭХ ЗАХИРАЛ
Ж.Усуглар
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Улаанбаатар хот
2015 оны 11 сарын 18 өдөр





GTS ADVOCATES
ATTORNEYS AT LAW

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Огноо: 2016.4.27 №: 01127

«Жи Ти Эс Адвокатс» ХХН
Монгол Улс, Улаанбаатар-14253
Сүхбаатар Дүүрэг 1-р хороо
Чингисийн өргөн чөлөө-15
Нью Сенчурн Плаза, 403 тоот
Утас: 1133 1020, 1133 2020
Факс: +976 7011 5060
И-мэйл: info@gtsadvocates.mn
Вэб хуудас: www.gtsadvocates.mn

Хэнд: Ти Ди Би Капитал ХХК
Хэнээс: Өмгөөллийн "Жи Ти эс Адвокатс" ХХН
Огноо: 2016 оны 4-р сарын 27-ны өдөр
Утга: Хуулийн дүгнэлт

Нэг. Оршил

Үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны бүртгэлийн журмын 4.2.2 болон 5.2.2 дахь хэсгүүдийг тус тус удирдлага болгон Багануур ХК-ийн талаарх энэхүү хуулийн дүгнэлтийг Хавсралт 1-т дурьдсан бичиг баримтанд тулгуурлан гаргаж байна.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Хавсралт 1-т тодорхойлж дурьдсан Хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлантай хамтатган, Хавсралт 2-т заасан тайлбар, мэдэгдлийг удирдлага болгон уншина уу.

Хоёр. Хуулийн дүгнэлт

1. Хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байдал

Багануур ХК нь Монгол Улсын хуулийн дагуу нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид албан ёсоор бүртгэгдсэн байна.

2. Хувьцаа эзэмшлийн байдал

Багануур ХК нь нийт 20,974,360 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 100 төгрөг. Тус компанийн нийт хувьцааны 75 хувийг Эрдэнэс МГЛ ХХК-иар дамжуулан төр, 25 хувийг Хууль зүйн дүн шинжилгээний тайлангийн Хавсралт 7-д заасан этгээдүүд эзэмшиж байна. Үүнээс 4,416,668 ширхэг буюу 21 хувийн хувьцаа бусдад барьцаалагдсан, 517 ширхэг буюу 0.003 хувийн хувьцаа шүүх, цагдаагийн байгууллагын байгууллагын шийдвэрээр тус тус тусгаарлагдсан байна.


3. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан хууль, тогтоомжийн хүрээнд зохих шаардлага хангасан эсэх

Хууль зүйн дүн шинжилгээний тайлангийн 5.1.37, 5.1.40, 5.1.52-д дурьдсанаас бусад тохиолдолд Багануур ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон Хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангийн Хавсралт 8-д тодорхойлсон эрх бүхий албан тушаалтан нь Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст тавьсан шаардлагыг хангаж байна.

1

0000218





4. Дүрэм, журмууд хууль тогтоомжинд нийцэж буй тухай

Хууль зүйн дүн шинжилгээний тайлангийн 5.1.72, 5.1.74, 5.1.76, 5.1.78-д дурьдсанаас бусад тохиолдолд Багануур ХК-ийн засаглал, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрэм, журмууд нь Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекс, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шаардлагыг хангаж байна.

Багануур ХК нь ТУЗ-ийн ёс зүйн кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах бодлогоо боловсронгуй болгох шаардлагатай байна.

5. Гэрээ, контракт хуульд нийцэж байгаа эсэх

Багануур ХК-иас байгуулсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээ, хэлцлүүд нь хуулийн шаардлага хангаж байх бөгөөд сүүлийн 3 жилийн дотор Их хэмжээний болон Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

6. Тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдал

Багануур ХК-ийн эзэмшдэг Тусгай зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр бөгөөд аливаа этгээдийн барьцаанд тавигдаагүй. Хууль зүйн дүн шинжилгээний тайлангийн 5.2.60-д дурьдсанаас бусад тохиолдолд Багануур ХК нь Ашигт малтмалын болон байгаль орчны хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн зөрчил гаргаагүй байна. Багануур ХК нь Усны тухай хуульд заасныг үндэслэн холбогдох этгээдтэй ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглах зөвшөөрөл авах шаардлагатай.

7. Эд хөрөнгө, үнэт цаасны өмчлөх эрхийн байдал

Хууль зүйн дүн шинжилгээний тайлангийн 5.5.7, 5.2.21-5.2.29-д дурьдсанаас бусад тохиолдолд Багануур ХК-ийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй үнэт цаас, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийн талаар аливаа гуравдагч этгээдийн эрх, маргаан байхгүй байна.

8. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх¹

8.1 Компанийн тухай хуулийн 60.3 дугаар зүйлд "... хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш **40-өөс доошгүй хоногийн дараа** хуралдуулна" гэж заажээ. Гэтэл Багануур ХК нь нэмэлт хувьцаа гаргах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гаргасан 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа тус хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 27 тоот тогтоол батлагдсанаас хойшхи 38 дах өдөр хуралдуулсан байна. Тайлбарыг Хавсралт 2-ын 7 дах хэсгээс үзнэ үү.

8.2 Багануур ХК нь компанийн зарласан хувьцаанаас 9,870,287 ширхэг энгийн хувьцаа нэмж гаргах шийдвэрээ 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 03 тоот хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор баталсан байна.

Багануур ХК-ийн Дүрмийн 7.1.1 дүгээр заалтад компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцлөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэйг заасан байдаг. Компанийн тухай хуулийн 38.3 дах хэсэгт зааснаар "**Хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцааг худалдан авах тухай саналаа хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 30 өдрийн дотор ирүүлнэ**" гэжээ.

¹ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6-р сарын 10-ны өдрийн хуралдааны 02 тоот тэмдэглэлийн 2.1 дэх хэсгийг үндэслэн нэмж оруулсан болно.



0000219

Handwritten mark

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУУЛЬ

Гэвч Багануур ХК нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн компаниас нэмж гаргаж байгаа 9,870,287 ширхэг энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоол болон ТУЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 23 тоот тогтоолоороо буюу 5 сарын дараа баталгаажуулсан байна.

№ 02

Багануур ХК-ийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр нь дээр дурдсанаас бусад асуудлаар холбогдох хууль, журам (Үнэт цаасны бүртгэлийн журам, Хувьцаат компанийн хурлын зар хүргэх журам гэх мэт)-д нийцсэн байх бөгөөд энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцэж байна.

9. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн, зөв байдал

Хавсралт 1-т тодорхойлсон Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээллүүд нь үнэн зөв бөгөөд аливаа худал, ташаа, үнэнийг гуйвуулсан зүйл агуулаагүй байна.


Хүндэтгэсэн,



0000720



Хавсралт 1. Хуулийн дүгнэлт гаргахад ашигласан хууль, тогтоомж, бичиг баримт болон нэр томъёоны жагсаалт




- “Ашигт малтмалын тухай хууль”** гэж УИХ-аас 2006 оны 7-р сарын 8-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийг,
- “Гүйцэтгэх удирдлага”** Компанийн тухай хуулийн 83.1 дэх хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхээр ТУЗ-өөс 2012 оны 11-р сарын 1-ний өдөр томилогдсон Мөрдорж овогтой Отгонбаярыг,
- “Дүрэм”** Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 11-р сарын 5-ны өдрийн ээлжит хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан дүрмийг,
- “Их хэмжээний хэлцэл”** гэж Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан хэлцлийг,
- “Компанийн тухай хууль”** гэж УИХ-аас 2011 оны 10-р сарын 6-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Компанийн тухай Монгол Улсын хуулийг,
- “Компанийн засаглалын кодекс”** гэж Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 5-р сарын 7-ны өдрийн 162 тоот тогтоолоор баталсан Монголын компанийн засаглалын кодексийг,
- “ТУЗ”** гэж Компанийн тухай хуулийн 76.1 дүгээр хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхээр Багануур ХК-ийн хувьцаа эзэмшигчдээс тухай бүр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийг,
- “Үнэт цаасны тухай хууль”** гэж УИХ-аас 2013 оны 5-р сарын 24-ний өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийг,
- “Үнэт цаасны бүртгэлийн журам”** гэж Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11-р сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмыг,
- “Үнэт цаасны танилцуулга”** гэж андеррайтер болох Ти Ди Би Капитал ХХК болон Багануур ХК-иас Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу бэлтгэн боловсруулсан үнэт цаасны танилцуулгыг,
- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”** гэж УИХ-аас 2008 оны 5-р сарын 22-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Монгол Улсын хуулийг,
- “Хөдөлмөрийн тухай хууль”** гэж УИХ-аас 1999 оны 5-р сарын 14-ны өдөр баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуулийг,



0000221

**“Хувьцаат компанийн хурлын зар
хүргэх журам”**



гэж Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 2-р дугаар сарын 15-ны өдрийн 34 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг (<http://www.frc.mn/djza/id/3512>);

“Хууль зүйн дүн шинжилгээний тайлан”

гэж тус Жи Ти эс Адвокатс ХХН-өөс Багануур ХК-ийн үйл ажиллагаанд 2016 оны 2-р сарын 26-ны өдрөөс 4-р сарын 27-ны өдрийн хооронд хийсэн хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг,

“Сонирхлын зөрчилтэй хэлцэл”

гэж Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан хэлцлийг


тус тус ойлгоно.



0000222

03

Хавсралт 2. Тайлбар, мэдэгдэл





1. Энэхүү хуулийн дүгнэлтийг гагцхүү уг дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжинд үндэслэн Багануур ХК-иас бидэнд дэлгэсэн баримт бичиг, мэдээллийн хүрээнд гаргасан болно. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагуудаас тодорхойлолт, лавлагаа авсан болно.
2. Хуулийн дүгнэлтийг хууль, тогтоомжинд тавигдсан шаардлагыг Багануур ХК хэрхэн мөрдөж, биелүүлж ажиллаж байгаа талаар харьцуулалт, шалгалт хийх замаар боловсруулсан болно. Түүнээс бус аливаа үйл явдлыг тайлбарлах зорилго агуулахгүй болно.
3. Хөндлөнгийн хуульчийн хувьд мэдэх боломжгүй, Багануур ХК, түүний охин компаниудаас дэлгээгүй орхисон аливаа чухал мэдээлэл байвал тийнхүү олж мэдээгүйгээс үүдэн бид аливаа хариуцлага хүлээхгүй.
4. Бид Багануур ХК-ийн байранд очиж бичиг баримттай танилцаж, зарим албан тушаалтнуудтай биечлэн уулзсан боловч тус компанийн шийдвэр гаргах түвшний бүх хүмүүс, тэр дундаа ТУЗ-ийн гишүүдтэй биечлэн уулзаагүй болно.
5. ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх мэдээллийг Цагдаагийн Ерөнхий Газраас бидэнд гаргаж өгөөгүй тул тэдгээр нь Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст тавьсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг бид гагцхүү тэдний өөрсдийн бичгээр гаргаж өгсөн баталгаа, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн бүртгэлийн нотолгоог үндэслэн баталгаажуулсан болно.
6. Компанийн зүгээс сонирхлын зөрчилтэй этгээдийн жагсаалтыг бидэнд бүрэн гаргаж өгөөгүй боловч Компанийн сүүлийн 3 жилд Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй гэдгийг тус компанийн гүйцэтгэх захирал М.Отгонбаяр 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 01/434 тоот албан бичгээр баталгаажуулан бидэнд мэдэгдсэн болно.
7. Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл нь "Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах" асуудлыг ерөнхийлөн, өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд хамааруулан зохицуулсан байх бөгөөд 60.3 дах хэсэгт хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах хугацааг тийнхүү хуралдуулах шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа байхаар тогтоосноос үзвэл хуулийн энэ шаардлага нь хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд хоёуланд нь хамаарахаар байна. Гэтэл Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйл нь "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал"-ын асуудлыг тусгайлан зохицуулсан байх бөгөөд хуулийн 61.9 дэх хэсэгт "...хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна" гэж заажээ. Гэвч Компанийн тухай хуулийн дээрх 2 заалтыг хэрхэн ойлгож, хэрэглэх талаар албан ёсны хуулийн тайлбар байхгүй байна. Иймд энэхүү хуулийн дүгнэлтийн 8.1 дэх хэсэгт дурьдсан процесс нь Компанийн тухай хуулийн 60.3 дах хэсгийг зөрчсөн эсэх талаар эцэслэн дүгнэх боломжгүй байна.
8. Багануур ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 27 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарласан. Тогтоолын 3 дахь хэсэгт Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөр, Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрөөр байхаар тогтоосон нь "Хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх журам"-ын 2.5 дах хэсгийг зөрчсөн буюу бүртгэлийн өдрийг нийтэд мэдээлснээс хойш 8 дахь хоног дээр тогтоосон боловч компани хурлын мэдэгдлийг 2015 оны 10 дугаар сарын 5-нд нийтэд мэдээлжээ. Энэ талаар үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн ТУ136-13 тоот "Тайлбар хүргүүлэх тухай" албан бичгийн хавсралтаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолд техник алдаа гарсан буюу зар хүргэх өдрийг тогтоолд алдаж бичсэн бөгөөд хурлын зар хүрсэн өдөр нь журамд нийцэж байгаа тул тогтоолд засвар оруулан Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн байна. Ийнхүү хэлбэржүүлсэн

6

0000223



тогтоол дээр журам зөрчсөнийг залруулсан байх бөгөөд хурал зохион байгуулах бодит процесс ажиллагааг журмын дагуу явуулсан гэж үзэж байна.



9. Хавсралт 1-т тодорхойлсон Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан нийгэм, эдийн засаг, татвар, санхүү, улс төрийн болон төрийн байгууллагын бодлого шийдвэртэй хэсгийг хуульч хүмүүс хянаж, шалгаж, нягталж, үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй тул гагцхүү Багануур ХК түүний охин компаниудын хууль зүйн ач холбогдол бүхий мэдээллүүдийн үнэн зөвийг бид хуулийн дүгнэлтээр баталгаажуулсан болно.
10. Багануур ХК, түүний охин компаниудаас бидэнд хуулбар хэлбэрээр гаргаж өгсөн аливаа бичиг баримт нь эх баримттайгаа таарсан, зохих ёсоор үйлдэгдэж гарын үсэг зурагдсан гэж бид найдсан болно.
11. Хууль зүйн дүн шинжилгээний тайланд ашигласан баримт, мэдээлэл, лавлагаа, тодорхойлолт нь хүчин төгөлдөр бөгөөд энэ Хуулийн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар тэдгээрт аливаа өөрчлөлт ороогүй гэж бид тооцон гагцхүү тэдгээр мэдээлэл, бичиг баримтанд үндэслэн хуулийн дүгнэлтийг гаргав.



7
0000222



03

Хавсралт 3. Хуулийн дүгнэлтэд дурдагдсан хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангийн холбогдох заалтууд



ТУЗ-ийн үйл ажиллагаа

5.1.37. Компанийн тухай хуулийн 77.1, 77.3 дугаар хэсгүүдэд ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно гэж заасан. Компанийн тухай хуулийн 77.5 дугаар хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно" гэж заасан байх тул эдгээр гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр жинхлэн томилох шаардлагатай.

5.1.40. Компанийн тухай хуулийн 75.8 дугаар хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна" гэсэн шаардлага заасан байдаг. Бид ТУЗ-ийн нийт 11 гишүүн, нарийн бичгийн даргад СЗХ-ны Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс олгосон компанийн засаглалын сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээний хуулбарыг хүлээн авч танилцсан. ТУЗ-ийн гишүүд болох Г.Ёндонгомбо, Л.Оюунчимэг нарын гэрчилгээг бидэнд ирүүлээгүй болно.

5.1.52. Компанийн гүйцэтгэх захирал ТУЗ-ийн 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 12 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот тогтоол, ТУЗ-өөс Компанийн үйл ажиллагааг үнэлсэн тогтоол, Компанийн Жилийн ажлын үр дүнгээр шагнал олгох журмыг тус тус үндэслэн 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Б/55 тоот тогтоолоор ТУЗ-ийн нийт 11 гишүүнд 5 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 3,905,208 төгрөгийн шагналыг олгохоор шийдвэрлэсэн байна.

Мөн 2015 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Б/110 тоот тушаалаар Компанийн ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн, Жилийн ажлын үр дүнгээр шагнал олгох журмыг үндэслэн нийт 17 гишүүн (чөлөөлөгдсөн болон шинээр томилогдсон гишүүдийг оролцуулаад)-д 1 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нийт 3,804,167 төгрөгийг олгохоор шийдвэрлэжээ. Ингэхдээ төрийн албан хаагчийнхаа хувьд төрийн төлөөллийг хэрэгжүүлж буй гишүүдэд урамшуулал олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.12 дугаар хэсэгтэй зөрчилдөж байх тул Компани цаашид энэ асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулах шаардлагатай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам

5.1.72. Компанийн засаглалын кодексийн 4.1.4 дүгээр заалтад компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг компани боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулан мөрдөх нь зүйтэй гэжээ. Компани ТУЗ-ийн 2012 оны 9 дүгээр сарын 9-ний 24 тоот тогтоолоор тус журмыг батлан мөрддөг ч энэ журмыг Компанийн засаглалын кодекс заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулаагүй байна. Уг журмын зарим зүйл, заалт нь Компанийн засаглалын кодекс, Компанийн тухай хуульд нийцэхгүй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагатай бөгөөд ингэхдээ **Хавсралт 11-д** дурдсан бидний санал, зөвлөмжийг журмын төсөлд тусгахыг зөвлөж байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

5.1.74. Компанийн тухай хуулийн 76.1 дүгээр хэсгийн 76.1.13 дугаар хэсэгт ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах эрхтэй талаар зааснаас гадна Компанийн засаглалын кодекс мөн энэ эрхийг баталгаажуулжээ. Компанийн ТУЗ-ийн 2012 оны 5 дугаар сарын 29-ний 12 тоот тогтоолоор Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлагдсан байх бөгөөд зарим зүйл, заалт нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн шаардлагыг хангахгүй байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Компанийн ТУЗ батлах шаардлагатай бөгөөд ингэхдээ **Хавсралт 11-д** дурдсан бидний санал, зөвлөмжийг журмын төсөлд тусгахыг зөвлөж байна.

8

0000225

Дотоод хяналтын журам



5.1.76. Компанийн Дотоод хяналтын журам болон түүнд өгсөн бидний санал, зөвлөмжийг Тайлангийн 5.1.64 дугаар хэсгээс харна уу.

Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах бодлого

5.1.78. Компанийн ТУЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор Компанийн "Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах бодлого"-ыг баталсан байна. Энэ журмыг батлах хууль зүйн үндэслэлийг Компанийн засаглалын кодексийн 5.8.1 дүгээр хэсэгт заасан байдаг. Тус журмын 4 дүгээр зүйл буюу "Компани дахь зөрчил" хэсгийг дахин боловсруулах шаардлагатай байна. Учир нь энэ хэсэгт "зөрчил" гэдэг нэр томъёог ашиглахдаа "сонирхлын зөрчил" гэж шууд нэрлэлгүй "зөрчил, маргаан" гэдэг утгаар хэрэглэсэн, мөн сонирхлын зөрчлийн асуудалтай хамааруулсан байх бөгөөд Компанид аливаа зөрчил маргаан үүсвэл ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бүртгэж, шийдвэрлэх эрх бүхий этгээдэд шилжүүлэхээр заасан байна. Энэ хэсгийг Компани дахь сонирхлын зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, түүнээс зайлсхийх харилцааг зохицуулах байдлаар тодруулж өөрчлөх нь зүйтэй.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр


5.2.60. Компани нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг жил бүр төлж байсан боловч бүрэн хэмжээгээр буюу ногдуулалт хийсэн хэмжээгээр бүрэн төлөөгүй байна. 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Компанийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн үлдэгдэл 1,048,225,690 төгрөг байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн үлдэгдлийн талаарх дэлгэрэнгүйг *Хавсралт 21*-ээс харна уу.

Хөрөнгө, санхүү, татвар

5.5.7. Компани нь бидэнд Монгол Улсын Хөгжлийн банк болон Компанийн хооронд байгуулсан 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 3-БН-ХО 2013-11 тоот зээлийн гэрээг ирүүлсэн бөгөөд 16,374,000,000 төгрөгийн дүнтэй энэхүү зээлийн барьцаанд доорх хүснэгтэд харуулсан 18 барилга байгууламжуудыг бусад хөдлөх хөрөнгүүдийн хамт барьцаалуулсан байна. Үүнд:

№	Хөрөнгийн нэр	Талбайн хэмжээ м2	Анхны өртөг /Төгрөг/	Зээлийн гэрээнд тохиролцсон үнэлгээ /Төгрөг/
1	Барилга /АБК/	4,481	2,767,186,800.00	1,644,041,500.00
2	"Уурхайчин" Спорт Цогцолборын барилга	1,368	1,229,330,113.00	1,132,729,300.00
3	Засварын байшин No 2	6,480	1,829,200,000.00	1,372,495,970.00
4	Үйлчилгээний автомашины заал, захиргаа	5,888	3,985,536,000.00	1,844,196,650.00
5	Төв агуулахын байр	2,880	1,553,112,000.00	929,975,770.00
6	Засварын байшин No 1	3,888	1,069,528,000.00	726,411,890.00
7	Бутлагчийн барилга / Тех No 1 /	112	413,958,000.00	185,831,233.80
8	Бутлагчийн барилга / Тех No 2 /	112	408,119,300.00	188,818,286.70
9	Бункерийн барилга No 1	72	211,222,400.00	92,701,951.32
10	Бункерийн барилга No 2	72	146,771,500.00	65,421,385.92
11	Компрессор станцын байшин	213	151,113,600.00	66,028,185.18
12	Хүчилтөрөгч станцын байшин	213	151,113,600.00	65,958,201.18
13	Бойлерын барилга / ЦХБ / Тех No 1	168	101,659,039.00	45,004,581.91
14	Бойлерын барилга / ЦХБ / Тех No 2	168	98,842,439.00	44,422,725.01

0000226



15	Хяналтын байр Тех No 1	288	68,669,700.00	30,137,975.12
16	Хяналтын байр Тех No 2	288	59,010,300.00	29,132,853.92
17	Зэвсгийн агуулах /19сая/	887	61,624,800.00	21,807,529.36
18	Лабораторийн байр	119	50,371,200.00	17,825,149.47
Зээлийн гэрээгээр тохиролцсон нийт үнэлгээ				8,502,941,139

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл, байгаль орчны асуудлууд
Маргаан

- 5.2.21. Компанийн 13631А тоот тусгай зөвшөөрөлтэй холбоотой буюу уг зөвшөөрлийн анх олгогдсон талбайгаас хасагдсан талбайтай холбоотой маргаан 2008 оноос хойш өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.
- 5.2.22. Анх 2007 оны 11 дүгээр сард Алтай Голд ХХК-д АМХЭГ-аас 12959А тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байна. Гэвч 2008 оны 4 дүгээр сард Алтай Голд ХХК-ийн 12959А тоот тусгай зөвшөөрлийг АМГТХЭГ-аас стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хязгаарын батлагдсан хүрээнд орсон гэсэн үндэслэлээр хүчингүй болгож Компанид шилжүүлсэн байна.
- 5.2.23. 2008 оны 6 дугаар сард Алтай Голд ХХК нь АМГТХЭГ-ын шийдвэрийг хүчингүй болгуулахаар Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд хандсан бөгөөд 2008 оны 9 сард шүүхээс АМГТХЭГ-ын шийдвэрийг хүчингүй болгож 12959А тусгай зөвшөөрлийг Алтай Голд ХХК-д буцаан олгожээ.
- 5.2.24. 2010 оны 9 дүгээр сард Алтай Голд ХХК нь 12959А тоот тусгай зөвшөөрлийг Алтайн Гянт ХХК-д шилжүүлсэн байна.
- 5.2.25. 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр анх Алтай Голд ХХК-д олгосон 12959А тусгай зөвшөөрлийг АМГ-аас хууль зөрчиж олгосон гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон.
- 5.2.26. 2012 оны 10 дугаар сард Компани нь АМГ-т Компанийн эзэмшлийн 13631А тусгай зөвшөөрлийн солбицлыг 2008 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар болгон өөрчлөх буюу нийт талбайн хэмжээг 3,325 га болгож нэмэгдүүлэх хүсэлт өгсөн боловч АМГ-аас сонгон шалгаруулалтын талбайд хамрагдсан тул буцаан олгох боломжгүй гэсэн хариу өгсөн байна.
- 5.2.27. Алтайн Гянт ХХК нь 2012 оны 11 дүгээр сараас 2015 оны 6 дугаар сарын хооронд 12959А тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон АМГ-ын шийдвэрийг хүчингүй болгуулахаар холбогдох шүүхэд удаа дараа нэхэмжлэл гаргаж байсан байна. Гэвч 2016 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг хангахгүйгээр шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийг үл зөвшөөрөн 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр Алтайн Гянт ХХК-иас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан байна.
- 5.2.28. 2016 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс гомдлыг хянаж үзээд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэгчийг хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн гэж үзэж, хэргийг хэрэгсэхгүй болгосоныг үндэслэлгүй бөгөөд хэрэгт авагдаагүй нотлох баримтанд үндэслэн шийдвэр гаргасан хэмээн дүгнэж анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.
- Анхан шатны шүүхийн хуралдаан 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр хуралдахаар товлогдсон байна.
- 5.2.29. Монгол Улсын ЗГ-ын 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 392 тоот тогтоолоор Багануур дүүргийн Нарийны талд орших Баруун хонхор L-49-1 нэртэй 1181,16 га талбайг нөөцөд авсан байна (Багануурын ордын маргаан бүхий талбай).

10
0000227



03



“БАГАНУУР” ХК-ИЙН НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТӨСЛИЙН АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

“Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь “Багануур” ХК-тай байгуулсан 12/02-419 тоот “Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ”, 16/11-62 тоот “Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт өөрчлөлт”-ийн дагуу нэмж хувьцаа гаргагч Компанийн нэмэлт хувьцаа гаргах үйл ажиллагаатай холбоотой дараах дүгнэлтийг хийж байна.

1. Компанийн товч танилцуулга

Багануурын нүүрсний уурхай нь 1977 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн №368 дугаар тогтоолоор 100 хувь төрийн өмчит хуулийн этгээд хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Монгол улсын Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн №63 тоот тогтоолоор Багануурын нүүрсний уурхайг хувьцаат компани болгон өөрчилж, нийт хувьцааны 25 хувийг нийтэд худалдаж, үлдсэн 75 хувийг төрийн өмчид үлдээн төрийн өмчийг төлөөлөх эрхийг Монгол улсын Засгийн газраас эрх олгосон байгууллагад олгохоор шийдвэрлэсэн. Тус тогтоолыг үндэслэн Монголын хөрөнгийн бирж нь 1994 оны 3 дугаар сарын 18-ны өдөр “Багануур” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,097,436,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 20,974,360 ширхэг хувьцааг анх бүртгэсэн бөгөөд үүнээс 75% буюу 15,730,770 ширхэг хувьцааг төрийн өмчид бүртгэжээ.

Төрийн өмчийн хорооны 2013 оны 9 дүгээр сарын 19 өдрийн 488 тогтоолын дагуу “Багануур” ХК-ийн төрийн өмчид бүртгэгдсэн 15,730,770 ширхэг хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэн бүртгэсэн. “Багануур” ХК-ийн хувьцаа нь Монголын Хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагддаг бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 4,776 хувьцаа эзэмшигчидтэй, компанийн 5 хувиас дээш хувьцааг эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигчтэй байна.

Танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Компани нь 2 охин, 1 хараат компанитай, ТУЗ-ийн 13 гишүүнтэй, Гүйцэтгэх удирдлагын баг нь 11 гишүүнтэй ба Компанийн 2015 онд баталсан орон тоогоор нийт 23 удирдах албан тушаалтан, 26 мэргэжилтэн, 75 инженер техникийн ажилтан, 44 ажилтан, 17 туслах ажилтан, 122 үйлчилгээний ажилтан, 812 мэргэжлийн ажилтаны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Компанийн төрийн эзэмшлийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК нь Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх, арилжааны зарчмаар ашгийн төлөө ажиллах нөхцлөөр хангах, компанийн үнэлгээг нь нэмэгдүүлэн зах зээлд өрсөлдөх чадвартай үндэсний компани болгохоор зорин ажиллаж буйг дурьдах нь зүйтэй.

Компани нь анх 1978 онд Төвийн эрчим хүчний системийн харьяа дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангах зорилгоор ажиллаж эхэлснээс хойш 38 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулан 2015 оны 2 дугаар сарын 9-нд 100.0 сая дахь тонн нүүрсээ олборлосон. Компанийн үйлдвэрлэлийн хүчин чадал нь 4.0 сая тонн бөгөөд дотоодын хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч жилд 3.6-3.8 сая тонн нүүрсийг олборлож, 16.0-18.0 сая шоо метр хөрс хуулж, авто тээвэртэй болон тээвэргүй хосолсон ашиглалтын системээр олборлолт явуулж байна.

0000222





Компани нь дотоодын нүүрсний хэрэгцээний 43 орчим хувийг дангаар хангадаг тэргүүлэх эрчим хүчний нүүрс олборлогчийн хувьд тасралтгүй өсөн нэмэгдэж буй нүүрсний хэрэглээг найдвартай, хангах үүрэг хүлээж байна.

2. Компанийн бизнесийн голлох хүчин зүйлс

Багануурын уурхай нь анх ЗХУ-ын ГИПРОШАХТ институтын боловсруулсан ТЭЗҮ-ийг мөрдлөг болгон ажиллаж байсан ба 1995 оноос техник технологийн шинэчлэл хийх, хөрс хуулалтын хоцрогдлыг арилгах, нүүрс олборлолтыг тогтворжуулах зорилгоор "Монгол нүүрс" төслийг хэрэгжүүлэн уурхайн өмнө тулгарч байсан зарим хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэсэн.

2014 онд Олом улсын хөгжлийн ассоциациас Монгол улсын Засгийн газарт үзүүлсэн зээлийн тусламжаар Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд Багануурын нүүрсний ордын нэмэлт хайгуул, нөөцийн тодотгол тооцооны ажлыг "Эрдгео" ХХК болон "Норвест" корпораци хийж гүйцэтгэн, орд газрын нөөцийг 290 сая тонноор нэмэгдүүлсэн ба нийт орд талбайн хэмжээнд тооцолсон нүүрсний нөөц 812 сая тонн болж ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.

Гэсэн хэдий ч Багануурын орд газрын 13631А тоот тусгай зөвшөөрөлтэй холбоотой буюу уг зөвшөөрлийн анх олгогдсон талбайгаас хасагдсан 1,181.16 га талбайг хамарсан талбайтай холбоотой маргаан 2008 оноос эхлэн үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийг хүртэл үргэлжилж байна. Тус маргаан нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаагаас ордын нөөцийн 53 гаруй хувь нь маргаантай талбайд хамаарагдаж байна.

Компани нь 2015 оноос эхлэн Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар уурхайн хаалт хүртэлх урт хугацааны ТЭЗҮ боловсруулж байгаа бөгөөд 2016 онд тус ТЭЗҮ-ийг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Улсын хэмжээнд нүүрсний эрэлтийн дийлэнхи хэсгийг эрчим хүчний нүүрс эзэлдэг бөгөөд эрчим хүчний нүүрсний уурхайнууд нь бүс, орон нутаг болон улсын хэмжээний дулаан, цахилгааны станцуудыг нүүрсээр хангадаг. Цаашид дулааны цахилгаан станцууд шинээр ашиглалтанд орох, хуучин дулааны цахилгаан станцуудад өргөтгөл хийгдэх, дотоодын эрчим хүчний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр Компанийн борлуулах нүүрсний нийлүүлэлт даган өсөх боломжтой.

Хэдийгээр улсын эрчим хүчний салбар тогтвортой ажиллаж, дотоодын нүүрсний уурхайнууд хэрэгцээт нүүрсийг цахилгаан станцуудад нийлүүлж буй ч нүүрсний борлуулалтын үнэ болон эрчим хүчний салбар төрийн хяналттай, зах зээлийн зарчмаар бүрэн ажиллахгүй байгаа нь Компанийн борлуулалтын орлогод байнга нөлөөлсөөр байна.

Компанийн хувьд түүхий эдийн нөөц болон дэд бүтэцтэй стратегийн ач холбогдол бүхий орд газар боловч тоног төхөөрөмжүүдийн насжилт өндөр, техникийн шинэчлэл тасралтгүй шаардагдах, нүүрсний уналаас хамаарсан уурхайн гүнзгийрэлт, уулын ажлын хоцрогдол, дотоод овоолгын гулсалтаас үүссэн хүндрэл ихтэй, гүний усны тэжээгдэл нэмэгдсэн зэрэг хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болох сөрөг хүчин зүйлүүд ажиглагдлаа. Харин техник технологийн шинэчлэлийг цаг тухайд нь хийх, ус шүүрүүлэх станцыг нүүлгэн шилжүүлэх, хөрс хуулалтын хоцрогдлыг багасгах, нүүрсний үнийг зах зээлийн зарчмаар тогтоох, нүүрсний чанарыг сайжруулан хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгосноор Компанийн борлуулалтын орлого нэмэгдэх, бизнесийн үнэ цэнэ өсөх, ашигтай ажиллах боломж бүрдэх юм.

Компани нь 1999 оноос Байгаль орчныг хамгаалах, ашиглалтын талбайг нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн анхдагч байгууллагын нэг бөгөөд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэн томоохон ажлуудыг дүүрэгтээ хийж гүйцэтгэсэн байна.

0000228



Компанийн бизнесийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар, шинжилгээ, эрсдэлийн хүчин зүйлүүдийг үнэт цаасны танилцуулгад Компаниас болон бусад эх сурвалжаас авсан мэдээллийн дагуу тусгасан болно.

3. Компанийн төсөлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ

Компани нь нэмэгдэж буй дотоодын эрчим хүчний нүүрсний хэрэгцээг тасралтгүй хангах, шинээр ашиглалтанд орох цахилгаан станцуудад нүүрс нийлүүлэх ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгцээтэй техникүүдийг худалдан авах, угсрах, туршилтын ажлыг хийн 2017 онд бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад 26.0 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

Нэмж хувьцаа гарган татан төвлөрүүлэх хөрөнгө оруулалтаар тус санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой бөгөөд Компани нь хөрөнгө оруулалтаар авах тоног төхөөрөмжийн сонголт, үнийн таамаглалыг компанийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж буй "Runge Pincock Minarco" судалгаанд үндэслэн тооцсон байна.

4. Компанийн нэмэлт хувьцааг зах зээлд байршуулах

Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 70 тоот тогтоол, Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 330 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Компанийн 2015 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 03, 05, 06 тоот тогтоолууд, 2016 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолуудын дагуу Компанийн шинээр нэмж гаргаж буй хувьцааг дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаална. 2016 оны 4 дүгээр сарын 11-ний бүртгэлийн өдрөөр компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг санал болгон арилжаалах ба тус эрхийг хэрэгжүүлсний дараа үлдэх хувьцааг олон нийтэд санал болгон арилжаална.

Андеррайтер нь нэмж гаргах үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгож, арилжаалагдаагүй үлдсэн хувьцааг Компанитай байгуулсан гэрээний дагуу худалдан авч болох бөгөөд худалдан авах үнэ нь хувьцааг нийтэд санал болгосон үнээс доошгүй байна.

5. Компанийн нэмэлт хувьцааны үнэ тогтоосон үндэслэл


Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйцэтгэж, үр дүнг "Хөрөнгийн үнэлгээний тайлан" болон "Бизнесийн үнэлгээний тайлан"-аар компанид хүргүүлсэн байна. Тайлангаар үнэт цаас гаргагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний үнэлгээний өдрөөрх бизнесийн үйл ажиллагааны үнэ цэнийг 58,627,522.6 мянган төгрөг буюу нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг 2795.20 төгрөг болохыг тодорхойлсон. Тус тайланд үндэслэн Компанийн ТУЗ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 29 тоот тогтоолоор Компанийн нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгох үнийг 2,650 төгрөгөөр тогтоосон байна.

6. Компанийн санхүүгийн тайлагнал

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Үндэсний аудитын газраас Компанийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр "Сүлд Аудит" ХХК-ийг томилон ажиллуулж, 2016 оны 1 дүгээр сарын 20-27, 2016 оны 3 дугаар сарын 3-17-ны өдрүүдэд аудитын ажлыг гүйцэтгэсэн байна. Үндэсний аудитын газрын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 3/620 тоот аудитын гэрчилгээгээр 50.5 тэрбум төгрөгийн хязгаарлалттай санал дүгнэлт гаргасан ба хөрөнгө оруулагчид компанид хүсэлт гарган тус тайлантай танилцах боломжтой байна. Харин Компанийн нэмэлт хувьцаа гаргах төслийн хөндлөнгийн аудитын байгууллага болох "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК нь Компанитай 2016 оны 2 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан гэрээгээр аудитын ажлыг 2016 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэсэн ба НББОУС, СТОУС-ын дагуу 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр



0000230



гаргасан дүгнэлтийг Компанийн тухай хууль, Аудитын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хүлээн авч баталгаажуулсан байна.

7. Дүгнэлт

Компани нь уурхайн хөрс, нүүрс тээвэрлэлтийн зардлыг багасгах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өрсөлдөх чадварыг сайжруулах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон 2014-2018 он хүртэлх Компанийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр болон Компанийн 2016-2025 оны санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дунд хугацааны хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Андеррайтер, зөвлөхийн дүгнэлтээр нэмэлт хувьцаа гаргагч Компани нь нэмэлт хувьцаа гарган шаардлагатай хөрөнгө оруулалтыг татан, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, ашигт ажиллагаагаа сайжруулан, компанийн засаглалыг улам бэхжүүлсэнээр улсынхаа эрчим хүчний нүүрсний хэрэгцээг тасралтгүй хангах үүргээ биелүүлж, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг хадгалж, үндэсний тэргүүлэгч компаниудын нэг болох боломжтой гэж дүгнэж байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

О.ОРХОН

КОРПОРАЦИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ


С.БАТЧИМЭГ


ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Т.ДАВААЖАВ



0009231





2008.12.06
Бүртгэсэн он сар өдөр

9010031046
Улсын гурвалжны дугаар

2008572
Төсвийн дугаар

Багаануур

Хувьцаат компани

/Хуулийн этгээдийн нэр хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тогтоол
/Имгэдэрийн нэр/

01
/дугаар/

1995.03.25
он сар өдөр

10.000
хэд

Нүүрс олборлох, борлуулах, боньдуулах
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

142000

Алтын зорсон ордын ашиглах

552000

Цайны газар

611000

Гадаад худалдаа

1000

Лугалх эрхлэх үйл ажиллагааны ашиг шим

Хугацаагүй
хугацаа

4


Хэргүүдийн тоо

2,091,456.0

Хувийн хөрөнгийн үйл ажиллагааны үндсэн баримт бичиг


Багаануур, 2-р хороо, Уурхайчин, Өөрийн байр - 00 улсас 1010121130, утас 2110121130, факс 012121130

Уулийн этгээдийн хэлбэр ба тэдний дотор




0000232






Харилцах банкны бүртгэл:



Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажиглан тэмдэг
Худалдаа хөгжлийн банк	Төгрөгийн	409031495	Х.Дуламжарал
Худалдаа хөгжлийн банк	Валютын	49903257	Х.Дуламжарал
Голомт тэв банк	Төгрөгийн	21040610	Х.Дуламжарал
Голомт тэв банк	Валютын	21250610	Х.Дуламжарал

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
1.	Төвөөр эрх зүйн төмөрлөгөөр хариуцаж	2007.05.03	
1.	Шинэчилсэн дүрмийг бүртгэв.	2012.06.15	Ш.Минжбат
2.	Мөрдөж овозтой Отголбаяр г захирал-р төмөрлөгөө бүртгэв.	2013.02.07	Ш.Минжбат
3.	Шинэчилсэн дүрмийг бүртгэв.	2014.05.19	Б.Шүрэнцэцэг
4.	Дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэв	2015.06.12	О.Шижиртуяа
	Дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэв	2015.12.02	О.Шижиртуяа



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.


0000233

2.3 Компанийн оршин байгаа хаяг:

а/ Аймаг, хот: Улаанбаатар хот

б/ Сум дүүрэг: Багануур дүүрэг

в/ Хороо: 3-р хороо, үйлдвэрийн хэсэг



Гурав. КОМПАНИЙН ТЭМДЭГ

3.1 Компани нь өөрийн барааны тэмдэг болон бэлгэдэл /эмблем/-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

3.2 Бэлгэдэл, барааны тэмдгийн загварыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

3.3 Тэмдгийг компанийн гүйцэтгэх удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээ хадгална.

Дөрөв. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

4.1 Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдсан, үүсгэн байгуулагчдын оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, бие даасан санхүүгийн тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

4.2 Компани нь байгаль орчинд ээлтэй сөрөг нөлөөгүй, тэргүүний дэвшилтэт техник, технологийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхолыг эрхэмлэсэн үр ашигтай бизнес эрхлэхийг үндсэн зорилго болгон дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна. Үүнд:

4.2.1 Нүүрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт

4.2.2 Гадаад дотоод худалдаа


4.2.3 Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа.

4.3 Компани нь хуулиар хориглоогүй бөгөөд орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

4.4 Компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

0000005





4.5 Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

4.6 Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагаа Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдана.

4.7 Компани нь үйл ажиллагаагаа нээлттэй ил тод явуулж ажиллагсад, хувьцаа эзэмшигчдийг компанийн үйл ажиллагааны мэдээллээр тогтмол хангана.

Тав. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

5.1 Компани нь энэхүү дүрмийн 4.2-т заасан үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн явуулна.

5.2 Монгол Улсын албан татварын тухай хуулиудын заалтыг баримтлан татвараа тодорхойлж цаг хугацаанд нь төлнө.

5.3 Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь эрх бүхий байгууллагад гаргаж өгнө.

5.4 Компани нь хувьцаа эзэмшигчдэд компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг танилцуулах үүрэгтэй.

5.5 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нийт ажилтнуудын өмнө хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.

5.6 Компани нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүрэгтэй.

5.7 Компани нь төр, хувийн хэвшлийн бусад аж ахуйн нэгж, дотоод, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллаж болно.

5.8 Компани нь үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эрхлэн явуулах ба техник, технологи, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээллийг хуулийн дагуу нууцлана.

5.9 Компанийн дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэх байгууллага бүртгэхээс татгалзсан тохиолдолд компани шүүхэд гомдол гаргах эрхтэй.

5.10 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

5.11 Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Зургаа. ХАРААТ БОЛОН ОХИН КОМПАНИ, САЛБАР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

0000236



6.1 Компани нь дангаараа болон бусад хуулийн этгээдтэй хамтран хараат болон охин компанийг байгуулан ажиллуулж болно. Хараат болон охин компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн үүрэг хүлээх хуулийн этгээд байна.

6.2 Хараат болон охин компанийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр байгуулах ба үйл ажиллагаа нь тухайн компанийн дүрмээр зохицуулагдана.

6.3 Компани нь үйл ажиллагаагаа өргөтгөх, хэрэглэгчдэд болон зах зээлдээ ойртох зорилгоор дотоодод болон гадаадад салбар, төлөөлөгчийн газрыг байгуулан ажиллаж болно.

6.4 Компани нь Улаанбаатар хотод төлөөлөгчийн газартай байна. Төлөөлөгчийн газар нь Төрийн болон бусад байгууллагуудтай харилцах, компанийн үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж, гүйцэтгэх удирдлагын баталсан журмыг баримтлан ажиллах бөгөөд хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

6.5 Төлөөлөгчийн газрын удирдлагыг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилох бөгөөд компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

Долоо. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

7.1 Хувьцаа эзэмшигч нь "Компанийн тухай" хуулийн 34, 35 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ:

7.1.1 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцлөөр тэргүүн ээлжинд худалдан авах;

7.1.2 Энгийн хувьцааг худалдах, худалдан авах опцион гаргах тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тухайн үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;

7.1.3 Компани нь ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн шийдвэрт заасан хугацаанд ногдол ашиг хуваарилах бөгөөд хугацаанд нь төлөөгүй тохиолдолд алдаг нэхэмжлэх;

7.1.4 Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, 53.2-г заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;

7.1.5 Хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдах үед Компанийн тухай хуулийн 65.6-д заасан баримт бичигтэй танилцах;

7.1.6 Компанийн энгийн хувьцааны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компани болон өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

0000237



7.1.7 Компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчийн шаардсанаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг танилцуулах, санхүүгийн ээлжит бус шалгалтыг хэдийд ч хийх;

7.1.8 Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар Компанийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасан үндэслэлээр холбогдох байгууллагад гомдол гаргах;

7.2 Хувьцаа эзэмшигч компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

7.3 Дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухай этгээд өөрийн эд хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

Найм. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

8.1 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө хувьцаанд хуваагдах бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,974,360 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх ба үүнээс 15,730,770 ширхэг нь төрийн өмч, 5,243,590 ширхэг нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцаа байна.

8.2 Компани нь энгийн болон давуу эрхийн хувьцаа нэмж гаргах, хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох, гаргасан хувьцааг бэлэн мөнгө болон биет хөрөнгөөр эргүүлэн авч болно.

8.3. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй.

8.4 Хуульд өөрөөр заагаагүй бол компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшлийн хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй.

8.5 Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хувьцаанаас бусад үнэт цаас гаргаж болно.

8.6 Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл хувьцаа нэмж гаргах замаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж болно.

8.7 Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

8.8 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.

8.9 Ногдол ашиг хуваарилах асуудлыг Компанийн тухай хуулийн 46,47 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Ес. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

0000233



9.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит, ээлжит бус байна.

9.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн / 4 / сарын дотор зарлан хуралдуулна.

9.3 Дүрэмд заасны дагуу болон шаардлагатай гэж үзвэл Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий этгээд зарлан хуралдуулж болно. Үүнд:

9.3.1 Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх /-ийн нийт гишүүний 50-иас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

9.3.2 ТУЗ-ийн хараат бус 2-оос доошгүй гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;

9.3.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;

9.3.4 Компанийн өр нь 2 жил дараалан өөрийн хөрөнгөнөөс илүү болж, хас. . утгатай гарсан;

9.3.5 ТУЗ шийдвэр гаргасан;

9.3.6 Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

9.4 Дараах асуудлыг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

9.4.1 Компанийн дүрэм болон дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;

9.4.2 Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон тусгаарлах хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

9.4.3 Компанийн хэлбэрийг өөрчлөх;

9.4.4 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

9.4.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;



9.4.6 Хувьцааг хуваах, нэгтгэх;

9.4.7 Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг батлах;

00000000



9.4.8 ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх, тэдний цалин, урамшууллын хэмжээг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;



9.4.9 Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг хууль тогтоомжид заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх;

9.4.10 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

9.4.11 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

9.4.12 Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

9.4.13 Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

9.4.14 Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

9.5 ТУЗ-ийн гишүүдийг Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгоно.

9.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

9.7 Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

9.8 Компанийн тухай хуульд зааснаар дийлэнх олонхоор, эсвэл кумулятив аргаар шийдэх асуудлаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9.9 Хурлын тооллогын комисс, санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох нөхцөл, эчнээ санал хураалт явуулах журам, хурлын тэмдэглэл хөтлөх зэрэг асуудлыг Компанийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Арав. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

10.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

10.2 ТУЗ нь 13 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. Компанийн ТУЗ-д төрийн төлөөллийг хэрэгжүүлэх гишүүдийг Толгой компанийн дүрэмд заасны дагуу нэр дэвшүүлнэ. Толгой компаниас томилсон болон бусад нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн кумулятив аргаар сонгоно. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох саналыг тус тусад нь

0000240



тоолно. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болно.

10.3 Төлөөлөн Удирдах Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.3.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох, энэхүү дүрмийн 1.3-д заасан зорилтын хүрээнд холбогдох асуудлаар шийдвэр гаргах;

10.3.2 Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах

10.3.3 Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

10.3.4 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

10.3.5 Компанийн зарласан хувьцааны тоо, хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;

10.3.6 Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

10.3.7 Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, түдгэлзүүлэх, чөлөөлөх;

10.3.8 Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах Хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;


10.3.9 Компанийн гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтаны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих

10.3.10 Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

10.3.11 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

10.3.12 Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

10.3.13 ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;



Handwritten signature in blue ink.

0030241

10.3.14 Компанийн шинээр худалдаж авах болон ашиглалтаас хасах, акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг толгой компанийн Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн он удирдамжийг үндэслэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх;

/Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хурлаар өөрчлөлт оруулсан/

10.3.15 Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

10.3.16 Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхолын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

10.3.17 Дотоод хяналтын алба байгуулан ажиллах журмыг батлах;

10.3.18 ТУЗ-ийн гишүүдийн ажил үүргийн хуваарь;

10.3.19 Компанийн худалдан авалтын төлөвлөгөөг баталж хяналт тавих;

10.3.20 Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх.

10.4 ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлнэ.

10.5 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

10.6 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

10.7 ТУЗ-өөс гаргасан тогтоол нь ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

10.8 ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.



10.9 ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.

10.10 ТУЗ-ийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

10.11 ТУЗ-ийн хуралд гишүүн бүр 1 саналын эрхтэй байна. ТУЗ-ийн хурлаас гарах шийдвэрийн талаар хуралд оролцсон гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

0030242





10.12 ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, ТУЗ-ийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

10.13 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна.

10.13.1 өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

10.13.2 өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;

10.13.3 төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

10.13.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй.

10.14 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй байна.

10.14.1 ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

10.14.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;


10.14.3 хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулах, тодруулга хийх;

10.14.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаа, санал боловсруулах;

10.14.5 Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих;

10.15 ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ. Аудитын хорооны хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ.

10.16 Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.



6600343

10.17 Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасны дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгана.

10.18 Цалин урамшууллын хороо нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6-д заасан чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна.

10.19 ТУЗ нь жилд нэгээс доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

10.20 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

Арван нэг. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

11.1 Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна.

11.2 Гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн дарга нэр дэвшүүлэх хороотой зөвшилцөн нэр дэвшүүлж, ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олонхи дэмжсэнээр 1 / нэг / жилийн хуацаагаар томилно.

11.3 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд ТУЗ-ийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

11.4 Гүйцэтгэх захирал нь хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

11.5 Гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

11.6 Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна.

11.6.1 Менежментийн ур чадвартай, 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх, удирдлагын зохих дадлага туршлагатай, дээд боловсролтой байх;

11.6.2 Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;


11.6.3 Ял шийтгэлгүй байх;

11.6.4 Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

0000244



11.7 Өдөр тутмын шуурхай үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.



11.8 Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд ТУЗ-ээс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

11.9 Гүйцэтгэх захирал дор дурьдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

11.9.1 ТУЗ-ийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх ба энэхүү тайланд тухайн хугацаанд хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхолын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх асуудлыг тусгасан байна.

11.9.2 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

11.9.3 Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн төсөв бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТУЗ-д танилцуулах

11.9.4 Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

11.9.5 Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

11.9.6 Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;


11.9.7 Гүйцэтгэх захирлын эрх үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

11.9.8 ТУЗ-өөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

11.9.9 Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

11.9.10 Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

11.9.11 Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах.



0000245

11.10 ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу гүйцэтгэх захирал зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг харицлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11.11 ТУЗ гүйцэтгэх захирал хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-г цуцлах шийдвэрийг хэдийд ч гаргаж болно.

Арван хоёр. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

12.1 Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирлууд, хэлтсийн дарга нар, ерөнхий ня-бо, охин компанийн захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргах, гэрээ хэлцэл байгуулахад оролцдог ажилтнуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

12.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхолын төлөө үнэнч шударгаар ажиллах ба компанийн ажил үүргийг гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авахыг хориглоно.

12.3 Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг Хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

12.4 Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

12.5 Үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулж, компанийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхолын зөрчил гаргахгүй ажиллана.

12.6 Шууд ба шууд бус байдлаар эсхүл гуравдагч талын нэрийн өмнөөс компанид нөлөөлж болох аливаа хэлцэл, материаллаг сонирхолтой асуудлын талаар ТУЗ-д мэдэгдэх


12.7 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орох бүрт 10 хоногийн дотор компанид мэдэгдэнэ.

12.8 Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84.4 дүгээр зүйлд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

12.9 Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь ТУЗ-ийн өмнө компанийн үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээнэ. Энэ дүрмийн 12.8-д заасныг зөрчин шийдвэр гаргасан албан тушаалтнууд хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.

0000246





12.10 Эрх бүхий албан тушаалтан нь ТУЗ-өөс зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхолын төлөө ашиглахгүй байх

12.11 Шийдвэр гаргахдаа сонирхолын зөрчлөөс зайлсхийж, сонирхолын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх

12.12 Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 12.10-т заасан үүргийг хүлээнэ.

12.13 Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгсөнөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ ногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

Арван гурав. ТОЛГОЙ КОМПАНИ БОЛОН КОМПАНИ ХООРОНДЫН ХАРИЛЦАА

13.1 Компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх олгосон этгээд болон Толгой компанийн гүйцэтгэх захирал хамтран хэрэгжүүлнэ.

13.2 Компанийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх журмыг Толгой компаниас батална. Толгой компани нь компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигчийн хувьд компанитай холбоотой гаргасан аливаа шийдвэрээ компанийн нийт энгийн хувьцааны нэг /1/-ээс дээш хувийг дангаараа эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.

13.3 Толгой компани нь компанитай Компанийн тухай хууль, толгой компанийн дүрмийн дагуу өөрийн төлөөллөөр дамжуулан харилцахаас гадна Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар, төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.

13.4 Толгой компани нь компанийн нэгдлийн хамаарал бүхий компаниудын нийтлэг эрх ашиг, үйл ажиллагаанд хамаарах асуудлыг зохицуулах үүднээс тэдгээрийн гүйцэтгэх удирдлагуудын хүрээнд зөвлөл ажиллуулна. Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг гүйцэтгэх удирдлагууд нь толгой компанийн төлөөлөн удирдах зөвлөлтэй хамтран батална.


13.5 Компани нь аливаа хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эрх бүхий байгууллага, Толгой компанийн шийдвэрийн дагуу эзэмшиж болно.

13.6 Компанийн нэгдлийн хоорондын харилцааг уялдуулах үүднээс компанид Толгой компани дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

13.6.1 Охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх болон толгой, охин, хараат компани хоорондын харилцааг зохицуулсан аливаа дүрэм журам, гэрээг батлах;

13.6.2 Компанийн хэвийн үйл ажиллагаа доголдож, санхүүгийн зохистой харьцаа, үзүүлэлт алдагдсан тохиолдолд аудитын дүгнэлтийг үндэслэн үйл

0000247



ажиллагааг тогтворжуулж, хүндрэлийг даван туулахад чиглэсэн тодорхой төлөвлөгөө төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

13.6.3 ТУЗ-ийн дүгнэлтийг үндэслэн компанийн шинээр худалдаж авах бөлөн акталж, данснаас хасах эд хөрөнгийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

13.6.4 ТУЗ-ийн дүгнэлтийг үндэслэн худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

/Энэхүү дүрмийн заалтыг 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрээр хассан./

13.6.3 Хувьцаа эзэмшигчийн эрхийг хувьцаа эзэмшигчийн хуралд хэрэгжүүлэх толгой компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох;

13.6.5 Шийдвэрлүүлэхээр ирүүлсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн талаарх охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэх;

13.6.6 Холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг гаргуулан авах, тайлан тэнцэлтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаар шалгуулах.

Арван дөрөв. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

14.1 Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

14.1.1 Өмчлөгчийн хяналт;

14.1.2 Дотоод хяналт;

14.1.3 Хөндлөнгийн аудит.

14.2 Өмчлөгчийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

14.3 Аудитын хороо 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг ТУЗ томилно.

14.4 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.

14.5 Компанийн аудитын хорооны ажиллах журам, компанийн Дотоод хяналтын журмыг ТУЗ батална.

14.6 Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна.

14.6.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;


14.6.2 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

14.6.3 Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

0800248



14.6.4 Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах;



14.6.5 Компанийн тухай хууль, дүрэм, хувьцаа эзэмшигчийн эрх зөрчигдсэн тухай хувьцаа эзэмшигчийн гомдлыг 14 хоногийн дотор хянан дүгнэлт гаргах, санал дүгнэлтээ ТУЗ-д оруулах;

14.6.6. Компанийн дүрэмд заасан болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

14.7 Аудитын хороо нь компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган, үйл ажиллагаагаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

14.8 Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

14.9 Дотоод хяналтын алба компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү, дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.

14.10 Дотоод хяналтын алба нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, ТУЗ-д танилцуулах үүрэгтэй бөгөөд улирал бүр компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.


14.11 Компанийн хөндлөнгийн аудитыг ТУЗ-өөс сонгосон мэргэшсэн аудитын байгууллагаар хийлгэнэ.

14.12 Хөндлөнгийн аудитын тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

Арван тав. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

15.1 Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87,88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

15.2 Сонирхолын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89,91,92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.



0000279

15.3 Компанийн тухай хуулийн 89.4-т заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотой заалтууд (нэг талаас) компани (нөгөө талаас) толгой компани эсхүл толгой компанийн харилцан холбоотой бусад компанитай хийсэн аливаа хэлцлийн хувьд хамаарахгүй.

15.4 Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 15.1, 15.2 –т заасан хэлцлийн талаархи мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Арван зургаа. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

16.1 Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

16.2 Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад танилцуулна.

Арван долоо. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

17.1 Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, дуусах хугацааг мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тогтооно.

17.2 Компани нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Аудитын тухай хууль” болон бусад хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайлан гаргаж татварын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн бирж болон хуулинд заасан бусад байгууллагуудад хугацаанд нь хүргүүлнэ.

17.3 Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

17.3.1 Санхүүгийн байдлын тайлан

17.3.2 Орлогын дэлгэрэнгүй тайлан

17.3.3 Мөнгөн гүйлгээний тайлан;

17.3.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан;

17.3.5 Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхолын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;

17.3.6 Нэмэлт тайлбар тодруулга;


17.3.7 Санхүүгийн тайлангийн тодруулга;

17.3.8 Бусад.

0000250



17.4 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.



17.5 Компани нь өөрийн хувьцаа эзэмшигч нарт компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлан, хувьцаа эзэмшигч нарын нэр, хувьцааны нэр төрөл, тоо, Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон мэдээллийг танилцуулна.

Арван найм. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

18.1 Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

18.1.1 Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ;

18.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг;

18.1.3 Компанийн салбар төлөөлөгчийн газрын болон охин компанийн дүрэм компанийн түүхэнд холбогдох баримт бичгүүд;

18.1.4 Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

18.1.5 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан гэрээ түүний биелэлттэй холбогдох баймт бичиг;

18.1.6 Аудитын байгууллагатай хийсэн гэрээ, дүгнэлт, холбогдох бусад баримтбичиг;

18.1.7 Санхүүгийн үйл ажиллагааны тайлан;

18.1.8 Хувьцаа болон үнэт цаас гаргах журам;

18.1.9 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг;

18.1.10 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

18.1.11 Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл /тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо, түүнд орсон өөрчлөлт/;



18.1.12 Бусад баримт бичгүүд.

18.2 Компани нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.



0000251

18.3 Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаагаар архивт хадгална.



18.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.

18.5 Компанийн талаархи мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

Арван ес. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

19.1 Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана. Компанийг татан буулгах үед хуульд заасан өр төлбөрийг нь барагдуулах, хувьцаа эзэмшигчдэд эд хөрөнгийг нь хуваарилах ба бусад асуудлыг шийдвэрлэнэ.

19.2 Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.


19.3 Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

Хорь. БУСАД ЗААЛТУУД

20.1 Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

20.2 Энэхүү дүрэм /нэмэлт өөрчлөлт оруулсан/ нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.

---oOo---



0000052





**"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Нэмэлт хувьцаа гаргах, дүрэмд
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дугаар заалт,
"Багануур" хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь заалтыг тус тус
үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн дүрмийн 8.1 дүгээр зүйлд "Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө хувьцаанд хуваагдах бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,974,360 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх ба үүнээс 15,730,770 ширхэг нь төрийн өмч, 5,243,590 ширхэг нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцаа байна" гэснийг "Компани нь нийт 30,844,647 ширхэг зарласан энгийн хувьцаатай байна. Компанийн гаргасан энгийн хувьцаа нь 20,974,360 ширхэг байх бөгөөд энгийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнэ 100 төгрөг байна. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ." гэж өөрчилсүгэй.

2. Зарласан хувьцаанаас 9,870,287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоон/ ширхэг хувьцааг Хөрөнгийн биржээр арилжаалсны дараа Компанийн дүрмийн 8.1 дүгээр зүйлд дараах өөрчлөлтийг оруулсугай.


2.1. Компани нь нийт 30,844,647 ширхэг энгийн хувьцаатай байна. Компанийн гаргасан энгийн хувьцаа нь 30,844,647 ширхэг байх бөгөөд энгийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнэ 100 төгрөг байна. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ." гэж өөрчилсүгэй.

3. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, мөрдөн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.АРИУНБОЛД



0000253



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах
эрхийг хувьцаа эзэмшигчдэд олгох тухай

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 62 дугаар зүйлийн 62.1.8, 62.1.15, “Багануур” ХК -ийн дүрмийн холбогдох заалтуудыг үндэслэн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААС ТОГТООХ НЬ:

Багануур ХК-иас нэмж гаргах 9 870 287 хувьцаанаас хувьцаа эзэмшигчдэд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ГАНБААТАР

0000254





**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Тэргүүн ээлжинд худалдан авах
хувьцааны үнийн тухай**

**Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 заалтыг үндэслэн ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААС ТОГТООХ НЬ:**


Тэргүүн ээлжинд худалдах энгийн хувьцааны нэрлэсэн үнийг нийтэд санал
болгож буй нэгжийн үнэтэй тэнцүү байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.АРИУНБОЛД

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.ГАНБААТАР

0000255





“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 18 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах
эрхийг хэрэгжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, 76.1.3 дахь заалт, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, 10.3.13 дахь заалт, 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн №01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолыг үндэслэн Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:


1. Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг нь хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн 9,870,287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг энгийн хувьцааг Компанийн ТУЗ-ийн тогтоох үнээр хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлсүгэй.
2. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журмыг энэ тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдах авах эрх хэрэгжүүлэх зарыг энэ тогтоолын Хавсралт № 2-оор баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх тухай хүсэлтийг энэ тогтоолын Хавсралт № 3-аар баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх тухай зар хүргэх, хүсэлтийг хүлээн авах арилжааг зохион байгуулах хуваарийг энэ тогтоолын Хавсралт № 4-өөр баталсугай.
7. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах тухай зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, тус журмаар тогтоосон хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг хүлээн авч, нэгдсэн бүртгэл гаргаж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, холбогдох ажилтнуудад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

Б.АРИУНБОЛД

0000256





“Багануур” ХК-наас нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 17 дугаар зүйлийн 17.2.7-д заасны дагуу “Багануур” ХК (цаашид “Компани” гэх)-ийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд санал болгох, санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх, тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан, худалдан авах санал ирүүлээгүй хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Хувьцааны үнэ, тоо ширхэг

2.1. Компани нь 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор нэмж гаргаж буй 9,870,287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг энгийн хувьцааг бүхэлд нь хувьцаа эзэмшигчдэд санал болгон тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлнэ.

2.2. Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.2-д заасны дагуу нэмж гаргаж буй хувьцааны зах зээлийн үнийг хараат бус хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтооно.

2.3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын дагуу тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд санал болгох хувьцааны үнэ болон тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтооно.

Гурав. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх

3.1. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигч буюу бүртгэлийн өдрөөрх энгийн хувьцаа эзэмшигч бүрт эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэгш олгоно.

3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд гаргаж буй хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа зэрэг мэдээллийг хүргэсэн байна.


3.3. Хувьцаа эзэмшигч нь тус журмын 3.2-г заагдсан мэдээлэл хүргэгдсэн даруйд хувьцаа худалдан авах саналаа тус журмын 1-р хавсралтаар баталсан хүсэлтийн дагуу бөглөн хувьцааны үнэ болон “ҮЦТТХТ” ХХК-ийн “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.6-д заасны дагуу үнийн дүнгийн 0.1 хувиар тооцсон шимтгэлийг төлсөн баримтын хамт хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 30 өдрийн дотор Компанид хүргүүлнэ.

3.4. Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ энэ журмын 3.1-т зааснаар бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлж болно.

3.5. Компани нь шаардлагатай тохиолдолд тус эрхийг хэрэгжүүлэх эсэх саналыг компанийн хувьцаа эзэмшигчдээс шаардах эрхтэй байна.

0000257





3.6. Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжинд худалдан авах эрх хэрэгжүүлэх журамтай холбоотой зөвлөгөө, зааварчилгааг Компаниас авах эрхтэй.

Дөрөв. Саналаа илэрхийлсэн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх

4.1. Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх бүхий хувьцаа эзэмшигч нь тус журмын 3.3-г заасан хугацаанд хувьцаа худалдан авах хүсэлт, хувьцааны үнэ болон шимтгэлийг төлсөн баримтаа Компанид ирүүлснээр тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх багалгаажина.

4.2. Компани нь тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг хүлээн авч, нэгдсэн бүртгэл гарган Андеррайтер, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч компанид хуваарьт хугацаанд хүргүүлнэ.

4.3. Компани нь Андеррайтер, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч компанийн тогтоосон өдөр тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг нэр заан эзэмшүүлэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр, компанийн нэр бүхий хувьцаа эзэмшигчдэд хувьцаа эзэмшүүлэхийг хүссэн албан тоотыг холбогдох баримтуудын “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон “Арилжааны төлбөр тооцоо” ХХК-д хүргүүлэн холбогдох гүйлгээг хийлгэнэ.


4.4. Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийн дагуу хувьцааны гүйлгээ хийх өдөр хувьцаа эзэмшигч нь Компанийн заасан дансанд хувьцааны үнэ болон холбогдох шимтгэлийг бүрэн байршуулаагүй нь хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болно.

Тав. Бусад

5.1. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх тухай мэдээлэл хүргүүлснээс хойш хувьцаа эзэмшигч нь тус журамд заасан хугацаанд худалдан авах саналаа ирүүлээгүй нөхцөлд тухайн хувьцаа эзэмшигчийг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

0000258





Багануур ХК-иас нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журмын хавсралт №1

Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах хүсэлт

Компанийн хүлээн авах хаяг:

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, “Багануур” ХК-ийн өөрийн байр,

2 давхар 201 тоот өрөө

Хэвлэл мэдээллийн ажилтан: С.Одончимэг

Утас: 99044373

Электрон шуудан: sanjaa_oogii@yahoo.com

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл


1	Хувьцаа эзэмшигчийн нэр	
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар Регистрийн дугаар	
3	Үнэт цаасны дансны дугаар/Префикс	
4	Төлбөр тооцооны дансны дугаар	Банкин дах компанийн үнэт цаасны төлбөр тооцооны данс №
5	Эзэмшиж буй хувьцааны тоо	
6	Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр худалдан авах хувьцааны хэмжээ	
7	Худалдан авах ширхэг	
8	Шимтгэл	
9	Нийт шилжүүлсэн үнэ	
10	Огноо	
11	Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг	
12	Холбоо барих утасны дугаар	

Захиалга хүлээн авсан мэргэжилтний тэмдэглэл

1	Захиалгад бүртгэх хувьцааны тоо	
2	Нэгж хувьцааны үнэ	
3	Хувьцааны үнийн дүн	
4	Холбогдох шимтгэл	
5	Нийт төлбөр тооцооны дүн	
6	Захиалга хүлээн авсан огноо	
7	Нэмэлт тэмдэглэл	
8	Захиалга хүлээн авсан мэргэжилтний гарын үсэг	

0000259





**Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах
эрх хэрэгжүүлэх тухай зар**

“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Багануур” ХК нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүү зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмын дагуу нийт 9,870,287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг хувьцаа нэмж гаргах гэж байна.

Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан 2016 оны 04 дугаар сарын 18-ний ТУЗ-ийн 24 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Багануур ХК-иас нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг үндэслэн Компанийн 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөр хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхтэй.

Иймд “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигч та бүхэн уг эрхээ хэрэгжүүлэх бол Компанид хандана уу.

- Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийн бүртгэлийн өдөр: 2016.04.11
- Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах хүсэлт хүлээн авах эцсийн өдөр: 2016.05.23

Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам болон бусад холбогдох мэдээллийг үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандаж эсвэл компанийн байранд ирж танилцана уу.

Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээсээ татгалзсан хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээ нь нэмэлт хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор нэмж гаргаж буй хувьцаатай хувь тэнцүүлэн багасахыг анхаарна уу.

“Багануур” ХК-аас хүсэлт хүлээн авах мэргэжилтний мэдээлэл:

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, “Багануур” ХК-ийн өөрийн байр,

2 давхар 201 тоот өрөө


Хэвлэл мэдээллийн ажилтан: С.Одончимэг

Утас: 99044373

Электрон шуудан: sanjaa_oogii@yahoo.com

0000260





ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2016 оны 24 тоот тогтоолын хавсралт №3

Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах хүсэлт

Компанийн хүлээн авах хаяг:

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, “Багануур” ХК-ийн өөрийн байр, 2 давхар 201 тоот өрөө
Хэвлэл мэдээллийн ажилтан: С.Одончимэг
Утас: 99044373
Электрон шуудан: sanjaa_oogii@yahoo.com

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

1	Хувьцаа эзэмшигчийн нэр	
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар Регистрийн дугаар	
3	Үнэт цаасны дансны дугаар/Префикс	
4	Төлбөр тооцооны дансны дугаар	Банкин дах компанийн үнэт цаасны төлбөр тооцооны данс №
5	Эзэмшиж буй хувьцааны тоо	
6	Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр худалдан авах хувьцааны хэмжээ	
7	Худалдан авах ширхэг	
8	Шимтгэл	
9	Нийт шилжүүлсэн үнэ	
10	Огноо	
11	Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг	
12	Холбоо барих утасны дугаар	

Захиалга хүлээн авсан мэргэжилтний тэмдэглэл

1	Захиалгад бүртгэх хувьцааны тоо	
2	Нэгж хувьцааны үнэ	
3	Хувьцааны үнийн дүн	
4	Холбогдох шимтгэл	
5	Нийт төлбөр тооцооны дүн	
6	Захиалга хүлээн авсан огноо	
7	Нэмэлт тэмдэглэл	
8	Захиалга хүлээн авсан мэргэжилтний гарын үсэг	

0000261





САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1 дэх хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 орны 5 дугаар сарын 18-ны 193 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн нэмж гаргах 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 9,870,287 /есөн сая найман зуун далан мянга хоёр зуун наян долоо/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэж, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 30,844,647 /гучин сая найман зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун дөчин долоо/ ширхэг болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, нэмж гаргах хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авахыг компанийн хувьцаа эзэмшигчдэд санал болгон уг эрхийг хэрэгжүүлэх ажлыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах, гүйцэтгэлийг Хороонд тайлагнах, олон нийтэд мэдээлэхийг “Ти Ди Би капитал ҮЦК” ХХК /О.Орхон/, “Багануур” ХК /М.Отгонбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

3. Нэмж гаргаж буй энгийн хувьцааг тэргүүн ээлжинд санал болгох, нийтэд санал болгох, арилжаалагдаагүй үлдсэн хувьцааг андеррайтерийн компанийн худалдан авах үнийг тус тус 2,650 /хоёр мянга зургаан зуун тавь/ төгрөгөөс доошгүй байхаар тогтоохыг зөвшөөрсүгэй.

4. Нэмж гаргаж буй хувьцааг худалдан авахыг нийтэд санал болгох ажиллагааны дүнд төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг 100 хувь төвлөрүүлж чадсан нөхцөлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

001208

5. “Багануур” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг холбогдох журмын дагуу зохион байгуулах, Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/-д үүрэг болгосугай.

6. Тус компанийн нэмж үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Багануур” ХК /М.Отгонбаяр/, “Ти Ди Би капитал” ХХК /О.Орхон/-д тус тус үүрэг болгосугай:

1/ тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж үнэт цаас гаргах шийдвэр гаргасантай холбогдуулж уг асуудлаар эсрэг саналтай, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа компанид эргүүлэн худалдахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;


2/ нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах;

3/ Аудитын компаниудын гаргасан дүгнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг андеррайтерийн дүгнэлтэд тусгах.

7. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ДЭД ДАРГА



ЭВАТБОЛД